




ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ



**АРГА ЗҮЙН
ЗӨВЛӨМЖ**



Улаанбаатар
2023



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



БОЛОВСРОЛЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ



НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Захиалагч: Боловсрол Шинжлэх Ухааны Яам

Гүйцэтгэгч: Боловсролын ерөнхий газар
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
Боловсролын үнэлгээний төв
Нийслэлийн Боловсролын газар

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтод “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтанд тавигдах шаардлага, удирдах ажилтныг бэлтгэх, томилох тогтолцоо, ажил үүргийн хуваарийг шинэчилж, сургалтын чанарыг хангах чиг үүргийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулан сургалтын байгууллагын менежментийн чадавхыг дээшлүүлнэ” гэж заасан.

Энэхүү хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, суралцагч бүрд чанартай боловсролыг эзэмшүүлэх, тэгш боломжийг бүрдүүлэх, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд сургуулийн удирдах ажилтан, багш, хамт олон хамгийн чухал үүрэг хариуцлагыг хүлээнэ. Ялангуяа технологийн хурдтай өөрчлөлт, байгаль орчин, нийгэмд гарч буй, цаашид тулгарах сорил, бэрхшээлүүдийг даван туулах, зохицон амьдрах чадвартай хүүхэд, залуу үеийг төлөвшүүлэхэд сургуулиуд өмнө байгаагүй шинэ үүрэг, зохион байгуулалттай болох шаардлагатай болж байна. Энэ саад бэрхшээлийг шинэ чиг үүрэг, зохион байгуулалтаар даван туулахад боловсрол өөрөө хувьсан өөрчлөгдөх хэрэгтэй байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Монгол Улсын боловсролын хуулиуд багцаараа шинэчлэгдсэн бөгөөд дараах өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх боломжтой болсон. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл
- Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилт
- Багшийн мэргэжлийн хөгжлийн шинэчлэл
- Олон улсын жишигт хүрсэн үндэсний үнэлгээ
- Боловсролын цахим шилжилт
- Сургуулийн менежмент

Дээрх шинэчлэлийг хэрэгжүүлэх сургуулийн удирдах ажилтнуудад зориулсан Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмжид суралцагч төвтэй сургуулийн менежментийг хөгжүүлэх, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, түүнд үндэслэн зөв шийдвэр гаргах, сургуулийн менежментийг сайжруулах арга зам, боломж, ижил төстэй байгууллагуудын туршлагыг багтаасан нь ажлын байрандаа тасралтгүй суралцах, хөгжих, хамт олноо манлайлан зөв менежментээр багаа удирдах, ур чадвараа дээшлүүлэх боломжтой болсноороо онцлогтой.

Боловсролын сэргэлтээр хот, хөдөөгийн болоод хувийн, төрийн сургуулийн чанарын ялгааг арилгаж, хамгийн сайн сургууль, цэцэрлэг гэрт ойрхон сургууль, цэцэрлэгийн тогтолцоотой болох энэ том үйлс та бүхний сэтгэл, зүтгэл, мэргэжлийн манлайлалаас шалтгаалах болно. Энэхүү зөвлөмжийг амжилттай хэрэгжүүлэхэд орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, боловсролын байгууллагууд харилцан уялдаатай хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Та бүхний удирдахуйн ур чадвар, манлайллаас байгууллагын соёл, хамт олон, хүүхдийн хөгжилд гарах ахиц өөрчлөлт хамаарах тул цаг үргэлж менежменттэй манлайлагч байхыг хүсэн ерөөе.

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

АГУУЛГА

Өмнөх үг	3
Товчилсон үгийн жагсаалт	8
Нэр томъёоны тайлбар	9

I БҮЛЭГ

СУРАГЧ ТӨВТЭЙ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?	13
1.1 Суралцахуйд гарч буй өөрчлөлт	14
Сурагчид юу хүсэж байна вэ?	16
Сургууль хэрхэн өөрчлөгдөж байна вэ?	18
Багш хэрхэн өөрчлөгдөх вэ?	21
Сургуулийн захирал юу хийх вэ?	23
1.2 Сургуулийн менежментийн загвар	25
“Гурван давхаргат пирамид” загвар	25
Богино хугацааны сургуулийн менежементийн зураглал	31

II БҮЛЭГ

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ШИЙДВЭР ГАРГАЛТ	43
2.1 Менежментийг сайжруулах ажлыг хаанаас эхлэх нь оновчтой вэ?	44
2.2. Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээ	49
2.3 Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээллийг Хаанаас авах, хэрхэн ашиглах вэ?	53
2.4. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс тулгамдаж буй асуудлыг хэрхэн тодорхойлох вэ?	68

III БҮЛЭГ

СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ, АСУУДАЛ ШИЙДЭЛ.	71
3.1 Суралцагчийн хөгжил, хамгааллыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?	72
3.1.1 Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх яагаад чухал вэ?	77
3.1.2 Сурагчийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт менежмент.	87
3.1.3 Удирдах ажилтны харилцааны ур чадвар сурагчийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд нөлөөлөх нь	89
3.2 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ?	91
3.2.1 Сургалтын хөтөлбөрийг судлах, ойлгох	91
3.2.2 Сургалт, үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх вэ?	103
3.2.3 Суралцахуй ба багшлахуй (сургалтын арга технологи)	111
3.2.4 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	119
3.3 Багшийн хөгжил	133
3.3.1 Багшийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох нь.	133
3.3.2 Багшийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн төлөвлөх	134
3.3.3 Багшийн манлайлал, хамтын ажиллагаа, соёл, өөрийн удирдлагатай суралцахуй	142
3.3.4 Багшийн өөрийн удирдлагатай суралцахуй, технологийн чадвар.	148
3.4 Сургалтыг зохион байгуулах таатай орчныг хэрхэн бүрдүүлэх вэ?	155
3.5 Сургуулийн материаллаг нөөцийг бүрдүүлэх аргачлалууд.	164
3.6 Сургуулийн удирдлага, манлайлал.	171
3.6.1 Сургуулийн зорилго, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт	171
3.6.2 Сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт	180
3.6.3 Байгууллагын хүний нөөц	185
3.6.4 Сургуулийн төсөв, санхүүжилт	190
3.6.5 Хамтын ажиллагаа, түншлэл.	190
3.6.6 Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах	193

ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Зөвлөмжийн гол хэрэглэгчид нь сургуулийн удирдлага (захирал болон бусад); дүүрэг, бүс нутаг, орон нутгийн боловсролын байгууллагын ажилтнууд болно.

Энэхүү зөвлөмж нь сургуулийн удирдлагын өнөөгийн бодлого, практикийг эргэн харах, цаашид хэрхэн ажиллах талаар нийтлэг ойлголтыг бий болгоход туслах зорилготой юм. Сургуулийн менежментийн талаар ойлгохоос эхлээд өөрийгөө үнэлэх, асуудлаа эрэмбэлэх, уялдаатай стратеги төлөвлөхөөс эхлээд суралцах болно. Тухайлбал,

- » Улс орны өнөөгийн нөхцөлд юуг онцлох, хэрхэн тасралтгүй тогтвортой авч явах вэ?
- » ЕБС-ийн сургалтын байгууллагын менежментийн зураглал
- » Танхимын болон онлайн сургалтын хослол, түүнийг хэрэгжүүлэх менежмент
- » Нэвтэд нь авч үзэх хөндлөн холбоотой ямар асуудлуудыг (cross-cutting issues) сонгох вэ?
- » Насан туршийн суралцахуй
- » Боловсролын чанар - суралцахуйн чанарыг тэргүүлэх чиглэл болгох ЯАЖ?
- » Байгууллагын болон сурагчдын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан сургуулийн менежментээ хэрхэн сайжруулах вэ?

Зөвлөмжийн агуулгын ерөнхий хүрээ

1-р бүлэг

Сурагч төвтэй сургуулийн менежментийг хэрхэн хөгжүүлэх вэ?

Сургууль, багш, сурагч хувьсан өөрчлөгдөхийн гол суурь нь юу болох, тэдгээрийг олон улс, үндэсний хэмжээнд ямар эрх зүйн баримт бичгийн хүрээнд шийдвэрлэх, ямар загвар аргачлалаар хэрэгжүүлэх талаар тусгасан.

2-р бүлэг

Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх, түүнд үндэслэн шийдвэр гаргах нь

Үнэлгээний ач холбогдол, сургуулийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг менежментээ сайжруулахад хэрхэн ашиглах, асуудлаа хэрхэн тодорхойлж, шийдвэр гаргах талаар тусгасан.

3-р бүлэг

Сургуулийн менежментийг сайжруулах арга зам, боломж юу байна вэ?

Сургуулиудад тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэж байгаа жишээ, кейс болон ижил төстэй асуудлыг хэрхэн шийдэж болох арга зам, арга аргачлалыг тусгасан.

Сургуулийн удирдлагууд агуулгыг ашиглахдаа өөрт тулгамдсан асуудал дээр тулгуурлан түүнийг шийдвэрлэхэд дэмжлэг болох агуулгыг сонгон судалж хэрэгжүүлж болно. Жишээлбэл, хэрэв алсын хараа тодорхойлохыг судлах сонирхол байгаа бол эсвэл сургуулийн өөрийн үнэлгээ хийх, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх чадварт суралцахыг хүсэж болно. Бүлэг бүрд тухайн агуулгын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалыг зөвлөмжилж өгсөн.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
АУБ	Анги удирдсан багш
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
БСШУ	Боловсрол Соёл Шинжлэх ухаан
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БЕХ	Боловсролын ерөнхий хууль
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ЗАН	Заах аргын нэгдэл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МХБ	Мэргэжлийн хөгжлийн бүлэг
МХХТ	Мэдээлэл, харилцаа, холбооны технологи
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их сургууль
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СӨЕБХ	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
СБААХ	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага
СЗ	Сургуулийн зөвлөл
ССМ	Сургуульд суурилсан менежмент
СҮА	Сургалт, үйл ажиллагаа
СДҮА	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСТХ	Үнэлэх-Сайжруулах-Төлөвлөх-Хэрэгжүүлэх
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХГҮА	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
ХСҮДҮШ	Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага
ЭМ	Эрүүл мэнд
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэсний байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага
OECD	Organisation for Economic Co-operation and Development
PISA	Programme for International Student Assessment
СХ	Сургалтын хөтөлбөр
СЗ	Суралцахуйн зорилт
СҮДШГТ	Суралцахуйн үр дүнгийн шалгуур гүйцэтгэлийн түвшин
СССХ	Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Бие бялдрын хөгжил – Хүний хөгжлийн суурь болсон биеийн өндөр жин, харьцаа, биеийн чанар (хурд, хүч, авхаалж самбаа, уян хатан чанар), дотоод эрхтэн тогтолцоо, физиологийн хөгжил;

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр - Ерөнхий боловсрол эзэмшихийн тулд оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй суралцагчдын амьдрах зориулалт бүхий сургуулийн бүрэлдэхүүн хэсэг;

Дотуур байрын үйлчилгээ - суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай гэрээлсний үндсэн дээр суралцагчдыг байрлуулан тэдний амьдралын хэвийн, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, асран хамгаалах, эрүүл мэнд, хөгжил хамгаалал, хоол хүнсний үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ;

Дотуур байрын орчин - дотуур байрын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах орчин;

СБААХ нь тогтвортой байдлыг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд, үйл ажиллагаа бүрд нэвтрүүлж, хэрэгжүүлэхийг илэрхийлсэн хандлага;

Сургуульд суурилсан менежмент (SCM)- Сургуульд суурилсан менежментийг боловсролын төвлөрлийг сааруулах нэг хэлбэр гэж тодорхойлдог. Энэ нь шийдвэр гаргах эрх мэдлийг сургуулийн түвшинд шилжүүлэх, дахин хуваарилах замаар оролцогч талуудын хяналт, хариуцлагыг нэмэгдүүлж сургуулийн менежментийг сайжруулах, тогтвортой байлгах чухал хэрэгсэл болдог.

Сургууль суралцахуйн зангилаа талбар (Schools as learning hubs) – Сургуулиуд хэвээр байгаа ч олон талт байдал, лаборатори туршилт нь нийтлэг үзэгдэл болсон. “Сургуулийн хана”-г нээх буюу сургуулиуд илүү нээлттэй ажилласнаар нийгэмтэй холбогдож, байнга хувьсан өөрчлөгддөг сургалтын арга хэлбэр, иргэний оролцоо, нийгмийн инновацыг дэмжих боломж бүрдэнэ.

Сургалтын хөтөлбөрийн интеграци (Curriculum integration)- сургалтын агуулгыг нэгтгэх/тодорхойлох үйл явц;

Судлагдахууны дотоод интеграци (Interdisciplinary integration)-Тухайн судлагдахуунд багтсан агуулга хоорондын интеграци;

Судлагдахуун хоорондын интеграци (Multidisciplinary integration)- Судлагдахуунуудын агуулгыг нийтлэг сэдэв, үзэгдэлд зангидсан интеграци ;

Судлагдахуун дамнасан интеграци (Transdisciplinary integration)- Судлагдахуунуудын агуулгаас давсан, өргөн хүрээг хамарсан интеграци;

Хичээл хоорондын агуулга/сэдэв (Cross-cutting themes)- Хэд хэдэн хичээл/судлагдахуунаар судалдаг сургалтын хөтөлбөрийн чухал агуулга/сэдэв;

Сургалтын орчин гэж сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг;

Сургалтын хэрэглэгдэхүүн - сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд ашиглах техник хэрэгсэл, багаж төхөөрөмж, урвалж бодис, загвар, үзүүлэн, тараах материал, сурах бичиг, гарын авлага, цахим хэрэглэгдэхүүнийг хамруулна;

Сургуулийн орчин - ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан сургуульд эзэмшүүлсэн газар, түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газар;

Сургуулийн гадаад орчин - суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлж, стандартын дагуу байгуулсан тоглоом, биеийн тамир, туршилтын болон задгай талбай, ногоон байгууламж, аж ахуйн үйл ажиллагааны бүс бүхий орчин;

Сургуулийн дотоод орчин - олон нийт, иргэний барилгын норм дүрэм, стандартын дагуу барьсан сургуулийн барилга байгууламжийн дотор суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах, тэгш боломжийг бүрдүүлсэн материаллаг орчин;

Танин мэдэхүйн хөгжил- Танин мэдэх үйл ажиллагааны бүрдэл болсон хүртэхүй, ой тогтоолт, ухагдахуун төлөвшил, асуудлыг шийдвэрлэх, учир шалтгаанд нь сэтгэх үйл явцын хөгжил;

Нийгэмшил- Хувь хүн нь бүлэг хүмүүстэй буюу нийгэмд зохицохын тулд нийгмийн хэм хэмжээ, үзэл баримтлал, эерэг хандлага, харилцааны чадвар эзэмших тасралтгүй үйл явц;

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх- Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх, эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх;

Хүүхдийн хамгаалуулах эрх - Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах;

Хүүхдийн хөгжих эрх- Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараах эрх эдэлнэ: хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших; хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших; хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах; хүүхэд шашин шүтэх, эс шүтэх; хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах; хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх;

Хүүхдийн оролцох эрх- хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох; хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх; хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах; хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах;

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлт - сургуулийн түвшинд сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлж шинэчлэх үйл явц юм.

Далд сургалтын хөтөлбөр - бичигдсэн болон төлөвлөсөн сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй сургуулийн орчин, соёлын нөлөөгөөр суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг илэрхийлэх сургалтын хөтөлбөр юм.

Өөрийн үнэлгээ нь сургууль тухайн жилийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чанар, нийцийг баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотой үнэлж, сайжруулах шаардлагатай асуудлыг илрүүлэх оношлох үнэлгээ юм.

Хөндлөнгийн үнэлгээ нь сургуулийн өөрийн үнэлгээ бодитой эсэхийг магадлан баталгаажуулах, сургалт, үйл ажиллагаагаа сайжруулахад шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох зорилго бүхий хөндлөнгийн байгууллагаас хийж буй үнэлгээ юм.

ТЭМДЭГЛЭЛ



СУРАГЧ ТӨВТЭЙ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

I БҮЛГИЙН ТОЙМ



ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ

- Сурагчид юу хүсч байна вэ?
- Сургууль хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Багш хэрхэн өөрчлөгдөх вэ?
- Сургуулийн захирал юу хийх вэ?



СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАГВАР

- Сургуулийн менежментийн гурван давхаргат загвар
- Сургуулиа хувирган өөрчлөх алхмууд
- Алсын хараа тодорхойлох Менежментийн жилийн зураглал боловсруулах аргачлал

1.1 СУРАЛЦАХУЙД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Дэлхий дахин Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааны хувьсаж буй боловсролын талаар хэлэлцэж байна. Боловсролын тогтолцоо улам бүр боловсронгуй болж хувь хүмүүс, улс орны эдийн засаг хөгжин цэцэглэх гол хөдөлгүүр нь болсныг бид мэднэ. Гэвч боловсролын чухал хүчин зүйлс болох мэдлэг, чадвар, хандлага, үнэ цэн ирээдүйд ямар байх, амьдралынхаа туршид суралцахад нь ямар орчныг бүрдүүлж, ямар боломжоор хангах талаар нухацтай бодох, энэ тухай хэлэлцүүлэг өрнүүлэх цаг үе ирээд байгааг дэлхий дахин хүлээн зөвшөөрч байна.

Сүүлийн жилүүдэд олон улс орон, үүний дотор НҮБ-ын гишүүн улс орнууд болон ЮНЕСКО, ЭЗХАХБ, ДЭЗФ зэрэг олон улсын байгууллагаас “Боловсролын ирээдүйг бүтээх нь”, “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ”, “Schools of the Future Defining New Models of Education for the Fourth Industrial Revolution” зэрэг судалгааны болон бодлогын баримт бичгийг боловсруулан хэлэлцэж байна.



Зураг. 1.1 ТХБ-ын Замын зураглалд тодорхойлсон тэргүүлэх чиглэл, ЮНЕСКО, 2020

Монгол Улс ч энэ хэлэлцүүлэгт нэгдэж байна. Манай улс урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 зэргийг батлан, 4-5 жилийн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд (i) Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлох, (ii) сургалтын хөтөлбөрийг монголын түүх, эх хэл, зан заншил, эх оронч үзэл хандлага, үндэсний өв уламжлалын агуулгаар баяжуулах, (iii) бүх нийтийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсний тухай боловсрол олгох (iv) сургалтын цахим платформ хөгжүүлэх, (v) боловсролын чанарыг олон улсад үнэлүүлэх асуудал туссан байна;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь (i) цахим сургалтын платформ (агуулга, хөтөлбөр, хичээл)-ыг хөгжүүлэх, (ii) сургалтын хөтөлбөрийг монголын түүх, эх хэл, соёл, зан заншил, эх оронч үзэл хандлага, үндэсний өв уламжлалын агуулгаар баяжуулах; (iii) бүх нийтэд харилцаа холбоо, мэдээллийн технологи, хүний эрх, жендэрийн боловсрол олгох, (iv) боловсролын чанарыг олон улсад үнэлүүлэх асуудалд анхаарсан байна.

Монгол Улсын Боловсролын багц хуулийг шинэчилж, хэрэгжүүлэх ажил эхэлж байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль СӨЕБХ шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Уг хуульд сурагч төвтэй тэгш хамруулан сургах, боловсрол эзэмших тэгш боломж хангах, хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, боловсролын агуулга, сургалтын хөтөлбөр, сурах бичгийн тогтвортой байдлыг хангах, сурагчийн хөгжил, төлөвшлийг дэмжихэд сургуулийн хамт олон, бусад талын оролцоог хангах зэрэг чиглэлээр тодорхой зохицуулалт хийсэн. Мөн боловсролын сургалтын байгууллагын эрх хэмжээг тогтоосон байна.



Төрийн мэдээлэл эмхэтгэлий 2023 оны №27 (1275)-д Боловсролын багц хууль хэвлэгдсэн

СУРАГЧИД ЮУ ХҮСЭЖ БАЙНА ВЭ?

Тэд эрс өөрчлөлт, гэнэтийн эргэлтийн үед амьдарч байна. Олон улс орны судлаачид ирээдүйг тогтворгүй, тодорхойгүй, нарийн төвөгтэй, хоёрдмол байдалтай (VUCA) гэж тодорхойлсон байна.¹ Гэсэн хэдий ч ирээдүйгээ хүмүүс өөрсдөө бүтээдэг, ирээдүй бол өнөөдөрт бүрэлдэж байдгийг бид мэднэ. Бидний сурагчид хараахан бий болоогүй ажлын байранд ажиллахыг, хараахан зохион бүтээгээгүй технологийг ашиглахыг, эсвэл бидний төсөөлж чадахгүй байгаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд суралцах шаардлага бий болжээ.

Сурагчид эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хурдацтай өөрчлөлтийг хүлээн авч дасан зохицож, тодорхой бус нөхцөлд тодорхой шийдвэр гаргаж чаддаг байхын төлөө суралцаж байна.

Хүснэгт 1.1 Ирээдүйн нийгмийн иргэн-дүр төрх²

Үнэт зүйл, хандлагын хувьд	<ul style="list-style-type: none">- бие махбод, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, ёс суртахуун нэгдэж цогцолсон төлөвшсөн хүмүүн;- ёс зүйтэй, хүмүүнлэг энэрэнгүй, бусдын уламжлал, итгэл үнэмшилд бүрэн хүндэтгэлтэй ханддаг, олон ургалч үзэлтэн;- энх тайван, эв нэгдлийг эрхэмлэсэн, эх дэлхийгээ хайрладаг дэлхийн иргэн- бусдын оронд өөрийгөө тавьдаг, бусдад итгэдэг, хариуцлага үүрдэг, энэрэн нигүүлсэгч;
Шинжлэх ухаанч байдал, суралцах арга барилын хувьд	<ul style="list-style-type: none">- шинжлэх ухааныг гүнзгий ойлгогч;- оюун ухаанаа сэтгэл хөдлөлтэй холбон, дэлхий ертөнцөө танигч;- асуух, тааварлах, эргэлзэх, ажиглах, турших, мэдээллийг ангилах, тасралтгүй дадлага сургуулилт хийх зэргээр судлан таних арга зүйг эзэмшигч;- насан туршдаа суралцагч, суралцахуйгаа удирдан чиглүүлэгч, суралцахуйн намтраа өөрөө, мэдлэгийг хамтран бүтээгч;- мета-танин мэдэхүйн чадвараа хөгжүүлэгч;- хамтран суралцагч;
Хувь хүний ур чадварын хувьд	<ul style="list-style-type: none">- идэвхтэй, үр бүтээлтэй оролцогч, хамтрагч;- инноваци бүтээгч;- цахим иргэн;- тодорхой бус байдлыг даван туулагч, дасан зохицогч;- ирээдүйгээ тодорхойлогч;

1 OECD, Боловсролын ирээдүйг цогцлоох нь, 2021

2 У.Туяа, М.Хүрэлтогоо, Г.Бүрэнжаргал, А.Мөнхмагнай нар, Боловсролын ирээдүйн чиг хандлага - баримт бичгийн шинжилгээний зарим үр дүн, 2022, БСҮХ-ийн УШ-ний цахим сэтгүүл

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлал боловсруулах үндэслэлд ирээдүйн суралцагч, иргэний дүр төрхийг “Чин шударга зан төлөвтэй, эх орноороо бахархаж эх хэл, ёс уламжлалаа өвлөн эзэмшдэг, сурах арга барил эзэмшин өөрийн авьяас чадвараа хөгжүүлдэг, бусадтай хамтран ажиллаж, төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чаддаг, эх байгальдаа болон бусдад ээлтэй, амьдрах эерэг хандлагатай, мэдлэг, мэдээллийн нийгэмд амь биеэ тэжээх, амьдрах бэлтгэлтэй байх нь шинэ зууны суралцагч”³ гэж тодорхойлжээ.

Сурагчид өөрийн суралцахуйн түүхээ бүтээж, судлагдахууны агуулгын мэдлэгээс гадна нийгэм, сэтгэл хөдлөлийн чадвараа хөгжүүлж байна. Сурагчдад судлагдахууны мэдлэгээс гадна асуудлыг хамтран шийдвэрлэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, удирдах чадварт суралцах нь танин мэдэхүйтэй адил чухал болж байна. Энэхүү чадварыг хөгжүүлэхэд гэр бүл, олон нийт, үе тэнгийнхэн болон сургууль хамтран үүрэг хүлээх болж байна. Сурагчид сургуулиас гадуурх урлаг, спортын үйл ажиллагаанд оролцох, олон нийтийн болон сайн дурын ажил хийх зэргээр олон талын харилцаанд орж, олон янзын нөхцөл байдалд суралцаж байна.

Сурагчид хаанаас ч суралцах боломжтой болж байна.

Өнөөгийн сургуулийн анги танхим, суралцахуйн орчин өөрчлөгдөж, хамтаар суралцах шинэ орон зай, интерактив, дижитал, хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэгдэхүүн бүхий орчин бий болж, кэйст тулгуурласан агуулга бүхий онлайн, цахим, зайн, холимог (hybrid, blended) хэлбэрт шилжиж байна. Технологийн тусламжтайгаар сургуулиас гадуур суралцах шинэ, алтернатив сувгууд бий болж байна. Үүнтэй холбоотойгоор сурагчдад технологийг, суралцах шинэ, алтернатив сувгууд ашиглах ур чадвар дижитал бичиг үсгийн боловсрол хэрэгтэй.




Зураг 1.2. Ковидын үеэр гэрээсээ онлайнгаар суралцаж буй сурагч

Сурагчид технологийн боломжийг ашиглан танхимын бус хэлбэрээр, зайнаас суралцах боломжтой болсон нь зөвхөн нийгмийн эрүүл мэндийн шалтгаанаар төдийгүй зуд зэрэг байгалийн гамшгийн үед хичээл сургуульдаа хамрагдах боломжгүй болсон сурагчдад дэмжлэг үзүүлэх, тэднийг суралцахуйн хоцрогдолд орохоос сэргийлэх боломжийг бидэнд олгож байна.

3 Мөнхжаргал Д., Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлал боловсруулах үндэслэл, 2021

СУРГУУЛЬ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА ВЭ?

Сургууль нь хаалттай бус, бүхэл эко системийн нэг хэсэг болж байна. Сургууль нь нийтээрээ танхимд суралцахаас гадна сургууль, анги танхимаас гадуур суралцахыг, сонирхлын бүлгүүд болон бусад байгууллагын, нийгмийн сүлжээг ашиглан суралцахыг хүлээн зөвшөөрдөг, суралцах үйл ажиллагааг илүү өргөн, нээлттэй, уян хатан орон зай болон хувиран өөрчлөгдөж байна.



Зураг 1.3. Интерактив цахим хичээл Medle.mn

Судлаачид “XXI зууны суралцагчийг XX зууны сургалтын арга зүйгээр, XIX зууны сургууль, сургалтын орчинд бэлтгэх боломжгүй” гэдгийг тэмдэглэж байгаа бөгөөд XXI зуунд сургуулийн талаарх ойлголт, хэв шинж, менежмент ихээр өөрчлөгдөж байна. Ямар ч тохиолдолд сурагчийн хувьд суралцах үйлийг нь хөнгөвчилж, баялаг болгож байдаг сургууль чухал. Учир нь суралцахуйн гол мөн чанар нь зөвхөн мэдлэг эзэмших үйл явц бус сургууль болон түүнийг тойрсон олон нийтийн харилцаа юм. Бид бусадтайгаа хамт болон бусдаас суралцаж байдаг. Үүнээс гадна зөвхөн суралцах зорилгыг өмнөө тавьж, нэг цаг хугацаа, орон зайд төвлөрсөн нөхцөлд хүн хамгийн сайн суралцдаг байна.

ЭЗХАХБ-аас ирээдүйн сургуулийн 4 сценарийг дараах байдлаар тодорхойлоод байна.

- Сургуулийн өргөжүүлэлт (Schooling extend) - Албан боловсролд хамрагдалт нэмэгдсээр байна. Олон улсын хамтын ажиллагаа, технологийн дэвшил нь бие дааж суралцах арга барилыг дэмжиж байна. Сургуулийн бүтэц, үйл явц хэвээр байна.
- Боловсролын аутсорсинг (Education outsourced) - Нийгмээс иргэдийг боловсролтой болгож, чадавхжуулах арга хэмжээнд шууд оролцох тусам уламжлалт сургуулийн тогтолцоонд өөрчлөлт ордог. Суралцахуй нь дижитал технологийг ашиглан илүү олон талт, уян хатан зохицуулалттай болж байна.
- Сургууль суралцахуйн зангилаа талбар (Schools as learning hubs) – Сургуулиуд хэвээр байгаа ч олон талт байдал, лаборатори туршилт нь нийтлэг үзэгдэл болсон. “Сургуулийн хана”-г нээх буюу сургуулиуд илүү нээлттэй ажилласнаар нийгэмтэй холбогдож, байнга хувьсан өөрчлөгддөг сургалтын арга хэлбэр, иргэний оролцоо, нийгмийн инновацыг дэмжих боломж бүрдэнэ.

- Чөлөөт суралцахуй (Learning as you go) - Боловсрол хаана ч, хэзээ ч тасралтгүй явагддаг.
- Техник технологид суурилсан нийгэмд шилжсэнээр албан ба албан бус сургалтын ялгаа арилж, үгүй болсон.

Эх сурвалж. Four OECD Scenarios for the Future of schooling, 2020, www.oecd.org

Сургууль бол сурагчдын суралцах орон зай, боломж юм. Тэдэнд илүү их орон зай боломж бий болж байна. Үүний тод жишээ КОВИД-19 цар тахал байлаа. Цар тахал бидэнд сургууль нь тусгаарлагдсан орчин биш юм гэдгийг ойлгуулж, сургууль болон багш нар суралцахуйн өөр бусад хүчин зүйлстэй харилцаанд орж, хүүхдүүдийн суралцахуйг дэмжиж, хамтран ажиллаж болохыг харуулсан.

Гэр бүлийн дэмжлэг, туслалцаа, хувь хүн хоорондын харилцаа холбоо суралцах томоохон орон зай юм. Танхимын сургалт цуцлагдсан үед суралцах үйлийг тасалдуулахгүй, амжилттай үргэлжлүүлэх цор ганц, хамгийн чухал хүчин зүйл нь эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг байсан. Мөн нийгмийн эрүүл мэнд, халамжийн тогтолцоо, олон нийтийн сүлжээ зэрэг нийгмийн институт нь хүнийг нийгэмшүүлэх, суралцах орон зайгаар хангахад чухал үүрэгтэй болж байна.



Зураг 1.4. Интерактив цахим хичээлээ үзэж буй ээж, хүү хоёр. Зургийг НҮБ-ийн Хүүхдийн сан & Gogo.mn

Сургууль улам бүр нээлттэй болж түншлэлийг хэрэгжүүлэгч болж байна. Сургууль бүр гадаад ертөнцтэй илүү сайн хамтарч ажиллах цаг үе ирсэн байна. Сургууль болон музей, театр, номын сан, спорт клубууд зэрэг нийгэм соёлын байгууллага, орон нутгийн бизнес аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааг бий болгож, суралцаж болох орон зайг нээж өгөх нь сурагчдад чухал ач холбогдолтой.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль (2023)

3.3. Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/, ерөнхий боловсролын сургууль энэ хуулийн 3.1, 3.2-т заасан боловсролын зорилгыг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Эдгээр үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин ч боловсронгуй болж байна. Тухайлбал, Монгол Улсын Соёлын тухай хуулийн 11 дүгээр зүйл бүхэлдээ “Соёлын боловсрол олгох үйл ажиллагаа”-г зохицуулсан байна.

Соёлын тухай хууль (2021)

4 дүгээр зүйл. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого

4.1.6. хувь хүний бүтээлч хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэнийг соён гэгээрүүлэх;

8 дугаар зүйл. Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэл

8.6. Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжинэ.

9 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны чиглэл

9.1.12. соёлын боловсрол олгохтой холбоотой үйл ажиллагаа;

Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ) нь сургуулийн менежментийг дэмжиж буй нэг хэлбэр болж байна. СБААХ нь тогтвортой байдлыг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд, үйл ажиллагаа бүрд нэвтрүүлж, хэрэгжүүлэхийг илэрхийлсэн хандлага юм. Тухайлбал, сургуулийн засаглал, менежмент, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааг зохицуулах механизмууд, судалгаа шинжилгээ, багш, хүний нөөцийн хөгжил болон сургалтын хөтөлбөр, сургуулийн дэд бүтэц, сурагчдын оролцоо, олон нийттэй харилцах харилцаа, түншлэл, хамтын ажиллагаа, байгууллагын соёл, үнэт зүйлс зэрэг бүх зүйлийг хамарна. Өөрөөр хэлбэл, сурагчдын сурах хөгжих, нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахын тулд сургуулийн хамт олны нэгдмэл, тасралтгүй, хамтын түншлэл бол СБААХ юм.⁴

Сургууль бүр өөр өөр хэрэгцээ, эхлэх цэгтэй байдаг бөгөөд сургуулиа энэхүү арга хандлагаар удирдахын тулд одоо байгаа зүйлийг үнэлэх, дутагдлыг арилгах төлөвлөгөө гаргах, ахиц дэвшлийн арга хэмжээг тодорхойлохоос эхлэх хэрэгтэй. Сургуулийг бүхэлд нь өөрчлөх эхний алхам бол сургуульдаа эерэг уур амьсгал, соёлыг бий болгох явдал бөгөөд энэ нь сургуулийн нийт хамт олны хамтын хүчин чармайлтыг шаарддаг.

4 2020. БОМСТ-ийн Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага гарын авлага

БАГШ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХ ВЭ?

Багш зөвхөн өөрийн заадаг судлагдахууны өндөр мэдлэг, туршлагатай байхаас гадна олон чадвараа хөгжүүлэх хэрэгцээтэй болж байна. Учир нь тогтворгүй, тодорхойгүй, ээдрээтэй ирээдүйд сурагчдаа бэлтгэх шаардлага үүссэн. Багш нарын өмнө “Одоогоор байхгүй ажлын байранд сурагчид маань амжилттай ажиллахын тулд ямар чадвараа, хэрхэн хөгжүүлэж, Би тэдэнд хэрхэн туслах вэ? Зохиогоогүй байгаа техник технологийг эзэмшихэд маань ямар бэлтгэл хэрэгтэй вэ?, эсхүл Төсөөлөөгүй нийгмийн асуудал тулгарахад хүүхдүүд хэрхэн шийдэхийг яаж заах вэ?” гэдэг олон асуулт байна. ЭЗХАХБ-ын боловсролын салбарт хэрэгжүүлэх стратегиа тодорхойлохдоо “Хувьсан өөрчлөгдөж буй дэлхийд хөгжиж цэцэглэхийн тулд сурагч арга хэмжээ авах, үйлдэл хийх хэрэгслүүдийг эзэмшиж (agency) сурагч багш хамтран ажиллах (co-agency) хэрэгтэй”-г тэмдэглэжээ.

“Нэг заах арга бүх сурагчид тохирно” гэдэг арга хандлагаас татгалзах хэрэгтэй болж байна. Танин мэдэхүйн сэтгэл зүй, тархи судлал болон нийгмийн сэтгэл зүй зэрэг салбарыг багтаасан “Суралцахуйн шинжлэх ухаан” шинээр хөгжсөнөөр бид хүн хэрхэн суралцдаг, хүний тархи хэрхэн ажилладаг талаар илүү ойлголттой болж байна. Мөн багш нар сурагчийн ялгаатай байдал, хувь хүний хэрэгцээг хангахад чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад суралцах хэрэгтэй болжээ.

Сурагч өөрийн суралцахуйн замналыг (learning trajectory) өөрөө дизайнчилж, хариуцлага хүлээж чаддаг болоход дэмжлэг үзүүлэх шинэ үүрэг багшид ногдох боллоо. Суралцахуй болон сургуульд гарч буй өөрчлөлт нь багшийн ажлын байрны тодорхойлолтыг өөрчилж байна. Ойрын ирээдүйд сурагч нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулах үүргээ ухамсарлаж, зорилгодоо хүрэхийн тулд ирээдүйгээ тодорхойлж, түүндээ чиглэсэн арга хэмжээ авч, өөрийн суралцахуйг чиглүүлэх чадварт суралцах шаардлагатай болж байна. Өөрийн суралцахуй, болон амьдралыг удирдан чиглүүлэх чадварыг эзэмшсэн байдал нь боловсролын үр дүнг илэрхийлнэ.

Хэдийгээр ирээдүй өөрчлөгдөж байгаа ч багшийн дэмжлэг, чиглүүлгийн ач холбогдол буурахгүй. Суралцахуй нь сурагч бусад оролцогчидтой (үе тэнгийнхэн, багш, сурган хүмүүжүүлэгч, дасгалжуулагч, ментор г.м.) нийгмийн харилцаанд орох үйл явц байдаг. Багш гэдэг нь суралцахуйн орчныг бүрдүүлж, суралцахуйг дизайнчилж өгдөг мэргэжилтэн бөгөөд мэргэжлийн олон янзын арга барилаар суралцахуйд дэмжлэг үзүүлнэ.

Ирээдүйн багш бол “Бусдаас болон орчноос хүлээн авсан шинэ мэдлэг, мэдээлэл, соёлын зүйлийг танин мэдэж ухаарсны үндсэн дээр үзэл бодлоо өөрчлөн өөрийн болгож хувирган, шинэ үнэт зүйлийг бүтээдэг, эзэмшсэн мэдлэг, чадвараа ашиглан ээдрээтэй асуудлыг шийдэх аргаа өөрчлөн хэрэглэж чаддаг, насан туршдаа тасралтгүй хөгжих хандлагатай, суралцахуйн хөтөч”⁵ юм.

Шигтгээ 1: Товч асуулт хариулт

А: XXI зууны шинэ багш хэн бэ?

Х: XXI зууны шинэ багш бол үзэл баримтлал юм. Энэ бол технологи, инноваци, сурагч төвтэй боловсролын хандлагыг хүлээн зөвшөөрдөг багш юм.

А: Энэ шинэ багш уламжлалт багш нараас юугаараа ялгаатай вэ?

Х: Энэ шинэ багш уламжлалт багш нараас хэд хэдэн зүйлээр ялгаатай. Нэгдүгээрт, тэд технологийг анхаарал сарниулах бус харин суралцах чадварыг сайжруулах хэрэгсэл гэж үздэг. Хоёрдугаарт, тэд сурагчдынхаа хэрэгцээ, сонирхлыг нэн тэргүүнд тавьж, хичээлээ төлөвлөдөг.

А: Шинэ багш ямар ур чадвартай байх ёстой вэ?

Х: Шинэ багш нь технологийн бичиг үсэг, дасан зохицох чадвар, бүтээлч байдал, харилцааны хүчтэй ур чадвар зэрэг олон төрлийн ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Тэд бусад багш, боловсролын мэргэжилтнүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах, үргэлж өөрчлөлтөд нээлттэй, шинэ, шинэлэг заах аргыг эрэлхийлдэг чадвартай байх ёстой.

А: Сургуулиуд энэ шинэ багшийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?

Х: Технологи, заах шинэлэг арга барилыг ашиглахад чиглэсэн мэргэжил дээшлүүлэх байнгын боломжоор хангах замаар энэхүү шинэ багшийн хөгжлийг дэмжих боломжтой. Нэмж дурдахад сургуулиуд хамтран ажиллах, туршилт хийх соёлыг бий болгож, багш нар санаа бодлоо хуваалцаж, шинэ зүйлийг туршиж үзэхийг дэмждэг байх хэрэгтэй. Эцэст нь, сургуулиуд сургалтын шинэ хандлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи, нөөц бололцоогоор хангахад анхаарах нь чухал.

Эх сурвалж. <https://parentingalpha.com/discover-the-6-qualities-of-the-21st-century-teacher/>

5 МУБИС-ийн захирлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар батлагдсан “Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал”-аас

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ ЮУ ХИЙХ ВЭ?

Сургуулийн ажлын үр дүн нь сурагчдын сурлагын ахиц, хөгжил төлөвшлөөр илэрнэ. Харин сургуулийн ажлыг сургуулийн захирал удирдана. Захирал сургуулийн алсыг харааг тодорхойлох, түүнд чиглэсэн сургалт, үйл ажиллагааны богино, дунд, урт хугацааны үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянах, санхүүгийн шийдвэр гаргах байдлаар сургуулийг удирддаг. Тэд бол манлайлагчид юм.

Сургуулийн удирдагчид хөгжиж, удирдах арга барилаа дээшлүүлж, бүтээмжээ нэмэгдүүлэх нь сурагчдын сурлагын түвшинг дээшлүүлэх гол хүчин зүйл бөгөөд багшийн удирдлага зөвхөн түүний зааж буй ангийн сурагчдын шалгалтын оноонд хамаарах бол захирлын удирдлага сургуулийн бүх сурагчдын оноонд нөлөөлдгийг судлаачид тогтоосон байна.⁶

Захирал нь боловсролын багц хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй. Тухайлбал, БЕХ-д зааснаар “33.3.3.тухайн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, суралцагчийг удирдан чиглүүлэх, тасралтгүй хөгжлийг хангах, үнэлэх, дэмжлэг үзүүлэх;” СӨЕБХ-д зааснаар “17.1.1.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, түүний хэрэгжилтийг мэргэжлийн түвшинд зохион байгуулахад багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоо, түншлэлийг хангаж ажиллах;”⁷ нь таны үндсэн чиг үүрэг болно.

Боловсролын ерөнхий хууль (2023)

33.3. Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.3.2. тухайн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх;

33.2.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах тусгай шаардлагыг хангасан байна:

33.2.1. багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр энэ хуулийн 27.1.2-т заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх;

⁶ CGD, Improving School Management in Low- and Middle-Income Countries: A Systematic Review, 2023

⁷ Бусад чиг үүргийг БЕХ-ийн 33, СӨЕБХ-ийн 17 дугаар зүйлээс дэлгэрүүлэн харна уу.

33.2.2. боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх.

Шигтгээ 2: Захирлын хариулах асуулт

Сургуулийн захирал өөрийн хийх ёстой гол гурван ажлаа хэр хэмжээнд гүйцэтгэдгийг дараах асуултад хариулах байдлаар сонжоод үзээрэй.

- 1) Мониторинг, үнэлгээ, хяналт
 - Сургууль дотор болж буй үйл явдлыг хэр сайн хянаж, үүнийг тасралтгүй сайжруулахад ашигладаг вэ?
 - Танай сургуулийн алсын хараа, зорилго, зорилт хэр биелэж байна вэ?
 - Багшийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажил тань сурагчдын сурлагын амжилтад нөлөөлж байна уу?
- 2) Зорилго, зорилт
 - Зөв зорилт тавьж, дагаж мөрддөг үү? Хэрэв зорилт, үр дүн хоёр зөрчилтэй байвал зохих арга хэмжээ авах уу?
 - Танай сургуулийн зорилго, зорилт сурагчийн хүлээж буй үр дүнтэй нийцэж байна уу?
 - Сургуулийн зорилго, зорилтоо тодорхойлохдоо сурагчийн хүсэж буй зүйл, багшийн ажилд болон сургуулийн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, ирээдүйн чиг хандлагыг судалсан уу?
 - Сургуулийнхаа зорилго, зорилтыг сурагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчид мэдэх үү? г.м
- 3) Дэмжлэг, урамшуулал
 - Сургуулийн хамт олон (сурагч, багш, ажилтан) болон хамтрагчдаа хэрхэн урамшуулдаг вэ?
 - Та ойрын үед хэнийг, хэрхэн урамшуулсан бэ?
 - Танай сургуульд сурагч болон бусад хэн нэгэнд үзүүлэх дэмжлэг тодорхой байдаг уу? Хэн, хаанаас дэмжлэг авахаа мэддэг үү?
 - Дэмжлэг үзүүлэх арга зам, энэ чиглэлээр үүрэг хариуцлага хүлээх хүмүүс тодорхой юу?

1.2 СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

Сургуулийн удирдлага өөрсдийн хийсэн шинжилгээндээ үндэслэн сургуулийнхаа онцлог, сурагчдынхаа хэрэгцээ, хүний хөгжилдөө тулгуурлан менежментийн загвараа боловсруулан сургуулиа удирддаг.

“ГУРВАН ДАВХАРГАТ ПИРАМИД” ЗАГВАР


Өмнөх 1.1 хэсэгт боловсрол хэрхэн хувьсан өөрчлөгдөж буй талаар, суралцагч, багш, сургалтын хөтөлбөр, сургууль хэрхэн хөгжиж буй чиг хандлагыг олон улсын болон өөрийн орны харьцуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэж авч үзсэн билээ.

Бидний хувьд сургуулийн өнөөгийн нийтлэг байдлыг тооцож, ирээдүйн чиг хандлагыг баримжаалан менежментээ тасралтгүй сайжруулах үйл явцыг сургуулиуд ямар зарчим, арга, хандлагаар хэрэгжүүлбэл богино, дунд, урт хугацаанд зорьсон үр дүндээ хүрч, суралцагч, төгсөгчдөд үр өгөөжөө өгөх боломжтойг бодолцон энэхүү “Гурван давхаргат пирамид” загварыг боловсруулсан болно.

Сургуулийн удирдлагын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөр өөр загвар хувилбарууд тухайлбал, PDCA (Plan-Do-Check-Action), R-PDCA (Research, Plan, Do, Check, Act)...түгээмэл хэрэглэгддэг. PDCA төстэй P-D-Study-A, R-PDCA, ADDIE (Analyze-Design-Develop-Implement-Evaluate) гэх мэт 3-5 алхамтай загварууд ч мөн байдаг. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO-21001/2018, MNS 21001/2021 “Plan-Do-Check-Action” стандарт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөж 2018 онд баталгаажсан. Харин Төлөвлөлт-Хэрэгжилт-Үнэлгээ-Сайжруулалт гэсэн стандарт Монгол улсад 2021 онд батлагдсан байна.

Энэхүү загварыг байгууллагын өөрчлөлтийн менежментийн онол (Theory of Changes), менежментийн ТХҮС (PDCA) загвар болон шинээр батлагдсан Боловсролын ерөнхий хууль, одоо хэлэлцэгдэж буй сургалтын хөтөлбөр шинэчлэлийн үзэл баримтлал зэрэгт үндэслэн боловсруулав.

Зураг 1.5. Сургуулийн менежментийн “Гурван давхаргат Пирамид” загвар



Ирээдүйн чиг хандлагад баримжаалж сургуулиуд алсын хараагаа тодорхойлох учраас менежментийн пирамид загварын оройн хэсэгт алсын харааг дүрслэв. Алсын хараа гэдэг бол сургууль бүрийн онцлог, үнэт зүйлийг болон сурагчдынхаа ирээдүйн дүр төрхийг харуулсан, урт хугацааны хүчин чармайлтын үр дүнд хүрэх цэг бөгөөд танай хамт олныг чиглүүлж нэгтгэж байдаг “Алтан гадас од” нь байх ёстой юм. Алсын харааг ихэнхдээ 5-10 жилээр тодорхойлдог.

Алсын хараанд хүрсэн эсэхээ хэмжих үзүүлэлт нь дунд, урт хугацааны үр дүнг хэмжих үзүүлэлтийг бодвол илүү чанарын шинжтэй, цогц, өргөн хүрээтэй ухагдахуунаар илэрхийлэгдсэн, үр өгөөжийг хэмжихүйц байхад анхаарах хэрэгтэй. Алсын харааг хэрхэн оновчтой тодорхойлох аргачлалыг дараагийн хэсэгт авч үзэх болно.

Пирамид загварын суурийн дөрвөн өнцөгт боловсролын үндсэн бүрэлдэхүүн болох сурагч, багш, сургалтын хөтөлбөр, сургуулийг оруулсан бөгөөд учир нь сургуулийн гол үйлчлүүлэгчид нь сурагчид, боловсролын үйлчилгээ үзүүлэгч гол субъект нь багш нар, сурагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичиг нь сургалтын хөтөлбөр, боловсрол олгох үйл явц өрнөдөг гол зангилаа талбар нь (learning hub) сургууль юм. Эдгээр нь хоорондоо салшгүй холбоотой, нэг нь нөгөөтэйгөө уялдсан, нэг нь нөгөөдөө багтсан шинжтэй байдаг учраас пирамидын суурийн зангилаа цэгүүд болгон

дүрслэв. Тухайлбал, сурагчдад тулгамдаж буй асуудал багшийн хөгжлийн хэрэгцээ, багшийн хөгжлийн хэрэгцээ нь сургуулийн хэрэгцээ болох гэх мэтээр нэг нь нөгөөгөөсөө урган гарах уялдаа холбоог илэрхийлсэн болно.

Мөн энэ бүрэлдэхүүн хэсгүүд одоо ямар түвшинд байгаа, богино хугацаанд буюу тухайн жилдээ хэрхэн өөрчлөгдөж сайжрахыг Үнэлэх-Сайжруулах-Төлөвлөх-Хэрэгжүүлэх (цаашид ҮСТХ гэх) мөчлөгөөр хэвтээ чиглэлд эргэхийг илэрхийлсэн бол цаашид дунд болон урт хугацаандаа хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хөгжиж сайжрахыг сууриас орой хүртэл ороомог маягаар тасралтгүй хөгжиж, дараагийн түвшиндээ хүрэхдээ мөн л ҮСТХ мөчлөгөөр үйл явц өрнөхийг сумаар зааж дүрсэлсэн болно.

Суурийг оройтой холбосон, тасалдсан шугамаар интеграцчилах үйл явцыг буюу салангид байдлаас хамтарсан хэлбэрт, цаашлаад нэгдмэл бүхэл байдалд шилжин хувьсан өөрчлөгдөх үйл явцыг илэрхийллээ. Өөрөөр хэлбэл, ирээдүйн чиг хандлагаас харахад сурагчдын мэдлэг чадвар, хандлага төлөвшил, бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд нь тэдний сайн сайхан байдлаар, цогц чадамжаар илэрхийлэгдэнэ. Үүнтэй нэгэн адил багш нарын арга зүй, мэдлэг чадвар, харилцаа хандлага ч хөгжлийн явцад улам цогц, нэгдмэл шинжтэй болох юм. Мөн багш нарын хамтын ажиллагаа сайжирч, дунд хугацаандаа баг, бүлгээрээ хамтрах байдал нь нэмэгдэх, урт хугацаандаа улам бүр нэгдэж, алсын хараандаа хүрэхийн тулд нэг итгэл үнэмшилд зангидагдаж, сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг илэрхийлнэ.

Өнөөгийн түвшинд сургалтын хөтөлбөрүүд салангид, судлагдахуун бүрийн суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэх, шинжлэх ухааны салангид мэдлэгийг эзэмшүүлэх хэв маяг давамгайл байгаа бол урт хугацаандаа хичээл хоорондын уялдаа холбоо сайжирч, сурагчдын сонирхол, ялгаатай байдал, сургууль, орон нутгийн онцлог, нийгмийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн сурагч төвтэй сургуулийн сургалтын хөтөлбөр (school based curriculum) болж интеграцчилагдах хандлагыг илэрхийлсэн болно.

Сургуулийг материаллаг болон үйлийн, соёлын орчин, суралцахуйн зангилаа талбар буюу орон нутаг, талуудын оролцоог хангасан нэгдмэл орчин болж хувьсан өөрчлөгдөнө гэж үзэж байна. Сургуулийн ханаар тусгаарлагдсан анги танхим, сургуулиар хязгаарлагдсан боловсрол эзэмших үйл явц дунд, урт хугацаандаа улам нээлттэй, нэгдмэл болж орон нутаг, олон нийт, эцэг эхийн оролцоо дэмжлэг нэмэгдэж, бэхэжсэн орон зай, суралцахуйн зангилаа талбар болно гэдгийг мөн загварт тусгав.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний сурагчдад тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдэх арга зам, хүрэх үр дүн, үнэлэх шалгуур нь

ялгаатай учраас уг загварт пирамидын суурийг гурван давхаргаар дүрслэн үзүүлсэн.

Сургуулийн хөгжлийг богино, дунд, урт хугацаанд нь харж нөөцөө зөв хуваарилах, үр дүнгээ эргэж нягтлан, орчин нөхцөл, цаг үеэ зөв мэдэрч, дотроосоо өөрчлөгдөн, тасралтгүй хөгжихийн тулд юуг хэрхэн анхаарах вэ? гэдгийг илүү тодорхой болгох үүднээс пирамидын давхарга тус бүрийг тайлбарлаж байна.

Суурийн давхарга бол та бидний одоо байгаа орон зай юм. Дээр тайлбарласанчлан мөчлөг бүрт багш нар салангид байдлаар ажилладаг, хамтын ажиллагаа учир дутагдалтай, байдгийг хавтайг олон хуваасан зураасуудаар дүрслэв.

Суурийн гол хэсэгт байгаа том дугуй дүрс бол урт хугацаанд шийдэгдэх суурь асуудлыг илэрхийлж буй бөгөөд түүний гол хэсэгт байх жижиг дугуй нь тухайн суурь асуудлаас нэг хичээлийн жилд хэрэгжих боломжтойг нь сургуулийн богино хугацааны буюу жилийн зорилго болгож бодитой тодорхойлохыг илэрхийлсэн болно. Өөрөөр хэлбэл, сурагчдад тулгамдсан асуудлыг илрүүлэхийг “үнэлэх” мөчлөг дээр эхэлж, цаг алдалгүй залруулах ажлыг багш өөрийн түвшинд хийхээс гадна тухайн жилийн турш сургуулиараа анхаарал хандуулах зорилго болгон тодорхойлно гэсэн үг юм.


Зураг 1.6. Пирамидын суурийн давхаргын тайлбар



- Өмнөх хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, боломжтойг нь даруй залруулах, тухайн жилийн зорилго, зорилгод тусгах;
- Багшийн хөгжлийн хэрэгцээ, шийдэл, зорилго зорилтыг тодорхойлох;
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт хийх, бага, дунд, ахлах ангийн түвшинд буулгаж уялдуулах;
- Жилийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх нөөц, орчинг бүрдүүлэх, талуудын оролцоотой хэрэгжүүлэх;
- Богино хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь сурагчийн ахиц амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний өгөгдөл, мэдээлэл байх тул мэдээллийг системтэй цуглуулах;

Пирамидын дунд давхарга нь суурь түвшингээсээ ахиж, алсын хараандаа хүрэх чиг шугам тогтож, бэхжих чухал үе юм. Зурагт үзүүлснийг анзаарвал өмнө суурийн хэсэгт байсан олон жижиг хэсгүүд цөөрч мөчлөг бүрт дөрвөн салангид бүлэг харагдаж байгаа нь интеграцчилагдах үйл явц дунд хугацаандаа хамтрах түвшинд хүрснийг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, сурагчийн мэдлэг чадвар, хандлага төлөвшил, эрүүл мэндийн асуудлууд суурь түвшинд жилийн зорилго зорилтуудын хүрээнд бага багаар, алхам алхмаар шийдэгдэж, дунд хугацааны зорилго хэрэгжсэн бол багш нар бүлгээрээ, багаараа хамтарч ажилладаг, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйд ч мөн интеграцчилагдах үйл явц өрнөж, сургууль орон нутаг, эцэг эх, асран хамгаалагч зэрэг талуудын оролцоо бэхжиж, хамтран ажиллах болсныг илэрхийлнэ.

Зураг 1.7. Пирамидын дунд давхаргын тайлбар



- Өмнөх жилүүдийн гүйцэтгэлд харьцуулсан дүн шинжилгээ хийх;
- Суурь асуудлын зарим хэсгийг шийдсэн байхаар дунд хугацааны зорилго, зорилтод тусгах;
- Багшийн хөгжлийн хамтын ажиллагаа тогтворжсон байх (сургалтын шинэ арга зүй, технологи);
- Сургалтын хөтөлбөрийг сургууль, орон нутаг, алсын хараанд нийцүүлэн баяжуулах;
- Сургуулийн нөөц, орчин сайжирсан, эцэг эх, орон нутгийн түншлэлийг бэхжүүлсэн байх;
- Дунд хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг өмнөх 2-3 жилийн сурагчийн ахиц амжилт болон гүйцэтгэлийн үнэлгээний дунджаар тооцоолох тул мэдээллийг системтэй цуглуулах, үнэлэх;


Дунд хугацааны менежментийн эхлэх цэг нь өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг харьцуулах, богино хугацааны зорилгын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийснээр эхэлнэ. Сайжруулах, засаж залруулах ажлыг тухай бүрт хийх нь богино, дунд, урт хугацааны менежментэд адил боловч суурийн түвшинд хийсэн, өөрчилж сайжруулах олон жижиг ажил дунд хугацаанд илүү цогц шинжтэй болохоороо ялгаатай. Тухайлбал, богино хугацаанд багш нар өөр өөрсдийн арга зүйг сайжруулах, эсвэл аль нэг ур чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн төлөвлөлт хийдэг байсан бол дунд хугацаанд тэдний хамтын ажиллагаа тогтмолжих, оролцогч талуудын дэмжлэг, түншлэл

бэхжих гэх мэт илүү чанарын түвшний өөрчлөлт гарах учиртай. Тиймээс дунд хугацааны зорилго зорилгод хүрсэн эсэхийг хэмжих шалгуур нь багш нарын хамтын ажиллагаа, сургуулийн соёл, хөтөлбөрийн баяжилт зэрэг дунд хугацааны үр дүнг хэмжихүйц шалгуур байх нь зохистой.

Пирамидын дээд давхарга нь та бидний хүрэхийг хүсэж буй алсын хараа, эрхэм зорилгоо хэрэгжүүлэх байдлыг илтгэнэ. Зургаас пирамидын суурийн болон дунд давхаргаас хэд хэдэн ялгаа байгааг харж болно. Тухайлбал, сургуулийн соёл, удирдлагын манлайлал, багш хамт олны үйл ажиллагаа улам бүр нэгдмэл болсныг салангид зураасууд арилснаар илэрхийлсэн байна. Энэ нь салангид байсан зүйлс интеграцчилагдаж бүхэл нэгдмэл болсныг илэрхийлнэ.

Энэ түвшинд сургуулийн стратеги төлөвлөлтийн биелэлтийг буюу алсын хараанд хүрсэн эсэхийг сурагчдад илрэх үр нөлөөгөөр, тэдний XXI зууны иргэний чадамжийг эзэмшсэн, сурагчийнхаа сонирхол, ялгаатай байдал, сургуулийн онцлог, орон нутгийн хэрэгцээнд нийцсэн сургуулийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн эсэхийг нягтална. Үүний үндсэн дээр дараагийн урт хугацааны алсын харааг шинээр томъёолохдоо цөм үнэт зүйлээ хадгалж, дараагийн 5-10 жилийн алсын хараагаа тодорхойлж, менежментээ боловсронгуй болох юм.

Зураг 1.8. Пирамидын дээд давхаргын тайлбар



БОГИНО ХУГАЦААНЫ СУРГУУЛИЙН МЕНЕЖЕМЕНТИЙН ЗУРАГЛАЛ

Үнэлгээний үр дүн буюу бодит байдал нь сургууль юуг хэрхэн өөрчлөх шаардлагатай болохыг тодорхой болгож өгдөг. Өмнөх бүлэгт менежментийн гурван давхаргат пирамид загварт үнэлгээг сургуулийг хувирган өөрчлөх үйл явцын эхлэл цэг гэж авч үзсэн ба ялангуяа, сурагчдын өмнө тулгарсан асуудлыг илрүүлж, засаж залруулахаас гадна жилийн төлөвлөлтөд тусгах, түүнийгээ хэрэгжүүлэх, дахин үнэлж сайжруулах тасралтгүй үйл явц болохыг үзүүлсэн.

Сургуулиуд хөндлөнгийн үнэлгээ, тухайлбал, байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж сурагчдынхаа тулгамдсан асуудал, бодит байдлыг хэрхэн тодорхойлох талаар зөвлөмжийг хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулна.

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сургуулиудын байршлаар А кластер буюу нийслэлийн, Б кластер буюу аймгийн, В кластер сум, багийн гэж ангилан кластер дотор нь эрэмбэлснийг та бүхэн мэднэ. Сургуулиуд газар зүйн байршлаас гадна, багш, сурагчдын тоо, материаллаг орчин, нөхцөл, удирдлагын бүтцийн хувьд харилцан адилгүй байгааг гурван сургуулийн жишээгээр хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1.2. Сургуулиуд ямар ялгаатай байна вэ?

Сургуулийн ерөнхий үзүүлэлт		Байршил		
		Нийслэл (..... сургууль)	Аймаг (..... сургууль)	Сум (..... сургууль)
Бүлгийн тоо	Бага	85	17	15
	Дунд	56	10	12
	Ахлах	44	5	7
Хүүхдийн тоо	Бага	3200	654	450
	Суурь	1800	264	250
	Бүрэн дунд	1200	123	150
Багшийн тоо	Нийт	250	49	46
	ЗАН-ийн тоо	8	5	4
	МХБ-ийн тоо	12	8	4

Удирдлагын бүтэц	Захирал	1	1	1
	Сургалтын менежер	5	3	2
	Нийгмийн ажилтан	3	1	1
	Сэтгэлзүйч	2	1	0
	Нягтлан	1	1	1
	Нярав	2	1	1
	Эмч	2	1	0
Орчин	Анги танхимын тоо	45	39	17
	Лаборатори	3	2	0
	Спорт заал	2	1	1
	Урлаг заал	2	1	1
	Багш нарын өрөө	2	1	2
	Цайны газар	2	1	1
	Интернет	тийм	тийм	тийм
	Ээлжийн тоо	2	2	2
	Кабинетаар хичээллэдэг эсэх	0	5	3

Эх сурвалж: Сургуулийн захирлын мэдээллээс

Хүснэгтээр харуулсан ялгаанаас гадна сум баг, аймаг, нийслэлийн сургуулиудын сурагчдын хэрэгцээ сонирхол, хүсэл мөрөөдөл, асуудал, асуудлын шалтгаан ч ялгаатай учраас сургуулиудын зорилго зорилт харилцан адилгүй байх нь ойлгомжтой.

Гүйцэтгэлийн үнэлгээний хувьд аль кластерт байх, сургуулийн онцлог ялгаанаас үл хамааран менежментээ сайжруулахад сургууль бүр анхаарлаа хандуулах нийтлэг зүйлс бий. Тухайлбал, сурагчдад тулгамдсан суурь асуудлыг хэрхэн илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэх зорилго, зорилтоо хэрхэн тодорхойлох, зорилгоо хэрэгжүүлэх төлөвлөлтийг хэрхэн оновчтой боловсруулах, энэ үйл явцад хэн, хэрхэн оролцох, хичээлийн жилийн менежментийн хэрэгжилтийн зураглалаа ямар дарааллаар, хэрхэн боловсруулах талаар сургууль бүр зохих ойлголт, аргачлалтай байх нь захирал, сургуулийн удирдах ажилтнуудад ач холбогдолтой юм.

Сурагчдад тулгамдсан асуудлыг илрүүлнэ гэдэг нь таамаг төдий, багш нар нэг өдөр сууж хэлэлцээд шийдчихдэг хялбар үйл явц биш харин мэдээлэл нотолгоо, үнэлгээний үр дүнд суурилж, бүх талын оролцоотой

дүн шинжилгээ хийж, суурь түвшин, хамрах хүрээ, шалтгааныг тодорхойлох тодорхой үе шаттай цогц үйл явц юм. Юун түрүүнд сурагчийн ахиц дэвшил, хөгжлийн үнэлгээг бодитой хийдэг байх, үнэлгээний шалгуур нь хөндлөнгийн үнэлгээний шалгууртай нийцдэг байх, зөвхөн сурлагын ахиц, амжилтыг үнэлээд зогсохгүй, хандлага төлөвшлийг үнэлэхэд анхаарах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл цуглуулж, шинжлэх замаар тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах нь зүйтэй.

Сурагчийг суралцахуйн түүхээ өөрөө бүтээгч, СҮА-ны идэвхтэй оролцогч гэж үзэж сургуулийн менежментийн бүхий л үе шатад үр дүнтэй оролцох боломжоор хангах нь чухал. Мөн багшаас гадна нийгмийн ажилтан, сургуулийн сэтгэл зүйч, эмч, үйлчилгээний ажилтнууд, эцэг, эх, асран хамгаалагчид зэрэг сурагчдын асуудлыг ажиглаж, мэдэрдэг бүхий л хүмүүс тэдэнд тулгамдсан асуудлуудыг илрүүлэхээс эхлээд сургуулийн менежментийн хэрэгжилтийг боловсруулахад оролцдог байх нь тэднийг алсын хараа, зорилго, зорилтдоо нэгтгэхэд тустай. Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд болон сургуулийн зөвлөл (СЗ)-ийн оролцоо нь тэдний хувьд хуулиар хүлээсэн чиг үүрэг юм. Энэ бүх үйл явцыг чиглүүлж, үр дүнтэй зохион байгуулах нь сургуулийн захирал, удирдлагын гол үүрэг байх учиртай.

Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцад талуудын оролцоо хангагдсанаар тэд тус бүртээ өөр өөрийн үүрэгтэй байж, асуудал бодитой, зорилго нэгдмэл, төлөвлөлт оновчтой, хэрэгжилт үр дүнтэй, хяналт олон талын, сайжруулалт тухай бүрт хийгдэх боломж бүрдэх юм. Гол нь тэд оролцоо, шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх, сурагч, сургуулиа тасралтгүй хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах санаачилга сайжирч, улмаар нөөцөө оновчтой зарцуулах үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Боловсролын ерөнхий хууль (2023)

40 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг
40.2.8. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиас зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, багш, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

40.3. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд гэрээний загварыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

23 дугаар зүйл.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага
23.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлагыг Боловсролын ерөнхий хуулийн 34.2-т заасан зөвлөл хэрэгжүүлнэ.

23.2.Зөвлөл нь цэцэрлэг, сургуулийн сургалт, үйл ажиллагаа, суралцагчийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой ба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
23.2.1.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх явцад санал, дүгнэлт гаргах;


Хүснэгт 1.3. Сургуулийн менежментийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоо

АЛХАМ	Сургуулийн СҮА-ны үндсэн оролцогчид			Сургуулийн бүтцийн нэгжүүд		
	Суралцагчид	Багш, ажилтан (сэтгэл зүйч, эмч, үйлчлэгч г.м)	Эцэг эх, асран хамгаалагчид	ЗАН, МХБ	Сургуулийн зөвлөл	Сурагчдын байгууллага
АСУУДЛАА ИЛРҮҮЛЭХ (Үнэлгээний үр дүнд илжилгээ хийх, баримт, нотолгоонд үндэслэх)	Асуудал илрүүлэх үйл явцад оролцох, өөрийн санал, нотолгоог гаргах	Сурагчийн гүйцэтгэл, нотолгоонд дүн шинжилгээ хийх (Явцын, эцсийн, хөндлөнгийн үнэлгээ, ажиглалт, тэмдэглэл г.м)	Хүүхдийн мэдлэг, чадвар төлөвшил, эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг өөрсдийн нотолгоонд үндэслэн тодорхойлох	Багш нараас ирүүлсэн асуудлуудыг эрэмбэлж, судлагдахуун, бага, дунд, ахлах ангийн түвшинд багцлах	Эцэг эх, асран хамгаалагчдаас ирүүлсэн саналыг нэгтгэх, сургуулийн хүрээнд тулгамдсан асуудлыг тодорхойлоход оролцох	Сурагчдаас ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэж, уламжлах, сургуулийн түвшний асуудлыг тодорхойлоход оролцох
ЗОРИЛГО, ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОХ (SMART байлгах)	Ангийн болон сургуулийн зорилго, зорилт тодорхойлоход оролцож, тэдгээртэй өөрийн зорилго, зорилтоо уялдуулах	Сурагчдад тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэсэн шийдэл, зорилго, зорилтыг санал болгох	Ангийн болон сургуулийн зорилго тодорхойлох хэлэлцүүлэгт оролцож, санал, шийдлээ гаргах	Багш нарын гаргасан шийдлийн хувилбаруудыг харьцуулж, эрэмбэлэх, багцлах	Эцэг эх, орон нутгийн зүгээс сургуулийн зорилго тодорхойлоход өгсөн саналыг нэгтгэх, сургуулийн зорилгыг эцэслэн тодорхойлоход оролцох	Сурагчдын болон ангийн зорилгыг нэгтгэж, сургуулийн зорилгыг эцэслэн тодорхойлоход оролцох

ТӨЛӨВЛӨХ (Сургалтын гол үйл ажиллагаа (СҮА))	Сургуулийн болон ангийн зорилгод хүрэхийн тулд өөрийн зүгээс хийх алхам, үйл ажиллагаа төлөвлөх, уялдуулах	Сургуулийн нэгдсэн зорилгод чиглэсэн СҮА-ны төлөвлөгөөнд санал өгөх, нэгдсэн төлөвлөлттэй өөрийн төлөвлөлтөө уялдуулах	Сургуулийн нэгдсэн зорилгод чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлтөд санал өгч оролцох	СҮА-ны төлөвлөгөөнд өгсөн багш нарын саналыг нягталж, нэгдсэн төлөвлөгөө, ЗАН, МХБ төлөвлөгөөнд тусгах, уялдуулах	Эцэг эх, орон нутгийн зүгээс сургуулийн СҮА-ны төлөвлөгөөнд өгсөн саналыг нэгтгэх, СЗ-ийн төлөвлөгөөнд тусгах, уялдуулах	Сурагчдаас ирүүлсэн саналыг нэгтгэж, сургуулийн болон өөрсдийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгах, уялдуулах
ХЭРЭГЖҮҮЛЭХ (Тогтвортой, тууштай хэвшүүлэх)	Өдөр тутмын хичээл, суралцахуйдаа идэвх чармайлт гаргаж, өөрийн зорилго, ангийн зорилгоо биелүүлэх	Өдөр тутмын хичээл, сургалтын болон дэмжих үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу чанартай зохион байгуулах	Сургуультай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх болон сургуулийн СҮА-ны төлөвлөлтийн дагуу дэмжлэг үзүүлэх	ЗАН, МХБ-ийн хүрээнд хариуцсан ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх, багш, сурагчийн хөгжлийг дэмжих	СЗ-ийн эрх үүргийн хүрээнд, төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэх, орон нутаг, эцэг эхийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэхэд анхаарах	Нэгдсэн төлөвлөлтөд тусгасан, өөрсдийн хариуцсан ажлыг хэрэгжүүлэх, сурагчдын оролцоог хангах
ҮНЭЛЭХ, САЙЖРУУЛАХ (няглах, дүн шинжилгээ хийх)	Өөрийн ахиц амжилтыг тогтмол үнэлж, ойлгоогүй дутуу эзэмшсэн мэдлэг чадвараа ахиулах	Хичээлийн судалгаа, явцын үнэлгээг хийж, тухай бүр нь засаж сайжруулах, харилцан хяналт тавих	Өөрийн болон үнэлгээнд оролцож, сайжруулах саналаа өгдөг байх	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хичээл ажиглалт хийх, сайжруулах зөвлөгөө, чиглэл өгөх	Сургуулийн тайланд үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, сайжруулах санал зөвлөмж өгөх	Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнд оролцох, өөрсдийн шийдэж чадахгүй асуудлаа зохих түвшинд уламжилж, санал гаргах

Сургуулийн тухайн жилийн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөхөөс өмнө орон нутгийн төрийн холбогдох байгууллагууд, тухайлбал, БШУГ, Цагдаагийн газар, хэлтэс, Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагуудтай мэдээллээ хуваалцаж, сургуулийнхаа зорилго зорилтыг ойлгуулах, тэдний хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөвлөж буй ажлуудтай уялдуулах хэрэгтэй.

Зураг 1.9. Талуудын үүрэг, оролцоо



Зурагт үзүүлсэн сумаар алхам, дараалал, чиглэлийг заасан болно. Тухайлбал,

- Алхам 1. Асуудал илрүүлэх. Оролцогч талууд тус тусын дүн шинжилгээ хийх бөгөөд дараа нь нэгж дээр багцалж, сургуулийн түвшинд эцэслэх дарааллыг нэг чигийн хэвтээ сумаар дүрслэв.
- Алхам 2. Зорилго, зорилт тодорхойлох. Эхлээд талууд шийдэл санал болгох, дараа нь нэгжийн түвшинд багцалж, сургуулийн түвшинд нэгдсэн зорилго, зорилт болгон тодорхойлно. Үүний дараа буцах сумуудаар нэгж, багш, анги, сурагч тус бүр зорилго зорилтоо сургуулийнхтайгаа уялдуулахыг хоёр чигийн хэвтээ сумаар үзүүлсэн болно. Өөрөөр хэлбэл, оролцогчоос гаргасан шийдэл шууд зорилго, зорилт болж чадахгүй, хэлэлцэж, нэгтгэсний дараа тус бүртэй уялдуулна гэсэн үг юм. Мөн сургуулийн зорилго, зорилтыг шууд захирал, удирдлага эсвэл дээрээс тодорхойлохгүй, оролцогч талуудын саналыг сонсож тусгах учиртай.
- Бусад алхмыг ч мөн энэ зарчмаар зурагласан болно. Энэхүү зарчим нь ялангуяа төлөвлөлтийн шатанд ач холбогдолтой бөгөөд тус тусдаа олон ажил төлөвлөж, нөөцөө тарамдуулахгүй, сурагчдад тулгамдсан хамгийн чухал асуудлыг шийдэхэд чиглэсэн нэгдмэл зорилгыг биелүүлэх хоорондоо уялдсан ажлыг төлөвлөж хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Зөвхөн богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлдээ анхаараад алсын хараа, холын зорилгоо орхигдуулбал сургуулийн хөгжил дээшээ биш дороо эргэлдэх хөдөлгөөн болж хувирдаг. Тиймээс богино хугацааны төлөвлөлт, урт хугацааны хөгжлийн төлөвлөлтөө тэнцвэртэй байхад анхаарч, хооронд нь уялдуулах хэрэгтэй.

Зураг 1.10. Алсын харааг тодорхойлох нь



Шигтгээ 3: Товч асуулт хариулт

А: Алсын хараанд юуг тусгах хэрэгтэй бол?

Х: Сургууль нь урт хугацаандаа сурагчдаа ямар хүн болгож хөгжүүлж, төлөвшүүлэхийг хүсэж буйгаа тод томруун, товч тодорхой тусгана.

А: Алсын хараа яагаад чухал вэ?

Х: Алсын хараа нь

- Өөр өөр үзэл санаа, үнэт зүйлтэй сурагч, багш, эцэг, эх, асран хамгаалагч, сургуулийн ажилтнуудыг нэгтгэдэг.
- Хамт олны шийдвэр, сургуулийн бодлого, үйл ажиллагааг нэг зүгт чиглүүлдэг.
- Хүн бүрийн ажил үүргийн утга учир, үнэ цэнийг илэрхийлдэг.
- Ажиллах эрч хүч, урмыг төрүүлдэг.
- Гадаад орчинд танай сургуулийг илэрхийлдэг.

А: Алсын харааг тодорхойлоход хэн оролцох вэ?

Х: Сурагч, багш бүр, ЗАН, МХБ нэгж, сургуулийн түвшинд хамт олноороо, эцэг эх, Сургуулийн зөвлөлийн оролцоотойгоор тодорхойлно.

А. Алсын харааг хэрхэн тодорхойлох вэ?

Х. Энэ нь тодорхой үе шаттай үйл явц байдаг. Тухайлбал, сурагчид, сургуулийн өмнө тулгарсан суурь асуудал, сурагчдын хүлээлт, тэдний хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг судлахаас эхэлж, оролцогчдын санал бодлыг цуглуулах, нэгтгэх, эцэслэн томъёолох хүртэл менежмент зохион байгуулалтын үйл ажиллагааг байдаг. Алсын харааг сурагч, багш, хамт олон, бусад оролцогч талуудад ойлгуулан таниулж, итгэл үнэмшил болгож, сургуулийн зорилго, зорилт, өдөр тутмын СҮА-нд тусгаж хэрэгжүүлэх нь чухал.

А. Алсын харааг хэзээ тодорхойлох вэ?


Х. Өмнөх алсын хараандаа хүрсэн эсэхээ дүгнэж, дараагийн 5-10 жилийн алсын хараагаа тодорхойлдог.

А. Сургуулийн алсын харааг тодорхойлох ажлын удирдан зохион байгуулж, нэгтгэн илэрхийлэх нь хэний үүрэг хариуцлага вэ?

Х. Захирлын үүрэг, хариуцлага.

Өмнө танилцуулсан менежментийн гурван давхаргат пирамид загварын суурийн давхаргад сургуулиуд менежментээ хэрхэн сайжруулах талаар тодорхой алхам, дараалал бүхий аргачлал, жишээг энэхүү хэсэгт танилцуулж байна. Энэ нь сургуулийн удирдлагууд санаа авч, өөр өөрийн сургуулийн нэг хичээлийн жилийн менежментийг хэрэгжүүлэх зураглалаа боловсруулахад дөхөм болно гэж найдаж байна.

Зураг 1.11. Талуудын оролцоо




Сургуулиуд сурагчийн хөгжил хамгаалал, багшийн хөгжил, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн орчин, удирдлагын манлайлал, оролцогч талуудын хамтын ажиллагаа түншлэл, сэтгэл ханамж ямар түвшинд байгааг байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, асуудлаа тодорхойлсон нь дамжиггүй. Мөн өнгөрсөн жилийн гүйцэтгэлээ тайлагнаж, биелээгүй зорилт, шийдээгүй асуудлын шалтгааныг ярилцаж дүгнэлт хийсэн байх учиртай.

Суурь асуудлаа шийдвэрлэж, амжилтаа ахиулж сайжруулахын тулд зөвхөн тааруу гүйцэтгэлтэй багш нар илүү их хичээж, эсвэл тааруу үнэлэгдсэн үзүүлэлтээ сайжруулж сайн үнэлгээ авахын төлөө ажиллах гэхээсээ илүү сургуулийн менежментээ бүхэлд нь сайжруулахын төлөө хамтарч, нэгдэж ажиллах нь чухал юм. Үүний тулд юуны өмнө сургууль хичээлийн жилийн менежментийн зураглалаа оновчтой боловсруулах шаардлагатай. Учир нь сургууль алсын хараагаа оновчтой тодорхойлоод орхихгүй, түүндээ хүрэхийн тулд урт, дунд хугацааны төлөвлөлтөө богино хугацаагаар нарийвчлан боловсруулж нэг зураглалд оруулснаар хүн бүрд ойлгомжтой, өдөр тутмын СҮА-г уялдуулан чиглүүлэхэд хялбар болдог.

Сургуулийн менежментийн зураглал гэдэг нь тухайн хичээлийн жилийн сургуулийн зорилго, тэргүүлэх зорилтууд (тодорхой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, бодитой, цаг хугацаатай) тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд болон түүнд хүрэхийн тулд төлөвлөж буй хоорондоо логик уялдаатай, оновчтой төлөвлөсөн гол үйл ажиллагааг нэг дор буулгасан зураглал юм.


Сургуулиуд нэг хичээлийн жилийн менежментийн зураглалаа хэлбэрийн хувьд олон янзаар гаргасан байх боловч доторх бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийн анзаарвал зорилго нь хэт ерөнхий, алсын хараатайгаа уялдуулаагүй, зорилт нь хэмжигдэхүйц бус, үйл ажиллагаа нь алсын хараа, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд чиглээгүй байх зэрэг дутагдалтай зүйл түгээмэл ажиглагддаг. Тиймээс нэг хичээлийн жилийн буюу богино хугацаанд хүрч биелүүлж болох зорилго зорилтоо үндэслэлтэй, суурь түвшин, хүрэх түвшингээ бодитой тооцож төлөвлөх нь чухал.

Зураг 1.12. Менежментийн зураглал (нэг хичээлийн жилээр) боловсруулах дараалал, анхаарах зүйлс



Сургуулиуд олон салангид төлөвлөгөө биш нэгдсэн цэгцтэй төлөвлөлт хийж түүнийгээ нэг хавтгайд зураглал болгон буулгаснаар оролцогч талууд нэгдмэл ойлголттой болж, тус тусын үүрэг хариуцлагын хүрээнд хувь нэмрээ оруулах, харилцан уялдаатай ажиллах, нөөцөө гол зорилгодоо чиглүүлэх боломж нэмэгддэг. Тиймээс дээрх дарааллын дагуу боловсруулсан бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг хавтгайд буулгах нь дараагийн чухал ажил юм.

Зураг 1.13. Сургуулийн менежментийн зураглалын жишээ (202...-202... оны хичээлийн жил)




ТЭМДЭГЛЭЛ

2

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ШИЙДВЭР ГАРГАЛТ

II БҮЛГИЙН ТОЙМ



ҮНЭЛГЭЭ

- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ
- Үнэлгээний ач холбогдол
- Үнэлгээний арга хэрэгсэл
- Шалгуур үзүүлэлт
- Индекс
- Урамшууллын хувь



ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМД ХАНДАХ

- Гүйцэтгэлийн системд нэвтрэх
- Хандах цонх
- Мэдээлэл авах боломжууд



МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ

- Сургуулийн үнэлгээ
- Багшийн үнэлгээ
- Шалгалтын үр дүн (судлагдахуунаар, түвшнээр, ангиар)



МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ

- Сургуулийн үнэлгээ
- Багшийн үнэлгээ
- Шалгалтын үр дүн (судлагдахуунаар, багшаар, ангиар)



АСУУДЛАА ТОДОРХОЙЛОХ

- Асуудлаа илруулэх
- Асуудлаа эрэмбэлэх
- Анхаарах зүйл

2.1 МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫГ ХААНААС ЭХЛЭХ НЬ ОНОВЧТОЙ ВЭ?

Монгол Улсын хэмжээнд 2021-2022 онд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнгийн үнэлгээг анх удаа хөндлөнгөөс зохион байгуулсан. Сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хөндлөнгөөс үнэлснээр сургуулийн менежментийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй мэдээллийг бий болгодог. Иймээс сургуулийн тасралтгүй хөгжлийг хангах менежментэд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ чухал байр суурийг эзэлдэг.

Менежментийн ухаанд хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй⁸ гэж үздэг. Өөрөөр хэлбэл, бид аливаа сургалт, үйл ажиллагааныхаа үр дүнг тодорхой үзүүлэлтээр хэмжиж, хянаж байж удирдаж чадна гэсэн үг. Сургуулийн удирдлагын багийн зүгээс сургуулийнхаа алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлж, сурагчдынхаа сурлагын амжилт, хөгжлийн төлөө зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагааг зохих цаг хугацаанд нь, тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжиж, үнэлснээр үйл ажиллагааныхаа үр дүн, алдаа оноог олж харах, цаашид юуг, хэрхэн өөрчилж, засаж залруулахаа оношлох боломжтой болно. Энэ талаар 1.2-т дэлгэрэнгүй танилцуулсан.

Аливаа үйл ажиллагааг өөрөө болон хөндлөнгөөс үнэлдэг. Боловсролын салбарт “хөндлөнгийн үнэлгээ” гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг ойлгоно. БҮТ-өөс 2021-2022 оны хичээлийн жилээс багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг хийж ирсэн. Харин энд та бүхэнд сургуулийн өөрийн үнэлгээ хийхэд ашиглаж болох зарим арга хэрэгсэл болон мэдээллийг танилцуулж байна.

Хүснэгт 2.1. Сургуулийн түвшинд хийгддэг үнэлгээний нийтлэг төрлүүд

Өөрийн үнэлгээний чиглэл	Хөндлөнгийн үнэлгээний чиглэл
<ul style="list-style-type: none">• Үйл ажиллагааны /гүйцэтгэлийн/ төлөвлөгөөний хэрэгжилтийн явц /ахиц/-ын үнэлгээ• Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ• Сургуулийн дотоод уур амьсгалын үнэлгээ• Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээ	<ul style="list-style-type: none">• Сурагчийн гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ• Багшийн гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ• Сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ• Боловсролын чанарын үнэлгээ• Санхүүгийн үнэлгээ

8 Питер Друкер

Үнэлгээг эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулдаг. Монгол Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-нд баталсан Боловсролын ерөнхий хууль (БЕХ)-ийн 35, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (СӨЕБХ)-ийн 26 дугаар зүйлээр “Боловсролын хяналт шалгалт, чанарын үнэлгээ”-тэй холбоотой зохицуулалтыг хийсэн байна. Тодруулбал, БЕХ-д Боловсролын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу зохион байгуулах, Боловсролын чанарыг 3 жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлэх зэргийг заасан бол СӨЕБХ-д ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, суралцагчийн хөгжил, сурлагын амжилтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулна гэж заажээ.

Боловсролын ерөнхий хууль (2023)

35.4. Боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийг хөндлөнгөөс үнэлнэ.

35.5 Боловсролын үнэлгээг цахимаар зохион байгуулж болох ба суралцагчийн ахиц дэвшилд дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах цахим системтэй байна.

Үнэлгээг ерөнхий утгаар нь тодорхой хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрсэн үр дүнг үнэлэх, хэмжихийн тулд мэдээлэл, нотлох баримт цуглуулах системтэй үйл явц гэж тодорхойлж болно.

Сургалтын байгууллагын үнэлгээ нь боловсролын байгууллагын үр нөлөө, чанар, үр ашгийг үнэлэх системтэй үйл явц юм. Үнэлгээний мэдээлэл нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын чанар, багшийн мэргэжлийн хөгжилд чухал шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг системтэй цуглуулахад үнэлгээний олон төрөл, хэлбэр, арга хэрэгслийг ашиглаж болно.

Боловсролын ерөнхий хууль (2023)

35.7. Боловсролын сургалтын байгууллага дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

35.8 Боловсролын сургалтын байгууллага энэ хуулийн 35.7-д заасан чанарын баталгаажуулалтын үр дүнд үндэслэж, чанарын сайжруулалтын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.

35.9 Энэ хуулийн 35.8-д заасан төлөвлөгөө нь боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний хэсэг болох бөгөөд түүний ажлын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь чанарын ахиц дэвшил байна.

Үнэлгээ нь тухайн сургалтын байгууллагын нөхцөл байдал, зорилго, хэрэгцээ шаардлагаас хамаарч өөр өөр байж болох бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг бодитой, найдвартай хэмжихийн тулд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хослуулж хэрэглэдэг туршлага нийтлэг байдаг.

Хүснэгт 2.2. Сургуулийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний ялгаа

№	Харьцуулах үзүүлэлт	Өөрийн буюу дотоод үнэлгээ	Хөндлөнгийн буюу гадаад үнэлгээ
1	Ерөнхий ойлголт	Сургуулийн гүйцэтгэл, үр дүнтэй байдал, сургалтын ерөнхий чанарыг үнэлэхийн тулд сургууль өөрөө хийдэг үйл явц	Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллага эсвэл хараат бус үнэлгээчдийн хийсэн үнэлгээ, шалгалт
2	Зорилго	Боловсролын байгууллага өөрийгөө сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх	Сургуулийн үйл ажиллагаа, тогтоосон стандарт, дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд бодитой, хараат бус үнэлгээ өгөх
3	Зохион байгуулах хэлбэр	Хамт олны оролцоонд тулгуурласан	Үндэсний хэмжээний мэргэжлийн байгууллага, үнэлээчид
4	Давтамж	Жилд 2-3 удаа	Жилд 1 удаа
5	Давуу тал	<ul style="list-style-type: none"> Тасралтгүй суралцах соёл төлөвшүүлэх Сургалтын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулах мэдээллээр хангах Сургууль өөрийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн шалгуур, үзүүлэлт, үнэлгээний хэлбэр, арга хэрэгслийг сонгох Сургуулийн хамт олныг бүрэн хамруулах Үнэлгээний хэлбэр, зохион байгуулах хугацаанд уян хатан байх боломж Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах Цаг алдалгүй сайжруулах зүйлсийг илрүүлэх 	<ul style="list-style-type: none"> Шударга, бодитой хүлээн зөвшөөрөгдөх байдал Бусад ижил төрлийн байгууллагатай харьцуулах Сургуулийн өөрийн үнэлгээний үр дүнг баталгаажуулах Мэргэжлийн байгууллага, үнэлээчдийн зүгээс өгөх зөвлөмж

6	Сул тал	<ul style="list-style-type: none"> • Субъектив байдал илрэх • Цаг хугацаа, нөөц их шаардах • Анхаарал хандуулах шаардлагатай зүйлсийг орхигдуулах • Үнэлгээний хэлбэр, арга хэрэгсэл тохирохгүй байх • Гүйцэтгэлийн шалгуур, үзүүлэлтэд хэт анхаарал хандуулах • Хүлээн зөвшөөрөгдөх байдал хангалтгүй байх • Өөрчлөлтийг эсэргүүцэх хандлага илрэх 	<ul style="list-style-type: none"> • Зардал, нөөц их зарцуулах • Хугацааны хувьд хязгаарлагдмал • Сургуулийн үйл ажиллагааг тасалдуулах • Нэг удаагийн агшин зуурын дүр зураг • Оролцогч талуудын оролцоо хязгаарлагдмал байх • Хөндлөнгийн үнэлгээний шалгуур, үзүүлэлтэд хэтэрхий ач холбогдол өгөх
---	---------	--	---

Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хослуулснаар сургууль нь сургалт, үйл ажиллагаа, үр дүн, нөлөөлж байгаа хүчин зүйлстэй холбоотой цогц мэдээлэлтэй болох юм. Үнэлгээ хийх нь сургууль давуу болон сул талаа илрүүлэх, сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлох, боловсролын үйлчилгээний үр дүнг сайжруулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын тулд системтэйгээр мэдээлэл цуглуулж буй явдал юм. Өөрөөр хэлбэл, сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээ нь байнгын сайжруулалт, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, хариуцлагын түвшнийг нэмэгдүүлэх, оролцогч талуудын оролцоог хангах чухал хэрэгсэл юм.

Боловсролын чанарын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг хөндлөнгийн үнэлгээнд сургуулиуд хамрагдаж туршлагатай болсон. Харин өөрийн үнэлгээний хувьд сургуулиудын туршлага ялгаатай байна.

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй БСШУС-ын сайдын 2019 оны А/803 тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д сургууль нь жил бүр батлагдсан шалгуурын дагуу өөрийн үнэлгээг хийхээр тусгажээ. Энэхүү журамд “өөрийн үнэлгээг сургууль, цэцэрлэг өөрийн зорилгодоо хүрч буй эсэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанар, нийцийг баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотойгоор үнэлж, байгууллагын түвшинд сайжруулах шаардлагатай асуудлыг илрүүлэх оношилгоог ойлгоно” гэж тодорхойлсон байна.

Үнэлгээ нь сургалт, үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах зэргийг багтаасан үйл явц юм. Тодорхой үзүүлэлтийн дагуу бодит өгөгдөл, мэдээллийг цуглуулснаар та бүхэн шинжлэн судлах материалтай болно.

Сургуулийн өөрийн үнэлгээний мэдээлэл цуглуулах хэрэгсэл

Та бүхэнд сургууль дээрээ өөрийн үнэлгээ хийхтэй холбоотой зарим хэрэгслийг санал болгож байна. Үнэлгээний мэдээлэл цуглуулах хэрэгсэл гэдэг нь шаардлага хангасан, бодит, үнэн зөв мэдээллийг олох, илрүүлэхэд туслах асуулга, ажиглалт болон ярилцлагын, тэмдэглэлийн хуудас байх юм. Тухайлбал, асуултууд бүхий асуулга, хичээл ажиглах үзүүлэлт, үнэлгээ, тэмдэглэл хийх талбар бүхий ажиглалтын хуудас, бүртгэх тэмдэглэх заавар бүхий маягт, чиглүүлэх асуулт бүхий ярилцлагын хөтөч зэрэг болно.

Та бүхэнд танилцуулж буй үнэлгээний хэрэгсэл нь зарим улс оронд болон манай улсад туршигдаж, хэрэглэгдэж үр дүнгээ өгч байсныг тэмдэглэж байна. Та удирдлагын багтайгаа зөвшилцөн эдгээр санал болгож буй хувилбаруудаас өөрийн сургуулийн хөгжлийн түвшин, онцлог зэргийг харгалзан сонгож, өөрчилж сайжруулан хэрэглэж болно. Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон бодомж, асуулт зэрэг нь зорилгоосоо хамаарч өөр өөр байдгийг сануулах юун.

Сургуулийн өөрийн үнэлгээний хуудсыг дараах линкээр татаж авч ашиглаарай.

Өөрийн
үнэлгээний
хэрэгсэл 1



Өөрийн
үнэлгээний
хэрэгсэл 2



Өөрийн
үнэлгээний
хэрэгсэл 3



Өөрийн
үнэлгээний
хэрэгсэл 4



Өөрийн
үнэлгээний
хэрэгсэл 5



2.2. СУРГУУЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.4.2-т “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх” үндсэн шалгуурыг баталсан. Энэхүү шалгуурт үндэслэн БШУ-ны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ыг шинэчилж, гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгууллаа.

Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулснаар багш, сургууль үр дүнгийн нэмэлт урамшуулал авах боломж бүрдсэн. БШУ-ны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/500 дугаар “Чиглэл батлах тухай” тушаалаар төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсан.


Энэхүү чиглэлд сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхдээ доор дурдсан үндсэн шалгуур, арга хэрэгслийг ашиглан цуглуулсан үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 100 хүртэлх оноогоор үнэлэхээр заасан.

Хүснэгт 2.3. ЕБС-ийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх шалгуур

№	Шалгуур	Онооны жин	Үнэлгээнд ашиглах мэдээлэл, арга, хэрэгсэл
1	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт	25	- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур 1-ийн 2 дахь үзүүлэлтийн үр дүн
2	Суралцагчийн хөгжил, хамгаалал	20	- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур 2-ын үр дүн
3	Багш, ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа	20	- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур 3-ын үр дүн
4	Сургалтын орчин бүрдүүлэлт	12	- Сургалтын орчин бүрдүүлэлт, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл ахуйн болон дотуур байр, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлага, стандартын хэрэгжилтийн байдлыг үнэлэх хуудас - Цахим сургуульд хамрагдалтын эзлэх хувь
5	Удирдлагын манлайлал, менежмент	15	- Хамт олноос авах асуулга - Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, мэргэжилтнээс авах асуулга
6	Сургалтын байгууллагын талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж	8	- Суралцагчдын сэтгэл ханамжийн асуулга - Эцэг, эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамжийн асуулга

Сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ нь багшийн үнэлгээтэй салшгүй холбоотой бөгөөд үүнийг дараах зураглалаар харууллаа.

Зураг 2.1. Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зураглал



Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийснээр сургуулиуд давуу болон сул талаа илрүүлэх, сайжруулах шаардлагатай чиглэлүүдээ тодорхойлох, боловсролын үйлчилгээнийхээ үр дүнг сайжруулах нөхцөл бүрдсэн. Үүнээс гадна сургуулийн түвшинд нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын тулд системтэйгээр мэдээлэл цуглуулж, түүнд тулгуурлан сургуулиа хөгжүүлэх менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ. Гүйцэтгэлийн үнэлгээ нь сургуулийн менежментийн сайжруулалт, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих хэрэгсэл болж байна.

Улсын хэмжээнд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг нийслэл, аймгийн төв, сум-баг гэсэн гурван байршлаар кластер үүсгэн, кластер тус бүрд 5 индексээр авч үзсэн.

Хүснэгт 2.4. Сургалтын байгууллагын индекс, эрэмбийн хувь

Индекс	Тухайн кластер дахь сургуулийн эрэмбийн хувь /N/
I	$95 \leq N$
II	$85 \leq N < 95$
III	$70 \leq N < 85$
IV	$60 \leq N < 70$
V	$N \leq 60$

Жишээ болгож 2022 онд зохион байгуулсан сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг кластер тус бүрээр харуулъя.

Жишээ 1.

А сургууль нь нийслэлийн кластерт хамаарах бөгөөд сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээгээр дараах үзүүлэлттэй байна.



Б сургууль аймгийн төвийн кластерт хамаарах бөгөөд сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээгээр дараах үзүүлэлттэй байна.



В сургуулийн сум-багийн кластерт хамаарах бөгөөд сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээгээр дараах үзүүлэлттэй байна.



Дээрх гурван тохиолдлын хувьд сургууль тус бүрийн анхны онооны (авбал зохих 100) дундаж ижил боловч стандарт оноо, эрэмбийн хувийн онооноос шалтгаалж сургууль бүрийн индекс ялгаатай байна. Нийслэлийн кластер дахь А сургууль 76.62 анхны оноотой III индекст, Б сургууль 76.62 анхны оноотой II индекст, В сургууль 76.57 буюу нийслэл, аймгийн төвийн кластераас доогуур анхны оноотой ч тэр нь тухайн кластертаа өндөр байгаа тул I индекст байна.

Анхны оноо, стандарт оноо, эрэмбийн хувь, индекс гэх ойлголтуудын ялгааг доор тайлбарлав.

Анхны оноо: Тухайн сургууль гүйцэтгэлийн үнэлгээгээр авбал зохих 100-аас авсан оноо. Нийт сургуулийг нийслэл, аймгийн төв, сум-баг хэмээн 3 байршилд бүлэглэснийг кластер гэнэ.

Стандарт оноо: Тухайн сургуулийн эрэмбийн хувийг тооцоолох математик үндэслэл нь үнэлгээний үр дүнг нормаль тархалттай гэж үзээд тархалтыг нь нормчлох юм. Иймд тухайн сургуулийн анхны оноог стандарт оноо рүү хөрвүүлж, үр дүнг тооцдог. Дараах томъёогоор анхны оноог стандарт оноо руу хөрвүүлдэг.

$$Z_i = \frac{x_i - \mu}{\sigma}, -3 \leq |Z| \leq 3$$

Энд нь i -р багшийн анхны оноо, нь нийт багш нарын дундаж оноо, нь стандарт хазайлт

Эрэмбийн хувь: Тухайн сургуулийг түүний хамаарах кластер дахь сургуулиудтай нь харьцуулахад хаана байгааг илэрхийлнэ.

Индекс: Тухайн сургуулийн хамаарах кластер дахь сургуулийн хөгжлийг илэрхийлэх тоон утга бөгөөд сургуулиудыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 индекст авч үзнэ.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн гарсан сургалтын байгууллагын эрэмбийн хувь нь тухайн сургуулийг нэмэлт урамшуулал авах эсэх, хэдэн хувийн урамшуулал авахыг тодорхойлно.

Дээрх Жишээ 1-д авч үзсэн А сургуулийн эрэмбийн хувь 84.89 байгаа нь нийслэлийн кластер дахь 139 сургуулийн 15.1 хувь болох 21 сургууль тухайн А сургуулийн өмнө эрэмбэлэгдсэнийг илэрхийлж байна.

Б сургуулийн эрэмбийн хувь 88.72 байгаа нь аймгийн төвийн кластер дахь 133 сургуулийн 11.2 хувь болох 15 сургууль тухайн Б сургуулийн өмнө эрэмбэлэгдсэн байна.

В сургуулийн эрэмбийн хувь 96.08 нь сум-багийн кластер дахь 383 сургуулийн 3.92 хувь болох 15 сургууль тухайн В сургуулийн өмнө эрэмбэлэгдсэнийг илэрхийлж байна.

Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ерөнхий боловсролын сургуульд дараах хүснэгтэд үзүүлсэн нэмэлт урамшууллыг жилд нэг удаа тооцож олгохоор заасан байна.

Хүснэгт 2.5. Индекст хамаарах сургуулийн нэмэлт урамшууллын хэмжээ

Индекс	Нэмэлт урамшуулал олгох хязгаар <i>/тухайн жилийн нийт хувьсах зардлаас тооцох хувь/</i>
I	6%
II	4%
III	3%
IV	2%

Сургууль нь нэмэлт урамшууллын 35-аас доошгүй хувийг байгууллагын менежментийг сайжруулахад зарцуулна.

Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг шударга, үнэн зөв зохион байгуулах нь сургуулиуд ахиц дэвшлээ тогтмол хянах, сайжруулах чиглэлүүдийг тодорхойлох, суралцагчдад чанартай боловсрол эзэмших, оролцогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зэрэг эерэг өөрчлөлтийг бий болгоно.

Сургалт, үйл ажиллагааныхаа гүйцэтгэлээ үнэлүүлснээр сургууль хамаарах кластертаа өөрийн үр дүнг сум, дүүрэг, аймаг, нийслэлтэй харьцуулах боломжтой болно. Ингэснээр нотолгоонд суурилж сургуулийн менежментийг тодорхойлох, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулахад шаардлагатай менежментийг хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ. Гүйцэтгэлийн үнэлгээнд багш, эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, БШУГ-ын мэргэжилтэн бүр хамрагдсанаар сургуулийн хөгжилд тэдний оролцоо, хамтын ажиллагаа илүү тодорхой болно.



2.3 ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС АВАХ, ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн талаарх тоон мэдээллийг Боловсролын үнэлгээний төвийн цахим тоон тайлангийн системээс авна.

Цахим тоон тайлангийн систем гэдэг нь тодорхой давтамжтайгаар хуримтлагдан, зохион



байгуулалттайгаар хадгалагддаг мэдээллүүдэд автоматаар дүн шинжилгээ хийхэд тусалдаг аналитикийн хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, олон төрлийн өгөгдлийг задлан шинжилж, үр дүнг энгийн, ойлгомжтой дүрслэл графикаар хэрэглэгчид харуулах, байгууллага дотор мэдээлэл солилцох зэрэг олон ажлыг богино хугацаанд харуулах чадвартай систем юм.

Энэ системийн зорилго нь сургалтын байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, бусдаас суралцах замаар үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг.

БҮТ-ийн цахим тоон тайлангийн систем нь технологид суурилсан бөгөөд сургуулийн захирал, сургалтын менежерүүд болон бусад албан хаагчдад гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана.

Цахим тоон тайлангийн системд сургууль бүр өөрийн “нэвтрэх нэр”, “нууц үг”-ээр нэвтрэх бөгөөд үүнийг өөрийн харьяа дүүрэг, аймгийн БШУГ-ын үнэлгээ хариуцсан мэргэжилтнээс авсан байна. “Нэвтрэх нэр”, “нууц үг”-ээ авснаар тухайн сургууль болон багш гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнтэй холбоотой тоон мэдээллийг харж, үр дүндээ шинжилгээ хийх боломж бүрдэнэ.

Анхааруулга:

Та системд нэвтрэх бүрдээ “НЭВТРЭХ НЭР”, “НУУЦ ҮГ”-ийг ашиглана. Мэдээллийн нууцлалаа хадгалахын тулд ЗӨВХӨН та л мэдэж байхаар нууц үгээ сольж болно.

Хамгийн гол нь нууц үгээ хэзээ ч мартаж болохгүй. Иймд нууц үг авмагц/сольмогц мартаггүй байх арга хэмжээг ЗААВАЛ аваарай.

Цахим тоон тайлангийн системээс ЕБС-ийн багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг хоёр оноор харьцуулсан мэдээллийг авах болно. “ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН” цонх руу нэвтэрч өөрийн сургуулийн гүйцэтгэлийг дараах алхмуудаар харна (Зураг 2.2).

Зураг 2.2. Цахим тоон тайлангийн системд нэвтрэх алхам





Тодруулбал, <http://www.eec.mn/> веб хуудасны “ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН” цонхонд хандаж, дараах чиглэлүүдээр мэдээллийг нарийвчлан авна. Үүнд:

- СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**
- Судлагдахуун
 - Агуулга
 - Үнэлгээний зорилт

- БАГШИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**
- Шалгуур
 - Үзүүлэлт
 - Хөгжлийн түвшин

Боловсролын үнэлгээний төвийн цахим хаягт нэвтрэхэд цонхны харагдах байдлыг Зураг 2.3-д үзүүлэв.

Зураг 2.3. Цахим хуудасны цонхны харагдах байдал



Цахим хаягаас “ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН” цонхыг сонгосноор БҮТ-өөс зохион байгуулдаг үнэлгээний бүх үр дүнг харах боломжтой. Эдгээрийг тус бүрд нь нэвтрэх эрхийн зохицуулалттайгаар шийдвэрлэсэн байдгийг Та мэдэх биз ээ.


Энэ удаа ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харах зорилготой тул “БГҮ статистик тайлангийн систем” цонхыг сонгоорой. Зураг 2.4-д үзүүлэв.

Зураг 2.4. “БГҮ статистик тайлангийн систем” цонхны харагдах байдал



Дээрх цонхыг сонгож, “нэвтрэх нэр”, “нууц үг”-ийг оруулна (Зураг 2.5).


Зураг 2.5. Нэвтрэх цонхны харагдах байдал



БШУГ-ын үнэлгээ хариуцсан мэргэжилтнээс авсан “нэвтрэх нэр”, “нууц үг”-ийг хамгаалалтын тоотой хамт оруулснаар сургуулийн буюу сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн гарч ирэх юм.

Цахим тоон тайлангийн системээс та бүхэнд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээ зураг, өгөгдөл, PDF, powerpoint хэлбэрээр авч ашиглах боломжтой. Үүний тулд тухайн цонхны баруун дээр байрлах доошоо чиглэсэн сумтай дөрвөлжин дүрс бүхий “Download” товч дээр дарснаар мэдээллийг ямар хэлбэрээр татаж авах сонголтууд гарч ирнэ (Зураг 2.6). Та бүхэн өөрт тохирсон хэлбэрийг сонгон ашиглах боломжтой юм.

Зураг 2.6. Цахим тоон системээс мэдээллийг татаж авах хэлбэрүүд



Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийн үндсэн болон дэд ангилал, мэдээллийн харагдах байдал, тоон утгын тайлбар зэргийг жишээгээр харуулъя.

Сургалтын байгууллагын үнэлгээ: Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүн бүхий цонхны харагдах байдлыг Зураг 2.7-д үзүүлэв. Тус цонхонд тухайн сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж оноо, хамаарах кластерын дундаж, улсын дунджийг хоёр оноор харуулсан байна. Цонхны зүүн дээд буланд байрлах “all”, “2022”, “2023” товчуудаас сонгож, мэдээллийг 2 оноор, зөвхөн 2022 оноор, 2023 оноор тодруулан харах боломжтой.

Зурагт 2.7-д жишээ болгож харуулсан А сургууль нь нийслэлийн **нэгэн** дүүргийн сургууль бөгөөд дундаж оноогоо өөрийн хамаарах дүүргийн, нийслэл (бусад дүүргийн)-ийн, улсын дундаж (нийт 3)-тай харьцуулах боломжтой байна.

Зураг 2.7. Гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүн (он, кластерын дунджаар)



Сургалтын байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн 6 шалгуур тус бүрийн үр дүнг та бүхэн авах боломжтой бөгөөд жишээ болгож Зураг 2.8-д үзүүлэв. Тухайн цонхноос сургуулийн гүйцэтгэл шалгуур бүрд ямар үзүүлэлттэй үнэлэгдсэнийг харна. Шалгуур бүрийн үр дүнг улсын дундажтай харьцуулах боломжтой. Баруун талын 1-6 тоогоор дугаарлагдсан товч бүр дээр дарж тухайн шалгуураар үнэлсэн үр дүнг дэд үзүүлэлтээр, боловсролын түвшнээр, багш бүрээр харна.

Зураг 2.8. Гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүн (шалгуур тус бүрээр)




Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг авахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

1. Сургуулийн дунджийн өөрчлөлтийг хоёр оноор харьцуулахдаа индексийн үзүүлэлттэй уялдуулан хараарай.
2. Сургуулийн дунджийг өөрийн сургуулийн хамаарах кластер болон улсын дунджийн өөрчлөлттэй хоёр оноор харьцуулан хараарай.
3. Сургуулийн дунджийг шалгуур тус бүрээр, хоёр оноор харьцуулахдаа улс болон хамаарах кластерын дундажтай харьцуулж, ялгаа болон өөрчлөлтийг нягтална. Үүнд:
 - а. Шалгуур бүрийн хувьд өссөн болон буурсан, өөрчлөлтгүй зэргийг нягтлах
 - б. Аль шалгуур дээр буурсныг харахдаа улс болон кластерын дундажтай харьцуулах
 - в. Аль шалгуур дээр өссөнийг харахдаа улс болон кластерын дундажтай харьцуулах
4. Шалгуур тус бүрээр улсын дундаж болон түүнээс дээгүүр үзүүлэлттэй болоход ямар зорилгоор, ямар үйл ажиллагааг ямар хугацаанд, хэний оролцоотой хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлоорой.

Энд үзүүлсэн ерөнхий алхмуудаас гадна мэдээллийг задалж харахдаа Зураг 2.9-ийг сайтар ажиглаарай.

Зураг 2.9. Мэдээллийг татаж авах хэлбэр




Үр дүнд нь сонгосон мэдээлэл “Excel” файлаар татагдаж гарах бөгөөд түүнийг хуулж авснаар тухайн мэдээллийг ямар хүснэгтээр хэрхэн ашиглахыгаа Та бүхэн шийдэж, түүнийг ямар мэдээлэлтэй харьцуулах, ямар шинжилгээ хийх талаараа хамтдаа зөвлөлдөөрэй.

Зураг 2.10. Сургалтын байгууллагын үнэлгээний үр дүн (үзүүлэлтээр)



Сургалтын байгууллагын гүйцэтгэлийг “1. сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт”, “2. суралцагчийн хөгжил хамгаалал” “3. Багш ажилтны тасралтгүй хөгжил”, “4. Сургалтын орчин бүрдүүлэлт”, “5. Удирдлага, манлайлал”, “6. Хэрэглэгчдийн сэтгэл ханамж” гэсэн шалгуур, шалгуур бүрд хамаарах 13 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд та бүхэн өөрийн сургуулийн шалгуур, үзүүлэлт тус бүрээр авсан оноог хоёр оноор, боловсролын түвшнээр, багшаар харьцуулан шинжлэх боломжтой. Зураг 2.11-д “**2. Суралцагчийн хөгжил, хамгаалал**”, түүнд хамаарах 3 үзүүлэлт бүрд тухайн сургуулийн үнэлгээний үр дүнг харуулсан байна.

Зураг 2.11. Сургалтын байгууллагын үнэлгээ (Суралцагчийн хөгжил хамгааллын үр дүн)



Дээрх зургаас “2. Суралцагчийн хөгжил хамгаалал”-тай холбоотой үзүүлэлтэд Та бүхэн анхаарлаа хандуулах ёстой. Бидний жишээ болгон тусгасан зураг дахь А сургуулийн хувьд сурагч хамгаалал, эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэсэн үзүүлэлтүүдийг харьцуулбал сурагч хамгааллын үзүүлэлт бусад 2 үзүүлэлттэй харьцуулахад сул байна. Харин хичээлээс гадуурх үйл ажиллагааны үзүүлэлт бусад 2 үзүүлэлттэй харьцуулахад өндөр байна.

Суралцагчийн хөгжил хамгааллын шалгуурыг боловсролын түвшнөөр авч үзэхэд, бага боловсролын түвшний үзүүлэлт суурь, бүрэн дундтай харьцуулахад сул байна.

Суралцагчийн хөгжил хамгааллын шалгуурыг Та багш бүрээр харах боломжтой.

Сургуулийнхаа хувьд:

Багшийн эзлэх хувь “Суралцагчийн хөгжил, хамгаалал” шалгуурын үзүүлэлтүүд	Сурагч хамгаалал	Эцэг эхийн оролцоо	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
Улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй багшийн эзлэх хувь			
Улсын дунджаас доогуур үнэлгээтэй багшийн эзлэх хувь			

Дээрх хүснэгтийн нэгтгэлийг гаргаж авснаар улсын дунджаас доогуур бөгөөд багшийн эзлэх хувь нь бусад 2-оос их байгаа үзүүлэлт дээрээ төвлөрч, сургуулийн бүлгийн хүрээнд авах арга хэмжээг тодорхойлж болох юм.

Эндээс харахад А сургуулийн хувьд бага боловсролын түвшинд сурагч хамгааллын асуудлыг анхаарах шаардлагатай. Сурагч, эцэг эх, нийгмийн ажилтан, сургалтын менежер, багш нарыг хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах ямар зорилго, зорилтыг дэвшүүлэх улмаар ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ тэдний оролцоог хэрхэн хангах гэсэн асуулт гарч байна.

Зураг 2.12. Сургалтын байгууллагын үнэлгээ (Багш, ажилтны тасралтгүй хөгжил)



“3. Багшийн тасралтгүй хөгжил” шалгуурыг “мэргэжлийн хөгжил”, “багшийн ёс зүй”, “мэргэжлийн бүлгийн хөгжил”, “технологи ашиглалт” гэсэн 4 үзүүлэлтээр үнэлсэн болно. Бидний жишээ болгон авсан А сургуулийн хувьд,

- Багшийн ёс зүй бусад 3 үзүүлэлттэй харьцуулахад дээгүүр байна.
- Технологи ашиглалтын үзүүлэлт бусад 3 үзүүлэлттэй харьцуулахад доогуур байна.
- Оноор нь харьцуулбал, багшийн ёс зүйн үзүүлэлт буурсан, мэргэжлийн бүлгийн хөгжил өссөн, технологи ашиглалтын үзүүлэлт өссөн байна.

Сургалтын орчин бүрдүүлэлт, удирдлагын манлайлал, хэрэглэгчийн сэтгэл ханамж гэсэн шалгууруудын үзүүлэлт тус бүрийн үр дүнд дээр зөвлөмжилсний дагуу шинжилгээ хийж, сургуулийнхаа асуудлыг тодорхойлоорой.

Хөтөлбөрийн хэрэгжилт: Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн “Хөтөлбөрийн хэрэгжилт”-ийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийн цонхны харагдах байдлыг Зураг 9-д харуулав. Тус цонхонд тухайн сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилт буюу бичгийн шалгалтыг судлагдахуун бүрээр, боловсролын түвшнээр бичгийн шалгалтад хамрагдсан суралцагчдын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг харуулсан байна. Үүний зэрэгцээ тухайн сургуулийн хамаарах кластерын дундаж, улсын дунджийг харуулсан нь

сургуульд өөрийн гүйцэтгэлийг бусадтай харьцуулах боломжийг олгож байгаа юм.

Зурагт 2.13-д жишээ болгож харуулсан А сургуулийн ахлах ангийн бичгийн шалгалтын үр дүн бага болон дунд ангийнхаас бага байна. Эдгээр үр дүнг мөн өөрийн хамаарах дүүргийн, нийслэл (бусад дүүргийн)-ийн, улсын дундаж (нийт 3)-тай харьцуулан харах нь тодорхой.

Зураг 2.13. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн мэдээллийн харагдах байдал (боловсролын түвшин, судлагдахуун, оноор)



Зураг 2.13-д сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын дундаж, кластерын дундаж, тухайн сургуулийн орон нутгийн дундаж болон судлагдахуун бүрээр суралцагчаас авсан бичгийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг харуулсан.


Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг авахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

1. Сургуулийнхаа хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг боловсролын түвшин болон хоёр оноор харьцуулж харна. Боловсролын аль түвшинд сул үзүүлэлттэй байна, тухайн түвшинд оноор харьцуулахад өөрчлөлт гарсан эсэхийг нягтлаарай.
2. Сургуулийн дунджийг улсын болон хамаарах кластерын дундажтай харьцуулан харна.
 - а. Сургуулийнхаа сул үзүүлэлттэй боловсролын түвшнийг тухайн орон нутгийн кластерын дундаж болон улсын дундажтай харьцуулан хараарай.
 - б. Суралцагчдын гүйцэтгэлийг оноор нь харьцуулж, өсөлт болон бууралтыг өөрийн сургуулийнхаа үзүүлэлттэй харьцуулан хараарай.

3. Судлагдахуун бүрийн хамгийн өндөр болон хамгийн доогуур үзүүлэлтийг нэг бүрчлэн шинжилнэ.
- а. Судлагдахууны гүйцэтгэлийг оноор нь харьцуулан ямар судлагдахууны хувьд хамгийн их болон хамгийн бага өсөлт гарсан, өөрчлөлтгүйг илрүүлнэ.
- б. Тухайн судлагдахууныг оноор сонгоод тухайн судлагдахууны хувьд боловсролын түвшнээр гүйцэтгэлийн дундаж ямар байгааг улсын дундажтай харьцуулан харна. Жишээлбэл, А сургуулийн математикийн судлагдахууны хувьд 2023 оны байдлаар сургуулийн гүйцэтгэлийн дундаж түвшнээр авч үзвэл бүрэн дунд боловсролд 39.0 буюу бага, суурь боловсролын түвшний үзүүлэлтээс доогуур байна. Үүнийг кластерын дундажтай харьцуулахад боловсролын түвшнээр кластерын дунджаас бага байна.
- А сургуулийн хувьд бага, суурь боловсролын 2023 оны математикийн гүйцэтгэлийн дундаж нь кластерын дундажтай харьцуулахад анхаарал татахуйц доогуур байна. Бага боловсролын хувьд 13.6, суурь боловсролын хувьд 29.1-ээр бага байна. Тэгэхээр тухайн сургуулийн хувьд хамгийн түрүүн амжилтаа кластерын дунджид хэрхэн дөхүүлэх вэ гэдэг нь зорилго болно.
- Мөн бүрэн дунд боловсролын түвшинд биологи, англи хэл судлагдахуунаар сурагчдын гүйцэтгэл 2023 онд буурсан байна. Үүний шалтгаан юу болохыг сургуулийн өөрийн үнэлгээгээр илрүүлэх хэрэгцээ байна.
- Та бүхэн судлагдахуун бүрээр оноор нь харьцуулсан мэдээллийг татан авч шинжилгээ хийнэ. Excel файл дээр сургууль өөрийн холбогдох мэдээллийг нэмж, харьцуулалт шинжилгээ хийх бүрэн боломжтой.
- в. Тухайн судлагдахууныг оноор сонгоод тухайн судлагдахууны хувьд боловсролын түвшнээр гүйцэтгэлийн дундаж ямар байгааг улсын дундажтай харьцуулан харж болно. Жишээлбэл, А сургуулийн хувьд улсын дундажтай харьцуулахад бага боловсролын хувьд 14.4%, суурь боловсролын хувьд 28.7%, бүрэн дунд боловсролын хувьд 11.1%-иар ялгаатай байна.

Цахим тоон тайлангийн системээс бичгийн шалгалтын үр дүнг судлагдахуун бүрээр, агуулгаар, үнэлгээний зорилтоор харах боломжтой. Тус бүрийн мэдээллийн цонхны харагдах байдлыг Зураг 2.14-2.16-д үзүүлэв.

Зураг 2.14. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн (судлагдахуунаар, багшаар)



Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн хэсэгт дээрх Зураг 2.14-д харагдах судлагдахууны гүйцэтгэлийн дунджийг оноор, кластерын болон улсын дундажтай хэрхэн харьцуулж, шинжилгээ хийхийг тусгасан.

Зураг 2.14 дээрх шалгалтын үр дүнд хэрхэн шинжилгээ хийхийг дараах байдлаар тодотгов. Үүнд:

1. “Судлагдахуун-багш” хэсэг дэх тухайн багшийн хичээл заадаг ангийн сурагчдын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг оноор харьцуулж харна.
2. Сүүлийн жилд тухайн багшийн заадаг хичээлийн сурагчдын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг кластерын болон улсын дундажтай харьцуулж, дээгүүр эсвэл доогуур болохыг тодорхойлно.
3. Сургуулийн нийт багш нарын хэдэн хувь нь улсын дунджаас дээгүүр эсвэл доогуур, дунджид ойр байгааг сүүлийн жилээр тооцоолно.
4. Шалгалтын гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх боломжийг тухайн үйл ажиллагаанд хамаарах үүрэг бүхий хүмүүсийн оролцоотойгоор тодорхойлоорой.

Зураг 2.15. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн (агуулгаар, ангиар)



Багшийн хичээл заадаг ангийн суралцагчдын гүйцэтгэл ямар агуулгаар хамгийн өндөр болон хамгийн сул байгааг тогтооно. Тухайн агуулгад хамаарах гүйцэтгэлийг оноор харьцуулан харна. Тухайн багшийн заадаг ангийн ямар агуулгад дэмжлэг хэрэгцээтэй байгааг тодорхойлоорой.

Зураг 2.16. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн (үнэлгээний зорилтоор, багшаар)



Хөтөлбөрийн хэрэгжилтийг судлагдахууны агуулга, анги, үнэлгээний зорилтоор нягталж харахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

1. Анги бүрийн шалгалтын үр дүнг 2 оноор харьцуулан харна. Ингэхдээ тухайн ангийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт ямар судлагдахууны шалгалтын гүйцэтгэлээр тодорхойлогдож буйг тодруулж хараарай.
2. Агуулгын үр дүнг судлагдахуун бүрийн үнэлгээний зорилт (мэдлэг ойлголт, чадвар, хэрэглээ)-оор гүйцэтгэлийн дунджийг харьцуулан харна.

- Тодорхой нэг судлагдахууны хувьд нэг ангиар, үнэлгээний зорилтоор гүйцэтгэлийн үр дүнг харна. Энэ үзүүлэлт нэг жилээр гарах тул 2022 эсвэл 2023 оноор харах нь сургуулийн удирдлагын шинжилгээ хийж буй зорилгоос хамаарна.
- Гүйцэтгэлийг ахиулах боломжийг тухайн үйл ажиллагаанд хамаарах үүрэг бүхий хүмүүсийн оролцоотойгоор тодорхойлоорой.

А сургуулийн хувьд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт болон сургалтын орчин бүрдүүлэлтийн шалгуур бусад шалгууртай харьцуулахад доогуур үзүүлэлттэй. Иймээс сургуулийн удирдлага сул үзүүлэлтийн учир шалтгааныг өөрийн үнэлгээг хийхдээ тодруулан, сайжруулах арга замаа хамт олноороо зөвлөн сургуулийн сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөндөө тусгаарай.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ. Багшийн гүйцэтгэлийг шалгуур, үзүүлэлт тус бүрийн үнэлгээ, хамрагдаж буй хөгжлийн түвшнээр нь цахим тоон тайлангийн системээс харж болно.

Санамж:

Та бүхэн хөтөлбөрийн хэрэгжилт буюу бичгийн шалгалтын үр дүнг ангиар, боловсролын түвшнээр, судлагдахуунаар, судлагдахууны агуулгаар, үнэлгээний зорилтоор, оноор нь харьцуулсан мэдээллийг татан авч шинжилгээ хийгээрэй. “Download” “Crosstab” сонголтоор мэдээллийг “Excel” файлаар татаж, сургуулийнхаа холбогдох мэдээллийг нэмж, харьцуулалт шинжилгээ хийх бүрэн боломжтой.

Зураг 2.17. Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан багшийн тоо

Тухайн сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан багшийн тоог он тус бүрээр харах боломжтой (Зураг 2.17).



Жишээлбэл, А сургуулийн хувьд 2022 онд 65 багш үнэлгээнд хамрагдаж байсан бол 2023 онд энэ тоо 53 болсон байна.


Тухайн сургуулийн багш нарын гүйцэтгэлийн үр дүнг бичгийн шалгалтаас бусад шалгуурын хувьд харуулах цонхыг Зураг 2.18-д үзүүлэв. Шалгуур бүрийн үнэлгээний үр дүнг багш бүрээр, оноор харах боломжтой. Зураг дээрх шалгуур бүрд харгалзах нүд гүн ногоон болох тусам тухайн багшийн үнэлгээний хувь ихсэж байгааг харуулна. Улаан руу ойртох тусам анхаарах шаардлагатай шалгуур гэсэн дохио өгнө.

Зураг 2.18. Багшийн үнэлгээ (бусад шалгуураар)




Харин тухайн шалгуурт харгалзах үзүүлэлтийн хувьд ямар үнэлгээ авсныг дараагийн цонхноос харах боломжтой. (Зураг 2.19). Тодруулбал, сургууль тухайн шалгуурт харгалзах үзүүлэлт бүрд авсан оноогоо харж болно. Жишээлбэл, А сургуулийн хувьд 2023 онд “Суралцагчийн хөгжил, хамгаалал, төлөвшил” нь бусад шалгуураас бага үзүүлэлттэй байна. Харин энэ шалгуурын хувьд 2.1, 2.2, 2.3 үзүүлэлтүүдээс “Сурагч хамгаалал” гэсэн үзүүлэлт хамгийн бага байна. Иймд тухайн сургууль энэ шалгуурын хувьд хэдэн багшийн үнэлгээний үр дүнг ахиулах хэрэгцээтэйг тодорхойлж, дэмжих үйл ажиллагаагаа тодорхойлно.

Зураг 2.19. Багшийн үнэлгээ (шалгуур, үзүүлэлтээр)



Та бүхэн сургуулийнхаа багш нарын хөгжлийн түвшнийг индексээр, судлагдахуунаар, багш бүрээр харах боломжтой. Тодруулбал, танай сургуулийн хэдэн багш ямар индекс, хөгжлийн хэддүгээр түвшинд хамрагдаж буй болон тэднийг судлагдахуун болон ангиар нь нэгтгэн харж болно.

Зураг 2.20. Багшийн үнэлгээ (хөгжлийн түвшнээр)



Сургууль багш нарынхаа хөгжлийн түвшнийг ангиар, судлагдахуун, багшаар харах боломжтой. Ингэхдээ хөгжлийн түвшнийг оноор харьцуулан харна. Үүнд:

1. Сургуулийн нийт багш нарын хэдэн хувь ямар хөгжлийн түвшинд хамаарч байгааг тодорхойлоорой.
2. Ямар судлагдахууны хувьд хамгийн доогуур, ямар анги хамгийн доогуур түвшинд байгааг тогтоогоорой.
3. Түвшин ахих боломжийг тухайн үйл ажиллагаанд хамаарах үүрэг бүхий хүмүүсийн оролцоотойгоор тодорхойлоорой.

2.4. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГЭЭС ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ТОДОРХОЙЛОХ ВЭ?

Сургуулийн менежментийг сайжруулахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь чухал алхам юм. Тулгамдаж буй асуудлыг гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын дагуу тодорхойлохдоо оролцогч талуудын төлөөллийг бүрэн байлгаж нээлттэй хэлэлцэх замаар зохион байгуулах хэрэгтэй.

Асуудал гэдэг Танд яаж ойлгогдож байна вэ? Сайжруулах шаардлагатай зүйл үү, болохгүй байгаа зүйл үү, магадгүй танай сургуулийн алдаа дутагдал уу, сул тал уу. Энэ үг бидэнд ихэвчлэн “сайжруулах шаардлагатай зүйл” гэсэн утгаар ойлгодог. Бид ч энэхүү зөвлөмжид энэ утгаар нь авч үзлээ. Харин “тулгамдаж байгаа” гэсэн үгийг цаг хугацааны хувьд тухайн хичээлийн жилд хамааруулан авч үзэв.

Гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийн сангаас танай сургууль шалгуур бүрээр ямар үнэлгээтэй байгаа, хоёр оноор харьцуулахад аль шалгуур дээр ямар өөрчлөлтүүд гарсан зэрэг нь сургуулийн хөгжлийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлох эх сурвалж болно. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн нь давуу сул талаа тодорхойлж түүнд үндэслэн багш нар илүү сайн багшлах, сургуулиуд илүү сайн ажиллахад нь баталгаатай мэдээллээр хангаж өгдөг.

Тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- » Сургуулийн захирал, сургалтын менежерүүд “БГҮ статистик тайлангийн систем”-д зөв нэвтэрч, мэдээлэлтэй нэг бүрчлэн танилцах чадвартай байх;
- » Систем дэх гүйцэтгэлийн үнэлгээтэй холбогдох мэдээллийг зөвлөмжид өгсөн зааврын дагуу нягталж, сургуулийн хэмжээний нэгтгэлийг бүх боломжит харьцуулалтыг хийх;
- » Сургуулийн удирдлагууд “БГҮ статистик тайлангийн систем” дэх бүхий л мэдээллийг багш, ажилтнуудад үр дүнгийн бодит байдлыг алдагдуулахгүйгээр танилцуулах;
- » Өмнөх хичээлийн жилийн зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлтийн байдлын талаар сургуулийн хамт олон (захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, ажилтнууд) ижил мэдээлэл, нэгдсэн ойлголттой болсон байх;
- » Сургуульд тухайн хичээлийн жилд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох хэлэлцүүлгийг сургуулийн хамт олны гишүүн бүр хүүхдийн хөгжил, амжилтын нийтлэг эрх ашигт нэгдэх, өөрийн байр сууриа нээлттэй илэрхийлэх, харилцан бие биенээ сонсох, харилцан биенээ хүлээн зөвшөөрөх, цагаа зохицуулах, идэвхтэй, хариуцлагатай байхаар зохион байгуулах;
- » Асуудлаа задалж, тухайн зүйл нь танай сургуулийн хувьд үнэхээр асуудал мөн эсэхийг тодорхойлох, асуудал задлах аргачлалтай холбоотой мэдээллийг QR -ийг уншуулан аваарай.
- » Асуудлаа тулгамдаж буй цаг хугацаагаар нь энэ хичээлийн жилийн хувьд, ирэх хичээлийн жилийн хувьд, ойрын таван жилдээ гэх мэтээр эрэмбэлэх,

Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний цахим тоон тайлангийн




системээс авсан мэдээлэлд шинжилгээ хийж, асуудлаа тодорхойлохдоо бидний санал болгож буй Загасан нурууны аргачлалыг ашиглаарай.

Загасан нурууг хэрхэн бүтээх вэ?

Тодорхой үйл явдлын шалтгаануудыг “загасны яс” хэлбэртэй зургаар харуулдаг арга ба тулгамдсан асуудлуудыг загасны “толгой” хэсэгт, тулгамдсан асуудлыг үндсэн шалтгааныг загасны “их биеийн ясны үзүүр” хэсэгт, хоёрдогч буюу бусад шалтгааныг “их биеийн ясны гол” хэсэгт харуулна.

Зураг 2.20. Асуудлын шалтгааныг тодорхойлох Загасан нуруу аргачлалын ерөнхий загвар



Сургуулийн зорилго, зорилтоо тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэл асуудлаа тодорхойлохоос эхлэх тул бид дээр дурдсан аргачлалыг зөвлөж байгаа юм.

Сургуулийн хамт олныг бүхэлд нь хамруулан Загасан нурууны зургийг бүтээгээрэй. Бүтээсэн зураглалдаа үндэслэн асуудлын үндсэн шалтгааныг арилгах сургуулийн сургалт үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж болно.

Танай сургууль оролцоонд тулгуурласан шийдэл гаргаж чадаж байгаа юу?

Сургуулийн сургалт, үйл ажиллагаа нь бүхэлдээ хүүхдийн хөгжлийг дэмжихэд зориулагдах тул сургуулийн менежментийн төвд хүүхэд байх учиртай.

Тэгэхээр сурагч, эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, сургуулийн удирдлага, ажилтнууд, орон нутгийн засаг захиргааны нэгжийн холбогдох албан хаагчид, хамтрагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн нээлттэй идэвхтэй оролцоог хангаж, сургуулийн түвшин дэх бүхий л шийдвэрийг гаргах нь хүүхдийн хөгжлийн тулгуур болно.

3

СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ: АСУУДАЛ ШИЙДЭЛ

III БҮЛГИЙН ТОЙМ



СУРАГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

- Сурагчийн хөгжил, хамгаалал
- Сурагчийн хөгжил, хамгааллын бүтэц, зохион байгуулалт




СУРГАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

- Сургалтын хөтөлбөрийг судлах, ойлгох
- Сургалтын төлөвлөлт
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга, технологи
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ



БАГШИЙН ХӨГЖИЛ

- Багшийн хөгжих хэрэгцээ ба төлөвлөлт
- Багшийн манлайлал, хамтын ажиллагаа, хамтран ажиллах соёл-Мэргэжлийн хөгжлийн бүлэг
- Багшийн өөрийн удирдлагатай суралцахуй ба технологийн чадамж



СУРГАЛТЫН ОРЧИН

- Материаллаг нөөц, хүртээмж
- Ашиглалт, зохион байгуулалт
- Эрүүл, аюулгүй орчин



СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

- Сургуулийн зорилго, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт
- Сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт
- Байгууллагын хүний нөөц
- Сургуулийн төсөв, санхүүжилт
- Хамтын ажиллагаа, түншлэл

❓ АСУУДАЛ

🧠 ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

📄 ЗӨВЛӨМЖ

3.1. СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ ХЭРХЭН НЭМЭГДҮҮЛЭХ ВЭ?

Сурагчийн хөгжил, нөлөөллийн хүчин зүйлсийг яагаад авч үздэг вэ?

Хүүхдийн хөгжилд төрөлхийн өгөгдөл буюу биологийн онцлог, нийгэм-эдийн засгийн хөгжил, сургалт хөгжлийн үйл ажиллагаа, гэр бүлийн орчин, амьжиргааны түвшин, хүмүүс хоорондын харилцаа хандлага гол нөлөөтэй.

Зураг 3.1. Хүүхдийн хөгжлийн бүрдэл



АСУУДАЛ

Сургуулийн орчинд хүүхэд чөлөөтэй хөдөлгөөн хийх (гүйж, харайх) боломж хязгаарагдмал, чанар муутай хүнсний бүтээгдэхүүнийг хяналтгүй хэрэглэх нөхцөл бүрдсэн.

- Шүдний өвчлөл их (*Олон өвчлөлийн суурь шалтгаан болдог*)
- Хүүхэд дэлгэцийн хэт их хамараалтайгаас хөдөлгөөний хомсдолтой, хөдөлгөөний дадал сул
- Хүүхдийн бие бялдын тэсвэр тэвчээртэй байдал хангалтгүй



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Нийслэлийн зарим сургууль усан бассейнд үйлчлүүлдэг, тогтмол хичээллэдэг хүүхдийн тоог нэмэгдүүлж чадсан байна. Усан спорт нь хүүхдийн бие бялдрын олон чадварыг өв тэгш хөгжүүлэхээс гадна эрүүл мэндийг дэмжих чухал арга зам юм. Мөн хүүхдүүдийн дунд биеийн тамирын спорт тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулах, оролцуулах ажлыг хийжээ. Үүнээс гадна хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Шүдний эрүүл ахуйг дэмжих” ажлууг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал, “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг хүүхдүүдийн дунд зохион байгуулсан туршлага сургуулиудад хэрэгжжээ.

Тэрчлэн хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний эвсэл суулгах чиглэлээр “Монгол бий биелгээ” завсарлагааны хөдөлгөөнт дасгалыг хийж хэвшин, эцэг эх асран хамгаалагч нартайгаа хамтран хийж түгээн дэлгэрүүлсэн байна.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Сурагчдын амны хөндийн эрүүл ахуй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран зохион байгуулах;
- Сурагчдын бие бялдрын өсөлт хөгжлийн үнэлгээг сургуулийн эмч, АУБ, биеийн тамирын багштай хамтарч хийдэг, хөгжлийн ахиц, өөрчлөлтөд үнэлгээ өгдөг байх, энэ талаар эцэг эх, асран хамгаалагч, дунд, ахлах ангийн сурагчдад мэдээлэл, зөвлөгөө өгдөг байх;
- Сургууль дээр хөдөлгөөнт дасгал хийж хэвших;
- Сургууль дээр эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх дүрэм журмыг мөрдөж ажиллах;
- Сургуулийн биеийн тамирын заал, биеийн тамирын гадна талбай нь стандарт шаардлага хангахуйц байхаар тохижуулах;



АСУУДАЛ

- Хүүхдийн цогц хөгжил, сурлагын амжилт хангалтгүй
- Сурагчдын математик сэтгэлгээний чадвар сул
- Сурагчдын сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, ангилах, нэгтгэх, учир шалтгаанд нь сэтгэх, системд нь сэтгэх чадвар доогуур
- Сурагчдын анхаарлын төвлөрөл сул
- Сурагчдын уншаад ойлгох, ойлгосноо илэрхийлэх, зохион бичиж найруулах чадвар сул



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн 1-12 дугаар ангийн бүх сурагчаас судлагдахуун бүрээр блюпринтийн дагуу боловсруулсан даалгавраар явцын үнэлгээ бүхий шалгалтыг зохион байгуулж, үр дүнд шинжилгээ хийж, багш нэг бүрт зөвлөгөө өгсөн. Гүйцэтгэлийн дундаж хувь суурь түвшинтэй харьцуулахад 5.8 хувиар ахисан үзүүлэлттэй гарсан байна.

Энэ нь сурагчдын танин мэдэхүйн хөгжлийг дэмжих ажил болжээ.

... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Судлагдахууны онцлогоос хамааран хичээлийн агуулгыг интеграцчилан ХГҮА-тай холбон танхимын бус сургалтыг зохион байгуулахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах
- Сургалтын заах арга зүй нь сурагчдын танин мэдэхүйн чадварыг хөгжүүлэх, суурь чадварыг эзэмшүүлэх ба ингэснээр мэдлэг, бүтээх, хувиргах чадвар бий болно. Үүний тулд хүүхдийн танин мэдэхүйн буюу суралцахуйн түвшинг нь үнэлж арга зүйгээ боловсруулахад багш нарыг мэргэжил арга зүйн хувьд чиглүүлэх (*Жишээ нь: Юмсыг хооронд нь тоо болон чанарын хувьд харьцуулах, ангилах үйлдлийг хичээлийн элементэд түлхүү оруулах, тухайлбал, зориулалт, дотоод нийтлэг онцлогоор ойлголтыг харьцуулах, ангилах гэх мэт үйлдлийг судлагдахууны онцлогт тохируулан ээлжит хичээлдээ сонирхолтой байдлаар тусгах, хичээл сургалтын үед хүүхдийн хийх үйл нь өгөгдсөн*)

нөхцөлийн гол шинж, уялдаа холбоог нь ойлгож дүгнэлт гаргахад чиглэх)

- Хичээл сургалтын үйл ажиллагаагаар сурагчдын анхаарлын төвлөрлийг нэмэгдүүлэхэд багш нарт арга зүйн дэмжлэгийг үзүүлэх, энэ тал дээр мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн зөвлөгөө дэмжлэгийг авч ажиллах
- Сурагчдаар гүйцэтгүүлэх гэрийн даалгаврын зохистой хэмжээ, агуулгыг багш нар хоорондоо хамтран үр дүнтэй болгоход менежментийг чиглүүлэх, *(гэрийн даалгавар хэт их байх нь анхаарлын төвлөрлийг бууруулан залхаах, суралцахуйн амжилтыг бууруулах, сурах хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй)*
- Хүүхэд логик дэс дараалалтайгаар санаа бодлоо бүтэн өгүүлбэрээр илэрхийлэх чадварыг хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулдаг байх *(сэтгэхүй, анхаарал, ой тогтоолт, хэл ярианы чадварыг дэмжихэд үр дүнтэй)*



АСУУДАЛ

Хүүхэд сурах хүсэл эрмэлзэл, сонирхолгүй, зорилгогүй, цаашилбал сургуулиас зайлсхийх, бие даан сурах чадваргүй

- Хүүхдийн өөртөө итгэх итгэл, бие даан сурах арга барил, багаар хамтран ажиллах өөрийгөө илэрхийлэх чадвар сул *(мета танин мэдэхүйн чадвар, сурлагын амжилт хангалтгүй)*
- Бие биеэ хүндэтгэж харилцах хэвшил, соёл дутмаг
- Харилцааны чадваргүй, бусдад өөрийгөө ойлгуулах, бусдыг ойлгох, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах удирдах чадваргүй
- Багшийн хүүхдэд үлгэр дуурайл үзүүлэх ёс зүйн манлайлал хангалтгүй
- Анги удирдсан багш хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжихэд зарцуулах цаг хомс, анги өрөө тасалгаа дутмаг
- Сурагчаа, ангиа таних, хөгжүүлэх сурган хүмүүжүүлэх нөлөө үзүүлэх нь сул
- Шинээр элссэн, шилжиж ирсэн, бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй сурагчдад үзүүлэх дэмжлэг дутмаг



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

“‘Words from the Heart’ илтгэлийн уралдаан гадаад хэлээр судалсан мэдлэгийг чадвар болгох, сурах идэвх, сонирхлыг нэмэгдүүлэх, сурагчдын чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхээр 2 үе шаттай 9-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулахад 80 гаруй сурагч илтгэлээ ирүүлж, шалгаруулалт явуулсан.

Мөн гадаад дууны тэмцээн 6-12 ангийн нийт 494 сурагч 114 дуугаар (англи, орос, солонгос, хэл дээр) дуулж оролцлоо. Тус тэмцээн нь сурагчдыг урлагаар дамжуулан тухайн орны хэл соёлын мэдлэгээ дээшлүүлэх, дуулах бүжиглэх авьяас болон хэлний мэдлэг чадвараа хөгжүүлэх, бусдаас суралцах, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой ажил болсон байна.

... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Хичээлээс гадуурх секц дугуйлангийн тоо төрлийг нэмэгдүүлэн, хүүхдийн оролцоог сайжруулсан хийгээд улмаар сурагчид багштайгаа хамтран орон нутгийн засаг захиргааны удирдлага, эцэг эх, үе тэнгийнхэн, сургуулийнхандаа тайлант өдөрлөг хийх, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ. 2023-2024 оны хичээлийн жилд шинээр 1-р ангид элсэн орж суралцах цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн сурагчдад “СУРГУУЛЬТАЙ ТАНИЛЦАХ” өдөрлөг, түүнд эцэг, эх, асран хамгаалагчдыг идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан нь хүүхдийн нийгэм сэтгэл зүйн дасан зохицох чадварыг дэмжих чухал ажил болсон байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Сурагчдад зан төлөвийн эерэг төлөвшил, ёс суртахууныг хөгжүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг улирал тутам зохион байгуулж үр дүнг нь тооцдог байх
- Хүүхэд бие даан сурах үйлээ төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, засан сайжруулах циклээр ээлжит хичээл, зөвлөн туслах үйлчилгээ, ХГҮА-г төлөвлөн хэрэгжүүлэх
- Хүүхдээ хөгжүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийг татан оролцуулах, үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулах, ингэхдээ эцэг эх, асран хамгаалагчтай харилцан зөвшилцөх, давуу

талд нь тулгуурлах, харилцан хүндэтгэлтэй хандах, эцэг эх асран хамгаалагчдын санаа бодлыг хүлээн зөвшөөрөх соёлыг төлөвшүүлэх

- Нэгдүгээр ангид элсэн суралцаж байгаа болон багаас суурь боловсролын түвшинд шилжин суралцаж буй сурагчдын дасан зохицох чадварыг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулах (*сурагчийн сурлагын амжилт, ахиц өөрчлөлт, хичээлийн оролцоо идэвх, сэтгэл ханамжийн эерэг түвшинд чухлаар нөлөөлнө*)
- Бусдыг хүндэтгэж харилцах соёлыг төлөвшүүлэхийн тулд дотоод дүрэм журам боловсруулан мөрдөх
- Багш бүр сурагчидтай харилцахдаа элэгсэг нээлттэй, тэвчээртэй, сэтгэлийн хөдөлгөөний сөрөг илрэлээс зайлсхийх ёс зүйн дүрэм журмыг мөрдөж ажиллах

3.1.1 ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮҮХДИЙН ЭРХ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Хүүхэд бүр алив хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй гэдгийг дэлхийн олон улс орон хүлээн зөвшөөрсөнчлөн Монгол Улс 1990 онд НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсноор хүүхдийн эрх хамгааллыг албан ёсоор хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн.

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй (Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016)

Монгол Улс нь Боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” тогтоол зэрэгтээ хүүхэд бүр аюулгүй, хүчирхийллээс ангид орчинд сурч хөгжих тухай заасан байдаг.



Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/453 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам




Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/214 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чиглэл

Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/453 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмаар хүүхдийг үл хайхрах байдал, сэтгэл санааны хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна гэж заасан байдаг.

Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/214 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чиглэл батлагдсан байдаг.

Зураг 3.2. Хүүхдийн үндсэн эрх



? АСУУДАЛ

Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд удирдлагын манлайлал, зохицуулалт дэмжлэг дутмаг.

- Хүүхдийн эрх, хамгааллын үйл ажиллагаа сургууль дээр хэрэгжихгүй байх;
- Хүүхэд, хөгжил, хамгааллын талаарх бодлого, журмын хэрэгжилт хангалтгүй;
- Мэргэжлийн бус нийгмийн ажилтнууд ажиллаж байгаагаас хүүхдийн хөгжил, хамгааллын ажил орхигдох;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байх;



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Орон нутгийн “Хүүхэд хамгааллын хамтарсан баг”, ГБХЗХГ, сургуулийн нийгмийн ажилтан нар эрсдэлт нөхцөлд байгаа, эрсдэл үүсэж болзошгүй хүүхдүүд дээр кейс үүсгэн хамтран ажиллаж шийдвэрлэжээ. Бага анги, дотуур байрны сурагчдыг эцэг эхэд нь хүлээлгэж өгөх “*гараас гарт*” үйл ажиллагааг хэвшил болгосон, энд АУБ, эцэг эх, сурагчийн гурвалсан гэрээ байгуулж хэрэгжилтийг хангаж ажилладаг болжээ.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Сургуулийн Хүүхэд хамгааллын Зөвлөлийн гишүүдийн **Хүүхэд хамгаалал-Хүүхэд хяналт** үйлчилгээг хэрэгжүүлж ажиллав. Эрх нь зөрчигдөж байгаа сурагчдын ар гэрээр очиж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, эцэг эх асран хамгаалагч нарын үүрэг таниулах хуулийг танилцуулж, зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилладаг. Эрсдэлд өртсөн хүүхдэд Хамтарсан багийн үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллав.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Сургуулийн хүүхэд хөгжил, хамгааллын алба нь хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байх
- Сургуулийн хүүхэд хөгжил, хамгааллын алба нь хүүхэд хамгаалал гэж юу болох, хамгааллын хүчин зүйлсийн талаарх багш ажилтан, сурагчдын мэдлэг ойлголт, чадвар, хандлагыг сайжруулах олон талт үйл ажиллагааг зохион байгуулдаг байх
- Нийгмийн ажилтны орон тоон дээр мэргэжлийн хүн ажиллуулах шалгуурыг бий болгож ажлын байрны тодорхойлолтыг мөрдөж ажиллах



АСУУДАЛ

Хүүхдийн хамгаалуулах эрх зөрчигдөх, багш хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах боломж хомс

- Сурагчдад хөгжил, хамгааллын үйлчилгээг үзүүлдэггүй.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг анги удирдсан багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хувиасаа гаргадаг.
- Хүүхэд хамгааллын зардлыг төсөвт суулгаагүйгээс үүдэн сургуулийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ хэрэгжих боломжгүй.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн багш ажилтны төлөөллөөс бүрдсэн, хүүхдийн хөгжил, хамгаалал гэсэн 2 баг байгуулж асуудлаа илрүүлж цаашид хийх үйл ажиллагааны чиглэл гаргаж дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэлээ.

- 7 хоног бүрийн 3 дахь өдрийг “Нийгмийн ажилтны өдөр” болгон сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн санал, асуудлыг сонсож үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.
- Хүүхдийн хүчирхийллийн мэдээлэл хүлээн авах зураглалтай болсон.
- Дэлгэрэнгүй судалгааны маягттай болж маягтын дагуу сургуулийн нийт хүүхдийн судалгаа авч мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн.
- Сургуулийн хажуугийн засмал замын гарцыг сэргээн будаж, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.
- ХГҮА нэгдсэн хөтөлбөр гаргаж, сургуулийн нэгдсэн хөтөлбөрт тусгахаар ажиллаж байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Хүүхэд хөгжил, хамгааллын алба, хүүхэд хамгааллын баг хамтран хүүхэд хамгааллын зөрчлийг хэрхэн таних, зөрчигдсөн тохиолдолд хэрхэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах зураглалтай байх, багш, сурагчид мэддэг байх.
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгайлан суулгах



АСУУДАЛ

Багш, сурагчийн харилцаа таагүй

- Сурагчийн хөгжих, оролцох эрх зөрчигдөх, үл хайхрал, ялгаварлан гадуурхалд өртөхөөс бүрэн сэргийлж чаддаггүй
- Хүүхэд сургуулиас завсардах, сурлагын хоцрогдол, зан төлөвийн доголдолд орох эрсдэлтэй.
- Үе тэнгийн дээрэлхэлт ихтэй.
- Сурагчид холоос хичээлд явдаг нь аливаа эрсдэлд өртөх магадлалтай
- Хүүхэд хамгааллын ажиллах зарчмын талаар багш, эцэг эх мэдлэггүй.
- Сурагчид тулгамдсан асуудлаа шийдэж чадахгүй сэтгэл гутралд орох зэрэг эрсдэлтэй.
- Ар гэрийн асуудалтай, асран хамгаалагч архины хамааралтай хүүхдүүд байдаг тул хичээл амрах үед сурагчдын амьдрах орчны аюулгүй байдал шийдвэрлэхэд төвөгтэй.
- Дугуйлан секцийн үйл ажиллагаа тогтмол бус, сурагч бүр өөрийн сонголтоор хамрагдах боломжгүй.
- Сурагчийн өөрийн удирдлагатай бие даасан клуб, зөвлөлийн үйл ажиллагаа сул, нийгмийн харилцаанд бие даан оролцох хөгжих боломж эрх хязгаарлагдмал.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Хүүхдийн Итгэлтэй утсыг сургуулийн орчинд тавьж өгсөн. Сэтгэл зүйчийн дэргэд “Сурагчдын бүлэг” байгуулан ажилласан. Сургуулийн хүүхдийн автобус Чингэлтэйн эцэсээс 37-р сургууль чиглэлд явж эхлэн нийт 20 сурагч үйлчлүүлж байна.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Сургуулийн хүүхэд хамгааллын багийн санаачилгаар сургуулийн хэмжээнд “Захиралдаа захидал бичье” захидлын хайрцгийг сургуулийн орчинд тулгамдаж буй асуудал, сургуулийн удирдлага болон багш ажилчдад хүргүүлэх талархал, багш, ажилчдын харилцаа хандлага, анги бүлэг, сурагчдын хооронд үүсэж буй зөрчил гэх мэт асуудлуудыг илрүүлэх зорилгоор ажиллуулсан. Үр дүнд нь сургуулийн орчинд тулгамдаж буй асуудал, сургуульд болон багш, ажилтнуудад хүргүүлэх талархал, багш, ажилчдын харилцаа хандлага, анги бүлэг, сурагчдын хооронд үүсэж буй зөрчил гэх мэт асуудлууд тодорхой хэмжээгээр илэрч, хариу арга хэмжээ авч ажиллажээ. Аяны хүрээнд ирсэн захидал тус бүрийн хариу арга хэмжээг авч, ирүүлсэн захидлын дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг захидлын эзэнд хариу болгон хүргэх ажлыг зохион байгуулснаар энэхүү үйл ажиллагаа цаашид тогтвортой, идэвхтэй хэрэгжих юм.

*... аймгийн ... сумын ерөнхий боловсролын
... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас*



ЗӨВЛӨМЖ

- Багш сургуулийн ажилтан бүр сурагчийн санаа бодлыг анхааралтай сонсох, сонсож байгаагаа үг яриа үйлдлээрээ илэрхийлдэг, сурагчийн хувийн болон соёлын онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, хүүхдийг шийтгэх янз бүрийн арга хэрэгслээс зайлсхийх мэдлэг, чадвар, хандлагатай байх
- Сурагчдын биед зохисгүйгээр хүрэх, гэмтээх, сэтгэл санааны дарамтад оруулж зохисгүй үг хэллэг хэрэглэж харилцах, үл хайхрахыг хориглосон дүрэм журмыг чанд дагаж мөрддөг байх
- Сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байх
- Сурагчаа сонсох өдрийг тогтмол болгож санал хүсэлтийн нээлттэй хайрцаг, итгэлтэй утас зэргийг ажиллуулж хэвшиж, хариу арга хэмжээ авдаг байх
- Үе тэнгийн дээрэлхэлтийн тохиолдлыг таних, мэдээлэх талаарх ойлголт хандлагыг сурагч, багш, ажилтан, эцэг эхчүүдэд бий болгох үйл ажиллагааг зохион байгуулдаг байх
- Сургууль, ангийн түвшинд дээрэлхэлтийн эсрэг дүрэм, журмыг боловсруулах

- Урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхний зөв харилцаа хандлагын талаар уулзалт ярилцлага хийж хэвших
- Хол гэртэй суралцагчдад сургуулийн автобусны үйлчилгээг нэвтрүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэйгээ харилцах, эрхийг нь зөрчихгүй байх, шийтгэлийн алив хэлбэрээс зайлсхийх, асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх чадвар дадал олгох олон талт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байх
- Багш нар өөрийн давуу талаа хөгжүүлэн секц, дугуйлан хичээллүүлж хүүхэд бүрийг тэгш хамруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд үр дүнтэй арга юм⁹.
- Төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, зөвлөгөөг өгч ажиллахыг хэвшил болгох
- Суралцагчийн оролцоонд тулгуурласан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх. Ялангуяа, суралцагч бие даан шийдвэр гаргах чадварыг дэмжин ажиллах



АСУУДАЛ

Стандартын бус анги танхим, зориулалтын бус гал тогоо, цайны газар нь сурагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлтэй

- Дотуур байрны хүртээмж дутагдалтай
- Сурагчид үл хайхрах, бие махбод, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй
- Үдийн хоол, дотуур байрын хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдал хангалтгүй
- Сургалтын орчин нөхцөл тааруухан
- 00 хүрэлцээгүй, орчин муугаас халдварт өвчин гарах магадлалтай
- Хүүхдийн эрүүл эсэн мэнд амьдрах эрх зөрчигдөх

Эдгээр асуудал нь сурах идэвх сонирхол, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх

9 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх буюу хөгжих эрхийг дэмжих хүрээнд сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал 2019 онд батлагдан хэрэгжиж байна.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орох шатыг налуу болгож янзалсан, 00 өрөөг шинээр хийсэн.

Нийтийн 00-ын өрөөнүүд болон нийтийн эзэмшлийн коридор, хонгилуудад их цэвэрлэгээ хийлгэж, цэвэрлэгээг дутуу хийдгийг болиулах зорилгоор их цэвэрлэгээг тогтмолжуулж цэвэрлэгээний өдөртэй болгож, 7 хоног бүр цэвэрлэгээ хийж хэвших чиглэл өгсөн. 2022-2023 оны хичээлийн жилд “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэхэд хяналт тавих, хяналтын комисс сургалтын менежер, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, секцийн ахлагч, эцэг эхийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр захирлын тушаалаар батлан ажиллаж байна.

... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Анги танхимд цэвэрлэгээ, агааржуулалт хийх хуваарь гаргаж, тоосжилтыг багасгах нано шүүлтүүр байршуулж цэвэрлэгээ үйлчилгээний хяналтын график хөтөлж хэвшсэн. Өдөр тутамд хоолны амт чанар, орц, норм, технологид хяналт тавьж ажилласан нь үр дүнтэй ажил болжээ.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Анги танхимд агаар сэлгэлт, тоосжилтгүй нөхцөлийг боломж нөөцдөө тулгуурлан бий болгох
- Гал тогоо нь эрүүл ахуйн шаардлагыг хангахуйц хүнсний агуулах савтай, тоног төхөөрөмж нь аюулгүй байх
- Дотуур байрны хүртээмж хангалтгүй тохиолдолд сурагчдын эцэг эх, асран хамгаалагчтай биечлэн уулзаж, албан ёсны гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд АУБ, Хүүхэд хөгжил хамгааллын алба хяналт тавьж ажиллах дүрэм журам боловсруулан мөрдөх
- Үдийн хоол хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд нь аюулгүй, хоолны цэс нь амин дэм, илчлэгийн шаардлага хангахуйц олон төрөл байхад дүрэм журмыг дагаж мөрдөх

- Сургуулийн орчин нөхцөлийг стандарт шаардлагын дагуу сайжруулах, тухтай орчныг бүрдүүлэн ажиллах, ялангуяа, ариун цэврийн өрөөний стандарт, эрүүл ахуй, ариун цэврийг тогтмол хангаж ажиллах дүрэм журмыг дагаж мөрддөг байх
- Боловсролын тусгай хэрэгцээт сурагчийн онцлогт тохирсон орчин нөхцөлийг бүрдүүлэх



АСУУДАЛ

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургууль, олон нийтийн хамтын ажиллагаа дутмаг

- Хүүхдийн хөгжил, хамгаалалд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоо хангалтгүй
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхэдтэйгээ хүмүүжлийн эерэг арга барилаар ханддаг байх
- Гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлан таниулах, хүүхэдтэйгээ насны онцлогт нь тохируулан хүмүүжлийн зөв аргаар хандах болон эрүүл аюулгүй орчинд хүүхдийг өсгөх тал дээр зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэжээ. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, дуу хоолойг сонсох аян өрнүүлж, тэдний санаа бодлыг тусгаж ажиллах үйл ажиллагаа хийгджээ. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш нарын дунд эерэг хандлагыг буй болгох “цахим захидал” үйл ажиллагааг зохион байгуулжээ. 2023.04.15-ны өдөр мэргэжил нэгт асран хамгаалагчийн өдөрлөгийг 9-10-р ангийн сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр эмч, цэрэг, цагдаа, эдийн засагч, хуульч, багш, технологич, зэрэг мэргэжилтэй 8 асран хамгаалагч нар оролцон сурагчдад ажил мэргэжлийн онцлог, дэвшин хөгжих боломж, цалин хөлсний мэдээлэл зэргийг танилцуулж зөвлөгөө өгчээ.

*... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын
... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас*



ЗӨВЛӨМЖ

- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд багш нарын хичээл заах арга зүй, үйл явцын талаарх ойлголт өгөх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах (*Ингэснээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн сэтгэл ханамжийн түвшин нэмэгдэх, хамтын үйл ажиллагаа сайжрах, хүүхдийнхээ суралцахуй болон төлөвшлийг дэмжих үр дүнтэй*).
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, хүсэлтийг нээлттэй авч, ажилдаа тусгаж ажилладаг соёлыг дадуулах
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхдийнх нь хөгжил, ахиц дэвшлийн талаар мэдээлэл тогтмол өгч ажилладаг байх
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хийх уулзалт зөвлөгөөг уламжлалт арга хэлбэрээс татгалзаж шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэх, үр дүнтэй бодит хамтын ажиллагааг бий болгох (*жишээлбэл, тэдний ажил мэргэжил, чадвар, боломж зэргийг харгалзан үзэж ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх*)
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхэдтэй зөв харилцах, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлсэн сургалт нөлөөллийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах
- Боловсролын тусгай хэрэгцээт суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд зөвлөн туслах ажил хийдэг байх, ингэхдээ ялгаварлан гадуурхсан мэт мэдрэмж төрүүлэхээс зайлсхийх чадвартай байх
- Сургуулийн үйл ажиллагааг орон нутгийн түвшинд мэдээлэх, таниулах ажлыг тогтмол хийдэг байх
- Сургуулийн үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөхөд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагатай хамтардаг байх

3.1.2 СУРАГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ МЕНЕЖМЕНТ

Сургууль нь үйл ажиллагааны зорилго, зорилтоо дэвшүүлэн, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулдаг. Байгууллагын үйл ажиллагааны зорилго, төлөвлөгөө нь сурагчдын хөгжил, хамгаалалд тулгамдаж буй асуудалд суурилсан, түүнийг шийдвэрлэх бодит алхмуудыг тусгасан байна. Энэ нь сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулж хяналт үнэлгээний механизм боловсронгуй болох үр дүнтэй.

Сурагчийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг дараах алхын хүрээнд зохион байгуулж болно.

Алхам-1: Сурагчийн хөгжил хамгааллын алба байгуулж хамтын ажиллагааг сайжруулах нь хөгжил хамгааллын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжих боломж юм.

Сургуулийн бүхий л үйл ажиллагааны төв нь сурагчийн хөгжил, хамгаалал байна.

Сурагчийн хөгжил хамгааллын алба нь сургуулийн болон орон нутгийн хүүхэд хамгааллын баг, сургуулийн удирдах зөвлөл, багш, багш нарын бүлэг, бие даасан клуб, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлөл, орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэгтэй байна.

Алхам-2: Сурагчийн хөгжил хамгааллын алба нь юуны түрүүнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно. Үүнд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, ажиглалт, асуулга, ярилцлага, баримт бичгийн шинжилгээний аргуудыг хэрэглэх боломжтой ба ингэснээр сурагчийн хөгжил, хамгаалалд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлыг илрүүлнэ. Хэрэв нэгээс дээш асуудал байвал тэдгээрийг шийдвэрлэх бодит боломж болон ач холбогдлын түвшингээр нь эрэмбэлэн сонголт хийж болно. Энд оролцогчдын санал, хамтын үйл ажиллагаа чухал ач холбогдолтой.

Алхам-3: Тулгамдсан асуудалд тулгуурлан тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны зорилго, зорилтоо SMART зарчимд нийцүүлэн дэвшүүлнэ.

Сургуулийн эрхэм зорилго, алсын хараа нь хүүхдийн эрхийн тухай хуулийн үндсэн зарчимд суурилсан байна¹⁰.

Алхам-4: Үйл ажиллагааны зорилго, зорилтын хэрэгжилтэд эергээр нөлөөлөх хүчин зүйлс ба саад болох хүчин зүйлсийг илрүүлнэ. Жишээлбэл, “Сурагчийн задлан шинжлэх, асуудлыг шийдвэрлэх чадварыг сайжруулах”

¹⁰ Хүүхдийн эрхийн тухай хууль

гэсэн зорилго дэвшүүлсэн тохиолдолд эергээр нөлөөлөх хүчин зүйлс нь багшийн ажилдаа хандах эерэг хандлага, багш нарын хамтын ажиллагаа бол сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн дэмжлэг сул гэж үзвэл үүнийг саармагжуулахад үйл ажиллагааны төлөвлөлтөө хийж болох юм.

Алхам-5: Зорилго, зорилтдоо хүрэх ажлуудыг тодорхойлно.

Алхам-6: Үнэлгээний шалгуур үзүүлэлтээ боловсруулна.

Алхам-7: Үр дүнгийн тайлагналтаа төлөвлөнө. Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш, ажилтан, олон,нийт, аж ахуйн нэгж байгууллагын гэх мэт төлөөллийн оролцоог хангана.

Алхам-8: Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгана. Орон нутгийн засаг захиргаа, хүүхэд залуучуудын хөгжлийн газар зэрэг аж ахуйн нэгж байгууллагатай үйл ажиллагааны төлөвлөгөөгөө уялдуулан зохицуулна.

Сурагчийн хөгжил, хамгааллын асуудлыг шийдвэрлэхдээ сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн хөгжил, сургалтын орчин, гэр бүл, олон нийтийн оролцоо, удирдлага манлайллын түвшинд цогцод нь авч үзнэ.

Сургуулийн орчин дахь хүүхэд хөгжил, хамгааллын асуудалд нийгмийн ажилтан сэтгэл зүйч манлайлах үүрэгтэй ба үйл ажиллагааны бусад субъектуудтай нягт хамтран ажиллана.

Зураг 3.3. Суралцагчийн хөгжил, хамгааллын албаны бүтцийн зөвлөмжилж буй хувилбар



Нийгмийн ажилтан нь боловсролын салбарын болон хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр баримталж буй хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах тайлагнах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулна.

Сургуулийн сэтгэл зүйчийн үндсэн чиг үүрэг нь хүүхэд хөгжил, түүнтэй холбоотой оношилгоо хийх, багш, ажилтан, удирдлагын багт сургалт хөгжлийн сэтгэл зүйн талын соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхдийн хөгжлийн талаар зөвлөн туслах, багш, ажилтанд хүүхэд хөгжлийн асуудлаар тусламж үзүүлэх, хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ хүргэх гэх мэт үүрэгтэй. Сурагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд үүсэж байгаа сэтгэл зүйн бэрхшээл болон төлөвшил, харилцаа, зан үйлийн доголдолтой уялдаатай цаг үеийн асуудлыг шийдвэрлэхэд тэрээр голлож ажиллана.

3.1.3 УДИРДАХ АЖИЛТНЫ ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР СУРАГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Сургуулийн үйл ажиллагааны үр ашиг буюу зорилгын биелэлтэд уг байгууллагын хамт олны сэтгэл зүйн уур амьсгал шийдвэрлэх нөлөөтэй байдаг.

Сургуулийн сэтгэл зүйн уур амьсгал нь удирдлага, багш, ажилтан, сурагч хоорондын харилцан үйлчлэл, хамтын ажиллагааны нэгдмэл байдал, сэтгэл ханамж юм. Иймд харилцааны уур амьсгал нь хэд хэдэн үзүүлэлтээр илэрнэ. Үүнд:

- Удирдлага, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, харилцан итгэлцэл, харилцан ажил хэрэгч шаардлага, шударга шүүмжлэл тавьдаг байх чадвар;
- Багш, ажилтан, сурагчид үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлдэг байх;
- Багш, ажилтан, сурагч сургуульдаа сэтгэл хангалуун байх;
- Багш, ажилтан, сурагчид харилцан бие биеэ дэмжих туслах чадвар сайтай байх;
- Багш, ажилтан, сурагч, эцэг эх, асран хамгаалагчид сургуулийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл олж авдаг байх зэргээр илэрдэг.

Удирдлага ба багш ажилтан хоорондын эерэг хүндэтгэлтэй харилцааны соёл нь нэг талаас сургуулийн орчин дахь сурагчийн хөгжил хамгааллын суурь болдог. Хэрэв багш, ажилтан удирдлагын зүгээс хүндэтгэлгүй, шударга бус,

бүдүүлэг харилцаанд өртөх аваас хөдөлмөрийн сэтгэл ханамжгүй байдалд орж бухимдал стрессээ ухамсрын ба ухамсрын бус түвшинд сурагчдад гаргах, тэдний дунд ямар нэгэн байдлаар сурагч хохирох, сургалт хөгжлийн үйл ажиллагааны чанар доголдох, ажлын байрны шилжилт хөдөлгөөн үүсэж мэргэжлийн багшийн хомсдолд орох зэргээр сурагчийн хөгжил хамгааллын асуудлыг бий болгодог. Иймээс

- Шат шатны удирдлага, багш, ажилтантай харилцах ёс зүйн дүрэмтэй, түүнийгээ таниулан сурталчлах, мөрдөх санцтай байх
- Багш, ажилтанд нөлөөлөх, зөвлөн дэмжих үйл нь багшийг сэтгэл санааны дарамт, зовнилд оруулахаас зайлсхийсэн, ардчилсан тэгш, хүндэтгэлтэй харилцаанд тулгуурлахыг үйл ажиллагааны зарчим болгох
- Хувь хүний эерэг чанарыг тодруулж, өөрийн үнэлэмжид нь сөрөг үл мөр үлдээхээс сэргийлдэг байх
- Хамт олны дунд багш, ажилтны нэр хүндийг ямагт эрхэмлэх, багш хүн олны дунд сэтгэл гонсойсон харагдах дургүй байдгийг тооцож харилцах чадвартай байх
- Багш, ажилтан санаа бодол, туршлагаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог бүрдүүлэх зэргийг байгууллагын соёл болгон төлөвшүүлэх шаардлагатай.

Сурагчийн хөгжил, хамгааллын өөрийн үнэлгээ хийх хэрэгсэл

Сурагчийн хөгжил хамгаалалтай холбоотой тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэн үйл ажиллагааны зорилго, зорилт болгон дэвшүүлж, түүнийг сайжруулахын тулд удирдлага, багш, ажилтан өөрийн үнэлгээ хийх нь асуудлыг олж харах гол арга юм.

Үр дүнд хэд хэдэн бодомж асуудал болж байгаа бол ач холбогдлын түвшин, шийдвэрлэх боломжоор нь эрэмбэлж болно.

Хүүхэд хамгааллын асуудлыг илрүүлэх өөрийн үнэлгээний арга



Байгууллагын сэтгэл зүйн уур амьсгалыг судлах өөрийн үнэлгээний арга



“Байгууллагын сэтгэл зүйн уур амьсгалыг үнэлэх аргачлал” (А.А.Урбанович, 2003) - ыг ашиглан сургуулийн харилцааны уур амьсгалыг тодорхойлж, түүнийг сайжруулах арга хэмжээ авч болно.

3.2 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЭРХЭН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ВЭ?

3.2.1 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ СУДЛАХ, ОЙЛГОХ


Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд

- Яагаад нэг хэлээр ярьж, бичиж, ижил утгаар ойлгох нь чухал вэ?

Яагаад гэвэл, сургалтын хөтөлбөрийг уншиж судалснаар дуугарах дуу нэг болж, өмнөх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сайн туршлагаа харилцан хуваалцах, шинэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ойлголтын зөрүүгээ арилгах болно.

Сургалтын хөтөлбөрийг судлахдаа дараах алхамчлалыг баримтлах хэрэгтэй.

Зураг 3.4. Сургалтын хөтөлбөрийг судлах дараалал



Эх сурвалж: боловсруулсан багийн шийдэл

Сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо гэж юу вэ?

Сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо гэдэгт сургалтын хөтөлбөр хоорондоо уялдаатай байж, сурган хүмүүжүүлэх арга зүй болон үнэлгээнд дэмжлэг үзүүлэхийг ойлгоно. Уялдаа холбоо нь хэрэгжилтийг нягт нямбай болгон чанартай үр дүнд хүрэхэд нөлөөлдөг. Сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог дотоод болон гадаад уялдаа холбоонд хамааруулж авч үздэг. Тухайлбал,

- Дотоод уялдаа холбоо нь сургалтын хөтөлбөрийн загвар (дизайн), бүтэц, ахиц дэвшилтэй холбоотой юм.
- Гадаад уялдаа холбоо нь сургалтын хөтөлбөрийн талаар нэгдмэл ойлголттой болгох, нийцтэй байдал, зөвшилцлийн цогц юм.

Зураг 3.5. Хөтөлбөрийн уялдаа холбооны стратеги


Сургалтын хөтөлбөрийг нэгтгэх стратеги	
Хуваагдсан/ Хуваах загвар	Холбох/Холбогдсон
Тайлбар. Сэдвийн хамрах хүрээг саланги болон ялгаатай үзэл баримтлал, чиглэлээр хуваадаг уламжлалт загвар	Тайлбар. Сэдэв тус бүрийн хамрах хүрээнд хичээлийн агуулга нь нэг жилийн эсвэл дараагийн жилийн сэдэв ойлголттой холбогддог.
Жишээ: Багш энэ загварыг Математик, Ш/Ухаан, Нийгмийн ухаан, Хэл судлал эсвэл хэл/хэлний шинжлэх ухаан, хүн судлал, технологи ба дүрслэх урлагт тусгаж ашигладаг.	Жишээ. Багш бутархай тооны ойлголтыг аравтын бутархайтай холбодог. Энэ нь эргээд мөнгө, дүн зэрэгтэй хамаардаг.
Багтах/Багтсан	Дараалсан
Тайлбар. Хичээл бүрийн хүрээнд багш нийгмийн ур чадвар, сэтгэн бодох чадвар, агуулгын тусгай ур чадвар зэрэг олон чадварыг зорилтот түвшинд тавьдаг.	Тайлбар. Хичээлийн сэдвүүд эсвэл нэгжүүдийг хооронд нь давхцуулахын тулд дахин боловсруулж, төстэй санаануудыг эмх цэгцтэй, дараалалд оруулсан байна. Тус тусдаа өөр хичээлүүд ч гэсэн үүнтэй адил санаануудыг тусгаж өгдөг.
Жишээ нь: багш ургамлын амьдралын мөчлөгийн дарааллаар олгох чадварыг фотосинтезийн нэгж дээр суурилан боловсруулдаг.	Жишээ нь: англи хэлний багш тодорхой цаг үеийг дүрсэлсэн түүхэн романыг толилуулж байхад түүхийн багш тухайн цаг үеийг зааж байна.
Хуваалцсан/ дундын	Вебтэй холбогдсон
Тайлбар. Хамтарсан төлөвлөлт, сургалт нь 2 аргаар явагддаг бөгөөд тэдгээрт давхцаж буй үзэл баримтлал, санаанууд нь зохион байгуулалтын элемент болон гарч ирдэг.	Тайлбар. Тухайн сэдвийг сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлийн сэдэвтэй холбож өгдөг ба тохирох ойлголт, ухагдахуун, сэдэв, санаагаар нь ялгадаг.
Жишээ: Шинжлэх ухаан, математикийн багш нар мэдээлэл цуглуулах, диаграмм хийх, график зурах зэргийг багаар заах боломжтой нийтлэг дундын ойлголт болгон ашигладаг.	Жишээ: Багш энгийн түгээмэл сэдвийг бусад агуулгын хүрээтэй холбож өгдөг.
Холбогдсон	Нэгдсэн
Тайлбар. Мета сургалтын арга нь олон янзын аргаар сэтгэн бодох, нийгмийн, оюун ухаан, технологид суралцах чадварыг холбож өгдөг.	Тайлбар. Энэхүү салбар дундын хандлага нь тодорхой сэдвүүдээр давхцаж байгаа агуулгыг нэгдсэн загварт тусгаж заадаг.
Жишээ нь: Багш нар унших, математик, шинжлэх ухааны чиглэлээр таамаглах чадварт чиглэдэг бол нийгмийн ухааны багш одоогийн үйл явдлыг урьдчилан таамаглахад чиглүүлдэг.	Жишээ нь математик, шинжлэх ухаан, нийгэм судлал, дүрслэх урлагийн чиглэлээр багш нар янз бүрийн загвараар дамжуулан агуулгад ханддаг.
Гүн орох	Сүлжээнд холбогдсон
Тодорхойлолт. Энэ хичээлүүд нь сурагчийн мэдлэг, туршлага, ур чадварын нэг хэсэг болж, сурагч бүх агуулгыг энэ өнцгөөр шүүж, өөрийн туршлагаар улам гүн судалдаг.	Тайлбар. Сурагч нь бүх зүйлсийг шинжээчийн нүдээр шүүж, холбогдох салбарын мэргэжилтнүүдийн гадаад сүлжээ рүү хөтлөх дотоод холболтыг хийдэг.
Жишээ нь сурагч бүхнийг шинжлэх сонирхолтой ба мэдлэгийг энэхүү өнцгөөр хардаг.	Жишээ нь архитектор программист мэдлэгийнхээ баазыг өргөжүүлж CAD/CAM технологийг загварчлахад өөрийн мэдлэгийн хүрээгээ ашигладаг.

Хичээл хоорондын залгамж холбоог яагаад хийх хэрэгтэй вэ?

Улс орнууд үндсэн судлагдахуун, суралцах үйл ажиллагаанаас гадна шинэ зууны болон цаг үеийн тулгамдсан асуудал, дэлхийн асуудлыг хөндсөн агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгах хандлагатай болж байна. Жишээлбэл, P21 байгууллага (2009) 21 дүгээр зууны чадвар эзэмшүүлэх цөм судлагдахуун (core Subject) ба судлагдахуун хоорондын сэдэв (interdisciplinary themes)-ийг санал болгожээ.


Сургуулийн удирдлага хичээл хоорондын агуулгын залгамж холбоог гаргахдаа хичээлийг гол цөм гэж үзэн сурагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг ямар зохион байгуулалттайгаар олгох менежментийг хийнэ.

Зураг 3.6. Сурагчдад мэдлэг, чадвар олгох зохион байгуулалт ба менежмент



Салбар хоорондын болон олон салбар дамнасан ойлголтууд нь шинжлэх ухааны салбаруудын хоорондын харилцаанд суурилдаг бөгөөд хичээлийн уялдаа холбооны талаарх ойлголтуудын ялгаа, түвшинг дараах байдлаар тайлбарлаж байна. Иймд сургуулийн удирдлагын баг энэхүү түвшинг баримтлахыг зөвлөж байна.

Зураг 3.7. Хичээлийн уялдаа холбоо, интеграцийн түвшин





АСУУДАЛ


- Багш нар хөтөлбөр боловсруулахдаа бусдын боловсруулсан бэлэн төлөвлөлтийг хуулж, менежерээр батлуулах, харуулах зорилгоор ашигладаг. Хүнээс авсан хөтөлбөрөө уншиж, судалж, өөрийн болгож хэрэгжүүлэх үйл ажиллагаа дутмаг
- Хөтөлбөрийн агуулга их, цаг бага
- Агуулгын залгамж холбоо, нэгж, ээлжит хичээлийн уялдаа холбоог тогтмол хийж, хичээлийг үр дүнтэй болгох тал дээр дутмаг



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн удирдлагууд агуулгын залгамж холбоог тухайн ангид болон хэд хэдэн анги дамнан заах агуулгаар гаргаж ирсэн бөгөөд хичээлийн жилийн төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөө боловсруулах, мөн сурагчийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийхдээ багш нар хэрэглэж байна. Тухайлбал, нэгж хичээлийн төлөвлөлтөд “энэ нэгж хичээл хүртэл юу сурав?”, “энэ нэгж хичээлийн дараа юу сурах вэ? гэдгийг харахын тулд агуулгын залгамж холбооны хүснэгтийг ашигладаг байна.

Хүснэгт 3.1. I-V ангийн математикийн хичээлийн Тоо тоолол агуулгын залгамж холбоо



Хүснэгт 3.2. Судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбоо

		Сургуулийн зорилго, зорилт															Бага боловсролын зорилго															Шалгуур																																																																					
Судлагдахуунууд	Математик	[Сургуулийн зорилго, зорилт]															[Бага боловсролын зорилго]															[Шалгуур]																																																																					
	Хэл	[Сургуулийн зорилго, зорилт]															[Бага боловсролын зорилго]															[Шалгуур]																																																																					
	Урлаг	[Сургуулийн зорилго, зорилт]															[Бага боловсролын зорилго]															[Шалгуур]																																																																					
		I улирлын зорилго															II улирлын зорилго															III улирлын зорилго																																																																					
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	72	73	74	75	76	77	78	79	80	81	82	83	84	85	86	87	88	89	90	91	92	93	94	95	96	97	98	99	100
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	72	73	74	75	76	77	78	79	80	81	82	83	84	85	86	87	88	89	90	91	92	93	94	95	96	97	98	99	100
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	72	73	74	75	76	77	78	79	80	81	82	83	84	85	86	87	88	89	90	91	92	93	94	95	96	97	98	99	100



ЗӨВЛӨМЖ

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын агуулга, арга зүйг интеграцчилах хэрэгцээ, шаардлага үүсэж болно. Энэ тохиолдолд сургуулийн бүх багш хамтарч сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, турших, хэрэгжүүлэх, үнэлэх шаардлага тулгардаг тул сургуулийн удирдлага боломжит цаг хугацааг гаргаж, дэмжин ажиллах хэрэгтэй болно.

Сургуулийн удирдлагууд нэг улиралд нэгээс дээш удаа өөр өөр хичээлийн багш нар хамтран хичээлээ заах цаг боломжийг олгож өгөх хэрэгтэй. Ингэхдээ дан ганц судлагдахууны интеграци бус, бүлэг сэдэв хоорондын (strand integration), бүлэг сэдвийн дарааллын (successive integration), ерөнхий чадварын (skills integration) зэрэг суралцахуйн олон төрлийн интеграцийг хэрэглэхээс гадна арга зүйн интеграцийг хэрэгжүүлж болно.

Зураг 3.8. Хамтарсан хичээл: интеграци, бүлэг сэдэв, арга зүй



Хэд хэдэн судлагдахууны хоорондын агуулгын залгамж холбоог гаргахдаа багш нар хичээлийн жилийн эхэнд үндэсний сургалтын хөтөлбөрөөс хэд хэдэн хичээл судлагдахуунаар судалж (Multidisciplinary integration) болох агуулга /сэдвүүдийн түүвэр жагсаалт гаргана.

Дараа нь юуг, хэн, хаана, хэзээ зохион байгуулахыг сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, тухайн агуулгыг аль хичээлээр хэн, хэрхэн эхэлж орох, хэрхэн үргэлжлүүлэх, хамтран заах боломжоо олж харна.

Хүснэгт 3.3. Интеграци: өргөслө, гүнзгийрэл

Бүлэг	I анги	II анги	III анги	IV анги	V анги
Анги хоорондын залгамж холбоо бүхий суралцахуйн зорилт					
Сэдэв хоорондын залгамж холбоо бүхий суралцахуйн зорилт /сэдэв бичнэ/					
Өргөсөл /кодоор бичнэ/					
Гүнзгийрэл /кодоор бичнэ/					

Зураг 3.9. Судлагдахуун хоорондын залгамж холбоо



Судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбоог гаргахдаа тухайн хичээлийг судлахын тулд өмнө нь судалж, амжилттай үнэлэгдсэн агуулга, эсвэл тухайн хичээлийн дараа судалбал зохих, залгамж холбоо бүхий мэдлэг, ур чадварыг гүнзгийрүүлэх нягт уялдаатай хоёр ба түүнээс дээш судлагдахууны сэдэв агуулгыг (Interdisciplinary integration) зааж өгч болно. Ингэснээр мэдлэгийг тогтсон бүтэц, агуулгаар хуваах буюу сэдэв бүрээр тусад нь олгодог байдлыг өөрчлөх боломжийг

нэмэгдүүлдэг.

Судлагдахууны сургалтын хөтөлбөрийн агуулга, сэдвүүдийг зааж сургах гэхээсээ илүүтэйгээр бусад судлагдахууны агуулгаар баяжуулж, сурагчдад хэт ачаалал үүсгэхгүйгээр нэмэлт сэдвүүдийг хэрэгжүүлснээр салбар хоорондын болон хамтын ажиллагааг хөгжүүлж болдог. (Transdisciplinary integration) Жишээ нь:

- Байгаль орчны боловсрол

- Иргэний ёс зүй, үнэт зүйл
- Эрүүл мэнд сайн сайхан байдал
- Соёлын олон янз байдал
- Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний боловсрол
- Жендерийн эрх тэгш байдал
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох боловсрол

Судлагдахуунуудын нийтлэг сэдэв, үзэгдэлд тулгуурлан хоёр болон хэд хэдэн хичээлийн агуулгыг интеграцчилан боловсруулж, хэрэгжүүлэхийн тулд өөр өөр судлагдахууны багш нар төсөлд суурилсан суралцахуйн загвараар хамтарсан хичээл зохион байгуулах боломжтой. Түүнчлэн бусад судлагдахуунаар юу сурч, эзэмшсэн болохыг мэдэхийн тулд судлагдахууны агуулгын залгамж холбоог боловсруулж ашиглаж болно.

Хүснэгт 3.4. Судлагдахуун хоорондын агуулгын хамаарал

Газар зүй, XII анги

Хотын төлөвлөлт

- Хөгжингүй ба хөгжиж буй орнуудын хот төлөвлөлтийн ялгааг харьцуулах;
- Хот байгуулалтын хэлбэр (төвлөрсөн, радиус, олон цөмт)-ийг тодорхой жишээн дээр тайлбарлах;
- Хотын дахин төлөвлөлтийн загвар боловсруулах;

Дизайн технологи, XII анги

Экстерьерийн төсөл боловсруулах

- Тойм зураг зурах арга техникт суралцах;
- Сонгосон объектын гадна талбайн план зурагт тохижилтын зохиомжийг хайх;
- Зураасны техник ажиллагаагаар зохиомж, өнгө, гэрэл, сүүдрийг зурах;
- Хүн ба хүрээлэн буй орчинг зурах;
- Мод ургамал, автомашин, тавилга эдлэл, материалын шинж чанарыг ялган зурах;

“Биологи” болон “Физик”, XII анги

- Агуулгын хувьд санал болгож буй нэгж хичээлтэй шууд холбогдох суралцахуйн зорилт байхгүй хэдий ч өмнөх ангиудад судалсан агуулгатай холбож болно. Тухайлбал, биологийн хичээлийн хувьд “хүний үйл ажиллагаа амьдрах орчны доройтолд нөлөөлж буйг илрүүлэх” талаас, физикийн хичээлийн хувьд “сэргээгдэх нөөцөөр эрчим хүчийг хангах” талаас судалж болно.

Энэ нь сурагчдын чадваруудыг хөгжүүлж, асуудалд илүү гүн оролцох боломжийг олгодог. Түүнчлэн хичээл хоорондын залгамж холбоог хэрэгжүүлэхэд сургууль, багш нарт олон талын дэмжлэг шаардлагатай. Тухайлбал, өөр өөр хичээлийн агуулгыг уялдуулах, хичээл хооронд ашиглаж болохуйц сургалтын нэмэлт материал боловсруулах, нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх, хичээл хоорондын уялдааг хангасан сургалтыг зохион байгуулахад шаардагдах хэрэгцээт эх үүсвэрүүдийг нэвтрүүлэх гэх мэт олон талын дэмжлэг, туслалцаа байж болно. Жишээ нь: Газар зүйн хичээлээр хот, хотжилт, хот байгуулалтын загварууд гэх мэт суурь ойлголтуудыг судалсан гэж үзээд хот төлөвлөлтийн асуудлыг газар зүй, биологи, дизайн технологи, физикийн хичээлүүдийн хүрээнд нэгтгэж судлах хичээлийн санааг үзүүлэв.

Зураг 3.11. Хэд хэдэн хичээлийн агуулгын уялдаа холбоо



Энэ нэгж хичээлээр дамжуулан сурагч хот төлөвлөх шаардлага, ач холбогдол, үндсэн зарчмуудыг мэдэж, өөрсдийн хэмжээнд төлөвлөлт хийх, ээлтэй хотыг бүтээхэд хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгодог болоход хамтын хичээлийн үр дүн байна гэж үзсэн.

Агуулгын залгамж холбоог хэрхэн хийх вэ?

Судлагдахууны агуулгын залгамж холбооны матриц гаргахдаа дараах алхмаар хийхийг санал болгож байна.

Алхам 1. Тухайн нэг судлагдахууны агуулгын давхардал, давтагдах байдал, өргөсөл, гүнзгийрлийг ялгана.

Алхам 2. Орон нутгийн онцлог, орчин, хэрэглэгдэхүүнээ урьдчилан тооцож, ажиглалт, туршилт, танхимаас гадуурх сургалтын хугацаа, улирлыг төлөвлөнө.

Алхам 3. Агуулга, арга зүйн нэгдлийг харж хичээл, үйл ажиллагааг хамтран төлөвлөнө. Агуулгын залгамж холбооны матрицыг хийхдээ дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- а) Харагдахуйц байдлыг тооцон ай (хамрах хүрээ) тус бүрийг нэг нүүрэнд багтааж, мөрийн дагуу судлах анги, баганын дагуу улирал болон сараар агуулгуудыг ангилна.
- б) Агуулга тус бүрийг Text Box-д аль болох энгийн, товч, тодорхой байхаар томъёолж бичнэ.
- в) Онцгой хамаарал бүхий агуулгуудыг сумаар холбоно. Холбосон агуулга давтагдаж байгаа бол ногооноор, өргөсөж байгаа бол хөхөөр, гүнзгийрч байгаа бол улаанаар текстийг будна гэх мэт

Агуулгын залгамж холбоог гаргаснаар дараах үр дүн гарна. Үүнд:

- Хичээл хоорондын залгамж холбоог гаргаснаар тухайн агуулгыг аль хичээлээр хэн, хэрхэн эхэлж орох, хэрхэн үргэлжлүүлэх, хамтран заах боломжоо олж харна.
- Агуулгын давхардал, давтагдах байдал, өргөсөл, гүнзгийрлийг ялгах боломжтой болно.
- Орон нутгийн онцлог, орчин, хэрэглэгдэхүүнээ урьдчилан тооцож, ажиглалт, туршилт, танхимаас гадуурх сургалтын хугацаа, улирлыг төлөвлөх боломжтой болно.
- Агуулга, арга зүйн нэгдлийг харж хичээл, үйл ажиллагааг хамтран төлөвлөснөөр багш нар нэгдсэн ойлголт, нэг үг хэллэгээр ярих боломжтой болж, сурагчдын ачаалал буурна.
- Сургалтаар дамжуулан сургуулийн зорилго, зорилтыг хэрхэн хэрэгжүүлэхээ хамтран төлөвлөнө.
- Үндэсний хөтөлбөрийг судалж агуулгын залгамж холбоог гаргаснаар:
 - Улирлын онцлогт тохируулах
 - Төсвийн нөхцөл байдлыг харгалзаж үзэх

- Багш хэрэгцээг нь ойлгож, хариуцлагатайгаар авч хэрэглэх боломж олгох
- Улирал болон сараар ялган харуулах нь багшид баримжаа өгөх сайн талтай

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг хамтын ажиллагаа, түншлэл

Орчин үеийн сургуулиуд үр дүнтэй сургалтыг зохион байгуулахын тулд хамтын болон ил тод байдлаар, багаар болон мэргэжлийн байгууллага, нийгэмлэгүүдтэй хамтрах нь чухал байдаг.



АСУУДАЛ

- Багш ажилтны хамтын ажиллагаа дутмаг, үйл ажиллагааны эргэх холбоо уялдаа муутай байсан
- Судалгаат хичээл зохион байгуулдаггүйгээс багш нар хамтран ажиллах, харилцан суралцах чадвар сул
- Багийн хамтын ажиллагаа сул
- Удирдлагын баг шинэ



ЗӨВЛӨМЖ

Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг (орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгэм, эцэг эх, орон нутгийн хамт олон) өргөнөөр оролцуулах шаардлагатай байдаг.

1. ОРОН НУТГИЙН ЗАСАГ, ЗАХИРГААНЫ ТҮНШЛЭЛ

- Засаг даргын тамгын газар
- Иргэдийн хурал
- Төрийн байгууллагууд
- Хувийн хэвшлийн байгууллагууд
- Хандивлагч байгууллагууд
- Сургууль
- Орон нутгийн иргэд

2. СУРГУУЛИЙН ДОТООД ТҮНШЛЭЛ

- Сургуулийн удирдлага
- Багш
- Сургуулийн бусад ажилтан
- Хандивлагч байгууллагууд
- Орон нутаг/олон нийт
- Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч
- Сурагч

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд талуудыг хэрхэн оролцуулах вэ?

Оролцогч талуудыг тулгарч буй асуудал, бэрхшээлийг даван туулах арга замыг хайх, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах нь нэн тэргүүний асуудал юм. Иймд оролцогч талуудыг татан оролцуулах хэд хэдэн аргыг санал болгож байна. Үүнд:

- *Орон нутгийн болон үндэсний түвшний* бодлогын шийдвэр гаргах албан тушаалтнуудыг оролцуулах
- Мөн бүлэгт эрдэмтэн судлаачид, ТББ, улс төрийн нам, шашны болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бүлгүүд, багш нарын холбоо, сургуулийн төлөөлөл багтаж болно. Эдгээр нөлөө бүхий албан тушаалтнуудад орон нутаг сургуулийнхаа сурагчдыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг мэдээлэх, танилцуулах, сургалт, үйл ажиллагааны талаар шуудан, цахим шуудангаар холбоо барих, мэдээлэл, санал бодлоо солилцох зорилгоор зөвлөлдөх уулзалтад урих байдлаар оролцооны түвшинг нэмэгдүүлж болно.
- *Хэвлэл, мэдээллийг татан оролцуулах:* Олон нийтийг хамарсан арга хэмжээ, товч танилцуулга, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний сэтгүүл гэх мэт харилцаа холбооны төрөл бүрийн арга, хэлбэрээр дамжуулан илүү өргөн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь ашиг тустай байж болно. Түүнчлэн нийт ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, сурагчдыг мэдээллээр хангах, үйл ажиллагаанд татан оролцуулах нь сургуулийн амьдралд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх боломжтой.
- *Багш нарыг татан оролцуулах:* Хамгийн чухал оролцогч тал бол багш юм. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл явцад шууд оролцдог багшийн оролцоо дараах онцлогтой. Үүнд:
 1. Хамтран ажиллаж, мэдлэгээ хуваалцаж, үйл явцад тэгш хувь нэмэр оруулдаг.
 2. Багш сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар мэдлэг, туршлага, ур чадвар хэрэгтэй вэ гэдгийг ойлгохын тулд оролцдог.
 3. Багшийн оролцоо улам бүр түгээмэл болж байгаа боловч тэдний цаг хугацаа хязгаарлагдмал байдаг тул нэмэлт үүрэг хариуцлага хүлээхэд ажлын ачаалал ихэсдэг, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаанд саад болдог захиргааны дарамт, шахалттай тулгардаг зэрэгтэй холбоотой юм. Инновац туршилтын төслүүдэд оролцож буй багш нар хувь хүний болон мэргэжлийн хувьд хөгжиж, санал болгож буй өөрчлөлтүүдийн талаар гүн гүнзгий ойлголттой болж чаддаг.

4. Санал болгож буй сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн үнэ цэн, сурагчдын оруулах хувь нэмрийг тэдэнд ойлгуулахад албан болон албан бус хэлбэрээр таниулдаг.

Сургуулийн удирдлага, багшийн хамтын ажиллагаанд анхаарах зүйлс:

- Сурагчдын үнэлгээг багш хамтран хийх менежментийг хэрэгжүүлэх;
- Үр дүнд шинжилгээ хийхэд хамтарч хичээл заах, цаг ашиглах боломжийг бүрдүүлэх;
- Багш боломжтой цагаараа бусад багшийн хичээл, сургалтад дэмжлэг үзүүлэх;
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг хамтран бэлтгэх, хэрэглэгдэхүүний нэгдсэн сан бүрдүүлэх;
- Бүлэг сэдвийн үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэхэд багш хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх;
- Дотуур байранд амьдардаг сурагчдад зориулсан хөгжүүлэх үйл ажиллагаанд багшийг татан оролцуулах;
- Багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор тусгайлан авч үзэж, зөвлөмжид тусгасан чиглэлийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Багш, эцэг эхийн хамтын үйл ажиллагаанд анхаарах зүйлс:

- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эерэг туршлагыг судалж, цаашид хүүхдийн сурах арга барил, мэдлэг, чадвар эзэмших үйл ажиллагаанд гэр бүл, олон нийтийн оролцоо, сургууль, багштай хамтран ажиллах боломжийг бүрдүүлж ажиллах
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийнхээ боловсрол, хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чадварыг хөгжүүлэх
- Сурагчдын суурь чадвар, мэдлэг, чадварын түвшин, сурах арга барилын онцлог ямар байгаа талаар мэдээллээр хангах
- Сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэхэд хүүхэддээ эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн нөхцөлд ямар дэмжлэг үзүүлэх талаар багш хамтран зөвлөгөө өгөх
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хурлыг хичээлийн жил эхэлмэгц, мөн сарын дараа сурагчийн хөгжилд ямар ахиц гаргасан талаар мэдээлэл өгөх хурлыг дахин хийх

3.2.2 СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ТӨЛӨВЛӨХ ВЭ?



АСУУДАЛ

Сургуулийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулахад тулгамдаж буй нийтлэг асуудал

Сургалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа ихэвчлэн агуулгын хуваарилалтыг хийж байна. Тодруулбал, ямар агуулга, нэгж хичээлийг хэзээ, хэдэн цагаар орохыг л төлөвлөдөг.

Төлөвлөхийн өмнөх нийтлэг асуудал:

- Сургалтын хөтөлбөр уншсан боловч бүрэн судлаагүй, багш нарын ойлголт ялгаатай
- Хүүхдэд тулгамдаж буй асуудлыг нэгтгэх (судлагдахуунаар, ангиар, боловсролын түвшингээр) байдал сул
- СҮДШ-ын талаарх ойлголт сул (үнэлгээ)


Төлөвлөхөд гарч буй нийтлэг асуудал:

- Багш, ажилтан, удирдлагын хамтын ажиллагаа сул
- Сургалтын хөтөлбөрт суурилсан хүүхдийн хөгжлийг цогцоор нь дэмжсэн сургуулийн зорилготой уялдаа бүхий сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт ховор (Сургуулийн зорилго, зорилт, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний уялдаа алдагдсан)

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөө

- Үйл ажиллагаа бүр өөр өөр зорилготой, салангид
- Сургуулийн зорилготой уялдсан эсэх нь бүрхэг
- ХГҮА болон СҮА-ны уялдаа сул, хамтарч гаргаагүй, тус тусдаа төлөвлөгдсөн

Зураг 3.12. Сургуулийн төлөвлөлтийн уялдаа холбоо



Төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?

Сургууль менежментийн зураглалд үндэслэн тухайн жилийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дээрх бүдүүвчийн дагуу сургалт, үйл ажиллагаанд оролцогч бүх талууд өөрсдөдөө холбоотой ажлыг түвшин бүрдээ нэгтгэн, сургуулийн удирдлага, менежментийн баг сургуулийн жилийн нэгдсэн төлөвлөгөөг гаргана. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, зохицуулах зорилгоор календарчилсан төлөвлөгөөг жил болон сараар уян хатан, хөдөлгөөнтэйгөөр гаргадаг.

Дээрх бүдүүвчийн дагуу нэг ба хоёр дугаар түвшний төлөвлөлтүүд сайн хийгддэг ба харин дунд шатны нэгжүүдэд төлөвлөлтийг нэгтгэх үйл ажиллагаа дутуу хийгддэгээс сургууль дээр олон саланги төлөвлөлтүүд хоорондоо уялдаагүй хэрэгжиж багш сурагчдад хиймэл ачаалал үүсгэдэг. Дунд шатны болон нэгдсэн төлөвлөлтийг сайн хийх нь олон саланги үйл ажиллагааг уялдуулан нэгтгэх, багш сурагчдын ачаалал буурах, ачааллыг тэнцвэржүүлэх боломж бүрддэг.

Анхан шатнаас гарч ирсэн /судлагдахуун тус бүрийн жилийн (Хүснэгт 1 буюу 94-р хуудасны судлагдахууны нэг ангийн агуулгын жилийн төлөвлөлт), сурагч, анги удирдсан багшийн, клуб, дугуйлан секц, ажилтны.. /төлөвлөлтийг ЗАН, анги нэгдэл болон аж ахуйн албаны түвшинд

нэгтгэнэ. Ингэхдээ ЗАН-ийн түвшинд судлагдахууны босоо болон хөндлөн, анги нэгдлийн түвшинд тухайн ангийн хичээлүүдийн залгамж холбоог, клуб, дугуйлан секцийн төлөвлөлт, хичээлээс гадуурх үйл ажиллагааг нийгмийн ажилтан анхан шатнаас гарч ирсэн саналын давхардлыг арилгах замаар сургуулийн зорилт болон сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг чадвартай уялдуулан нэгтгэн гаргах нь чухал.

Нэгтгэж харахыг хүсэж байгаа бүх зүйлийг нэг төлөвлөгөөнд буулгах амаргүй юм. Тиймд сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг дараах 2 хэлбэрээр боловсруулж болно. Эдгээр төлөвлөлт нь **шинээр нэмэлт ажил хийж байгаа бус** багш бүрд тус тусдаа хавтсанд байдаг салангид төлөвлөлтүүдийг зорилго, чиглэлээр нь нэгтгэж, хүүхдийг хөгжүүлэх боломжийг уялдаанд нь авч үзэхэд дөхөм болгож буй явдал юм. Үүнийг бага боловсролын жишээн дээр үзүүлбэл,

Жишээ 2. Судлагдахууны зорилго, зорилттой уялдсан төлөвлөгөө

Хүн ба орчин, хүн ба байгаль хичээлийн 1-5 дугаар ангийн агуулгын нэгдсэн төлөвлөгөө (Тухайн судлагдахууны жилийн төлөвлөгөөг боловсролын түвшингээр нэгтгэн харуулна. Ингэхдээ ээлжит хичээл бүрээр эсвэл суралцахуйн зорилтоор нэгтгэж болно).

Энэхүү төлөвлөгөөнд тухайн судлагдахууны (Хүн ба орчин, Хүн ба байгаль) 1-5 дугаар ангийн бүх хичээлийг нэгтгэж, уялдаа холбоог тэмдэгт юм уу өнгөөр ялгаж тэмдэглэнэ. Ингэснээр сурагчдад байгалийн ухааны хичээл дээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд (МЧХ) дэмжлэг үзүүлэх хичээлүүдийг (тухайн МЧХ-ыг хөгжүүлэх давтамжийг тооцох) харах боломж бүрдэнэ.

Хүснэгт 3.5 Судлагдахууны зорилго, зорилттой уялдсан төлөвлөгөө

2023-2024 оны хичээлийн жилийн 1-5 дугаар ангийн Хүн ба орчин, Хүн ба байгаль хичээлийн нэгдсэн төлөвлөгөө								
Улирал	I		II		III		IV	
Анги	9	...	11	...	1	...	4	..
I		Δ		Δ		Δ		
II				Δ			Δ	
III		Δ		Δ				
IV			Δ				Δ	
V	Δ				Δ			

Тайлбар: Хүснэгтийн нүд бүрд ээлжит хичээлийн сэдэв юм уу суралцахуйн зорилт байна.

	Зургаар илэрхийлэх чадвар
Δ	Нягт нямбай хандах байдал

Жишээ болгож авсан илэрхийлэх чадвар болон аливаад нягт нямбай хандах хандлага нь тухайн сургуулийн сурагчдад тааруу хангалтгүй байж болох юм.

Тэгвэл үүнийг системтэй хөгжүүлж болох зураглалыг судлагдахууны нэгдсэн төлөвлөлтөд тусгах боломжтой. Дээрх төлөвлөлтийг судлагдахуун бүрээр боловсролын түвшингээр нэгтгэн хийх шаардлагатай.

Хүснэгт 3.6. Судлагдахууны нэгдсэн төлөвлөгөө

Учраг	Судлагдахууны нэгдсэн төлөвлөгөө (Хүн ба орчин, хүн ба байгаль, 1-5 дугаар анги)									
	Iр урварт		Iр урварт		Iр урварт		Iр урварт		Iр урварт	
I анги	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)
II анги	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)
III анги	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)
IV анги	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)
V анги	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Миний нэгдсэн үзэгдэл (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Сонгохуйн гаймаа (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)	Орчин үеийн үзэгдэл (8 үг)
Суралцахуйн Аргаар	1. Суралцахуйн аргаар тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 2. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 3. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 4. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 5. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 6. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 7. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 8. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ?		1. Суралцахуйн аргаар тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 2. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 3. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 4. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 5. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 6. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 7. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 8. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ?		1. Суралцахуйн аргаар тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 2. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 3. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 4. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 5. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 6. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 7. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 8. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ?		1. Суралцахуйн аргаар тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 2. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 3. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 4. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 5. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 6. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 7. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 8. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ?		1. Суралцахуйн аргаар тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 2. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 3. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 4. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 5. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 6. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 7. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ? 8. Тухайн үзэгдэл нь ямар чиглэлтэй вэ?	
Учир	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл	Миний үзэгдэл

Мэдлэг, чадвар, хандлагаараа уялдсан хичээлүүд дээр судлагдахуунд суурилсан "ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА"-г хийж тухайн чадварыг хөгжүүлэх заах аргын шинэ санааг бий болгох бүрэн боломжтой. Энэ нь тухайн жил хийгдэх хичээлийн судалгааны "СЭДЭВ" болдог.

Төлөвлөгөөний загварууд нь сургууль бүрд ижил байх албагүй. Гэхдээ ерөнхийдөө дараах зүйлсийг багтаасан байх ёстой. Үүнд:

Тус төлөвлөлтөд тусгах зүйл

1. Тухайн ангийн судлагдахууны суралцахуйн зорилт, ээлжит хичээлийн сэдвүүдийг хичээл орох хугацаанд харгалзуулан байршуулах
2. Холбоо хамаарлыг харуулах
3. Тухайн судлагдахуунаар илүү хөгжүүлэхийг хүсэж буй мэдлэг, чадвар, хандлагын уялдааг ялган тэмдэглэх

- Нэгж хичээлийн сэдэв, эсвэл суралцахуйн зорилт (зарим сургуулийн хувьд ээлжит хичээлийг тусгасан байдаг)
- Хичээл хоорондын уялдаа холбоо
- Сургуулийн зорилттой уялдсан хичээлийн давтамж

Жишээ болгож авсан бие даан суралцах болон асуудлыг хамтарч шийдвэрлэх чадвар нь тухайн ангийн эсвэл бага, дунд, ахлах ангийн түвшинд сурагчдад тулгамдсан асуудал байж болох юм.

Тэгвэл үүнийг системтэй хөгжүүлж болох зураглалыг ангийн нэгдсэн төлөвлөлтөд тусгах боломжтой.

Хүснэгт 3.7. Төлөвлөлт (ангиар)

2023-2024 оны хичээлийн жилийн 5 дугаар ангийн нэгдсэн төлөвлөгөө								
Улирал Судлагдахуун	I		II		III		IV	
	9	...	11	...	1	...	4	..
Монгол хэл		*		*		*		
Математик				*			*	
Хүн ба байгаль		*		*				
Эрүүл мэнд			*				*	
Биеийн тамир г.м	*				*			
Тайлбар: Хүснэгтийн нүд бүрт ээлжит хичээлийн сэдэв юм уу СЗ байна.								
	Бие даан суралцах- гэрийн даалгавар							
*	Багаар ажиллах- асуудлыг хамтарч шийдвэрлэх чадвар							

Анхаарах зүйл

- Багшийн жил бүр судлагдахуунаараа хийдэг төлөвлөгөөг нэгтгэж сургуулийн нэгдсэн төлөвлөгөөг дээрх 2 хувилбараар гаргаж байна. Иймд сургууль дээр сургалтын хоёр л төлөвлөлт байх юм байна гэж ташаа ойлгож болохгүй.
- Дээрх нэгдсэн төлөвлөгөөг захирал, сургалтын менежерийн удирдлагын дагуу багш нар нэгдэж гаргана. Төлөвлөгөөний биелэлт ч мөн удирдлагад шууд хамааралтай болно.

Хүүхэд хөгжил, хамгааллын нэгдсэн төлөвлөгөө

Хүүхэд хөгжил, хамгааллын нэгдсэн төлөвлөгөө нь анги удирдсан багш, нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйч, клуб, дугуйлан, секцүүд зэрэг анхан шатнаас гарч ирсэн хичээлээс гадуурх олон үйл ажиллагааны төлөвлөлтийг хүүхэд хамгааллын баг, сургуулийн зорилго, зорилт болон сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг, чадвартай уялдуулан нэгтгэж, давхардлыг арилгаж гаргах нь чухал.

Хүснэгт 3.8. Хүүхэд хөгжил хамгааллын нэгдсэн төлөвлөгөөний уялдаа

Энгийн Сур	7 нэгж	хүүхдийн нэгжлийн дэвсгэв					хүүхдийн өвчлөлөг дэмжих			хүүхэд хамгааллын үйлчилгээ		Тогтмол явагдах ажил	
		Хүүхдийн эрх зөвхөөрх талварыг сургалт	Амьдрал үз чадварыг сургалт	Эрүүл мэндийн асуудлыг үзүүлэх сургалт	Урлаг, гэр бүл нэгжлүүх сургалт	Танин мэдлийн нэгжл	Өвч бэлдсэн нэгжл	Олон нийт, эзний өргөцрө	Хүүхдийн эрх зорихыг байгуулага	Гэр бүлийн эрх зорихыг хамгаалах	Сургуулийн эрх зорихыг хамгаалах		Моймлын эрх зорихыг хамгаалах
1,2 үндэс	1		4, 6 настуйдын дэсгэр зорихыг сургалт		2. сургууль, дотуур байрныг танилцуулах	7. үндэрийн цаг		3. өвч хүүхдүүд		7. үндэс гэр бүл	1. хүүхэд хамгааллын харуу үйлчилгээ		
	2	1. хүүхдийн эрх зорихыг талварыг ерөнхий ойлголт		1,3. нийэм уржигүйн боловсрол		5. Сошиолтой шинжлэг ухаан				2. суралчдын цагийг хуваарийг гэрлэх, танилцуулах		Санал хүсэлтийг байрцаг ажиллуулах	
	3		4. мэдлэг, хүндлэг өс					2. хүүхдийн хурал				6. сэтгэлгүйн мэдлэг	Сургуулийн тохиолот үйл ажиллагаанд байгуулага, нэгдэл, олон нийтийн оролцоог хангах
	4		3. Гэр утга (галдралт мөнөөсг өрөмбөг)		5. Ажил ба хөгжл	2. Оюун ухаан, сэтгэлийн наадам, үйл ажиллагаа		2. бичиг, амьсганд хурал			6. стресс менежмент		
	5				2. Мөнгө өсгөх, амьсг, сойлом талвар	2. спортын эргэ хөгжл							
10-р сар	6	1. хүүхдийн эрх зорихыг мэдэглэх			5. тасалт хөгжл		1. сургуулийн үндсэн зөвлөлөгсгэриг хий				1.6. ганцаарчлалын харуулага	6. "Моймол ба бэ" зөвлөлөгсгэриг хий	Дотоод мөрг боломжилд тулгуурлан дуулианг амьсглуулах
	7	2. бичиг зөв зорихыг зөв талварши		6. сэтгэлийн гэр сайхан	7. эргэ үндэс	2. Оюун ухаан, сэтгэлийн наадам, үйл ажиллагаа			1. дотуур байрны хөгжлөгсгэриг хүүхдийн эрх зорихыг гэрлэх				
	8		3. шүүд утга (амьсг мөндийн эргүүл мөнд)			2. спортын эргэ хөгжл							Хүүхдийн өвчлийн удирдлагын байгууллагыг байгуулах, танилцуулах ажиллуулах

Мэргэжлийн дэсгэр ажилтнууд тус тусын амьсгг харууцан гүйцэтгэг болон хамтын ажиллагаанд тулгуурлан бусдын дэмжлэгийг авч нэ чуул.

1	2	3	4	5	6	7
Суралчдын амьсггын мэдлэг	Ажил үндэсдэн бэлтхийн харууцан гүйцэтгэг ажил	Сургуулийн мөнгөний харууцан гүйцэтгэг ажил	Дотуур байрны бэлтхийн харууцан гүйцэтгэг ажил	Суралчдын менежерын харууцан гүйцэтгэг ажил	Сэтгэлгүйн	Нөмөрлөгсгэриг

Зорилт 1
Зорилт 2

Тус төлөвлөлтийг боловсруулахдаа

- Сургуулийн зорилго, зорилттой уялдуулах
- Хүүхэд хөгжил болон хүүхэд хамгааллын асуудлыг цогцоор нь авч үзэж сургалтын хөтөлбөрөөр эзэмших мэдлэг чадвартай уялдуулах
- Сурагчийн санал санаачилгад тулгуурлах, оролцоог жигд хангах
- Анхан шатнаас гарч ирсэн төлөвлөлтийн давхардлыг арилгаж, багш, сурагчдын ачааллыг тооцох, тэнцвэржүүлэх
- Олон талын оролцоог хангах, дэмжлэг авах, эцэг эх, асран хамгаалах, харгалзан дэмжигч тогтмол оролцуулах, хөгжүүлэх
- Бусад байгууллагуудын /цагдаа, эрүүл мэндийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, боловсрол шинжлэх ухааны газар, төрийн бус байгууллагууд.../ төлөвлөлтүүдийг хичээлийн жилийн эхэнд авч сургуулийн төлөвлөгөөнд тусгадаг байх
- Үйл ажиллагаа бүрийн дараа оролцогчдоос судалгаа авч байнга сайжруулдаг байх

Сургуулийн нэгдсэн төлөвлөгөө

Сургуулийн менежментийн зураглалын дагуу сургуулиас дэвшүүлсэн сургалтын зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахын тулд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хүүхэд хөгжил, хамгааллын нэгдсэн төлөвлөгөө, сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн сургуулийн нэгдсэн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулдаг.

Зөвлөмжийн 1-р бүлгийн хичээлийн жилийн менежментийн зураглал болон 3.4-р хэсгийн сургуулийн тухайн хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт сэдвээс хараарай.



ЗӨВЛӨМЖ

Жилийн төлөвлөлтийн загвар 1. Судлагдахууны зорилго, зорилттой уялдсан төлөвлөгөөг нэг багш хийхэд хүндрэлтэй байдаг. Иймд ЗАН эсвэл мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтарч боловсруулна.

Жилийн төлөвлөлтийн загвар 2. Сургуулийн зорилго, зорилттой уялдсан төлөвлөгөөг нэг багш хийх боломжгүй тиймд тухайн анги нэгдэл, 5-р ангийн бүх багш хэрэв суурь боловсрол бол 7-р ангид хичээл заадаг бүх багш нараараа хамтарч боловсруулна.

- Сургуулийн зорилго, зорилт болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэх нэгдсэн “УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ийг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулахыг зөвлөж байна. Нэгдсэн уулзалтаас өмнө ЗАН, МХБ, анги нэгдлээрээ уулзсан байх ёстой.

Зураг 3.14. Хэлэлцүүлгийн зохион байгуулалт



Тайлбар: Б- бага боловсрол, С- суурь боловсрол, БД- бүрэн дунд боловсрол

Үүний дараа бага, дунд, ахлах ангийн түвшинд хэлэлцсэн үр дүнг (давуу тал, тулгамдсан асуудал түүний шалтгаан, шийдэл) нэгдсэн УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ танилцуулж, цаашид хичээлийн жил дуусахаас өмнө эсвэл дараагийн улиралд юунд анхаарах, бидний хэрэглэж буй арга болж байна уу үгүй юу гэдгийг нарийвчлан ярилцаж бүх хүний оролцоо саналд үндэслэсэн шийдвэр гаргана.

Сургуулийн удирдлага, захирал нь уулзалт, хэлэлцүүлгээс гарсан санал, шийдвэрт үндэслэн шаардлагатай дэмжлэг (оновчтой зохион байгуулалт, мэргэжлийн удирдлага, манлайлал, хичээл сургалтын орчин бүрдүүлэх, багшийн хөгжил, эцэг, эх олон нийтийн оролцоог хангах)-ийг тухай бүр үзүүлж ажиллана.

3.2.3 СУРАЛЦАХУЙ БА БАГШЛАХУЙ (СУРГАЛТЫН АРГА ТЕХНОЛОГИ)

Сурагчийн бие даан суралцахуйг дэмжих нь яагаад чухал вэ?

Бие даан суралцахуйтай холбоотой олон янзын нэр томъёо, ойлголт байдаг. Эдгээрээс хамгийн ерөнхий хэрэглэгдэж буй нь “өөрийн удирдлагатай суралцахуй” юм. Үүнд сурагч суралцахуйгаа ойлгох, суралцахуйд сэдэл тэмүүлэлтэй, хариуцлагатай оролцох, багштай хамтран суралцахуйн орчныг бүтэцчилхэд оролцох зэргийг багтаадаг. Бие даан суралцах гэдэг нь сурагч ганцаараа суралцана гэсэн утга биш юм. Сурагч мэдлэг, мэдээллийг идэвхгүй хүлээн авагч, багшийн зааврыг хүлээгч, багшаас хараат байдалтай суралцах бус харин өөрийн суралцахуйг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, өөрийгөө үнэлэх, өөрийн суралцах үйл ажиллагаагаа хянах чадварт суралцах нь чухал байдаг.



АСУУДАЛ

- Сурлагын амжилт хангалтгүй (48,7%)
- Сурагчийн бие даан суралцах чадвар сул
- Бага ангийн сурагчдын ойлгон унших чадвар сул
- Бага, дунд, ахлах ангийн монгол хэл, математик, байгалийн ухааны хичээлийн сурлагын амжилт сул
- Сурагчийн дэвтрийн тэмдэглэл хангалтгүй, үлдэц бага



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

“Үсгэн өрөг”-ийн дугуйланг тусгай хуваарийн дагуу хичээллүүлж эхэлсэн. Энэ дугуйланд 1-5 дугаар ангийн бүх сурагч хамрагдсан. Үүний үр дүнд:

1. Үгийн баялаг нэмэгдсэн.
2. Шинэ үгийг тогтоох чадвар сайжирсан.
3. Хурдтай сэтгэдэг болсон.
4. Шинийг эрэлхийлэх сонирхол нэмэгдсэн.

Сурагчдын цээжээр бичих чадварыг хөгжүүлэх зорилгоор “**НАНДИН**” сонсдог картыг 1-5 ангийн нийт сурагч хичээлдээ болон гэрийн даалгаварт ашиглаж хэвшсэн. Ингэснээр сурагчид ухаалаг утсыг зөв ашиглах, бие даагаад гэрийн даалгавраа хийх боломжтой болсон.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Өглөө бүр ном унших, уншлагын хурдыг тэмдэглэх, эхээс ойлгосон зүйлээ хүснэгтийн аргаар болон зурган хэлбэрээр бичиж зурах, сэтгэгдлээ ярих, эхэд задлан шинжилгээ тогтмол хийснээр эхийг унших, ойлгох чадварт ахиц гарсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

“Байгалийн ухааны өртөөгөөр аялъя” интеграци хичээл зохин байгуулсан нь сурагчдыг байгалийн ухааны хичээлд дурлах, тэдний сонирхлыг татах үр дүнтэй хичээл боллоо.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

“Самбар төлөвлөлт, дэвтрийн бичиглэл” 7 хоног аян сар бүр тогтмол зохион байгуулж хэвшсэнээр сурагчдын дэвтрийн үйл ажиллагаа 2 сарын хугацаанд 30.0 хувиар сайжирсан. Самбар төлөвлөлт сайн багш нарын төлөвлөлтийг бүх багш, эцэг эх, асран хамгаалагч, харилцан дэмжигчдэд хүргэсэн нь үр дүнтэй болсон

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн удирдлагын зүгээс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багшид дэмжлэг үзүүлнэ.¹¹

- Сурагч бүрд суралцахуйн замын зураг бий болгож, одоо хаана байгаа, цаашид хаана очихоо мэдэхэд туслах хэрэгтэй.
- Сурагчид өөрийн суралцахуйн зорилгоо тодорхойлох, сонгох боломж олгох
- Алхам алхмаар ядралгүй суралцах боломжийг төлөвлөн, зохион байгуулах. (Явцын үнэлгээнд суурилах, асуулт асуух, харилцах)
- Харилцааг хөгжүүлэх
- Анги, гэрийн даалгаврын биелэлт, эргэх холбоог сайжруулах
- Хамтын ажиллагааг дэмжих
- Эргэцүүлэлт сургалтын арга хэрэглэх. Өдөр тутмын суралцахуйн үр дүнгийн тэмдэглэл, суралцахуйн гэрээ байгуулах гэх мэт арга хэрэглэх.

¹¹ БХ. Сурагчийн бие даан суралцах дасгал ажлын дэвтэр. 9 цуврал бичлэг https://www.youtube.com/watch?v=z2-_H6E1eUw

Багш сургалтын арга зүйгээ өөрчлөхийг яагаад чухалчилж байна вэ?

Мэдээллийн эрин зуунд өөрт хэрэгтэй мэдээллийг хүссэн газраасаа хүссэн цаг хугацаандаа олж авах асуудал чухал болоод байна.

Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд Боловсрол эзэмших сургалтын хэлбэрийг дараах байдлаар тусгасан.

- 8.1. Сургалт нь танхимын, танхимын бус, эдгээрийг хосолсон хэлбэрийн зохион байгуулалттай байна.
- 8.2. Бага ангийн сургалтыг заавал танхимаар зохион байгуулна.
- 8.3. Танхимын бус сургалтад зайн, дэмжигч болон явуулын багшийн, цахим сургалт хамаарна.
- 8.4. Тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчид ганцаарчилсан сургалт явуулж болно.



АСУУДАЛ

Хичээл төлөвлөлттэй холбоотой	<ul style="list-style-type: none">- Сургалтын хөтөлбөрөө уншиж, өөрийн болгож хэрэгжүүлэх үйл ажиллагаа дутмаг- Багш бүрийн хичээлийн бэлтгэл хангалтгүй
Нээлттэй эх сурвалж ашиглахтай холбоотой	<ul style="list-style-type: none">- Багшийн medle.mn нэвтрэлт, ашиглалт хангалтгүй- Багшийн хариуцлага, интернэтийн орчин, багшийн МХТ-ийг ашиглах чадвар сул- Бэлэн эх сурвалжуудыг (medle.mn дасгал ажлын хуудас, видео хичээл) шууд хэрэглэж байгаа.
Багшлах арга зүйг сайжруулахтай холбоотой	<ul style="list-style-type: none">- Анги дүүргэлт их багш дутагдалтай байгаа нь багш төвтэй, идэвхтэй бус сургалтын арга давамгайлахад нөлөөлсөн.- Багшийн асуулт даалгавар нь сурагчдыг сэдэлжүүлэх, мэдлэг бүтээхэд чиглэхүйц биш, багшийн яриа, тайлбар давамгайлсан, бэлэн мэдээлэл өгсөн, уламжлалт хандлагатай хичээлүүд давамгайлж байна.- Ээлжит хичээлд сурагчдын ялгаатай түвшинг харгалзаж хөгжүүлдэггүй- Бүх сурагчид сурах бичгийн даалгавар ажиллуулдаг- Гэрийн даалгаврыг хүүхэд бүрд ижил түвшинд өгдөг хэдий ч шалгадаггүй



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Багш бүр сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, арга зүйн зөвлөмж, үнэлгээний шалгуур зөвлөмж зэргийг судлан заах арга зүй, хичээлийн явцын үнэлгээнд тусган ажиллаж, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтөө сайжруулсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

“Зорилготой 40 минут”, “Оновчтой хэрэглэгдэхүүн” ээлжит хичээлийг үе шаттайгаар зохион байгууллаа.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

8 платформыг идэвхтэй ашиглаж, хичээл, сургалт, хөтөлбөр, төлөвлөлтдөө тусган ажиллав.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Судалгаат хичээл зохион байгуулснаар багш нар хичээлээ хамтран бэлтгэх, төлөвлөх, хэлэлцэх, үнэлэх, дүгнэх, шинжилгээ хийх чадварт ахиц өөрчлөлт гарсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Зарим дутагдалтай байгаа мэргэжлийн багшийн хичээлийг 7 хоног бүрийн Бямба гаригт нэмэлт хичээлээр зохион байгуулсан. 8 сургууль сургуулийнхаа стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах талаар заалтыг нэмж оруулсан.

... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн удирдах ажилтан нь багш нарт дараах зөвлөмжийг хүргэж ажиллах хэрэгтэй.

Анги танхим дахь хүүхдийн тоо их байх нь асуудалд олон ургалч үзлээр хандах, асуудлын шалтгааныг олон талаас нь олж харах сурагч төвтэй сургалтыг зохион байгуулах нэг гол хөшүүрэг болдог тул олон хүүхэдтэй ангид ээлжит хичээлийг удирдан зохион байгуулах аргад суралцах нь багшийн өмнө тулгамдаад байгаа бас нэг асуудал юм. Сурагч төвтэй суралцахуйг хэрэгжүүлэхийн тулд багш туршигдаж нотлогдсон, сургалтын онолд суурилсан арга зүйгээр ээлжит хичээлийг удирдан чиглүүлэх нь хичээлийн явц дахь багшийн ачааллыг багасгаж, сурагчийн сурах арга барилд ахиц гаргах нэг түлхүүр болно. Багш ээлжит хичээлийн явц дахь

ачааллаа бууруулахын тулд хичээлийн бэлтгэл судалгаа болон хичээл төлөвлөлтийг боловсруулахад хамтран ажиллаж, цаг зарцуулах нь чухал юм.

Бэлэн арга зүйгээр Workshop, хэлэлцүүлэг өрнүүлэх ба сурагч төвтэй, оролцоонд суурилсан бүтээлч арга зүйн загваруудыг дараах эх сурвалжаас уншиж судлаарай.¹²

1. Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүй (Problem-Based Learning - PBL)
2. Үзэгдэлд суурилсан сургалтын арга зүй (Phenomenon-Based Learning -PhBL)
3. Хэл агуулгыг интеграцчилах арга зүй (Content Language Integrated Learning -CLIL)
4. Төсөлд суурилсан сургалтын арга зүй (Project-Based Learning -PrBL)
5. Даалгаварт суурилсан сургалтын арга зүй (Task based learning)
6. Тонгоруу сургалт (Flipped learning)-ын арга зүй
7. Ялгаатай суралцахуйн арга зүй (Different learning - Differentiated instruction)
8. Ганцаарчилсан сургалтын арга зүй /тэгш хамруулан сургах боловсролын жишээн дээр/

Мэдээллийн технологийн хөгжлийг ашиглан чанартай, хэрэгцээтэй мэдлэг, боловсрол олгох, эзэмшихийн тулд боловсрол олж авах хэлбэр нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран, чөлөөтэй сонгон судлах бололцоог олгох шаардлага тавигдаж байна. Сургууль бүр өөрийн сургуулийн сурагч, багшийн тоо, анги танхимын хүрэлцээ зэргийг харгалзан хосолсон сургалтын дараах загваруудаас өөрийн сургуулийн онцлогт тохируулан сонгон хэрэгжүүлж тогтсон загварыг сургалтад нэвтрүүлэх нь чухал болоод байна.¹³ Үүнд:

1. “Буудал сэлгэх загвар”
2. “Лаб сэлгэх загвар”
3. “Ганцаарчилсан сэлгэлт хийх загвар”
4. “Тонгоруу сургалтын загвар”
5. “Уян хатан сургалтын загвар”
6. “Сонголтын загвар”
7. “Өргөжүүлсэн виртуал сургалтын загвар”

¹² БШУЯ, Сурагч төвтэй, тэгш хамруулах, оролцоонд суурилсан бүтээлч арга зүй. Цахим сургалтын модуль <https://s3.ap-southeast-1.amazonaws.com/assets.aplus.mn/h/2-12-new.pdf>

¹³ БХ. ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж. 2021 он. <https://s3.ap-southeast-1.amazonaws.com/assets.aplus.mn/h/1-1-new.pdf>

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр

Монгол улсын нутаг дэвсгэр дээр сургалт, үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн бүх сургууль үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Үндэсний сургалтын хөтөлбөрт тусгасан суралцахуйн зорилтыг өөрийн аймаг орон нутаг, сургуулийн онцлог, ялгаатай соёлд нийцүүлэн нутагшуулах нь бусад сургуулиас ялгагдах онцлог болж байгаа тул СССХ-ийг далд сургалтын хөтөлбөр гэж нэрлэх болжээ.



АСУУДАЛ

Сургуулийн нэгдсэн сургалтын хөтөлбөргүй.
Төлөвлөлтийн дагуу хичээл ордоггүй.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Тогтвортой хөгжлийн “Эрүүл мэндийг дэмжих” зорилгын хүрээнд “Эрүүл хүнс -Энх амьдрал” төслийг санаачлан хэрэгжүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт интеграцчилж, сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрч байна. Үүнд:

- Сурагчид, асран хамгаалагчид, харгалзан дэмжигчид олон нийтийг сургалтад хамруулснаар эрүүл зөв хооллолт, хүний биед хор хөнөөл үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдлэгтэй болж, хүнсний бүтээгдэхүүний илчлэг норм, шошго, хаяг, сав баглаа боодол, хоол хүнс хадгалах сав, хүнсний ногооны эрүүлжүүлэх ач тусыг ойлгож, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх зөв дадалд суралцаж байна.
- Сурагчид хоол хүнсийг зөв сонгон хэрэглэх дадал хэвшилтэй болсноор сургуулийн хог хаягдлын хэмжээ багассан.
- Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл, сургалт явуулснаар багш, сурагчдын 60.0-аас дээш хувь нь өөрийн гараар бэлтгэсэн үдийн хоолыг идэж заншсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

СССХ-ийг боловсруулах нь ямар ач холбогдолтой юм бэ? Цаг үрсэн ажил биш үү? гэх асуулт гарч болно.

СССХ-ийг хөгжүүлэх нь үндэсний сургалтын хөтөлбөрөөс салангид тусдаа зүйл биш, үндэсний сургалтын хөтөлбөрт суурилсан байна гэдгийг мартаж болохгүй. СССР гэдэг нь сургуулийн түвшинд бүх багшийн оролцоотойгоор боловсруулсан, сургалтыг илүүтэй амьдралд ойртуулж, хэрэгжихэд хялбар дөхөм болгосон, тухайн орон нутаг, сургуулийн орчин, соёлын олон янз байдлыг тусгасан гэдгээрээ ялгагдах болно. Иймээс тухайн сургуулийн багш нар хамтраад “3W1H”-ийн зарчмаар сургалт, үйл ажиллагааг төлөвлөж СССР-ыг боловсруулна.

- -Юуг сургах (орон нутаг, сургуулийн онцлог, соёлын ялгаатай агуулгаар баяжуулах)
- -Хэн оролцох (сургуулийн удирдлага, багш нарын баг, орон нутгийн иргэдтэй хамтран)
- -Хаана явуулах (сургалтын анги танхимд, туршлагын талбайд, музейд, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, сургуулийн үйл ажиллагаагаар гэх мэт)
- -Хэрхэн хэрэгжүүлэх (орон нутгийн иргэдээс суралцах, нийгэм, хүрээлэн буй орчноос суралцах) гэдэгт л өөрчлөлт хийнэ гэсэн үг.

Энэ нь багшийн бүтээлч, бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэх, ажлын байран дээрээ бусдаас суралцах, сургалтын арга зүйгээ “солонгоруулах” боломжийг нээж өгдөг сайн туршлага юм.

СССХ-ийг турших, хэрэгжүүлэхэд юуг анхаарах вэ?

СССХ-ийг турших, хэрэгжүүлэхдээ “хэрэгжүүлэх арга зам”, “сургалтын загвар (learning models)”, “сургалтын арга (Learning methods)” гэсэн нэр томъёоны талаар сургуулийн бүх багш, ажилтан нэгдсэн ойлголттой болсон байх нь чухал. Энэхүү зөвлөмжид дээрх ойлголтуудын талаар товч тайлбар оруулав.

СССХ-ийг турших, хэрэгжүүлэх арга зам

- *Сургалтын хөтөлбөрийн агуулгыг орон нутгийн онцлог, ялгааг тусгаж баяжуулна.* Тухайн орон нутгийн газар зүйн онцлог, түүх соёлын үнэт үйлс, амьтан, ургамлын аймгийн онцлог, ТХБ гээд олон шинэ агуулгаар үндэсний сургалтын хөтөлбөрийг баяжуулан, агуулгыг амьдрал, хэрэглээнд ойртуулах

- *Орон нутгийн иргэдийн оролцоонд суурилах.* Орон нутагтаа ажиллаж, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хичээлдээ урих, тэдний ажил, амьдралын түүхэн замнал туршлага, шинэ санаа, бүтээлээс суралцах боломж нөхцөлийг бүрдүүлэх
- *Орчинд нь сургалтыг явуулах.* Сургалтыг танхимаас гаргах, практик хэрэглээтэй уялдуулах, сургалтын агуулга, арга зүйг интеграцчилж хүний нөөцийг чадавхжуулах, сурагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг сургалтын технологи, арга хэрэгслийг сургалтад нэвтрүүлэх зэргийг багтаан ойлгоно

Сургалтын загвар (learning models) гэж шинэ ур чадвар, мэдлэг мэдээлэлд суралцах аливаа үйл ажиллагааны үе шат, хэлбэрийг хэлнэ. Орчин үед сургалтын загвар нь сургалтын хэв маяг, онол арга зүй, сургалтын стратегийг дагаж олон төрөл, ангиллаар хөгжиж байна. Жишээ нь: Асуудал шийдвэрлэх сургалтын загвар (Problem-Based Learning - PBL), төсөлд суурилсан сургалтын загвар (Project-Based Learning -PrBL) гэх мэт.

СССХ-ийг төсөлд суурилсан сургалтын загвараар хэрэгжүүлнэ гэвэл дараах үе шатаар сургалтыг төлөвлөж, хийж сурах зарчимд суурилсан идэвхтэй сургалтын аргуудыг ашиглан сургалт, үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Зураг 3.15. Төсөлд суурилсан сургалтын загвар: төлөвлөлт зохион байгуулалт



Зураг. Экспансив суралцахуйн цикл (Engestrom, 1999, p.384)

Төсөлд суурилсан суралцахуйгаар СССР-ыг туршин хэрэгжүүлэхэд сургалтын агуулга, арга зүйг интеграцчилах хэрэгцээ, шаардлага үүсэж болно. Ийм тохиолдолд сургуулийн бүх багш хамтарч сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, турших, хэрэгжүүлэх, үнэлэх шаардлага тулгардаг

тул сургуулийн удирдлага боломжит цаг хугацааг гаргаж өгөх, урамшуулах, сургалтын орчинг бүрдүүлэхэд туслах, бусад талын оролцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэргээр дэмжиж ажиллах хэрэгтэй болно.

3.2.4 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Сургалтын үйл ажиллагаанд анализ хийх, үнэлгээг ойлгож бодитой хэрэгжүүлэх замаар давуу, сул тал, асуудал, бэрхшээлээ илрүүлж сайжруулах нь сургуулийн менежментийн үндсэн асуудал юм.

Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх суралцахуйн үр дүн, шалгуурыг хангаж байгаа байдал болон хүүхэд бүрийн хөгжлийн түвшинг бодитой тодорхойлох, суралцахуйд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, улмаар багшлахуй болон суралцахуйг дэмжих сургалт, үйл ажиллагааны үндсэн хэсэг юм.

Үнэлгээний өгөгдөл юунд хэрэгтэй вэ?

Хүснэгт 3.9. Үнэлгээний өгөгдлийг хэрэглэх нь

Үндэсний түвшинд	Сургуульд	Багшид	Эцэг эхэд
<ul style="list-style-type: none"> • Сургалтын үр дүнд хяналт тавих • Сэргээх • Зөвлөмж • Зохицуулга • Нөөцийг хуваарилах • Шийдвэр гаргах 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн сургалт, үйл ажиллагаанд хяналт тавих • Сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх • Нөөцийн хуваарилалт, чадамжийг дэмжих • Шийдвэр гаргах 	<ul style="list-style-type: none"> • Өдөр тутмын сургалт үйл ажиллагааг төлөвлөх • Тохируулга хийх • Дэмжлэг шаардлагатай сурагчдыг илрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийнхээ сурлагын амжилт, алдаа онооны талаар баримжаа авах цаашид дэмжих, хамтрахад санал өгөх, • Эцэг эхийн оролцоо хариуцлага нэмэгдэх
Үндэсний үнэлгээнүүдийн үр дүн	Аймаг дүүрэг сургуулийн түвшний үнэлгээний үр дүн	Өдөр тутмын хичээлийн ажиглалт, тэмдэглэгээ, Нэгж, улирлын үнэлгээ, СДҮА, даалгавар үнэлгээний тайлан	Үнэлгээний хуудас Даалгавар/ ажлын хуудаст өгсөн багшийн фийдбак,



АСУУДАЛ

- Үнэлгээг зөвхөн үр дүнгээ дүгнэх байдлаар ойлгодог, сургалтын үйл ажиллагааг дэмжих тасралтгүй цогц үйл ажиллагаа болохыг ойлгодоггүй
- Үнэлгээний төлөвлөлт хийдэггүй, сурагчдад танилцуулдаггүй



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

1. “ХАМТДАА ХӨГЖИЖ-ҮРСЭЭ ДЭМЖЬЕ” сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид уулзалт зөвлөгөөнийг улирал бүрийн эхний долоо хоногт хийж тухайн улиралд сурагчдын үзэж судлах агуулгын хүрээнд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө өгч, үнэлгээний аргачлалыг тайлбарлан сургалтыг хийдэг. Үүний үр дүнд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ гэрийн даалгавар хийхэд нь дэмжлэг үзүүлэх, хараа хяналт сайжирч хүүхдээ ойлгох, дэмжих зэргээр эерэг үр дүн гарсан.
2. Суралцахууд суурилсан мэргэжлийн бүлгээр ажиллан “ИНТЕГРАЦИ ГЭРИЙН ДААЛГАВАР”-ыг туршин хэрэгжүүлсэн. Ингэсээр сурагчдын ачааллыг бууруулах, даалгаврыг сонирхолтой өгөөжтэй болгох, сурагчид хоорондоо болон эцэг эхтэйгээ хамтран ажиллах, өөрийгөө үнэлэх, боломжийг олгоод зогсохгүй багш нар хамтран ажиллах агуулга арга зүйгээ нэгтгэх боломж бүрдсэн өгөөжтэй ажил байлаа.



“ХАМТДАА ХӨГЖИЖ-ҮРСЭЭ ДЭМЖЬЕ”




“ИНТЕГРАЦИ ГЭРИЙН ДААЛГАВАР”



ЗӨВЛӨМЖ

Зураг 3.16. Сургалт ба үнэлгээ хоорондын хамаарал



Үнэлгээ бол араас нь хийдэг дүгнэлт бус сургалтын тасралтгүй үйл явц юм.


Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн хийх вэ? Үнэлгээг хийхдээ суралцахуйн болон үнэлгээний зорилгоос хамаарч ялгаатай алхмуудыг гүйцэтгэх боловч дараах үндсэн үе шатуудыг дамждаг. Үүнд:

Зураг 3.17. Үнэлгээний үе шат



Дээрх үндсэн алхмын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх олон хэлбэрийн үнэлгээг бид хийдэг.

Зураг 3.18. Үнэлгээний PDCA



Гэвч эдгээр үнэлгээнээс бид зөвхөн сул гүйцэтгэлтэй болон хоцрогдолтой байгаа агуулгыг л ялган харж чаддаг.

Тэгвэл эдгээр олон төрлийн үнэлгээний зорилго, хэлбэрээс хамаарч сургууль, багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах олон мэдээллийг цуглуулж багшлахуй суралцахуйг сайжруулах боломж байгааг багцлан тоймлон орууллаа.

Хүснэгт 3.10. Үнэлгээний үр дүнгээс цуглуулах мэдээлэл

Зорилго	Түвшин	Хэлбэр	Цуглуулах мэдээлэл
Оношлох	Анги танхи дахь болон сургуулийн үнэлгээ	Оношлох үнэлгээ	Гүйцэтгэлд үндэслэн хоцрогдсон болон ахисан түвшинд тохируулан агуулгаа хаанаас эхлэх зорилгоо тодорхойлох, чадварын гүйцэтгэлд үндэслэн арга зүй, даалгавар, үйл ажиллагаа, арга зүйгээ хэрхэн төлөвлөх
Суралцахуйг дэмжих		Явцын үнэлгээ	Төлөвлөсөн даалгавар үйл ажиллагааг хэрэгжүүлэх гүйцэтгэж буй явцад нь сурагчдын алдаа болон ахицыг ажиглан зөвлөх чиглүүлэх, суралцахуйг дэмжих, ялгаатай байдалд үндэслэн арга зүй, төлөвлөлт, даалгаврын тавил, хэрэглэгдэхүүнд өөрчлөлт оруулан тохируулах
Ахицыг тооцох		Нэгжийн болон улирлын үнэлгээ	Сургалтын эхэнд ба төгсгөлд хийж харьцуулж ахиц өөрчлөлтийг тооцдог Суралцахуйн зорилт, шалгуур болон суралцахуйн үр дүнд хэрхэн хүрч буй байдлыг илрүүлэх, гүйцэтгэлд үндэслэн дараагийн нэгж/улирлын төлөвлөлтөд тохируулга хийх
Сургалтын үр дүнг тооцох		Төгсөх болон анги дэвших шалгалтын үнэлгээ	Суралцахуйн зорилт, шалгуур, суралцахуйн үр дүнд хүрсэн байдлыг илрүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үр дүнг тодорхойлж сайжруулах
Метакогнитив чадвар, хөгжлийг дэмжих		Сургалт, үйл ажиллагааны тайлан, дүгнэлт	Хичээлээс гадуурх болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны үр дүнг тооцох сургалтын хөтөлбөртэй уялдуулан СДҮА-г хамтран төлөвлөх, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих сайжруулах

Гүйцэтгэлийн үнэлгээ	Хөндлөнгийн үнэлгээ	Сургууль, орон нутгаас зохион байгуулж буй хөндлөнгийн шалгалт	Аймаг, дүүрэг, сургуулийн түвшинг зорилготойгоор илрүүлж, шаардлагатай дэмжлэг, чиглүүлэг, үйл ажиллагааг төлөвлөх
		Чанарын шалгалтын анализ	Хөтөлбөрийн хэрэгжилтэд анализ хийж тохируулга, чиглүүлэг, дэмжлэг үйл ажиллагааг төлөвлөх
		Гүйцэтгэлийн үнэлгээний	Сурагчид ямар ай, ямар мэдлэг чадварын хувьд сул байгааг илрүүлэх, агуулгын хоцрогдол хаана байгааг тодорхойлох судлагдахуун тус бүрээр улс, бүс, аймгийн түвшинд хаана яваагаа харьцуулах дүгнэлт хийж сайжруулах Хөтөлбөрийн хэрэгжилтэд сургалтын, багшийн чадвар, удирдлага, хамтын ажиллагаа, оролцогчдын сэтгэл ханамж, зэрэг нөлөөлөх бүхий л хүчин зүйлийг илрүүлэн сургуулийн сургалт үйл ажиллагааг сайжруулах
Жагсаан эрэмбэлэх		Олимпиадын үнэлгээ, оролцоо	Эзэлсэн байр, медаль гэж харахаас илүү багш болон сурагчийн ахисан түвшний даалгавар үйл ажиллагааг гүйцэтгэх мэдлэг, чадвар, багшид шаардлагатай үр чадварыг тодорхойлох
		ЭЕШ-ийн үнэлгээ	Үндэсний түвшинд сурагчдыг их, дээд сургуульд эрэмбэлэн элсүүлэх зорилготой багш сургуулийг үнэлэх зорилгогүй ч сургууль багш ЭЕШ үр дүнгээс сонгон судлах хичээлийн чанар хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг харьцуулан судалж сонгон судлах хичээлийн хэрэгжилтээ сайжруулан ажиллах боломжтой

Дээрх хүснэгтээс бидний хийж байгаа олон төрлийн үнэлгээний үр дүнг зөвхөн оноо, жагсаалт гэхээс илүү маш олон төрлийн мэдээллийг цуглуулж багшлахуй болон суралцахуй, сургалт үйл ажиллагааг сайжруулах боломжтой. Иймд сургуулийн менежментийн чухал нэгэн асуудал бол үнэлгээний үр дүнд анализ хийж сурах явдал юм.

Эцсийн үнэлгээнээс илүү явцын үнэлгээг яагаад чухалчлах ёстой вэ?

Бид сургалт, үйл ажиллагааны дараа үр дүнг хэмжиж, тоон утгаар эрэмбэлж жагсаахаас илүүтэй явцын үр дүнг хэмжиж, суралцах явцад нь алдааг нь засахад дэмжлэг үзүүлэх, ахиц дэвшлийг урамшуулан цаашдын үйл ажиллагаанд нь урам өгч сэдэлжүүлэх замаар суралцахуйг сайжруулж үзэл баримтлал түлхүү хэрэгжих байна.

Хүн хэдийгээр олон давтамжит үйл ажиллагааны үр дүнд чадвар, хандлага төлөвшин тогтдог хэдий ч нэгэнт буруу тогтсон мэдлэг, чадвар дадлыг араас нь засахад хүндрэлтэй, цаг хугацаа их шаарддаг. Иймд сурагч яг тухайн үйлийг гүйцэтгэж байх явцад нь алдааг нь засаж, аргад нь дадуулан, зөв рүү нь чиглүүлж өгснөөр сурагчийн сурах идэвх урам нэмэгдэн, мэдлэг чадвар богино хугацаанд зөв бүрэлдэх, боломжтой болдог.



АСУУДАЛ

Үр дүнгийн буюу эцсийн үнэлгээнд түлхүү анхаардаг, явцын үнэлгээний ач холбогдлыг ойлгодоггүй явцын үнэлгээг сул хийдэг



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

...-р сургуулийн үнэлгээний хуудас												
Сурагчийн нэр	Явцын үнэлгээ				Гэрийн даалгавар				Нэгжийн үнэлгээ			Дундаж
	Ирц	Идэвх	Оролцоо	багийн ажил	1	2	3	4	нэгж 1	нэгж 2	нэгж 3	

Явцын үнэлгээг ирц идэвх оролцоог ерөнхий байдлаар оноожуулан үнэлж байна.



ЗӨВЛӨМЖ

Багшлахуй ба суралцахуйн үйл ажиллагааны үндсэн хэсэг бол явцын үнэлгээ юм.

Явцын үнэлгээг анги танхимд хэрэгжүүлнэ гэдэг нь хичээл, сургалт, үйл ажиллагааг сурагч бүрийн хэрэгцээнд нийцүүлнэ гэсэн үе юм. Өөрөөр хэлбэл, багш хичээл үйл ажиллагааны үед сурагчийн даалгавар, үйл ажиллагааны гүйцэтгэлд байнга ажиглалт тэмдэглээгээ хийж алдааг засахад чиглүүлэх ахицыг урамшуулан дэмжих замаар суралцахуйг дэмжих

үйл явц юм. Явцын үнэлгээ нь сурах үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг: Үүнд

- сурагчидтайгаа суралцахуйн зорилгоо ярилцах
- сурагчид юу мэдэж, чадаж байгааг ойлгох, хэлэх
- тухайн даалгавар үйл ажиллагааны хүрэх үр дүн, хийсэн байх шалгуур ямар байдаг талаар сурагчид ойлгоход туслах
- өөрийн болон анги хамт олны үнэлгээг дэмжих
- сурагчдын цаашид хийх алхмуудыг нарийвчлан чиглүүлсэн хариу өгөх.

Өдөр тутмын үйл ажиллагаанд тулгуурлан сурагчдын ахиц, амжилт, сурах үйл ажиллагааны үр дүнг харуулахад дараах арга замыг ашиглаж болно.

Явцын үнэлгээг хэрэгжүүлэх арга зам

Хүснэгт 3.11 Явцын үнэлгээг хэрэгжүүлэх арга зам

Арга/ техник	Ажиглалт, тэмдэглэгээ	Хариу мэдээлэл
Богино хугацаанд мэдээлэл цуглуулах (Асуулт асуух, гар, эрхий хуруу, гэрлэн дохио өргөх...)	Арга техникийг хэрэгжүүлэх алхам Шалгуур	Үнэлгээний төлөвлөлт /хугацаа агуулгын хүрээ, арга хэлбэр/-сурагч эцэг эхэд нээлттэй байх Шалгуур тодорхой байх / гүйцэтгэлийн түвшин, /
Ойлголтыг илрүүлэх (оюуны зураглал, KWL, шат ба жагсаалт, венийн диаграмм, мэдлэгийн картууд, урсгал диаграмм ...)	Рубрик Ажиглалтын хуудас Асуулгын хуудас	Алхам тус бүрийн гүйцэтгэл-, өөрийн үнэлгээний шалгах хуудас
Хичээлийн төгсгөлд (дүгнэлт, тэмдэглэл, ойлголтын тойрог, эргэцүүлэх тэмдэглэл)	Өөрийн үнэлгээний хуудас Үе тэнгийнхний үнэлгээний хуудас	Даалгаврыг үнэлэх аргачлалд үндэслэсэн зөвлөмж Даалгаврын анализ, зөвлөмж
Хичээлийн дараа (гэрийн даалгавар, бүтээлийн сан, бие даалт, даалгавар, төсөлт үйл ажиллагааны явц, багийн ажил дүгнэлт ...)	Бие даан гүйцэтгэх ажлын удирдамж Ярилцлагын асуултууд	Дүгнэлт, зөвлөмж Багшийн чиглүүлэг, дэмжлэг зөвлөгөө, Алдааны шинжилгээ, тайлбар

Явцын үнэлгээг хэрэгжүүлэх дээр дурьдсан арга техник, ажиглалт тэмдэглэгээ, хариу мэдээлэл өгөх хэлбэрүүдээс тус бүр нэг жишээ орууллаа. Үүнийг сургуулын удирдах ажилтан багш нарын хамт хэрэгжүүлэх боломжтой.

QR кодыг уншуулан дэлгэрүүлж судлаарай



Хүснэгт 3.12. Сурагчид бие биеэсээ асуулт асуух

	Аргын санаа	Гол үр дүн	Хичээлийн аль хэсэгт хэрэглэж болох
1	Сурагчид бусад сурагчдын асуулт тайлбар, танилцуулгыг сонсож ойлгоогүй зүйлийнхээ талаар асуулт тавихыг дэмжих	<ul style="list-style-type: none"> Хамтын ажиллагаа гэсэн санааг дэмждэг – ганцаараа бодсоноос хоёулаа бодсон илүү дээр Өөрийн ойлгоогүйгээ эргэцүүлнэ Бие биеэсээ суралцана Алдаа, болон дутуугаа нягтална, засна 'Асуулт асуух эргэцүүлэн бодоход сургана. 	<p>Сурагчид даалгаврыг гүйцэтгэн, өөр хувилбаруудыг судлах ба ач холбогдол, давуу болон сул талын тал, бэрхшээл, үр дүнгийн талаар богино танилцуулга хийнэ.</p> <p>Сурагчид тэмдэглэл хөтөлж, асуух асуултаа бэлтгэнэ.</p> <p>Багш чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэж, ангийн бусад гишүүдээс асуулт авч, танилцуулга хийж буй багийн гишүүдээс хариулт авна.</p> <p>Оролцоог жигд хангах</p>

Хүснэгт 3.13. Сурагчийн багаар ажиллах чадварыг үнэлэх ажиглалтын хуудас

Огноо:	Хичээл/Үйл ажиллагааны нэр:				
Багийн гишүүд:					
Сурагч	нь	Огт гүй	Хааяа	Ихэвчлэн	Үргэлж
Өөрийн дотнын найз нөхдөөсөө гадна, олон сурагчтай хамтарч ажилладаг					
Өөрийн материал, хэрэглэгдэхүүн, санаа, бодлыг бусадтай хуваалцдаг.					
Бусдын санал, бодлыг сонсдог, харгалзаж үздэг, хүндэтгэдэг.					
Тухайн ажил, үйл ажиллагааг гүйцэтгэхэд баримтлах дүрэм, журмыг дагадаг.					
Бусдад зааж тусалдаг					
Манлайлдаг					
Шаардлагатай үед бусдаас дэмжлэг хүсэж алдаагаа засдаг					
Баг доторх өөрийн үүрэг, хариуцлагаа биелүүлдэг.					
Багийн хэлэлцүүлэгт оролцдог.					
Багийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулдаг.					
Дүгнэлт сурагчид өгөх зөвлөмж:					

Эх сурвалж: Мусиал, Д., Гаяла, Н., Жэй, Т., & Кэй, Б. (2009).

Хүснэгт 3.15. Нэгж хичээлийн даалгавар төлөвлөлт

"Геометр ба асуудал шийдвэрлэх" нэгж хичээлийн төлөвлөлт

Сургалтын зорилт	Сургалтын үр дүн	Нэгж хичээл	МР	Замнал хичээлийн үйл ажиллагаа	Хэрэгжүүлүүр	Шалгуур		
						Мэдэг	Чадвар	Харилцаа
4.2a Өнцгийг төгөлдөг триангулолоор өгөгдөл хэмжээг унших, бичих, зөв олох өгөгдлийг таних.	Суралч өнцгийг триангулолоор хэмжих, өнцгийн хэмжээг унших, бичих, зөв олох өгөгдлийг таних, тэгш өнцөгт параллелистид, цугилдаггүй таних, өгсөн даалгасраар нь бүтэц чадвартай болно.	Өнцөгт хэмжээ 16 цагт	1	Суралч өнцгийн хэмжээг триангулоор хэмжих, унших, бичих, зөв олох өгөгдлийг таних, тэгш өнцөгт параллелистид, цугилдаггүй таних, өгсөн даалгасраар нь бүтэц чадвартай болно.	Гарни, шүргэм, триангулоор, өнцгийн эвчээр хялбар, ноль			
4.2b Тэгш өнцөгт параллелистид, цугилдаггүй таних, өгсөн даалгасраар бүтэц.	Тэгш өнцөгт параллелистид, цугилдаггүй таних, өгсөн даалгасраар бүтэц.		2	Тэгш өнцөгт параллелистид, цугилдаггүй таних, өгсөн даалгасраар бүтэц.	Биец, даалгас, зураг, цугилдаг хийхэд харгалзах найрцаг, цэцэг			
4.3a Өрчөгч план зураг, зорчих замын тухайн үзэмжгэй тайлбарлах, координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих, өгсөн координатаар цэг тусгагчлан.			3	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.	Төгсөөрхөн хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.			
4.3b Агаар тал нь тэгш өнцөгт тусгагчлан, тэгш өнцөгт дүрсийг тусгагчлан тусгагчлан хувиарлах.	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих, байрлалыг унших, бичих, байрлалыг таних, өгсөн даалгасраар унших, бичих, өгсөн координатаар цэг тусгагчлан.		4	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.	Хүснэгт, тусгагчлан, координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.			
4.3c Хэрчим тэгш өнцөгт гурвалжныг тусгагчлан зөв.	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих, байрлалыг унших, бичих, байрлалыг таних, өгсөн даалгасраар унших, бичих, өгсөн координатаар цэг тусгагчлан.		5	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.	Тусгагчлан, тэгш өнцөгт, тэгш өнцөгт гурвалжныг таних, өгсөн даалгасраар унших, бичих.			
4.3d Хэрчим тэгш өнцөгт гурвалжныг тусгагчлан зөв.	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих, байрлалыг унших, бичих, байрлалыг таних, өгсөн даалгасраар унших, бичих, өгсөн координатаар цэг тусгагчлан.		6	Суралч координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.	Хүснэгт, тусгагчлан, координатын хавтгайг таних, өгсөн даалгасраар унших, бичих.			

Эх сурвалж: ... аймгийн ... –р сургууль, математикийн хичээлийн нэгжийн төлөвлөлт



ЗӨВЛӨМЖ

Сургуулиудад зөвлөн туслах ажлын явцад гарч байгаа нийтлэг асуудал бол БҮТ-өөс боловсруулан 2021 онд батлагдан гарсан “Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, түүнийг хэрэглэх зөвлөмж”-ийг төлөвлөлт, хичээл үйл ажиллагаандаа тусгаагүй, ойлголтын зөрүүтэй байдал нийтлэг ажиглагдаж байгаа нь багшийн төлөвлөсөн даалгавар үйл ажиллагаа нь хөтөлбөрөөр хүлээгдэж буй үр дүн хүрч буй эсэхэд тухай бүр нь хянах, боломжгүй байдалд хүргэдэг. Хяналтгүй тул алдааг нягталж сайжруулалт хийх боломжгүй болдог. Иймд удирдлагын зүгээс үнэлгээний шалгуурыг судлах, ойлгох, төлөвлөлт, даалгавар, үнэлгээнд тусган хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах зайлшгүй шаардлага байна.

Сурагчийн үнэлгээ гэдэгт “сурагчийн сурлагын амжилтын түвшин тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно. Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна¹⁴.

14 Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж БҮТ, УБ 2021

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаар гүнзгийрүүлэн судалж жилийн болон нэгжийн төлөвлөлт, хичээл даалгавартаа тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 3.16. Үнэлгээний шалгуурт суурилсан жилийн болон нэгжийн төлөвлөлт

Хувилбар:хичээлийнангийн жилийн төлөвлөлт

Улирал		7 хоног	Бүлэг сэдэв	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Ээлжит хичээл, үндсэн үйл ажиллагаа	цаг	Гүйцэтгэлийн түвшин				Хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэрэгсэл		Хичээл хоорондын интеграци, /СДҮА/		
										1	2	3	4	Байгаа	Шаардлагатай			
										7							8	9
1-р улирал	1			C31	Нэгж1													
	2			C32														
	3			C33														
	5			C34														
	7			C35														
	9			C36														
2-р улирал	1																	
	2																	
	9																	
3-р улирал	1																	
	2																	
	9																	
4-р улирал	1																	
	2																	
	9																	
Нийт																		

Боловсруулсан.....

1. Энэхүү төлөвлөлтийг мэргэжлийн багш анги бүрээр боловсруулна
2. Сургалтын хөтөлбөрөөс тухайн хичээлийн бүх суралцахуйн зорилтын жагсаан бичнэ
3. Үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн, суралцахуйн үр дүнгийн шалгуурыг хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмжөөс тусгаарай.
4. Ээлжит хичээлийн үндсэн үйл ажиллагааг суралцахуйн үр дүн, шалгуурт үндэслэн, суралцахуйн удирдамж дахь сурах үйл ажиллагаанаас голлох үйл ажиллагаанд үндэслэн бичнэ. Ингэж ээлжит хичээлийг сэдэв тавихаас илүү шалгуурт үндэслэн суралцахуйн үндсэн үйл ажиллагаагаар төлөвлөснөөр ээлжит хичээлийг агуулга төвтэй биш сурагчдын гүйцэтгэх үйл ажиллагаа төвтэй даалгавар үйл ажиллагаа төлөвлөхөд тодорхой болдог.
5. Гүйцэтгэлийн түвшинг хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурын харгалзах түвшинд баримжаалан голлох үйл ажиллагаандаа нийцүүлэн нарийвчлах боломжтой
6. Хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэрэгслийг нэгж, ээлжит хичээл бүрээр төлөвлөснөөр багш хичээлийг чадварт суурилсан бодитой, хүртээмжтэй

оролцоотой хөтлөх, үнэлгээний хэрэгслээр дамжуулан үйл ажиллагааг дэмжих чиглүүлэх боломж бүрдэнэ

7. Тухайн нэгжтэй холбоотой нэмэлт /СДҮА/ үйл ажиллагааг төлөвлөсөөр сургалтын болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны холбоог хангах, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар сургалтыг дэмжих олон талын боломж бүрдэнэ. /нэгж бүрээр заавал гарах албагүй/

Бүх судлагдахууны үнэлгээний шалгуур, зөвлөмжийг <http://ebook.eec.mn/> холбоосоор татан авч төлөвлөлт, даалгавар, үнэлгээнд тусган хэрэгжүүлээрэй.

Суралцахуйг дэмжих даалгавар боловсруулах, даалгаврын гүйцэтгэлд анализ хийх

Багш нарт тулгамдаж буй бас нэг асуудал бол даалгавар боловсруулах/сонгох чадвар болон сурагчийн гүйцэтгэсэн даалгаварт анализ хийх чадвар юм. Энэ нь хичээл ихэвчлэн агуулга төвтэй, багшийн үнэлгээ голчлон мэдлэг шалгадаг тул чадварын хөгжил, цогц чадамж, сурах арга барилтөлөвшүүлэх хөтөлбөр бодитой хэрэгжихэд асуудал үүсэж байна. Иймд удирдлагын зүгээс даалгавар боловсруулах анализ хийх арга зүйд дэмжлэг үзүүлэн ажилласнаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах боломж бүрдэнэ.



АСУУДАЛ

- Даалгавар сонгох/боловсруулах мэдлэг чадвар, арга зүй дутмаг, даалгаварт үнэлгээний шалгуурын тусаагүй
- Даалгаврын гүйцэтгэлд тоон анализаас хэтэрдэггүй чанарын буюу шалгуурт суурилсан чадвар, хандлагын анализ хийдэггүй



ЗӨВЛӨМЖ

Багш даалгаврыг сургалтын төгсгөлд авдаг шалгалтын нэг хэсэг гэж ойлгож ач холбогдол өгөх нь сул байдаг. Сурагчдынхаа сэтгэн бодох, эргэцүүлэх, бусадтай харилцах болон насан туршдаа суралцах чадварыг бэхжүүлэхийн тулд эдгээр чадварыг илрүүлэхүйц даалгаврыг зохиож/сонгож хичээл, үйл ажиллагаагаар хэрэгжүүлж гүйцэтгэлд дүгнэлт хийн дээрх чадваруудыг дэмжих нь хөтөлбөрийг бодитой хэрэгжүүлэх үндсэн зам юм. Даалгавар боловсруулахад таксономын тухай ойлголт чухал.

Даалгаврыг боловсруулах эсвэл сонгоход багш дараах алхмын дагуу ажиллана.

Зураг 3.19. Даалгавар, даалгаврын сан



1. Үнэлгээний төрлийг тогтоох (түвшин тогтоох, оношлох, явцын, эцсийн үнэлгээний аль нь вэ?)
 - **Оношлох**- Өмнөх мэдлэг чадварыг илрүүлэх, хаанаас эхлэхээ тодорхойлох
 - **Явцын**- Мэдлэг бүтээх- шалгуур, гүйцэтгэлд үндэслэн чиглүүлэх, дэмжих
 - **Үр дүнгийн**- Суралцахуйн зорилт, суралцахуйн үр дүн, шалгуураа хангаж буй эсэх
2. Үнэлэх ажлын зорилгыг тодорхойлох (юуг үнэлэх вэ?) Гүйцэтгэлийн ямар шалгуур эсвэл шалгуурын багцын эзэмшилтийг үнэлэх гэж байгааг тодорхойлж бичнэ. Суралцахуйн зорилт, агуулгын хамрах хүрээ, эзэмшилтийн түвшин, илрүүлэх чадвар,
3. Зорилгын хэрэгжилтийг үнэлэх хэлбэрийг сонгох (юугаар үнэлэх вэ?) тухайлбал,
 - Баримтын болон ухагдахууны мэдлэг-олон сонголтот даалгавар г.м.
 - Үйлийн мэдлэг, чадвар-богино хариултат асуулт г.м.
 - Хэрэглэх болон задлан шинжлэх чадвар- аман, бичгийн, бүтээлч ажил гэх мэт.
4. Үнэлгээний шалгуур: Даалгаврын гүйцэтгэл, асуултын хариултыг үнэлэх шалгууруудыг шаардлагатай бол харгалзах гүйцэтгэлийн хамт бичнэ. Даалгаврын блюкринт боловсруулах, даалгаврын тоог тогтоох
5. Даалгавар боловсруулах:
 - Даалгавар НӨХЦӨЛ- үнэлгээний зорилго дахь гүйцэтгэлийн шалгуурын мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэх бодит амьдралын асуудлыг тусгасан байна
 - Гол хэсэг-АСУУДАЛ, хариултын хувилбар зааварчилгаа, аюулгүй ажиллагааны дүрэм, үр дүнг нэгтгэх хэсэг, гүйцэтгэлийг үнэлэх,

дүгнэх асуултууд, туршилт эсвэл судалгаа гүйцэтгэх зааварчилгаа, аюулгүй ажиллагааны дүрэм байна

- Хариултын хэсэг

6. Даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал боловсруулах

- Асуултын хариултыг үнэлэх шалгуурууд, харгалзах гүйцэтгэлийн түвшинг бичнэ
- Сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, дүгнэх, үр дүнг хэрэглэх
- Нэмэлт асуулт: Даалгаврын гүйцэтгэлийг эргэж дүгнэх, үр дүнг нэгтгэх, үнэлэх асуултууд байна

Даалгаварт анализ хийх. Багш нар даалгаврын гүйцэтгэлээс зөвхөн зөв хариултад анхаарлаа хандуулж, буруу хариултын шалтгааныг илрүүлдэггүйгээс сурагчдад фийдбак/хариу мэдээллийг ихэвчлэн авсан ба алдсан оноонд суурилан өгдөг.

Иймд даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал алхам 6 боловсруулж сурах нь даалгаврын гүйцэтгэлд анализ хийх үндсэн арга зүй болдог. Жишээ болгож даалгаврын үнэлгээний схемийг орууллаа.

Хүснэгт 3.17. Даалгавар гүйцэтгэлд анализ хийх арга зүй

Дугаар	Сурагчдаас ирж болох хариултын төрөл	Хариултын тайлбар	Оноо	Шаардлагатай дэмжлэг	
4	а	1 17	Сургуулийн хашаан доторх модыг зөв тоолсон.	1	Таних тэмдгийг ажиглах, зөв ялган таних
		2 19	Хашааны гадна талын модыг тоолсон	0	Тоолох аргачлалыг санал болгох
		3 36 гэх мэт	Гадна доторх бүх модыг тоолсон.		Үүнд: нэг бүрчлэн, багцалж, тэмдэглэгээ хийж гэх мэт
		4 9, 22, 31 г.м	Зүлгийг тоолсон		Таних тэмдгийг ялган таних
		5 26, 31, 67 г.м	Зүлгийг мод болон нэмж оруулсан		Харандаа, үзгийг зөв сонгон хэрэглэх
		6 Алдаж тоолсон болон бусад /16, 18 г.м/	Таних тэмдгийн модыг оруулж тоолсон		Дахин нягтлах

b	1	3 ба баруун эсвэл баруун хойд	Зүг чигийг зөв олж 3 дугаартай байшин, сургуулийн баруун эсвэл баруун хойд талд гэж зөв нөхөж бичсэн байх	2	План зурагт буй зүг чигийн тэмдэг ашиглаж болно. Баруун, зүүн, хойд, урд гэдгийг зөв хэлэх/ард, хажууд гэж биш/
		Аль нэгийг зөв бичсэн бол		1	
	2	Өмнө хойд зүгийн андуурсан	5		
c	3	Зүг чигийг тэмдэглэх таних тэмдгийг ашиглаж сураагүй.	бусад	0	
	1	Сургуулийн хаалга голлоогүй учир зүүн талаар явна. Эсвэл Зүүн тал нь ойрхон харагдаж байгаа учир гэх мэт шалтгааныг зөв бичсэн бол		2	Тайлбар бичихгүйгээр зурсан байх магадлалтай
	2	Учир шалтгаан тайлбарлаагүй зөвхөн зүг бичсэн болон дөт харагдах хэсгийг олж зурсан бол	Зүүн	1	Зурахдаа дөт харагдах эсэхийг ажиглахгүйгээр сургуулийн байшин дээгүүр давуулж зурж болохгүйг ойлгуулах чухал
		Зүг чигийн баримжаагүй.	баруун		
	3	Хаалга гэдэг тэмдгийг мэдэхгүй байна.	Хойд, урд	0	
4	Хариулаагүй. Тайлбар бичээгүй				

Багш даалгаврын шинжилгээнээс “0” оноо буюу алдааны шалтгаанд илүү төвлөрөн ажилласнаар сурагчийн алдаатай ойлголт, агуулгын хоцрогдол, дэмжлэг шаардлагатай сул хөгжиж буй чадварыг илрүүлэх нь дараагийн нэгж, ээлжит хичээлийн оношилгоо болж ээлжит хичээлийн төлөвлөлтдөө тусган сайжруулах боломж бүрддэг.

3.3 БАГШИЙН ХӨГЖИЛ

3.3.1 БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ



АСУУДАЛ

Багш ажлын байранд хамтдаа сурч хөгжих хэрэгцээ хангагддаггүй

- Сурагчийн үзэл хандлага, сонирхол хэрэгцээг тооцдоггүй
- Сурагчийн ялгаатай байдалд нийцсэн арга зүй, төлөвлөлтгүй
- Цахим ур чадвараа дээшлүүлэх боломж бага
- Үр дүнтэй хамтран ажиллаж чаддаггүй, ачаалал их
- Багш мэргэжлийн хөгжлийн хэрэгцээгээ баримт нотолгоонд суурилж тодорхойлдоггүй

- Багшийн мэргэжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийхдээ багш нарын саналыг авдаггүй
- Багш тодорхой зорилго, агуулгагүйгээр сургалтад хамрагдах, хичээлийн судалгаанд оролцох гэх мэтээр ерөнхий нэрээр төлөвлөдөг
- Төлөвлөгөөний 90.0 хувь нь багш нарын сонгосон модуль сургалт, хамрагдсан МХБ нэрсийн жагсаалт төдий байна. Үйл ажиллагаа нь тодорхой бус



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сурагчдад тулгамдаж буй асуудлыг илрүүлснээр түүнийг шийдвэрлэх багшийг хөгжүүлэх хэрэгцээгээ тодорхойлсон байна. Ингэхдээ **БШҮ - ээр доогуур үзүүлэлттэй үнэлэгдсэн суралцахуйн зорилтуудын анализ**

Суралцахуйн зорилтууд доогуур үзүүлэлттэй үнэлэгдэхэд хүргэсэн **шалтгаануудыг илрүүлэх багшийн өөрийн үнэлгээ**

Доогуур үзүүлэлттэй үнэлэгдсэн **суралцахуйн зорилтуудад хийсэн анализ**, өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэсэн **багшийн хөгжлийн төлөвлөгөө** гэсэн 3 үе шаттай ажил хийсэн байна.

... аймгийн ... ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Үүний дараа багш асуудлын шалтгааныг ярилцан бүлэглэснээр бага, суурь, ахлах ангийн сурагчдад тулгамдаж буй асуудлуудыг танин мэдэхүй буюу мэдлэг, чадварын, сэтгэл хөдлөл, нийгэмшихүй буюу хандлага төлөвшлийн, эрүүл мэнд, бие бялдрын гэж бүлэглэн нэгтгэв.

Эдгээр асуудлуудыг үүсгэж буй шалтгаанаар нь багцлан, хэрхэн шийдвэрлэж болохыг ярилцсанаар нэн яаралтай шийдвэрлэх суурь асуудлуудын хүрээнд ирэх хичээлийн жилийн зорилгыг “Бүтээлч сэтгэлгээтэй, хамтран суралцагч, эрүүл хүүхэд” гэж тодорхойлохоор төсөөлсөн байна.

... аймгийн ... ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Сурагчдын гүйцэтгэлд (хөндлөнгийн үнэлгээ) хийсэн дүн шинжилгээнд үндэслэн багшийн хөгжих хэрэгцээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх

Багшийн өөрийн үнэлгээнд тулгуурлан хөгжих хэрэгцээгээ тодорхойлох

- Багш өөрийгөө үнэлж, багшлахуйдаа эргэцүүлэл хийх нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн нэг гол стратеги бөгөөд багшийн мэдлэг, гүйцэтгэл, итгэл үнэмшил, үр дүнг шударгаар үнэлэх, үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандах, өөрийн давуу тал, хөгжлийн зорилтоо таних, ажлын арга барилаа хөгжүүлэхэд мэдээлэлтэй байх, идэвхтэй үүрэг гүйцэтгэж сайжруулахад ихээхэн тустай.
- Өөрийгөө үнэлэх нь хичээл дээр болон ажлын байран дээр тохиолдсон зүйлсийг бүртгэх, цуглуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх, эргэцүүлэл хийх үйл явцаас эхлэх бөгөөд өөрийн үнэлгээний зарим арга хэрэгсэлтэй ажиллаж, багшлахуйгаа сайжруулах бодит хэрэгцээгээ олж мэдэхэд чиглэнэ.
- Сурагчдын сул үзүүлэлттэй суралцахуйн зорилтуудын хүрээнд багш өөрийн үнэлгээ, эргэцүүлэл хийхээс гадна сургуулиуд өөрийн харьяа БШУГ болон мэргэжлийн байгууллагууд, ББИДС, бусад сургуулиудтай хамтран багшийн өөрийн үнэлгээний санг бүрдүүлж болно. Өөрийн үнэлгээний энэхүү хуудаст судлагдахууны хүрээнд багшийн зайлшгүй мэдэж байвал зохих агуулгуудыг багтаах нь үр дүнтэй.

Багшийн үнэлгээний хуудсыг боловсруулахад хичээл сургалтын үйл ажиллагаа, арга зүй төлөвлөлттэй холбоотой байж болох зарим асуултуудыг жишээгээр орууллаа.

Хичээлийн төлөвлөлтийн талаар өөрийгөө үнэлэх асуултуудын жишээ:
Хичээлийн төлөвлөгөө гэдэг нь сурагчид юу сурах ёстой, түүнийг хичээлийн цагаар хэрхэн үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, зорилгодоо хүрсэн эсэхээ яаж үнэлэх тухай зураглал юм.

Шигтгээ 1: Багш хөтөлбөрөө үнэлэх товч асуулт

- Та хичээлийн төлөвлөлтөө өөрөө боловсруулж, хичээл бүртээ ашигладаг уу?
- Нэгж хичээл төлөвлөхдөө хамгийн түрүүнд зорилго буюу сурагчид юуг мэддэг чаддаг болсон байхыг тодорхойлдог уу?
- Зорилгодоо хүрсэн эсэхийг илрүүлэх үнэлгээний гүйцэтгэлийн 4 түвшин бүхий даалгаврыг боловсруулан, түүнд чиглэн ажилладаг уу?
- Зорилгод хүргэх зорилтуудыг ээлжит хичээл болгон төлөвлөдөг үү?
- Ихэнх ээлжит хичээлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг сурагч төвтэй төлөвлөж чаддаг уу?
- Ээлжит хичээл бүрээр зорилгод чиглэсэн танин мэдэхүйн түвшнээр бэлтгэсэн асуулт, асуудал ба туршилт төлөвлөдөг үү?
- Ээлжит хичээл бүрээр ажлын хуудас, хэрэглэгдэхүүн, бусад эх сурвалж ашигладаг уу?
- Ээлжит хичээл бүрээр сурагчдад олгохыг зорьсон хамгийн чухал мэдлэг ойлголт, санаа, ур чадварыг үлдээж чадсан эсэхээ үнэлдэг үү?
- Нэгж хичээлийн төгсгөлд үнэлгээний даалгаварт дүн шинжилгээ хийдэг үү?
- Үнэлгээний дүн шинжилгээнд үндэслэн, эргэцүүлэл хийн, хөтөлбөрөө сайжруулдаг уу?

Шигтгээ 2: Хичээл хооронд интеграцчилах, цаг, гэрийн даалгаврыг нэгтгэх товч асуулт

- Суралцахуйн зорилтууд хоорондын уялдааг хангаж интеграцичилсан төлөвлөлт хийдэг үү?
- Судлагдахуун хоорондын уялдааг хангаж интеграцичилсан төлөвлөлт хийдэг үү?
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу орон нутгийн музей, үйлдвэр байгууллага, байгальд ажиглалт, туршилт судалгаа хийх төсөлт ажил, асуудалд суурилсан, үзэгдэлд суурилсан сурагч төвтэй бие даасан сургалтыг дэмжих төлөвлөлт хийдэг үү?
- Сурагчдын ачааллыг бууруулах, оролцоог хангах, сонирхлыг татах, цаг хэмнэх, гэрийн даалгаврыг бодит ахуйтай холбон нэгтгэх зорилгоор судлагдахуунаар нэгтгэсэн бие даах ажил, гэрийн даалгавар төлөвлөдөг үү?

Шигтгээ 3: Өөрийгөө үнэлэх товч асуулт

Сурагчийн гүйцэтгэлийг сайжруулахад үнэлгээний ямар төрлүүдийг хэрхэн ашигладаг вэ?


- Сурагчдынхаа ахиц дэвшлийг үнэлэхийн тулд танд ямар төрлийн мэдээлэл хэрэгтэй вэ?
- Суралцахуйн үр дүн, шалгуур, үнэлгээний даалгавар ба хичээл төлөвлөлт, түүний арга зүй хэрхэн холбогдох вэ?
- Сурагч эзэмшсэн байвал зохих чадварыг эзэмшсэн эсэх, эзэмшсэн байдал нь хэр зэрэг байгааг хэрхэн илрүүлэх вэ? Энэхүү мэдээлэл нь багшид ямар ач холбогдолтой вэ?
- Суралцахуйн үр дүн, шалгуур, гүйцэтгэлийн дөрвөн түвшний даалгаврын талаарх ойлголтоо хэрхэн үнэлэх вэ?
- Зорилгодоо хүрсэн эсэхийг илрүүлэх үнэлгээний гүйцэтгэлийн 4 түвшин бүхий даалгаврын боловсруулалтдаа та сэтгэл хангалуун байдаг уу?

Шигтгээ 4: Арга зүйн талаар өөрийгөө үнэлэх товч асуулт

Сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд сурагчдын хэрэгцээ, чадварт тохирсон сургалтын арга стратегийг боловсруулж чадаж буй гэдэгтээ итгэлтэй байдаг уу?

- Сурагчдыг суралцахуйд татан оролцуулах, сонирхлыг төрүүлэх бодит амьдрал дээрх жишээ, зүйрлэл, нөхцөл байдлыг тусгаж төлөвлөдөг үү?
- Асуултуудыг танин мэдэхүйн доод эрэмбээс дээд эрэмбийн дагуу урьдчилан бэлтгэдэг үү? Сурагчид хэрхэн хариулж болох хувилбаруудыг тооцдог уу?
- Хамтран ажиллах, эрж хайх, оновчтойг сонгох, эргэцүүлэн дүгнэж, өөрсдөө мэдлэг бүтээх танин мэдэхүйн дээд түвшний үйлээр хөтөлдөг үү?
- Сургуулийн зорилгоор тодорхойлогдсон сурагчдад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах үйл ажиллагаа, арга зүйг төлөвлөдөг үү?
- Сурагчдад юуг хэрхэн сайжруулах, өөрийгөө болон бусдыг үнэлэх боломж олгон, түүнд өөрийн алхмыг нийцүүлдэг үү?
- Суралцахуйг дэмжсэн, танин мэдэхүйн ач холбогдол өндөр эх сурвалж, бусад хэрэглэгдэхүүн ашигладаг уу?
- Сурагчдад юу амархан, юу хэцүү байх вэ гэдгийг бодолцон, ялгаатай байдлыг зохицуулж, тохирсон үйл ажиллагаа, дэмжлэгийг үзүүлж чаддаг уу?
- Хичээлийн төгсгөлд хүрсэн түвшинг үнэлж дүгнэсний дараа ялгаатай байдлыг хангах, олон янзаар шийдэж болох бүтээлч даалгавар өгдөг үү?
- Сурагчид хичээлд идэвхтэй оролцож, зорилгодоо хүрч чаддаг уу?
- Хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах, бүтээлийн үзэсгэлэн гаргах, өөрийн сурах барилаар даалгавар гүйцэтгэх, бие даах, хамтран ажиллах зэргээр сурагч бүрт сурч мэдсэнээ илэрхийлэх боломжуудыг олгож чаддаг уу?
- Анги танхимын менежментийн асуудлуудыг хэрхэн анхаарч, төлөвлөдөг вэ?

Зураг 3.20. Багшийн өөрийн үнэлгээний зураглал



Багш эдгээрийг ганцаарчлан гүйцэтгэж, хариултын хуудасны дагуу өөрийгөө үнэлж, хөгжлийн хэрэгцээгээ үндэслэлтэйгээр тодорхойлно.

3.3.2 БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХ



АСУУДАЛ

- Сургуулийн зорилго, багшийн бодит хэрэгцээтэй холбоо хамааралгүй олон ажлыг нэг нэг өдрөөр төлөвлөх нь түгээмэл
- Сургуулийн үйл ажиллагааны болон багшийн хөгжлийн төлөвлөгөөнд сурагчдад тулгамдаж буй асуудал, сургуулийн зорилго болон багшийн бодит хэрэгцээтэй холбоо хамааралгүй олон тооны ажлыг нэг нэг өдрөөр төлөвлөх нь түгээмэл байна.



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн тухайн жилийн зорилго буюу сурагчдад юу тулгамдаж байгаа, тэд юуг, хэрхэн сурахыг хүсч буйд нь нөлөөлдөг багшийн үүргийг тодорхойлж, сурагчдыг бүтээлчээр сэтгэдэг, хамтдаа суралцах чадварыг хөгжүүлдэг

багштай болохын тулд багшийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааг түүнд чиглүүлэн төлөвлөх, ингэхдээ ганцхан өдрөөр бус жилийн туршид хичээл сургалтын үйл ажиллагаанд шингээн хэрэгжүүлэх, үр дүнг тооцох зэргийг дараах байдлаар төлөвлөлтөд тусгах нь зүйтэй. Үүнд:

- Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулалт хийх МХБ-ыг байгуулах
- Хичээлийн жилийн эхэнд сурагчдын бүтээлч сэтгэлгээ ямар түвшинд байгааг илрүүлэх асуулга, даалгавар, судалгаа авч, суурь түвшинг илрүүлэх
- Үр дүнд шинжилгээ хийж, сургуулийн жилийн нэгдсэн төлөвлөлтөд бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх үйл ажиллагаанууд төлөвлөх, шалгуур боловсруулах
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд нийт багшид шаардлагатай мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааг багшийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах
- Тус МХБ нь бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх үйл ажиллагаануудыг хариуцан зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багш нарт дэмжлэг үзүүлэх
- Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг үнэлж, тайлан тавих. Жишээлбэл, нэгдүгээр улиралд багш нарт зориулж “Бүтээлч сэтгэлгээ гэж юу вэ? Бүтээлч сэтгэлгээг хэрхэн хөгжүүлэх вэ? гэх мэтчилэн онолын сургалт төлөвлөх, хоёрдугаар улиралд ЗАН бүр бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж буй нэг жишиг хичээл бэлтгэн хичээлийн судалгаа хийж, хөтөлбөрөө энэ чиглэлээр сайжруулах, үр дүнгээр хэлэлцүүлэг зохион байгуулах, гуравдугаар улиралд судлагдахуун хооронд 2-3 хичээлийн интеграц бүхий бүтээлч гэрийн даалгавар сурагчдад өгч, нэг гэрийн даалгавраар тэдгээр хичээлд үнэлгээ тооцох, дөрөвдүгээр улиралд багш сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргах зэргээр сургуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд багшийн хөгжлийг чиглүүлсэн төлөвлөлтөөр харилцан дэмжвэл үр дүнтэй. Түүнчлэн ХГҮА-д бүтээлч хандлагыг дэмжихүйц өөр бусад үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг дэмжих орчныг бүрдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулах зэргээр сургуулийн зорилгыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх цөөн тооны ажлыг харилцан холбоотой бүхий тодорхой хэдэн үйл ажиллагаагаар нэгтгэн зангидаж, үр дүнгээ тооцох хяналт шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлж, засан сайжруулж явах нь сургуулийн менежментийг хэрэгжүүлэх үндсэн зорилго юм.

Нар хөрш зэрэгцээ сургуулийн багш нар нэгдэн МХБ байгуулж, БШУГ, багш бэлтгэх их сургууль, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран ажлын байранд мэргэжил дээшлүүлэх шат дараатай сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой ба ЗАН, МХБ-ээр хамтран сургалт, үйл ажиллагааг дараах хэлбэрүүдээр зохион байгуулж болно.

Үүнд:

Ажлын байранд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах

- Судлагдахууны онолын сургалтуудыг мэргэжилтнүүдээс авах
- Хүүхдийн хөгжил, сэтгэл судлал, тархи судлал зэрэг онолын сургалтуудыг мэргэжилтнүүдээс авах
- Онлайн курс, вебинар, подкастууд дээр хамтран суралцах
- Ажлын байран дээр жижиг багаар хэрэгцээт сургалтад хамрагдах
- Мэргэшсэн мэргэжлээр магистрын зэрэг олгох сургалтад хамрагдах

Ажлын байранд мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах

- Хамт олондоо зөвлөгөө өгөх, тэднээс зөвлөгөө авах, харилцан туршлага солилцох
- Хичээлийн болон үйлийн судалгаа хийх
- Мэтгэлцээн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Шинэ илтгэл, сэтгүүл, нийтлэл, ном болон багшлах тухай баримтат киноны талаар бүтээлч харилцан ярианы клуб байгуулах
- Туршлагатай багш нар туршлага багатай багш нарыг менторлон дагалдуулах
- Багш нар судлаач, мэргэжилтэн, багш бэлтгэх сургуулийн багш нараас суралцах боломжтой байхаар тусгайлан зохион бүтээсэн үзэсгэлэн, бага хурал, илтгэлд оролцох
- Олон улсын солилцоо, багш солилцоонд оролцож, шинэлэг зүйл суралцах, туршлагаа түгээн дэлгэрүүлэх, туршлага судлах
- Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны тодорхой болон ерөнхий талуудын талаарх мэдлэг, үнэлэмжийг нэмэгдүүлэх өөрийн эргэцүүлэл, уншлага, судалгаа хийх

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэлбэрүүд үр дүнтэй байхын тулд дараах нийтлэг шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Багш нарын хэрэгцээ сонирхолд нийцсэн байх
- Практик ач холбогдолтой байх
- Тодорхой зорилго, тогтсон хугацаа, үр дүнг тооцсон байх
- Сургалт, үйл ажиллагаа бүр эргэцүүлэлтэй байж, дадал хэрэглээ болгон хэвшүүлдэг байх
- Хамтын сэтгэлгээ, хүчин чармайлттай байх

Багш нарын хэрэгцээг ЗАН, МХБ, сургалтын менежер хамтран нэгтгэж, сургуулийн хэмжээнд багш нарын хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, түүнийг хангах сургалт, үйл ажиллагааг бие даан болон БШУГ, орон нутгийн бусад сургуультай хамтран, БЕГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний А/210 тоот тушаалаар тодорхой зааж өгсний дагуу төлөвлөнө.

Зураг 3.21. ЗАН болон МХБ-ийн төлөвлөгөө

2023 - 2024 оны хичээлийн жил												ЗАН болон Мэргэжлийн хөгжлийн бүлгийн төлөвлөгөө																										
IX			X			XI			XII			I			II			III			IV			V			VI			VII								
I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III						
Судлагдахууны онолын мэдлэгийн сургалт			Хүүхдийн хөгжил ба суралцахуйн онолын төлөөрх сургалт			XXI зууны чадвар ба хүүхэд төвтэй арга зүйн сургалт			Үнэлгээ, үнэлгээний шалгуурын дагуу даалгавар боловсруулах сургалт			Хүүхэд төвтэй арга зүйг хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Хичээл хоорондын хөндлөн интеграц хийх аргачлал			Туршилт, хэрэглэгдэхүүн хосолсон сургалтын аргачлалыг сайжруулах үйл ажиллагаа																				
			Судлагдахууны онолын модлогийг сайжруулах баталгах үйл ажиллагаа			Цахим ур чадварыг хөгжүүлэх сургалт			Үнэлгээний журмыг /A42G/ хэрэгжүүлэх, үнэлгээний зорилго, үнэлгээний шалгуурын дагуу даалгавар боловсруулах үйл ажиллагаа						Сэдэв хоорондын интеграцчилсан төлөвлөлт хийх үйл ажиллагаа			Туршилт, хэрэглэгдэхүүн хосолсон сургалтын аргачлалыг сайжруулж, хөтөлбөрт тусгах үйл ажиллагаа																				
Багшийн өөрийн үнэлгээ									Хяналт, шинжилгээ үнэлгээ																													

■ Судлагдахуунд суурилсан МХБ

■ Суралцахууд суурилсан МХБ

■ ЗАН



3.3.3 БАГШИЙН МАНЛАЙЛАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА, СОЁЛ, ӨӨРИЙН УДИРДЛАГАТАЙ СУРАЛЦАХУЙ



АСУУДАЛ

Багшийн манлайлал, хамтын ажиллагаа, хамтран ажиллах соёл дутмаг

- Багшлахуйн бүхий л ажлаа зөвхөн мэргэжлийн багш нарын хүрээнд Заах аргын нэгдэл, секцийн ажлаар ярилцдаг
- Сурагчдын даалгаврын гүйцэтгэл, суралцаж буй байдалд анализ хийх, хичээлээ хамтран төлөвлөх ажил дутмаг
- Сургууль дээр судлагдахууны МХБ байгуулсан боловч ЗАН, секцийн ажлаа орхигдуулсан
- Нэгдсэн төлөвлөлт багатай учир аливаа ажилд оролцохдоо бие биенээ хүлээж цаг их алддаг
- 2 ээлжинд хичээллэдэг болохоор хамтран ажиллахад хэцүү, бүлгээрээ уулзах цаг зав гардаггүй
- Олон жил ажилласан багш нар залуу багш нарыгаа бүлгийн ажлаа хий гэдэг, тухайн асуудлаар багш нар санал, бодол зөрдөг, маргалддаг, зөвшилцөлд хүрч чадахгүй тардаг
- Орон нутгийн боловсролын байгууллагын чиглүүлэг, сургууль, сургалтын менежерийн зөвлөгөө, манлайлал дутмаг
- Багш нар сонирхлоороо болон өөрийн багшлахуйд тулгамдсан асуудлаа шийдэхийн тулд бүлэгт нэгдээгүй
- Багш ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх боломжуудыг эрэлхийлэх, бие даан суралцах чадвар сул



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

1. Нэг бодлогыг олон аргаар бодох, өгүүлбэртэй бодлого хялбар аргаар бодох аргачлалд суралцан хичээлдээ ашиглаж байна.
2. Хүрд хэрэглэхгүй үржүүлэх үйлдэл хялбар хийх арга зүйгээр хичээл төлөвлөн зааснаар сурагчдад сонирхолтой хичээл болсон.
3. Ээлжит хичээлийн төлөвлөлтийг чадварт суурилан төлөвлөх арга зүйд суралцсан.

Үр дүн: Ажлын байран дээрээ бие даан суралцсанаар ажлаа төлөвлөх, өөрийн удирдлагатай суралцахын чухлыг ойлгосны зэрэгцээ технологийн чадамжаа хөгжүүлсэн.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

... түүх, нийгмийн ухааны багш нэгдэн судлагдахууны мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллаж сурлагын амжилт тодорхой хувиар ахисан, багш бүрийн арга зүй хөгжсөн байна.

1. Аймгийн бүх багш онлайн уулзалт хийж, 2022 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд анализ хийн ярилцсан.
2. Түүх, нийгэм судлал хичээлийн 2 дэд бүлэгт хуваагдан бүлгийн ажлын төлөвлөгөө боловсруулсан.
3. Бүлгийн ахлагчаа сонгон ажиллах дүрмээ боловсруулан баталсан.
4. Анги бүрээр агуулгын гүйцэтгэл гарган ямар агуулга дээр алдаа байгааг илрүүлсэн.
5. Гүйцэтгэлийн үнэлгээний даалгавар/суралцахуйн зорилт шинжлэн дийлэнх сурагчдын сул гүйцэтгэсэн даалгаврын алдааны шалтгааныг тодруулсан.
6. Гүйцэтгэл сул шалгагдсан агуулгаар хичээл төлөвлөлтөө сайжруулах арга замаа эрэлхийлсэн
7. Багш бүр дэд багуудад хуваагдан нэгж хичээлийн төлөвлөлт боловсруулан хичээл заасан үр дүнгээ онлайн уулзалтаар ярилцсан.
8. Заах, үр дүнг хэлэлцэх, сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг тооцон ажилласан.
9. Хичээлийн арга зүйн санаа, туршлага болгон бичих, бусдад түгээх ажил эхлүүлсэн.
10. Бүлгийн ажлын үр дүнд Нийгэм судлал хичээлийн агуулгаар жишиг даалгаврын “Цахимном” ажлын дэвтэр, Түүхийн хичээлээр “Хялбаршуулсан цахим арга зүйн материал” боловсруулан хэрэглэж байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Бүрэн дунд боловсролын сонгон судлах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ахлах багшийг ажиллуулж, эдгээр багш цахим сургуулийн судлагдахууны багш нартай хамтран сонгон судлах хөтөлбөрийн дэлгэрэнгүй төлөвлөлт боловсруулах, цахим хэрэгсэл ашиглан нэгж хичээл төлөвлөн хэрэгжүүлэх зэргээр мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллаж байна.

Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллана гэдэг нь багшлахуй, суралцахуйд тулгамдсан асуудлаа ажлын байран дээрээ багаар хамтран шийдэх хамгийн зөв гарц мөн бөгөөд багшлахуйн ажлаас тусдаа бие даасан ажил биш гэдгийг багш нар ярилцлагын тэмдэглэлд дурьджээ. Мөн харилцан суралцах, хамтран ажиллах соёлд суралцсан нь бидэнд маш их үр дүнтэй байлаа гэжээ..

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

“Ментор багш” хөтөлбөр БЕГ-ын цахим хуудсаар зарлагдсаныг олж мэдээд хамрагдах хүсэлтээ өгөгдсөн асуултын дагуу цахимаар илэрхийлсэн. Үүний дараа багшийн хөгжлийн талаар эсээ бичсэнээр уг хөтөлбөрт хамрагдах багшийн шалгуурт тэнцэж 2022-2023 оны хичээлийн 9 сарын турш ажлын байран дээрээсээ суралцан хөгжиж байна.

1. Чанартай арга зүйн зарчимуудыг судалж ажилдаа тусган хэрэгжүүлж эхэлсэн.
2. Энэхүү хөтөлбөрт хамрагдаж байгаа нэг ангийн Зөвлөх багш нарын заах арга зүй, бодит кейсүүдийг хэрхэн шийдвэрлэсэнээс суралцаж байна.
3. Ээлжит хичээл бүрдээ суралцахуйд суурилсан сургалтын аргуудыг хэрэглэх, сэдэлжүүлэх бодлогыг хэрэглээнд суурилах, нээлттэй асуултаар асуудлын учир шалтгааныг илрүүлэн сурагчдын эргэцүүлэн, бүтээлчээр сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ багаар хамтран ажиллах, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхийн төлөө эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч олон нийтийг сургалтын үйл ажиллагаанд оролцуулж хамтран ажиллаж байна.

Боловсролын ерөнхий газраас зарлаж буй багшийн хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг цаг алдалгүй авч хамрагдан хөгжих бүрэн боломжтой. Багшийн хөгжил надаас шалтгаална.

2022-2023 оны хичээлийн жилд Ментор багш хөтөлбөрт хамрагдан өөрийгөө хөгжүүлж буй багшийн сэтгэгдэл

Багш өөрийн мэргэжил, арга зүйгээ хөгжүүлэх нэг боломж нь хөгжих хэрэгцээндээ үндэслэн сонгон суралцдаг “Модуль” сургалт бөгөөд энэхүү сургалтад хамрагдсан нэгэн багшийн жишээг танилцуулъя.

- Сургалтын модуль зарлагдмагц сургалт бүрийн товч танилцуулгыг судалсан.
- Математикийн тооцоололд суралцуулах хялбар аргуудыг эзэмших, хичээл төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх хэрэгцээ надад үүссэн тул энэ модуль сургалтыг сонгон бүртгүүлсэн.
- Medle.mn цахим хаягаар сургалтын бүртгэл баталгаажсан, сургалт хэзээ эхлэх, хэрхэн суралцах тухай цахим шуудан ирсэн.
- APLUS цахим сургалтын платформд суралцсан.

Сургалтаар “Тоо тоолол” айн агуулга, арга зүй, арав, зуу, мянга, олон оронтой тооны дугаарлалыг таниулах, 10, 100-ийн дотор нэмэх, хасах үйлдлийг энгийн хялбар аргаар таниулах агуулгыг сонгон суралцсанаар миний заах арга зүйд дараах өөрчлөлт гарсан.



ЗӨВЛӨМЖ

Багшийн манлайлал, хамтын ажиллагаа, соёлыг хөгжүүлэхэд мэргэжлийн хөгжлийн бүлгээр яагаад хамтарч ажиллах хэрэгтэй вэ?

1. Багш, мэргэжлийн хөгжлийн бүлэгт нэгдсэнээр ажлын байран дээрээ хөгжих боломж нээгдэнэ.
2. Багшлахуй болон суралцахуйд тулгамдсан асуудалд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах нөхцөл бүрдэнэ.
3. Багш нар ажлын байран дээрээ хамтран хөгжих, харилцан суралцах соёлыг бий болгоно.

Зураг 3.22. Мэргэжлийн хөгжлийн бүлгийн бүдүүвч* зураглал



Мэргэжлийн хөгжлийн бүлэгт хэрхэн нэгдэн ажиллах вэ?

Хүснэгт 3.19. Мэргэжлийн хөгжлийн бүлэг ажиллах алхам

Алхам	Хийх ажил	Агуулга
НЭГ	Асуудлаа тодорхойлох	Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, судалгаа, санал асуулга гэх мэтээр тогтооно.
ХОЁР	Бүлэг байгуулах	Сонирхол, тулгамдсан асуудлаа шийдэх хэрэгцээ, дүрэм батлана.
ГУРАВ	Асуудлын шалтгааныг эрэлхийлэх	Багшлах арга зүй, сурах арга барил, оролцоо, бусад хүчин зүйлийн нөлөөллийг гаргана.
ДӨРӨВ	Бүлгийн ажлын төлөвлөгөө боловсруулах	Асуудал шийдэхэд чиглэсэн, уян хатан, зорилгодоо нийцсэн, ямар арга замаар асуудал шийдэх вэ гэдгээ тодорхойлно.
ТАВ	Төлөвлөгөөний дагуу ажиллах	Явц, үр дүнг хэлэлцэнэ, сайжруулна. Хамтын оролцоо, манлайллыг чухалчилна
ЗУРГАА	Үр дүнг хэлэлцэх	Бүлгийн ажлын үр дүнд асуудлаа хэрхэн шийдэв, бэрхшээл, сургамж, цаашид анхаарах зүйлийг тодруулна.

Дээрх хүснэгтэд дурдсан асуудлаа тодорхойлоход хэрэглэгдэх ажлын хуудсыг та бүхэнд хүргэж байна. Мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллахдаа шийдвэрлэх асуудлаа бодитой тодорхойлохыг хичээгээрэй.

Хүснэгт 3.20. Ажлын хуудас 1: Асуудлыг тодорхойлох

Асуултууд	Бичих хэсэг
Шийдвэрлэхээр сонгосон асуудлаа бичих	
Энэ асуудал яагаад чухал вэ?	
Асуудлын шалтгаан юу вэ? Ямар аргаар шалтгааныг тодруулах вэ?	
Энэ асуудал хэнд хамгийн их хамаатай вэ?	
Хэн энэ асуудлыг илүү их анхаарах шаардлагатай вэ?	
Уг асуудлыг ямар арга замаар шийдэх боломж байгаа вэ? Түүний давуу тал	
Асуудал шийдэгдсэний дараа гарах үр дүн юу байх вэ? Хэрхэн хэмжих вэ?	
Асуудлыг сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтөд хэрхэн тусгах вэ?	

Боловсролын салбарт хийгдэж буй бодлого, хууль эрх зүй, төсвийн шинэчлэлийн хүрээнд багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооноос багшийн тасралтгүй хөгжлийн тогтолцоонд шилжиж дараах өөрчлөлтийг хийж байна. Үүнд:

- танхим төвт төвлөрсөн сургалт, үйл ажиллагаанаас-цахим платформд суурилсан ажлын байран дахь сургалт, үйл ажиллагаанд
- батлагдсан нэг хөтөлбөрт сургалтаас-багш хэрэгцээндээ үндэслэн сонгон суралцдаг “Модуль” сургалтад
- Суралцахуйд болон судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын үйл ажиллагаанд шилжиж байна.

Дээрх чиг хандлагын хүрээнд багшийн тасралтгүй хөгжлийг сургуульд суурилсан менежментэд тусган хэрэгжүүлэх зөвлөмжийг энэхүү хэсэгт тусгасан болно.

Багшийн мэргэжлийн хөгжлийн зураглал

Сургуулийн удирдлага дараах зураглалын дагуу мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг удирдан явуулах боломжтой.

Зураг 3.23. Багшийн мэргэжлийн хөгжлийн зураглал



Мэргэжлийн хөгжлийн хэрэгцээгээ тодорхойлох
Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, өөрийн үнэлгээнд тулгуурлан хөгжих хэрэгцээгээ тодорхойлно.



Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах
A/210 тушаалын дагуу төлөвлөлт хийнэ.
Энэхүү зөвлөмжийн нэгдүгээр бүлгийн 1.3 хэсэгт бичигдсэн өөрийн үнэлгээний хэрэгсэл 5-ыг ашиглаарай.



Мэргэжлийн хөгжлийн бүлэгт нэгдэн ажиллах
2022 оны 08 сарын 17-ны өдрийн БЕГ-ын даргын баталсан аргачлал ашиглана.

Сургуулийн удирдах ажилтан нь багш өөрийн хэрэгжүүлсэн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг үнэлэхэд дараах ажлын хуудсыг ашиглах боломжтой.

Хүснэгт 3.21. Ажлын хуудас 2: Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг үнэлэх рубрик

№	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт				
		Хангалттай сайн (41-50)	Сайн (31-40)	Дундаж (21-30)	Дунджаас доогуур (11-20)	Хангалтгүй (10 түүнээс доош)
1	Хаяг	1.Орон нутаг 2.Сургууль 3.Мэргэшил 4.Хичээлийн жил 5.Овог нэр 6.Огноо бүрэн цэгцтэй	Бүрэн боловч 1-2 хэсгийг дутуу	3 хэсгийг бичиж, бусдыг дутуу, эсвэл эмх цэгцгүй	3-аас дээш хэсгийг дурдаагүй. Бичвэрийн шаардлага хангалтгүй	Эдгээрийг огт бичээгүй. Дутуу, дизайн нь эмх цэгцгүй, шаардлага хангаагүй
2	Эргэцүүлэл, өөрийн үнэлгээ, зорилго	Эргэцүүлэл, өөрийн үнэлгээ, зорилго уялдаатай бүрэн зөв гаргасан	Эдгээрийн аль нэг нь дутуу, эсвэл эргэцүүлэл-өөрийн үнэлгээ-зорилго уялдаа муутай	Эргэцүүлэл, өөрийн үнэлгээ, зорилго нь уялдаа тодорхой бус	Эргэцүүлэлгүй, өөрийн үнэлгээ хангалтгүй, зорилго тодорхой бус	Эргэцүүлэлгүй, өөрийн үнэлгээтэй, зорилго оновчгүй

3	Үе шат, хугацаа	Зорилгодоо хүрэх үйл ажиллагааг бүрэн оновчтой, үе шатаар нь төлөвлөсөн.	Үйлийг төлөвлөсөн ч бүтээлч үйл биш	Үйлийг дутуу төлөвлөсөн.	Зорилгодоо хүрэх үйл тодорхойгүй, оновчгүй	Үйл ажиллагааг төлөвлөөгүй, төлөвлөсөн нь шаардлага хангахгүй
4	Арга, зохион байгуулалт	Сонгосон үйлээ хэрэгжүүлэх арга, зохион байгуулалтыг оновчтой бүрэн төлөвлөсөн.	Үйлээ хэрэгжүүлэх арга барил оновчтой ч зарим хэсэг нь дутуу, ойлгомж муутай	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэлбэр оновчгүй, дутуу	Арга, зохион байгуулалтын хэлбэр оновчгүй, дутуу, буруу	Үйлээ хэрэгжүүлэх арга, зохион байгуулалтын хэлбэрээ сонгоогүй.
5	Нөөц, дэмжлэг тусалцаа	Шаардлагатай нөөц, дэмжлэгийг зөв оновчтой сонгосон	Нөөц, дэмжлэгийг дутуу тооцсон	Нөөц, дэмжлэгийг тогтоосон ч оновчгүй эсвэл дутуу	Нөөц, дэмжлэгийг оновчтой тогтоогоогүй эсвэл буруу	Нөөц болон дэмжлэгийг тогтоогоогүй
6	Гүйцэтгэлийн нотолгоо	Хөгжсөн байдлаа юугаар яаж нотлохоо урьдчилан тооцсон.	Хөгжлийн нотолгоог дутуу гаргасан	Хөгжлийн нотолгоог оновчгүй, дутуу	Нотолгоог оновчгүй, буруу	Гүйцэтгэлийн нотолгоог огт төлөвлөөгүй, буруу

3.3.4 БАГШИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГАТАЙ СУРАЛЦАХУЙ, ТЕХНОЛОГИЙН ЧАДВАР

Багш яагаад өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж технологийн чадвараа хөгжүүлэх хэрэгтэй вэ?

- Багш мэдээлэл технологийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх
- Хичээл сургалтын үйл ажиллагаанд технологи ашиглах болсноор сурагчдын сонирхол, танин мэдэх үйл ажиллагаа идэвхжиж, мэдлэгийн чанар дээшилж, мэдээллийн соёлыг эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ.



АСУУДАЛ

Багш мэдээллийн технологийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх хэрэгцээ шаардлага хангагддаггүй

- Сургалтын цаг болон хичээлийн цаг давхцдаг
- Мэргэжлийн багш нартай хамтран нэгж, ээлжит хичээлийн бэлтгэл хангах боломж байдаггүй
- Гадаад хэлний мэдлэг болон сурагчдын сонирхол, түвшинд нийцсэн хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй дутмаг



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Багш нар хичээлийн явцад сурагчдыг сэдэлжүүлэх, үнэлэх зорилгоор Moodle, Kahoot, Mentimeter Khan Academy, Brilliant, Plickers зэрэг апплейкшн платформын тодорхой модулийг бие даан судалж ашиглаж байна. Жишээ нь: Багш Plickers платформ ашиглан сурагч бүрт QR код тараан өгч сургалтын эхэнд болон төгсгөлд 1-2 минутын хугацаанд үнэлж болох юм.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Бүх багшид Microsoft хаяг үүсгэсэн хэдий ч багш нар төдийлэн ашиглахгүй байна. Бид энэхүү бүртгэлтэй хаягаараа дамжуулан тус платформд нэвтэрсэн тохиолдолд олон төрлийн апплейкшн ашиглан хичээлдээ хэрэглэх боломжтой хэрэглэгдэхүүн бэлтгэх, дундын мэдээлэл солилцох, бүлэг нээж ажиллуулах боломж бүрдэж байна.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Багш нар гар утас, таблет, нөтбүүк зэрэг хэрэгслээр дамжуулан интернэт орчинд олон төрлийн апплейкшн, сургалтын цахим платформ ашиглаж байна. Жишээ нь: Medle.mn сургалтын цахим платформд байршуулсан цагийн хуваарилалт, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт, цахим хичээл, интерактив хэрэглэгдэхүүн, виртуал лабораторийг ашиглан хичээлийн бэлтгэлээ бэлтгэж үр дүнд хүрсэн жишээ олон бий.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Математик, физик, биологи, хими, байгалийн шинжлэх ухааны хичээлд www.phet.colorado.edu сайтад байршуулсан виртуал лабораториуд байдаг. Багш нар тус виртуал лабораторийн ажлын заавар боловсруулан хичээлдээ ашиглаж байна. Мөн гэрийн даалгаварт туршилт ажлыг гүйцэтгэхэд сурагчид ихэд идэвхтэй оролцдог байна. Энэ лабораториуд нь вэб технологид суурилан HTML5 дээр бичигдсэн тул хэмжээ бага, онлайн болон оффлайн орчин ажиллах бөгөөд дурын интернэт хөтөч ашиглан ухаалаг төхөөрөмж ажиллах боломжтой.

... нийслэлийнн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ


Удирдлагын багаас дараах зохион байгуулалтыг хийхийг зөвлөж байна.

- Танхим болон цахим технологи ашиглан мэргэжлийн болон заах арга зүйгээ хөгжүүлэхэд орчин нөхцөлөөр дэмжих
- Уулзалтын цагийг харгалзан үзэж хичээлийн хуваарьт тухайн цагт хичээл тавихгүй байх
- Багш нар хэсэг бүлгээрээ нэгдсэн платформ дээр суурилан харилцах талбар үүсгэн зайн сургалтаар мэргэжлээ дээшлүүлэх боломж олгох
- Мэдээлэл нэгтгэх, өөрийн эргэлзээтэй ойлголтоо бататгах зорилгоор онлайн уулзалтыг хийх
- Онлайн хэлбэрийн уулзалтаар бие даан судалсан агуулгаараа мэдээлэл солилцох, санал бодлоо нэгтгэх, шинэ мэдлэг ойлголт өгөх танилцуулга хийх зэрэг арга хэлбэрээ чанаржуулах
- Багш цахим хэрэгдэгдэхүүнийг хамтран боловсруулан бэлтгэж, мэдээллийн технологийн болон мэргэжлийн мэдлэг чадвараа хөгжүүлэх боломж бүрдүүлэхийн зэрэгцээ хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах дундын хэрэглэгдэхүүний сан үүсгэх
- Танин мэдүүлэх (мультимедиа, интерактив технологийг эзэмших, түүгээр дамжуулан мэргэжлийн мэдлэг чадвараа дээшлүүлэх)
- Үйл ажиллагаанд хөтлөх (мэдээлэлд шинжилгээ хийх арга, хайх систем, машин болон мэдээлэл харилцааны технологийг эзэмших)
- Бие хүнийг хөгжүүлэх(түүний аналитик систем, харилцах ба холбоо тогтоох чадвар, хувирамтгай байдал) – ᠔ мэдээллийн технологийг оновчтой хэрэглэх арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн нь сурагчийн сурах сэдэл төрүүлэхүйц байдал, агуулга нь бодит амьдралын асуудалд суурилсан байдал, тодорхой үйл ажиллагаанд хөтөлсөн байдал, өргөн сонголттой байхыг шаардлага болгон чиглүүлээрэй.

Таны мэдээлэл давхцаагүй тохиолдолд та сургуулийн менежерт хандан өөрийн мэдээллийг боловсролын мэдээллийн технологийн ESIS системд бүртгүүлнэ үү.

Зураг 3.25. ESIS системд бүртгүүлэх заавар



Та өөрийн и-мэйл хаягийг ашиглан **Aplus.mn**-д нэвтэрч орно.

Баруун дээд буланд миний профайл цэс дээр дараад хувийн мэдээллээ бөглөн **“Багш болох”** хүсэлт дээр овог, нэр, РД бичнэ.

Таны **ESIS** бүртгэлтэй таны мэдээлэлтэй давхацсан тохиолдолд баталгаажиж үндсэн сургалтад хамрагдах эрхтэй болно.

Багшийн мэргэжлийн хөгжлийг сургуулийн удирдлагын зүгээс хэрхэн дэмжих вэ?



АСУУДАЛ

Төлөвлөгөөнүүд уялдаа холбоогүй

- Багшийн ажлын төлөвлөгөө, мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө, сургуулийн төлөвлөгөө хоорондоо уялдаа холбоо бага
- Олон төрлийн төлөвлөгөө нь цаасны ажлыг нэмэгдүүлдэг
- Төлөвлөгөөнүүдийг уялдуулах маш төвөгтэй
- Олон үйл ажиллагааг төлөвлөдөг тул төлөвлөсөн ажлаа хийж амждаггүй

- Зарим тохиолдолд төлөвлөөгүй ажил хийх болдог
- Үр дүнтэй, хэрэгцээтэй сургалт дутмаг байдаг
- Багшийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаггүй
- Өөрсдийн санаачилгаар сургалт, үйл ажиллагаанд хамрагдах нь ховор



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Цаг хугацаа хүрэлцдэггүй, төлөвлөгөөнүүд уялдаа холбоогүй байдагтай холбоотой асуудлыг шийдвэрлэж буй сургуулиудын зарим туршлагаас

- Сургуулийн багш бүр мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө гаргасан. Багш нартай хамтран суралцахууд суурилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.
- Сургуулийн төлөвлөгөөг хамт олноороо ярилцаж боловсруулдаг.
- Долоо хоногийн аль нэг өдрийн тодорхой цагийг багш хөгжих цаг болгож, тухайн цаг дээр сургуулийн зүгээс өөр ажил төлөвлөдөггүй.

... нийслэлийн ... дүүргийн ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэж буй сургуулиудын зарим туршлагаас

- Багш өөрийн хэрэгцээнд тулгуурлан сургалтуудаас сонгон хамрагдах
- Arplus.mn, Esurgalt.mn сургалтуудад хамрагдах
- Үндсэн сургалтад хамрагдсан багш нар бусад багш нартаа сурч мэдсэн зүйлээрээ сургалт зохион байгуулах, түгээн дэлгэрүүлэх
- ЗАН болон бусад чөлөөт цагаараа бусдаасаа суралцах
- Аймгийнхаа бусад багш нартай туршлага солилцох, хамтран ажиллах

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Мэргэжлийн хөгжлийг дэмжих орчинтой холбоотой асуудлыг шийдвэрлэж буй сургуулиудын зарим туршлагаас

- Төсвийн шинэчлэлийн хүрээнд олгогдож буй санхүүжилтийг багш нар ЗАН болон хэсэг бүлгээрээ нийлж хэрэгцээтэй зарим техник хэрэгслээ худалдан авах
- Нэмэлт интернэт датаг багш өөрөө зохицуулдаг

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Багшийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэж буй сургуулиудын зарим туршлагаас

- Сургуулийн түвшинд багшийн ёс зүйн дүрмийг багш нарт танилцуулж, гарын үсэг зуруулах
- Багшийн ёс зүйн талаар сургалтууд зохион байгуулах
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд ёс зүй, харилцаа, хандлагын талаар сургалт зохион байгуулах
- Багш өөрөө цаг барих, мэндлэх зэргээр сурагчдад үлгэр дуурайл болох
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гурвалсан гэрээ байгуулах
- Сургуулийн сэтгэл зүйчидтэй уулзаж зөвлөгөө авах, хамтран ажиллах
- Сургуулийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сургалтад хамруулах, чадавхыг сайжруулах

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн түвшинд багшийн ажлын төлөвлөгөө, мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө, ЗАН-ийн төлөвлөгөө, мэргэжлийн хөгжлийн бүлгийн төлөвлөгөө, сургуулийн төлөвлөгөө гэх мэт олон төлөвлөгөөг уялдуулах, багш нарт хөгжих цаг боломж гаргах зохицуулалтыг сургуулийн удирдлагын зүгээс хийхийг зөвлөж байна.

- Төлөвлөгөөг гаргахдаа олон үйл ажиллагаа төлөвлөхдөө бус зайлшгүй шаардлагатай гол үйл ажиллагаануудыг бодитой төлөвлөх
- Олон төрлийн төлөвлөгөөг хооронд нь уялдуулан төлөвлөх (төлөвлөгөө боловсруулахдаа багш нарын оролцоог дэмжих)
- Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг сургуулийн төлөвлөгөөнд тусгах
- Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцдаа сайжруулж байх
- Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу багш мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх цаг хугацааны боломжоор хангах, зохицуулалт хийх шаардлагатай байна.

Багшийн хөгжих хэрэгцээнд сургалтыг нийцүүлэхэд удирдлагын зүгээс манлайлахыг зөвлөж байна. Үүний тулд, багш мэргэжлийн хөгжлийн хэрэгцээгээ өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр зөв тодорхойлох шаардлагатай.

Сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр ажилласан зарим сургуулиудын багш нарын төлөөллөөс мэргэжлийн хөгжилтэй холбоотой асуулгын судалгаа авч багшийг мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж болохыг зөвлөж байна.

Зураг 3.26. Багшийн хөгжих хэрэгцээг тодорхойлох агуулгын хувилбар



Үндсэн, зорилтот болон сонголтот сургалтаас гадна сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа болох үйлийн судалгаа, хичээлийн судалгаа, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаа, ахмад, туршлагатай багшийг дагалдан сурах, бусад багш нарын хичээлд суух зэрэг хэлбэрүүдийг өргөн ашиглаарай.

Мөн сургуулийн удирдлагын зүгээс залшгүй хамрагдахаас бусад мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш өөрөө сонгох боломж нөхцөлөөр хангаж, дэмжээрэй. Ялангуяа,

- Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсаны дараа багш сурч мэдсэн зүйлээ ажилдаа туршин хэрэгжүүлэх, үр дүнг бусадтай хуваалцах,
- Шинээр сурч мэдсэн зүйлсээ хэрэгжүүлж, туршихад нь цаг боломж олгох,
- Сургалтын дараа ажлын ачааллаар хэт дарахгүй байх,
- Сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэхэд нь тулгарч буй бэрхшээлийг нь сонсох, зөвлөн туслах,
- Бусад сургуулийн багш нартай хамтран суралцах боломж бүрдүүлж, холбоо тогтоож өгөх
- Сургуулийн дотоод нөөц боломжоо ашиглан багшийн хөгжлийг дэмжих орчныг бий болгох гэх мэт

Мөн багшийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой дараах нийтлэг зүйлсэд сургуулиудын удирдлага анхаараарай. Үүнд:

1. Багш, ажилтныг ёс зүйн алдаа, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах
2. Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд чиглэсэн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх. Тухайлбал, тэдний эрх, үүргийг танилцуулж, багш, ажилтанд хүндэтгэлтэй хандах талаар тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх
3. Багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн алдаа, зөрчлийг цаг тухай бүрд нь илрүүлж шийдвэрлэх, тухайн алдаа, зөрчил гарах болсон шалтгаан нөхцөлийг илрүүлж, арилгах арга хэмжээ авч хэвших
4. Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлж, байгууллагыг соёлыг хэвшүүлэх

3.4 СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТААТАЙ ОРЧНЫГ ХЭРХЭН БҮРДҮҮЛЭХ ВЭ?

Зураг 3.27. Сургалтын стратеги, орчин

Сургалтын орчин нь сурагчдын сурлагын амжилт, хөгжил төлөвшил, сэтгэл зүйд чухал үүрэг гүйцэтгэдэг. Орчин үед сургуулийн анги танхимаас гадна гэртээ сурах орчин, суралцахуйн стадион, виртуал орчин гэх мэт сургалтын орчныг өргөн утгаар авч үзэх болсон байна. Монгол улсын боловсролын ерөнхий хуулийн 3.1.12.-т “сургалтын орчин” гэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг” гэж тодорхойлсон байна. Суралцагчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, орчны эрүүл аюулгүй байдал, орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын орчныг бүрдүүлэхэд сургуулийн менежмент нь чухал юм.



Сурагч төвт суралцахуй: гол зорилго нь бүх сурагчийн хувь хүний хэрэгцээнд нийцүүлэн суралцах боломжийг нээх юм. Түүнчлэн ирээдүйд шаардлагатай чадвар, чадамжийг эзэмших үндсийг бүрдүүлэхийн зэрэгцээ сурагчид бие даан удирдах чадвараа хөгжүүлэх, нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжлийг дэмжих юм.

Багш нарын хамтын ажиллагаа: 2011 оны Стэнфордын судалгаагаар багш нарын хамтын ажиллагаа их байх тусам суралцагчийн амжилт сайн байдаг болохыг тогтоожээ. Багш хамтран ажиллах олон боломж бий болсон үед бий болдог “нийгмийн капитал” нь гадны мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх “хүний капитал”-аас илүү үр дүнтэй гэж судалгаагаар дүгнэжээ. Нэмж дурдахад, багшийн хамтын ажиллагаагаар сургуулиуд 21-р зууны боловсролын зорилгыг дэмжсэн салбар дундын төслүүд, багаар хичээллэх, блок хуваарийг санал болгох боломжтой.

Эерэг уур амьсгал: Сургуулийн эерэг уур амьсгал нь нийгэм, төлөвшлийн хөтөлбөртэй холбоотой. Энэ төрлийн хөтөлбөр нь сэтгэл хөдлөлөө удирдах, илэрхийлэх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, хариуцлагатай шийдвэр гаргах ур чадварыг эзэмших, хөгжүүлэх, дадлагажуулахад оршино.

Технологийн интеграц: Компьютерын лабораторитой хэдий ч интернэтэд нэвтрэх боломж хязгаарлагдмал, зөөврийн төхөөрөмжүүдийн хэрэглээ хязгаарлагдмал, анги танхим дахь технологийн бага хэрэглээ зэрэг нь технологийн интеграцчлалын хувьд цаг үеэсээ хол хоцорсон болно.

Уян хатан хуваарь: Ердийн хичээлийн өдрийн хуваариар сургалтын зорилго болон хичээлийн явц хоёрын хоорондын холбоог хангах нь тийм ч хялбар биш. Өөрөөр хэлбэл, хичээлийн өдрийг 40 минутын хичээлийн цагуудад жигд хуваах нь сургалтын хөтөлбөрийг хүргэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг хамруулах үр дүнтэй арга боловч сурагчдын жинхэнэ оролцоо, гүнзгий ойлголтоор хэмжигдэх бодит суралцахад үр дүнтэй байж чадахгүй.

Хамтын ажиллагаа, түншлэл: Хүрээлэн буй орчин, олон нийт, глобал хамтын ажиллагаа, түншлэл нь боловсролд туйлын чухал биш ч сургалтын орчныг бүрдүүлэхэд чухалд тооцогдоно.

OECD-ийн санал болгосон Сургалтын орчны үнэлгээний хөтөлбөр (Learning Environments Evaluation Programme) сургуулийн сургалтын материаллаг орчин боловсрол, суралцахуйд хэрхэн дэмжлэг үзүүлдэг, сургалтын үр дүнд нөлөөлөх чухал хүчин зүйлүүдийг тодруулахдаа дараах 3 хэмжигдэхүүнээр үнэлдэг. Эдгээрийн цаана 1) аюулгүй, тав тухтай байдал, 2) орон зайн ашиглалт, орон зайн зохион байгуулалт, 3) сургуулийн талаарх мэдээллийг илрүүлэхийг зорьдог. Үүнд:

Сургалтын үр дүнтэй орчныг бүрдүүлэх (үр дүнтэй байдал)

- » Сургууль эсвэл сургуулийн тогтолцоо боловсролын зорилтоо зохих ёсоор биелүүлэх чадвар. Боловсролын үр дүнтэй байдлын судалгаанууд нь тодорхой нөөцийн орцууд нь үр дүнд эерэг нөлөө үзүүлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийдэг, өргөн хүрээ

Нөөц ба орон зайн төлөвлөлт, ашиглалт, менежментийн хувьд орон зайг илүү үр ашигтай ашиглах боломжийг олгох (үр ашигтай байдал)

- » Боловсролын үр ашиг: боловсролын зорилтуудыг аль болох бага зардлаар биелүүлэх. Өөрөөр хэлбэл, үр ашиг гэдэг нь үр дүнтэй байх ба үүнд хамгийн бага зардлаар хүрэх нэмэлт шаардлага юм.

Хэрэглэгчдийн тав тух, хүртээмж, эрүүл, аюулгүй байдал (хүртээмжтэй байдал)

- » Боловсролын хүрэлцээ: Хүн ам зүй, нийгэм, улс төрийн өөрчлөлтийн үед суралцагчийн суралцах чадварт хамгийн их нөлөөлөхүйц боломж(жишээлбэл, аюулгүй байдал, ус, байгалийн гэрэл, эрчим хүч, дулаан, технологийн хүртээмж ...)-оор хангахад шаардлагатай барилга байгууламжийн суурь бүрэлдэхүүн хэсэг.

Эндээс харахад сургуулийн материаллаг орчин нь сурагчдын сурлагын амжилт төдийгүй тэдний сэтгэл хөдлөлийн чадвар зэрэг сургуулийн нийт амьдралд нөлөөлдөг бөгөөд чухал хүчин зүйл болдгийг харж болохоор байна. Мөн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг даган сургалтын орчныг түүнд нийцүүлэн өөрчилж байх шаардлагатай байна.



АСУУДАЛ

Сургуулийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны тайлан, үр дүнгээс сургуулиудад тулгамдаж буй орчинтой холбоотой асуудлыг дараах гурван чиглэлд ангилж байна. Үүнд:

- Эрүүл, аюулгүй байдал
- Нөөц, хүртээмж
- Зохион байгуулалт, ашиглалт

Орчны эрүүл, аюулгүй байдал

- » Анги танхим, орчны аюулгүй байдал хангалтгүй
- » Спорт заалны аюулгүй байдал хангалтгүй
- » Дотуур байрны сурагчид, үдийн хоол, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах
- » Сургууль орчмын ногоон байгууламж хангалтгүй
- » Бохирын систем, 00-ын үнэр ойр орчмын ангиудад үнэртдэг, салхитай үед сургууль нийтээрээ 00-ын үнэр үнэртдэг
- » Замын хөдөлгөөний аюулгүй байдал
- » Цахилгааны болон галын аюулгүй байдал



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Орчны үнэлгээг хийж, эрсдэлтэй нөхцөл байдлыг илрүүлж, сургуулийн гадаад болон дотоод орчинд эрсдэлтэй зүйлсийг засан сайжруулсан.

Орон нутаг болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөөлөвч, хамгаалалт, аюулгүйн гарцын тэмдэг тэмдэглэгээ гэрэлтүүлгийг хийсэн

Сургууль өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан багш, ажилчид, сурагчдын санаачилгаар мод, бут тарих Эко клуб байгуулсан.

Ногоон байгууламж, камержуулалтыг шийдэхэд сургуулийн төсвөөс гадна ТББ, төсөл, хөтөлбөрүүдэд төсөл бичиж санхүүжилт авсан.

Багш, сурагчдын хүрээнд зорилтот аяныг өрнүүлэн асуудлыг шийдвэрлэсэн.

.....аймгийн сумын ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж боловсролын зорилгод хүрэхэд сургуулийн орчин чухал гэдгийг өмнө дурдсан. Сүүлийн үеийн боловсролын орчинд гарч буй өөрчлөлтөөс харахад сургуулийн орчин нь эрүүл, аюулгүй байхаас гадна хэрэглэгчийн ая тухыг хангахыг шаардаж байна.

Сургуулийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд сургууль, олон нийт, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо чухал үүрэгтэй. Тиймээс үүнд дараах стратеги чухал. Үүнд:

Зураг 3.28. Орчны менежментийн бүтэц

Менежментийн бүтэц: ХАБЭА-н ажилтан эрсдэлийн үнэлгээ хийнэ гэсэн нийтлэг буруу ойлголт байдаг ч үнэндээ эрсдэлийн үнэлгээг ХАБЭА-н ажилтан, шугаман удирдлага, мэргэшсэн ажилтны төлөөллөөс бүрдсэн баг хийх урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа:

- юуг, яаж
- эрсдэлийн үнэлгээ хийх
- хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлах
- хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлох



үнэлгээг тодорхой давтамжтайгаар төлөвлөн, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгож, хэрэгжүүлэх хамтын ажиллагаа: оролцоог хангах, хамтрах Сургуулийн сургалтын орчныг бүрдүүлэхэд сургалтын хөтөлбөрийн онцлог, хэрэглэгч буюу суралцагч, багшийн хэрэгцээ, олон нийт, орон нутгийн хэрэгцээ, санхүүгийн нөөц боломж зэрэг олон зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

Зураг 3.29. Сургалтын орчныг бүрдүүлэхэд оролцох, хүчин зүйлс



Prakash Nair (2014) нь багш төвтэй сургалтаас зайлсхийх, дээр дурдсан суралтын стратегид гарч буй өөрчлөлтөд нийцсэн сургуулийн орчны дизайнчлалын 4 зарчмыг санал болгосон. Бид сургалтын орчныг үнэлэх, төлөвлөх, бүрдүүлэх, ашиглахад энэхүү стратегийг ашиглахыг зөвлөж байна.

Зураг 3.30. Сургуулийн орчны дизайнд баримтлах зарчим



Сургалтын орчныг үнэлэх аргачлал өөрчлөгдөж байна. Өмнө нь сургуулийн барилга байгууламж, хүрээлэн буй орчны бүрдэл, чанарыг хэмждэг байсан бол сүүлийн үед сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих сургалтын орчны үр нөлөө талаас үнэлж байна.

Гэтэл манай улсын хувьд сургуулиуд сургалтын орчноо үнэлэх практик зөвхөн эрүүл, аюулгүй орчноор хязгаарлагдаж байгаа нь ажиглагдаж байна. Харин сургалтын орчныг хэрэглэгчийн тав тух, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг элемент талаас үнэлэх нь хангалтгүй байна. Сургалтын орчны үнэлгээ нь дараах циклийн дагуу, давтамжтай, тасралтгүй хийгдэнэ.

Зураг 3.31. Сургалтын орчны үнэлгээний цикл



Тиймээс цаашид сургалтын гадаад, дотоод орчны үнэлгээг дараах 2 чиглэлээр, 1) эрүүл, аюулгүй байх талаас нь эрсдэлийн үнэлгээ, 2) эрүүл, тав тухтай байх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин талаас нь хийхийг зөвлөж байна.

Дараах үнэлгээний хуудас, зөвлөмжийг ашиглан сургуулийн орчны эрүүл, аюулгүй байдалд өөрийн үнэлгээг хийж болно. Үүнд:

Сургууль, дотуур байрны эрүүл ахуй, аюулгүй орчны талаарх стандарт, дүрэм, журамд баримжаалсан хяналтын хуудас	
Сургалтын орчин, дотуур байрын үйлчилгээ	Сургалтын орчин
БШУ-ны Сайдын тушаал. 2023.03.28. Дугаар А/127	БШУС-ны Сайдын тушаал 2019.12.27. Дугаар А/803
Дотуур байр, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй	Галын аюулгүй байдал
ЭМ-ын Сайдын тушаал.2023.03.06. Дугаар А/78	ОБЕГ-ын даргын тушаал. 2020.10.28. Дугаар А/235
Аюулгүй байдлыг үнэлэх арга зүй, зөвлөмж	
Гамшгийн үнэлгээний ерөнхий арга зүй	Сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж

Мөн эрүүл, аюулгүй байх талаас нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийж болно.

Харин сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тохируулгат орчин талаас нь үнэлэхдээ хэрэглэгчийн /багш, сурагч/ сэтгэл ханамж, хэрэгцээний үнэлгээ хийнэ. Энэ нь дараах зүйлсэд төвлөрөх болно.

- Бүх хэрэглэгч сургалтын орчныг сайн ашиглаж чадаж байна уу?
- Багш сургалтын орчинд оновчтой ажиллаж чадаж байна уу?
- Сургалтын орчны сургалтын зорилго нь сурагчдын суралцах туршлагад илэрч байна уу?

Энэ талаар энэхүү зөвлөмжийн сургалтын орчин хэсгийн ашиглалт, зохион байгуулалт хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Сургуулийн гадаад, дотоод орчны эрүүл, аюулгүй, тав тухтай байдалд үнэлгээ хийж, үр дүнгийн дагуу хийх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн асуудал тулгардаг нь сургуулиудын жишээнээс харагдаж байна. Тиймээс асуудлыг ач холбогдлын түвшнээр эрэмбэлэн, хэрхэн сайжруулах талаар сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган, төсвийн төлөвлөлтөд тусгах шаардлагатай.

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2.-д "Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд ..., төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, ... төлөвлөж зарцуулна."

Сургуулиуд гадаад, дотоод орчны тохижилтын зарим асуудлаа орон нутгийн захиргаа, ТББ, төсөл, хөтөлбөрүүдийн санхүү, нөөцийн тусламжтайгаар шийдвэрлэсэн байна.



АСУУДАЛ

Материаллаг нөөц, хүртээмж

- Сургалт-туршилтын байгууламж, анги танхим хүрэлцээгүй
- Сүүлийн үед авч байгаа сургалтын хэрэглэгдэхүүн шаардлага хангахгүй, туршилтын багаж хэрэгслийг ашиглах заавар, зөвлөмж байхгүй
- Цахим орчин бүрдүүлэлт хангалтгүй, хүрэлцээгүй
- Дотуур байрны хүүхэд амьдрах өрөөний ширээ, сандал хүрэлцээгүй
- Ариун цэврийн өрөө хүрэлцээгүй



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн сургалтын орчныг сайжруулах чиглэлээр БШУЯ, БЕГ, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоотойгоор 350 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг авч багш, сурагчдын ая тухай орчин нөхцөлд ажиллах, сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

.....аймгийн сумын..... ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Дэлхийн Зөн олон улсын байгууллагаар 20,000,000 төгрөгийн “Стандартад нийцсэн сэтгэл зүйчийн өрөө тохижуулах” төслийг дэмжүүлэн засварын ажлыг эхлүүлээд 90.0 хувьтай ажиллаж байна.

Зөгийхөн төслийн хүрээнд Гүүд Нэйборс Монгол ОУ-ын ТББ-ын Мангирт ОНХХ-ийн дэргэдэх Хүүхдийн эрхийн клубын гишүүдийн санаачлагаар манай сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын хэрэгцээнд зориулсан компьютер болон принтерийг сургуулийн номын санд байршуулж сурагчид үнэ төлбөргүй ашиглаж байна.

“Гоё сургууль” төслийг аймгийн орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

.....аймгийн сумын..... ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Сургалтын орчны материаллаг нөөц, хүртээмжтэй холбоотой асуудлын ихэнх нь санхүүжилт буюу нөөцийн хуваарилалт, хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэгдсэн байна.



ЗӨВЛӨМЖ

Бидний 1-р бүлэгт санал болгож буй сургуулийн менежментийн пирамид загварыг ашиглан богино, дунд, урт хугацаанд бүхлээр нь харж сургалтын орчинд шаардагдах материаллаг нөөцийг тодорхойлох, ингэхдээ орон нутаг, талуудын оролцоог хангахад анхаарна.

Сургалтын орчинд зайлшгүй шаардлагатай материаллаг нөөц, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нь тухайн сургуульд хүрэлцээтэй байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор сургуулийн гадаад, дотоод материаллаг орчныг үнэлэх өөрийн үнэлгээний хуудсыг боловсруулна.

Сургалтын орчин дахь материаллаг нөөц, хүртээмжийн өөрийн үнэлгээ хийхдээ дараах үнэлгээний хэрэгсэл, зөвлөмжийг ашиглаж болно. Үүнд:

Сургалтын орчинд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад тавигдах шаардлага, түүнд баримжаалсан хяналтын хуудас

Сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт батлах тухай	Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
БСҮХ-ийн захирлын тушаал. 2022.10.28. Дугаар А/70	БШУ-ны Сайдын тушаал. 2023.03.28. Дугаар А/127
	
Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам	Цахим сурах бичиг, ерөнхий боловсролын сургалтад ашиглах сургалтын нээлттэй материалд тавих шаардлага
БШУ-ны Сайдын тушаал. 2022.11.14. Дугаар А/465	БШУ-ны Сайдын тушаал. 2021.05.21. Дугаар А/193
	
Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай	
МУ-ын Засгийн газрын тогтоол. 2022.03.02. Дугаар 91	
	

Тухайн сургуулийн онцлогоос хамаарч өөрийн үнэлгээний хуудсыг сайжруулан боловсруулж болно.

Сургууль өөрийн үнэлгээгээр илрүүлсэн материаллаг нөөцтэй холбоотой асуудлуудыг ямар хугацаанд хэрхэн яаж шийдвэрлэх талаар төлөвлөгөө гарган, дотоод нөөц бололцоо, бие даасан төсөл хөтөлбөрөөр шийдэх боломжтой юу гэх мэтээр шинжилгээ хийнэ.

Салбар дундын болон төсөлд-суурилсан суралцахуйг бодитоор хэрэгжүүлэх үнэ цэнтэй орчинг бий болгохын тулд орон нутгийн олон нийтийг татан оролцуулах, хамтран ажиллах, засаг захиргааны байгууллагуудын тухайн жилийн зорилго, төлөвлөгдсөн ажилтай уялдуулан богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргана.

3.5 СУРГУУЛИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ АРГАЧЛАЛУУД

Сургалтын багаж тоног төхөөрөмжийг хэрхэн бүрдүүлэх вэ?

Өөрийн сургуулийн сурагчдын сурах хэрэгцээнд тулгамдсан асуудал, сургуулийн зорилготой нягт уялдаа холбоотой байхад анхаарна.

Сургалтын материаллаг орчин тэдгээрийн ажиллагаа, ашиглалтын баталгааг хангахдаа тогтвортой байдлын зарчмуудад нийцүүлэн, хүүхдэд ээлтэй, тодорхой зорилго, ялгаатай суралцахуйд зориулсан, уян хатан, аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэхэд чиглэнэ.

Материаллаг нөөцийг бүрдүүлэхдээ олон талаас нь хэрэглэх боломжийг нь харгалзан үзнэ. Жишээ нь: Байгалийн ухааны хичээлүүдээр ашиглах боломжтой сургалт туршилтын байгууламжийг ургамал, амьтны төрөл зүйлтэй танилцах, улирлын өөрчлөлт, шавьж, амьтны төрөл зүйлтэй танилцах шийдлийг бодолцож, ногоон байгууламжийг байгуулахдаа өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ сургалтад ашиглаж болохуйцаар төлөвлөж гадаад орчны ногоон байгууламж, сургалт туршилтын талбайн асуудлыг хамт шийдвэрлэнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сонгоход тавигдах шаардлагыг үндэслэн “Сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт” батлагдан гарсан. Mlab 1.0 цахим бүртгэлийн системд өөрийн сургуульд байгаа хэрэглэгдэхүүний бүртгэл үүсгэснээр шаардлага хангасан, хангаагүй, засварлах, эд анги сэлбэх шаардлагатай, нэмэлтээр авах шаардлагатай кабинет, лабораторийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сургуулийн захирал, сургалтын менежер, санхүүгийн ажилтан, багш танилцах боломжтой.



Mlab 2.0 Багш, у
дирдлагад зориу
лсан гарын авла



Mlab 2.0 Мэргэж
илтэнд зориулса
н гарын авлага

Сургалтын багаж, төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээс гадна хэрэглэгдэхүүнийг хадгалах байршуулах кабинет, лаборатори, анги танхимын онцлог, ашиглалт зориулалтыг тооцон тоноглол, хийц, загвар, гоо зүй, интерактив байдал зэргийг тогтмол сайжруулна.


Сургалт туршилтын байгууламж, анги танхимын хүртээмжийн асуудлыг хэрхэн шийдэх вэ?

Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтийн, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулж, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан танхимын бус сургалтаар хөгжүүлэх нь оновчтой.

Монгол Улсын Засгийн Газрын “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 2022 оны 91 дүгээр тогтоолоор танхимын бус сургалтын зардлыг нийт хувьсах зардлын 0.2 хувь байхаар баталсан.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хөгжүүлэхийн тулд дараах байдлаар танхимын бус сургалтын зардлын тодорхой хувийг тусгаж, сурагчийг хөгжүүлэх чиглэлээр байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг харуулсан жишээ загварыг санал болгож байна.

Зураг 3.32. Хүүхэд хөгжлийн үйл ажиллагааг бусад нөөц дээр тулгуурлах шийдвэрлэх жишээ





АСУУДАЛ

Ашиглалт, зохион байгуулалт

- Ахлах ангийн сурагчид цахим хичээлд хамрагдах боломж хомс
- Номын сангийн үйл ажиллагаа хангалтгүй, баяжилт хийгддэггүй



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Орон нутагт хүсэлт гаргаж цахим танхим байгуулж, нөхөн хангалтын зардлаас таблет авсан.

Хичээлийн жилийн эхэнд сургуулийн сурагчдад “Уншихаа боливол сэтгэхээ болино” аян өрнүүлж сурагч бүрийг сүүлийн үеийн уран зохиолын болон хүүхдийн ном бэлгэлэх зуны даалгавар өгсөн.

“Орчноо номоор гоё”-1 сарын аянг зохион байгуулж сурагчдын нас сэтгэхүйд тохирсон тэдний оюун бодлыг тэлэх номын хандивын аянг зохион байгуулж Хэрлэн 4-р сургуулийн багш нар хамрагдсан.

Хамт олон сургуулийн орчныг сайжруулан сурагчдын амрах, хичээл давтах, ном унших таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна. “НОМ ХАНДИВЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-г санаачлан үлгэрийн, уран зохиолын, арга зүйн гарын авлага зөвлөмж зэрэг нийт 2208 ширхэг номыг цуглууллаа.



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн сургалтын орчныг хэрхэн бүрдүүлэх вэ?

Сургуулийн зорилго, зорилтод нийцсэн сургалтын орчныг бүрдүүлэхийн тулд маш нарийн төлөвлөлт, цогц арга барилыг шаарддаг. Иймээс сургууль, хамт олон сургалтын орчны асуудлуудыг шийдэхдээ дараах 5 чиглэлийг харгалзан үзэхийг санал болгож байна. Үүнд:

Сургуулийн зорилго, зорилтыг ойлгох: Сургуулийн алсын хараа, хичээлийн жилийн зорилго, зорилт нь танай сургуулийн сургалтын орчинг төлөвлөх үндэс суурь болно.

Оролцоог хангах: Сургуулийн зорилготой нийцсэн орчныг бүрдүүлэхийн тулд багш, сурагч, эцэг эх, асран хамгааагч, харгалзан дэмжигч удирдлагуудыг оролцуулах нь зүйтэй. Энэ нь тэдэнд ойлголтоо нэгтгэх, нэг зорилгын төлөө хамтарч ажиллах, санал санаачлага гаргах, дэмжих, баталгаажуулах боломжийг олгодог.

Сургалтын хөтөлбөрийг дэмжих Сургуулийн зорилго, зорилт сургалтын хөтөлбөрөөр дамжин хэрэгждэг. Иймээс сургуулийн анги танхим, номын сан болон бусад орон зайг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжсэн байхаар зохион байгуулж, технологийн хэрэгсэл, интерактив самбар, боловсролын програмууд, онлайн платформууд, дижитал нөөцүүдийг үр дүнтэй хуваарилах нь зүйтэй.

Сонирхол татахуйц хөтөлбөрийг дэмжих Сургуулийн зорилго, зорилтод нийцсэн, сурагчдыг идэвхтэй, урам зоригтой суралцах, төсөл хөтөлбөрт хамрагдах, хэрэгжүүлэх, багаар хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн сургалтын орчин бий болгох хэрэгцээ үүссэн байна.

Багшийн хөгжлийг дэмжих Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх, хамтдаа хөгжих соёл, хандлагыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйцээр багш хөгжлийн төвийн ашиглалт, зохион байгуулалтыг төлөвлөх нь зүйтэй.

Сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг хэрхэн оновчтой тодорхойлох вэ?

Сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг оновчтой тодорхойлох нь сурагчдад чанартай боловсрол олгох, сургуулийн зорилгыг биелүүлэхэд чухал нөлөөтэй байдаг. Сургалтын орчны асуудал, бэрхшээлийг оновчтой тодорхойлохын тулд үнэлгээний үр дүн, баримт, нотолгоонд үндэслэх нь зүйтэй. Ингэхийн тулд ямар мэдээллийг хэрхэн цуглуулж болохыг дараах хүснэгтээр харуулья.

Хүснэгт 3.22. Сургалтын орчны талаар мэдээлэл цуглуулах арга зүйн хувилбар

Чиглэл	Агуулга
Ажиглах, сонсох	Хичээл, сургалтын үйл ажиллагаа, явц, хамаарал, сурагчийн зан байдал, ирц, идэвх оролцоог тогтмол ажигла. Оролцоо дутмаг, идэвхи санаачлагагүй, хичээлдээ дургүй, эсвэл дэг журамгүй байх нь үндсэн асуудлуудыг илтгэж болно
Санал хүсэлт цуглуулах	Судалгаа, фокус группын ярилцлага, нээлттэй хэлэлцүүлгээр сурагч, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид болон бусад оролцогч талуудын санал хүсэлтийг идэвхтэй авах
Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нягтлах	Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ нь сонирхолтой бөгөөд бодитой, сургалтад ашиглаж буй хичээлийн хэрэглэгдэхүүн, материалууд нь шаардлага хангахуйц байна уу?

Нөөцийн бэлэн байдлыг нягтлах	Сургалтын орчин нь сурах бичиг, технологи, хичээлийн хэрэглэгдэхүүн, туслах ажилтан зэрэг шаардлагатай нөөцөөр хангагдсан эсэхийг үнэлнэ. Нөөцийн хомсдол нь хичээл, сургалтын чанар, үр дүнд шууд нөлөөлдөг.
Технологийн ашиглалтыг нягтлах	Технологийг сургалтын орчинд хэрхэн ашиглаж байгааг үнэлэх. Суралцахад саад болох техникийн асуудал байна уу? Технологи нь сургалтыг дэмжиж байна уу эсвэл саад болж байна уу?
Анги доторх уур амьсгалыг ажиглах	Ангиудын ерөнхий уур амьсгалыг анхаарч үзээрэй. Сурагчид хоорондоо эерэг харилцаатай, нэгдмэл зорилготой, хамтарч ажиллах сонирхолтой, бие биенээ дэмжсэн эерэг хандлага байна уу?
Үнэлгээ ба санал хүсэлтийн стратеги	Үнэлгээг хэрхэн хийж, санал хүсэлтийг хэрхэн өгч, авч байгааг нягтлаарай. Үнэлгээ нь сургалтын үр дүнтэй нийцэж байна уу? Санал хүсэлт нь цаг үеэ олсон, бүтээмжтэй, хэрэгжүүлэх боломжтой юу?
Зорилгодоо хүрэх явцыг хянах	Сургуулийн зорилго, зорилтод хүрэх ахиц дэвшлийг тогтмол хянах. Хэрэв төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байгаад байвал энэ нь сургалтын орчинд асуудал үүсч болзошгүйг илтгэнэ.
Өмч хөрөнгийг зөв, зохистой хуваарилагдсан эсэхийг нягтлах	Бүх сурагч суралцах боломж, нөөцийг тэгш хүртэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх. Сурагчдын дунд ялгаатай байдал үүсгэхгүй байхад анхаарах
Гадаад хүчин зүйлсийг судлах	Нийгэм, эдийн засгийн сорилт, олон нийтийн асуудал, боловсролын бодлогын өөрчлөлт зэрэг сургалтын орчинд нөлөөлж болзошгүй гадны хүчин зүйлсийг анхаарч үзээрэй.

Сургуулийн зорилго, зорилттой нийцсэн суралцахуйн орчныг бүрдүүлэхийн тулд бид орчны чиглэлээр хийгдсэн судалгаа, үнэлгээ, шинжилгээний үр дүнгүүдтэй танилцаж тэдгээрийн давхцал, харилцан хамаарал, хазайлт, шалтгааныг тогтоох хэрэгтэй.

Ингэснээр сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг бодитой, оновчтой илрүүлэх нөхцөл бүрдэнэ. Асуудлаа илрүүлсний дараа хамт олноороо хэлэлцүүлж тухайн хичээлийн жилд сайжруулах гол ажил, шийдлээ тохирох нь зүйтэй. Мөн сургалтын орчны чиглэлээр хийж хэрэгжүүлэхээр сонгосон ажлууд тань дараах шаардлагыг хангасан эсэхийг дахин нягталж үзэхийг зөвлөж байна. Үүнд:

- Сургуулийн зорилго, зорилтод чиглэсэн байх
- Сурагчийн хэрэгцээнд нийцсэн байх
- Суралцагч төвтэй сургалт, суралцахуйн төрөл бүрийн хэв маягийг дэмжсэн байх
- Сурагчдын ялгаатай байдлыг тооцсон байх

Сурагч төвтэй сургалтын орчныг хэрхэн төлөвлөх вэ?

Шийдлээ тодорхойлсны дараа сургууль төсөв санхүү, цаг хугацаа, хүний нөөцөөс хамааран урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тусгаж өгнө. Сургуулиуд сургалтын орчныг сайжруулах төлөвлөлт хийхдээ дараах зүйлсийг харгалзан үзэхийг санал болгож байна. Үүнд:

1. Сургалтын арга зүй, багшлахуйн загвар, суралцахуйн арга хэлбэр улам олон төрөл болж байгаатай холбоотой түүнд шаардлагатай орчныг судалж, ялгаатай байдлыг тооцох; (сурагчдыг амьдрах чадварт сургахын тулд өөр өөр судлагдахууныг нэгтгэж, бодит амьдралын жишээн дээр тулгуурласан интеграци хэлбэрийн сургалтыг зохион байгуулах гэх мэт)
2. Сурагчдын суралцахуйн арга барил, онцлог, ялгаатай байдлыг таньж тогтоон, түүнд тохируулах; (стандарт анги танхимаас гадна зарим орон зайн хэлбэр, дизайн, тавилгыг өөрчлөх гэх мэт)
3. Хичээл, сургалтын үйл ажиллагааг МХХТ-ийн хэрэгслээр явуулах; (онлайн эх сурвалж, программ хангамжид нэвтрэх, бүртгүүлэх зардлыг төлөвлөх гэх мэт)

Хүснэгт 3.23. Асуудал шийдвэрлэх хувилбар

Асуудал шийдвэрлэсэн жишээ.	
Өгөгдөл цуглуулах	Сурагчдад тулгамдсан асуудал: (хувиар) <ol style="list-style-type: none">1. Асуудал шийдвэрлэх чадвар сул2. Хариуцлагагүй3. Харааны бэрхшээлтэй
	Асуудал: (Өөрийн үнэлгээгээр хангалгүй үр дүн үзүүлсэн) <ol style="list-style-type: none">1. Сургалтын тоног төхөөрөмжийн хүртээмж2. Интернет орчин3. Ногоон байгууламж
	Асуудал (Хөндлөнгийн үнэлгээгээр хангалтгүй үр дүн үзүүлсэн) <ol style="list-style-type: none">1. Компьютер, тоног төхөөрөмжийн хүртээмж2. Цэвэр усны хангамж3. Туршилт хийх бодис урвалж

Үр дүнг шинжилж нэн тэргүүнд сайжруулах гол асуудлаа тодорхойлох

Сурагчдын аль асуудлыг шийдэхэд сургалтын орчин хамгийн их нөлөөлөх вэ?

Багш нар хэлэлцээд АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ЧАДВАР-ыг хөгжүүлэхэд сургалтын орчны асуудлын шийдлүүд чухал гэж үзсэн.

АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ЧАДВАР-ыг хөгжүүлэхэд сургалтын орчны хувьд тулгамдсан аль асуудлыг шийдэх вэ?

Хамт олноороо хэлэлцээд БУ-ны туршилт хийх орчныг бүрдүүлэх, багш нарын санал болгосон бодис урвалж, багаж хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар болсон.



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн бүхий л үйл ажиллагааны гол цөм нь сурагч гэдгийг онцолж аливаа асуудлын шийдэл нь тэдний хэрэгцээнд нийцэж буй эсэхэд анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, сурагч төвтэй, суралцахуйн төрөл бүрийн хэв маягийг дэмжсэн, тав тухтай сургалтын орчны дизайныг бий болгож, тэнд суралцаж буй сурагчдын хэрэгцээнд нийцсэн шийдлүүд гаргахыг зөвлөж байна. Тухайлбал,

- Сурагчид бие биендээ тусалж, асууж, зааж, хамтарч ажиллах боломжтой байх,
- Ялгаатай хөгжилтэй сурагчдад хэрэгтэй үед нь тусламж үзүүлэх, ямар нэгэн асуудал гарвал багш шууд очих боломжтой байх,
- Олон төрлийн мэдээллийн эх сурвалж руу холбогдох боломжтой байх гэх мэт

Сургуулийн орчны хувьд нэн тэргүүнд сайжруулах асуудлаа тодорхойлсны дараа тухайн асуудлыг хэрхэн арилгах шийдлээ хамт олноороо хэлэлцэж төсөв санхүү, хүний нөөцөө хуваарилж, үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Сургуулиуд сургалтын орчныг сайжруулах төлөвлөлт хийхдээ дараах зүйлсийг харгалзан үзэхийг санал болгож байна. Үүнд:

1. Сургалтын арга зүй, багшлахуйн загвар, суралцахуйн арга хэлбэр улам олон төрөл болж байгаатай холбоотой түүнд шаардлагатай орчныг судалж, ялгаатай байдлыг тооцох; (Тухайлбал, сурагчдыг өөрт тулгарсан асуудлаа шийддэг, амьдрах чадвартай иргэн болгон бэлтгэхийн тулд өөр өөр судлагдахууныг нэгтгэж, бодит амьдралын жишээн дээр тулгуурласан интеграци хэлбэрийн сургалтыг зохион байгуулж байна)

2. Сурагчдын суралцахуйн арга барил, онцлог, ялгаатай байдлыг таньж тогтоон, түүнд тохируулах, Тухайлбал, стандарт анги танхим гэхээсээ илүү хэлбэр, дизайн, тавилгыг өөрчилж байна
3. Хичээл, сургалтын үйл ажиллагааг МХХТ-ийн хэрэгслээр явуулах, Тухайлбал цаасны хэрэглээ эрс багасаж, онлайн эх сурвалж, программ хангамжид нэвтрэх, бүртгүүлэх зардал төлөвлөх хэрэгтэй болж байна

Сурагчдад тулгамдаж буй асуудлыг арилгахад хамгийн их нөлөө үзүүлж, хувь нэмэр оруулах сургалтын орчны шийдэл, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлага, багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч оролцоо жигд байх нь чухал байдаг.

3.6 СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

Сургуулийн удирдлага яагаад хэрэгтэй вэ?

1. Зорилго, зорилтыг томъёолох
2. Зорилгодоо хүрэх арга замыг нарийвчлан тодорхойлох
3. Хүний болон санхүүгийн нөөцийн хуваарилалт ашиглалтыг оновчтой зохион байгуулах

Удирдлагын манлайлал яагаад хэрэгтэй вэ?

1. Идэвхжүүлэх, сэдэлжүүлэх
2. Ажлын үр дүнг бодитой үнэлэх,
3. Урамшуулах, анхааруулах
4. Хяналт тавих
5. Хамт олны үнэт зүйл, итгэл үнэмшлийг хамгаалах, таатай уур амьсгал бүрдүүлэх
6. Инноваци нэвтрүүлэх (шинэ санаачлагыг бодит болгох/бүтээгдэхүүн, амьдралд хэрэгжүүлэх, шинэ үнэ цэнийг бий болгох)

3.6.1 СУРГУУЛИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ

Нэгдсэн төлөвлөгөөг хийхтэй 1-р бүлгийн гурван давхаргат пирамид загвартай холбон хийх хэрэгтэй.

Нэгдсэн төлөвлөлт нь хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлсон төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаа гэж ойлгоно.

Алсын хараа, эрхэм зорилго яагаад хэрэгтэй вэ?

1. Алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө сургуулийг бүхэлд нь чиглүүлэх
2. Аливаа шийдвэр гаргахад баримтлах гол тулгуур буюу жанжин шугам нь байх
3. Сургуулийнхаа тухай цэгцтэй ойлголт өгөх

Сургуулийн алсын хараа нь “бид хаана хүрэх вэ?” гэсэн урт хугацааны зорилт байна.

Эрхэм зорилго нь урт хугацааны зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хийгээд **сурагчийн хүсэл эрмэлзлэл, сонирхолд хөтлөгдсөн** удирдлагын үйл ажиллагааны үр дүнг товч тодорхой, үйл үгийн ирээдүй цагийн хэлбэрээр илэрхийлсэн байна.

Эрхэм зорилгодоо хэрхэн хүрэх вэ?

Эрхэм зорилгодоо хүрэх зорилтуудаа тодорхойлж, зорилт бүрийг урт, дунд, богино гэсэн үе шаттайгаар төлөвлөнө.

Нэгдсэн төлөвлөлт яагаад хэрэгтэй вэ?

- Алсын хараа, эрхэм зорилгод хүрэхэд баримтлан ажиллах зарчмаа тодорхойлох
- Бодитой хэрэгжүүлэх зорилго, зорилт, арга замыг бий болгох
- Хүний болон санхүүгийн нөөцийг үр дүнтэй хуваарилах
- Шийдвэр гарах
- Баг, хамт олны хүчийг нэгтгэх

Сургуулийн удирдлага нь жил бүр сургалт, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зорилгыг тодорхойлно.

Зорилго нь:

- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилготой нийцсэн байна.
- Тодорхой, бодитой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, хугацааны хязгаартай байна.



АСУУДАЛ

1, 2-р бүлэгт дурдагдсан агуулгын хүрээнд дараах асуудлууд гарч байна. Сургуулийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөлт хангалтгүй

- Сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, уриа тодорхой бус
- Сургуулийн үйл ажиллагааны болон менежментийн төлөвлөлтөд оролцогч талууд болох сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал бага тусгагддаг
- Уялдаа холбоогүй олон төлөвлөгөөтэй
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэх ажилд багш нарыг тэгш оролцуулдаггүй
- Сургуулийн удирдлагын багийн бүтэц, ажлын хуваарилалт оновчгүй, нэгдсэн төлөвлөгөө байхгүй
- Стратеги төлөвлөгөөг зөвхөн дээд шатны байгууллагад харуулахаар хийдэг
- Хичээлийн жилийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо оролцоог хангадаггүй, зөвхөн удирдлагын байр сууринаас төлөвлөн хэрэгжүүлдэг
- Багш нарын дийлэнх нь ээлжит хичээл бүрийг багш төвтэй аргаар хэрэгжүүлж, багшийн үйл ажиллагаа давамгайлсан ээлжит хичээлийн хөтөлбөртэй.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Жилийн үйл ажиллагааны төлөвлөлтөд анализ хийж, дүгнэх, ач холбогдлоор нь эрэмбэлэх, уялдаа холбоог илрүүлэх судалгаа хийв.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд 16 зорилт, 122 ажлыг тусгасан байна.

Математик аргачлалаар тооцож үзэхэд нэг сард дунджаар 10, 7 хоногт дунджаар 2.5 ажил төлөвлөгдсөн байна.

Ажлын ач холбогдол, оновчтой байдал чанар үр дүнгээр эрэмбэлэн нэгтгэж, ачааллыг багасгах талаар захирлын зөвлөлөөр хэлэлцэн багцлахад 16 зорилт 101 ажил болж төлөвлөгөөнд тодотгол хийхээр ажиллаж байна.

6 дугаар сарын 10 – ны үеэр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг тооцож гаргахаар ажиллаж байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд

“Сургууль, дотуур байрны орчинд сурагчийн үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны 2023 төлөвлөгөө” – г шинэчилсэн. Дотуур байрны сурагчдын дунд ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДЭВТЭР аялуулж байгаа нь үр дүнгээ өгч байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Сумын Засаг даргын 2023 оны 5р сарын 1-ний өдрийн А/31 тоот захирамжаар Сургуулийн захирлаар ахлуулсан “Сургуулийн 2024 – 2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг” – ийг байгуулан 1 – р үе шатны төлөвлөгөө (SWOT шинжилгээ хийх) гарган хэрэгжүүлж эхлээд байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Ирэх хичээлийн жилд бид бүхэн удирдлагын манлайлал, үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, манлайллаа дээшлүүлэх, удирдлагын хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллахад багш, ажилтнуудын саналын авч тусган ажиллахаар төлөвлөж байна. Бид санал асуулгын дараах хуудсыг боловсруулав.

Бид таны санал хамгаас чухал тул товч, тодорхой илэрхийлж, идэвхтэй оролцоно уу!

САЙН БАЙНА УУ? ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ДЭВЭГҮҮЛЭ	
<p>БСШУАМНААС 2023 ОНЫГ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЖИЛ БОЛГОН ЗАРГАСАН БИГЭЭ</p> <p>Менежмент гэдэг нь байгууллагын зорилгыг тодорхойлж, түүнд хүрэх замыг нарийн тодорхойлж, үйлдвэрлэлийн нөөцүүдийн ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ идэвхжүүлэн МАНЛАЙЛЖ, улмаар ажлын үр дүнг үнэлэн хяналт тавих үйл ажиллагаануудын нэгдэл юм.</p> <p>Ирэх хичээлийн жилд бид бүхэн МАНЛАЙЛАЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ сайжруулах тал дээр үйл ажиллагаандаа дүнгалт хийж төлөвлөн хэрэгжүүлэхэд таны санал хамгаас чухал тул таныг тодорхой илэрхийлж идэвхтэй оролцоно уу!</p> <p>1. Сургуулийн захирал. Мэргэжил болон манлайлалын үр чадварын талаар :</p> <p>Санал _____</p> <p>2. Ахлах бөгөөд БУ-ны сургалтын менежер. Мэргэжил болон манлайлалын үр чадварын талаар :</p> <p>Санал _____</p> <p>3. Дунд бөгөөд НУ-ны сургалтын менежер. Мэргэжил, манлайлалын үр чадварын талаар :</p> <p>_____</p>	<p>Санал _____</p> <p>4. Бага ангийн сургалтын менежер. Мэргэжил манлайлалын үр чадварын талаар :</p> <p>Санал _____</p> <p>5. Нийгмийн ажилтан. Мэргэжил, манлайлалын үр чадварын талаар :</p> <p>Санал _____</p> <p>6. Нягтлан бодогч. Мэргэжил болон манлайлалын үр чадварын талаар :</p> <p>Санал _____</p> <p>7. НТБ болон хүүмүүлийн арга зүйч. Мэргэжил болон манлайлалын үр чадварын талаар :</p> <p>_____</p>

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Сургуулийн зорилго, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийг багш, удирдлага, ажилтны ажлын байрны тодорхойлолтод үндэслэн тухайлсан бүдүүвчээр хийхийг зөвлөж байна. Яагаад бүдүүвчээр хийх нь чухал вэ гэвэл, **нэгд**, юу хийх вэ гэдгээ зохион байгуулах, **хоёрт**, хэн юу хийх гэж байгаа нь ойлгомжтой байх, **гуравт**, нарийн дараалал, дэгтэй байх нь ойлголтоо нэгтгэж, ажил үүргүүд хуваарилагдаж, удирдлагын зүгээс чиглүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Бүдүүвчийг дараах асуултад хариулахаар зураглаарай. Үүнд:

1. Зорилгоо томъёолж, нэгдсэн төлөвлөлт хийх ажил ямар дараалалтай хийгдэх вэ?
2. Ажлын үр дүн хаана нэгтгэгдэх вэ?
3. Багшийн харъяалагдах анхан шатны нэгж аль нь вэ?
4. Анхан шатны нэгж ажлын үр дүнгээ дараагийн шатны нэгждээ хэрхэн танилцуулах, зөвлөгөө авах, тайлан өгөх вэ?
5. Ямар дүрэм журмын хүрээнд зохицуулагдах вэ?

Сургуулийн зорилго, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийг хийхдээ дараах 14 зарчмыг баримтална.

Үе шат нь хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, нөөцийг хуваарилах, түвшин/нэгж бүрээр төлөвлөх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагаа гэж ойлгоно.

Төлөвлөлтөд баримтлах зарчим

1. Боловсролын салбарын бодлого, хууль эрх зүйд нийцсэн байх
2. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх
3. Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх
4. Нөөцөд үндэслэсэн байх
5. Ил тод, нээлттэй байх
6. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх
7. Зорилго, зорилт хэмжигдэхүйц байх
8. Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх
9. Төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх
10. Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах
11. Бүх талын оролцоог хангасан байх
12. Түншлэлийг зохистойгоор хангах


13. Оролцогч талуудын хариуцлага (хүлээсэн үүргээ биелүүлэх)

14. Нэгтгэн тайлагнах

Ингэснээр сургуулийн зорилго, үйл ажиллагааны талаар тулгамдаж буй асуудлыг цэгцлэхэд эергээр нөлөөлнө.

Багшийн харьяалагдах анхан шатны нэгж нь багш мэргэжлээрээ өсөх, хөгжих боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн, арга зүйн дэмжлэг авах, багаар ажиллах таатай уур амьсгалыг бий болгохыг зорино.

Зураг 3.33. Сургуулийн зорилгоо тодорхойлж, төлөвлөтөө нэгдэх зураглал



Зураглалын дагуу зорилго, төлөвлөлтийг **сурагчийн хүсэл эрмэлзлэл, сонирхолд хөтлөгдсөн** дээрээс доошоо, доороос дээшээ чиглэх тэнцвэрийг ханган алхамчилна.

Анхан шатны нэгж – тухайн сургуулийн онцлогоос хамаарч заах аргын секц эсвэл заах аргын нэгдэл байж болно.

- Дунд шатны нэгж – тухайн сургуулийн онцлогоос хамаарч заах аргын нэгдэл эсвэл сургалтын менежер байж болно.
- Хэрвээ тухайн сургуулийн дунд шатны нэгж нь заах аргын нэгдэл байвал дараагийн шатны нэгж нь сургалтын менежер байна.
- Дэмжих баг нь сургуулийн үйлчилгээний тухайлбал, сургуулийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт хариуцсан ажилтан гэх мэт байна.

Санал хүсэлт хүлээн авах баг нь сургуулийн үйл ажиллагаатай холбоотой бичгээр ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч нэгтгээд, боловсруулалт хийж,

сургуулийн зорилго, зорилтод тусгах саналыг оруулах эсэхийг шийдэж, хүүхэд хөгжил, хамгааллын албад хүргүүлнэ.

Хүснэгт 3.24. Сургуулийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийг нэгтгэх алхамчлал

<i>Алхам нэг</i>	Сурагчийн гүйцэтгэл, хүсэл сонирхолд тулгуурлаж багш зорилгоо тодорхойлоод, анхан шатны нэгжийн (заах аргын секц эсвэл заах аргын нэгдэл) хүрээнд хэлэлцэж, нэгтгээд дараагийн шатны нэгжид (заах аргын нэгдэл эсвэл сургалтын менежер) хүргүүлнэ.
<i>Алхам хоёр</i>	Анхан шатны нэгжүүдийн саналыг* нэгтгэж, дараагийн шатанд хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. *Жишээ нь: Шаардлагатай гэж үзвэл анхан шатны нэгжээс ирүүлсэн саналд зөвлөн тусалж, засаж сайжруулах чиглэл өгч болно.
<i>Алхам гурав</i>	Ирүүлсэн саналыг сургуулийн менежментийн баг* - аар хэлэлцэж, батална. *Жишээ нь: Шаардлагатай гэж үзвэл дунд шатны нэгжээс ирүүлсэн саналд зөвлөн тусалж, засаж сайжруулах чиглэл өгч болно. Баталсан зорилго, төлөвлөлтийг оролцогч талуудын төлөөллийн 10.0 хувьд хэлэлцүүлж, саналыг харгалзан сайжруулалт хийнэ. Тухайлбал, сургуулийн нийт сурагчдын 10.0 хувь гэх мэт. Сайжруулж баталсан зорилго, төлөвлөлтийг сургуулийн захиралд хүргүүлнэ. Хэлэлцүүлгийн үе шатанд захирал саналаа хүргүүлж болно. Мөн захирал нэгжүүдэд зөвлөн тусалж, саналаа тусгаж болно.
<i>Алхам дөрөв</i>	Менежментийн багаас баталсан зорилго, төлөвлөлтийг сургуулийн захирал баталгажуулна.

Менежментийн баг батлагдсан сургалт, үйл ажиллагааны зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө дараах хүснэгтэн хэлбэрт оруулна. Мөн нэгдсэн “Сургуулийн сургалт, үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө” – г хийж нээлттэй тавьж болно.

Сургуулийн тухайн хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт

*Хүснэгт 3.25. Сургуулийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн
хүснэгтлэх хувилбар*

Д/д	Агуулга	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
Сургалт үйл ажиллагаа							
Зорилт 1							
1.1	Үйл ажиллагаа						
1.1.1	Үйл ажиллагаа						
1.1.2	Үйл ажиллагаа						
1.2	Үйл ажиллагаа						
1.3	Үйл ажиллагаа						
Зорилт 2							
2.1	Үйл ажиллагаа						
2.2	Үйл ажиллагаа						
2.3	Үйл ажиллагаа						
Хүүхдийн хөгжил, хамгаалал							
Зорилт 1							
1.1	Үйл ажиллагаа						
1.2	Үйл ажиллагаа						
1.3	Үйл ажиллагаа						
Зорилт 2							
2.1	Үйл ажиллагаа						
2.2	Үйл ажиллагаа						
2.3	Үйл ажиллагаа						

Удирдлагын манлайллыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулах тухайд

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд ерөнхий боловсролын сургуулийн удирдлагын удирдах чадварын жагсаалтыг анхлан боловсруулж, хэрэглэсэн нь удирдах ажилтнууд өөрсдийн чадвараа хөгжүүлэх, хэрэгцээ шаардлагаа тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой болов. Иймд удирдах ажилтан өөрийн болон багш, хамт олны үнэлгээнд үндэслэн хөгжүүлэх шаардлагатай чадвараа илрүүлж, удирдлагын хөгжлийн төлөвлөгөө боловсруулж ажиллахыг зөвлөмжилж байна. Бид зөвлөн тусалж ажилласан ерөнхий боловсролын зарим сургуулийн багш нарын удирдлагуудынхаа чадварыг үнэлсэн байдлыг жишээ болгон хүснэгт 12- р харуулав.

Хүснэгт 3.26. Ерөнхий боловсролын зарим сургуулийн удирдах ажилтны чадварыг багш нарын чадварт үндэслэн эрэмбэлсэн нь

Удирдах чадварыг товчилсон тэмдэглэгээ	Эрэмбийн утга	Эрэмбэ	Удирдах чадвар
A_{12}	0.10716	1	Зохицуулан зохион байгуулах чадвар
A_{17}	0.1021	2	Гүйцэтгэлийн үр дүнг тооцох чадвар
A_{15}	0.09368	3	Өөрийгөө илэрхийлэх, удирдах чадвар
A_9	0.08014	4	Үр дүнг үнэлэх чадвар
A_8	0.06588	5	Санал, санаачлагыг дэмжих чадвар
A_{11}	0.06333	6	Бусдад боломж олгох чадвар
A_{16}	0.06277	7	Бусдын хичээл зүтгэлийг мэдрэх чадвар
A_{10}	0.06005	8	Хамтран ажиллах чадвар
A_{18}	0.05497	9	Урамшуулан дэмжих чадвар
A_{14}	0.05442	10	Бусдыг хүндэтгэх, дэмжих чадвар
A_1	0.04458	11	Ирээдүйг угтан дүгнэх чадвар
A_{13}	0.04258	12	Бусдыг сонсох, ойлгох чадвар
A_3	0.03942	13	Нийтлэг зорилгод нэгтгэх чадвар
A_5	0.02177	14	Бусдад нөлөөлөх чадвар
A_7	0.01559	15	Шинийг эрэлхийлэх чадвар
A_2	0.00641	16	Нөхцөл байдлыг системчлэх чадвар
A_6	0.00415	17	Бусдыг дагуулах чадвар
A_4	0	18	Өөрийгөө байнга хөгжүүлэх чадвар

Дээрх хүснэгт 12 –оос харахад тухайн удирдах ажилтны зохицуулан зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, өөрийгөө илэрхийлэх, удирдах чадвар бусад чадваруудаас дээгүүр эрэмбэлэгдсэн бол өөрийгөө байнга хөгжүүлэх, бусдыг дагуулах, нөхцөл байдлыг системчлэх чадвар доогуур

эрэмбэлэгдсэн байна. Иймд удирдах ажилтны хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, түүндээ доогуур эрэмбэлэгдэж байгаа чадвараа хөгжүүлэх зорилго, үйл ажиллагаагаа төлөвлөх зэргээр ажиллахыг зөвлөж байна.

Удирдах чадварыг эрэмбэлэх судалгааны аргачлал (QR уншуулах)

- Алхам 1 Асуулгын хуудас боловсруулах
- Алхам 2 Мэдээлэл цуглуулах
- Алхам 3 Ажиглалтын тархалтыг олох
- Алхам 4 Онолын тархалтыг олох
- Алхам 5 Онолын тархалтыг үндэслэн эрэмбэлэх



3.6.2 СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт юунд чиглэх вэ?

Сургалт, үйл ажиллагаа нь тодорхой зорилго, зохион байгуулалттайгаар сурагчийн хөгжилд нөлөөлж, тэдний хэрэгцээг хангахад чиглэнэ. Иймд багш нэг бүрийг чиглүүлэх, дэмжих, чадавхижуулах нөхцөлийг бүрдүүлсэн зохион байгуулалт хийх нь чухал юм.

Сургалт, үйл ажиллагааг яагаад зохион байгуулдаг вэ?

Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулснаар **“Юуг? хэн? хэрхэн? яаж? хэнтэй зохион байгуулж, үр дүнгээ дүгнэж, хэрхэн сайжруулах вэ?”** гэдэг нь тодорхой болдог.



АСУУДАЛ

- Сургуулийн захирал, сургалтын менежерүүд сургалт, үйл ажиллагаа болон дотоод зохион байгуулалтын аливаа үйл ажиллагаанд манлайлан оролцдоггүй, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, шилдэг арга зүй, технологийг сургалтад нэвтрүүлэх ажлыг дэмжих, багш нарт зөвлөн туслах, хамтран ажиллах чадвар сул
- Сургуулийн захирал, удирдлагууд хамт олноо ялгаварлаж харьцдаг, өөрийн хүрээлэл үүсгэдэг, урамшуулдаггүй, үр дүн тооцдоггүй.
- Удирдлагын баг нэгдсэн ойлголттой биш, хамтын ажиллагаа муу,

- бие биеэ харилцан зөвшөөрөхгүй байх хандлагатай.
- Сургалтын аргуудыг оновчтой сонгох, хэрэглэх, анги сурагчтай ажиллах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх ажилд чиглүүлэх, зөвлөн туслах байдал хангалтгүй
 - *сурагчид, багш нар анги, танхим, нийтийн эзэмшлийн үйлчилгээнд анхаарал хандуулахдаа жигд биш*



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Жишээ 1: Сургуулийн захирлын санаачилгаар сургуулийн нийт сурагчид сард 1 удаа, багш ажилчид улиралд 1-2 удаа амралтын өдрөөр сургуулийн анги танхим, өрөө, тасалгааг цэвэрлэх, үйлчилгээний ажилчдынхаа ажилд туслах, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурагчдад зөв үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор

- “Тоосгүй гутал” аян
- “Хөөсний баяр” үйл ажиллагааг эхлүүлж, уламжлал болгон хэвшүүлсэн байна

Сургуулийн захирал, хамт олонтойгоо анги, танхим, өрөө, тасалгааг цэвэрлэснээр, анги танхим нь эмх цэгцтэй, цэвэр, ая тухтай орчинд ажиллахад ихээхэн дэмжлэг үзүүлсэн. (Сургуулийн хаалгаар ороход цагаан өнгөтэй шалны алчуур угтдаг нь сургуулийн орчин ямар цэвэр цэмцгэр болохыг илэрхийлнэ).

Хүүхдүүд хичээлийн бус цагаар коридор, буланд байршуулсан ширээ сандалд сууж, хичээлээ давтахдаа:

- Хүний хөдөлмөрийг хүндэтгэх
- Дүрээмт хувцас, гутлаа цэвэрхэн өмсөх
- Багш нараас зөв үлгэр дуурайлалд суралцдаг бол сургуулийн хамт олны уур амьсгалд эерэг дулаан харилцааг төлөвшүүлж чаджээ. Мөн энэхүү үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх хүрээнд Баянхонгор аймгийн сургуулийн нийгмийн ажилтнуудад туршлага болгон танилцуулсанд тэд талархан хүлээж авсан бөгөөд Эрдэнэцогт, Баян-Овоо зэрэг сумдын сургуулиуд хэрэгжүүлсэн байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Жишээ 2: Сургуулийн нийт багш нарын дунд “Сурах бичгээ судалж дуусгая” аяныг өрнүүлж, сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, үнэлгээний шалгуур, зөвлөмжийг судлах, өөрийн заадаг ангийнхаа сурах бичгийн дасгал даалгаврыг бодох, хийж гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг гарган, сургуулийн захирлаар батлуулж, багш нар нь ажиллаж эхлээд байна. Мэргэжлийн багш нарын хамгийн эхнийх 2023 оны 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд дуусах бол сүүлийн багш нар 2024 оны 3 дугаар сард дуусгахаар зураглалаа гаргасан. (Үүнд: *Матемаикийн багш нар 6 дугаар ангиас 12 дугаар анги хүртэлх 7 сурах бичгийг бодож дуусгах бол биеийн тамрын багш 1-ээс 5 дугаар ангид хичээл заадаг бол дасгал бүрийг өөрөө хийж, гарын жижиг булчинг хэрхэн хөгжүүлэх вэ? гэдгээс эрүүл мэндээ хамгаалах энгийн дадал хэвшлийг хэрхэн төлөвшүүлэх талаар нэг бүрчлэн хийж тэмдэглэх юм*). Тухайн сургуулийн хувьд 2024 оны 3 дугаар сард **“Зааж байгаа хичээлдээ онолын болон заах арга зүйн чиглэлээр мэдлэг, чадвар дутмаг багшгүй болно.”** гэж зорьж байна.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Жишээ 3: Багш нар хүүхэд бүрийг хөгжүүлэх бодитой, үр дүн гаргахуйц шийдлийг эрэлхийлж, **“Нэг баг–Нэг арга зүй”** хичээлийн сайн технологи, багийн хичээлийг санаачлан зохион байгууллаа. Энэ нь багш нар сонирхлын бүлгээр багт хуваагдаж, багууд хичээл бүр дээр нэг, нэг шинэ арга зүйн санааг дэвшүүлж, хичээлээ бэлтгэнэ гэсэн үг. Бэлтгэсэн хичээлүүдээ нэг долоо хоногийн хугацаанд зааж дуусаад, энэ долоо хоногт ямар хичээлүүд дээр ямар үр дүн гарав, юуг сайжруулах шаардлагатай байв, цаашид арга зүйн санааг хэрхэн баяжуулж, сурагчдын идэвхи оролцоог сайжруулах вэ гэх мэтээр хэлэлцүүлэг өрнүүлдэг болсон байна.

Үүний үр дүнд хичээлийн арга зүйн санаа баяжиж, агуулгын давхардал, нэг хүүхдэд очих олон ижил төрлийн даалгаврын ачаалал багасч, хүүхдүүд бие даан сурах арга барилд суралцах, багш нар бие биенээсээ туршлага судлах, улмаар хамт олны дунд эерэг уур амьсгал бий болсон зэрэг олон давуу талууд бий болсон.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Жишээ 4: Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах гол арга нь ээлжит хичээл бүрийг чанартай заахад чиглэсэн байх хэрэгтэй гэдэгт багш нар нэгдсэн. Иймээс хичээлийн судалгааг мэргэжлийн хөгжлийн бүлгээр хийхэд төвлөрч

- Хичээлийн бэлтгэл судалгаа
- Хичээлээ заах
- Хичээлийн хэлэлцүүлэг хийж, үнэлэх
- Хичээлээ сайжруулахад анхаарч ажилласан.

Үүний үр дүнд ээлжит хичээлийн бэлтгэл сайн хангагдаж, багш нарын арга зүй, ажлын хуудас сайжирч, байгалийн ухааны 20, хүмүүнлэгийн ухааны 46 багшийн нэгж хичээлийн төлөвлөлт сайжирч, сурагчдын сурлагын чанарт тодорхой өөрчлөлт гарсан байна. Манай сургуулийн багш нар Сайн хичээл үйл ажиллагаа-Багш сурагчдын ахиц амжилт гэдэгтэй санал нэг байгаа.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

Дээр дурдсан ажлуудыг хэрхэн зохион байгуулсныг зөвлөмж байдлаар сийрүүлбэл,

- Багш, удирдах ажилтнуудын цэвэрлэгээ хийх анги танхимын хуваарь гарган, кабинет хариуцаагүй багш, ажилчдыг сургуулийн нийтийн эзэмшлийн талбай, коридоруудыг цэвэрлэхээр зохион байгуулах
- “Хөөсний баяр”-ын үеэр дотоод үзелээр хөгжим, ая сонсгон хөгжилтэй, тааламжтай байдлаар цэвэрлэгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх
- Сургуулийн захирал, удирдлагууд идэвх санаачилгатай, бусдыг уриалан манлайлж оролцох
- Хамгийн гол нь нийт багш ажилчдын саналыг авч, харилцан тохиролцсон, ойлголцсон тохиолдолд хэрэгжүүлэх
- Хэрэв цөөн хүн ямар нэг шалтгаанаар нэг удаагийн цэвэрлэгээнд ирээгүй бол сургууийн удирдлагын зүгээс ямар нэг арга хэмжээ авах гэх мэт асуудал үүсгэхгүй байх хэрэгтэй.

Хамт олон нь хамтарч ажиллаад, сургуулийн удирдлагын зүгээс урьдчилан хуваарь гаргаж байгаа болохоор дараа дараагийн ажлуудад багш нар урьдаас ажлаа төлөвлөж, идэвх санаачилгатай оролцохоос гадна бусад үед ч орчноо цэвэр байлгах дадал хэвшилтэй болдог сайн талтай байна.

“Сурах бичгээ судалж дуусгая.” Ажлыг зохион байгуулах алхамчлал

- Энэ ажлын ач холбогдлыг багш нарт ойлгуулах, “Хийгээд үзье” гэх сэтгэлийг төрүүлсэн байх
- Ажлын календарчилсан төлөвлөгөөг захирлаар батлуулахаас өмнө сургалтын менежерүүд багш бүрээс саналыг авч, хугацааг өөрсдөөр нь тодорхойлуулах
- Нэгэнт хамт олноороо хэлэлцэж, тохиролцоод хийж эхэлсэн бол удирдлагууд багш нарыг хугацаандаа чанартай гүйцэтгэж байгаад хяналт тавьж, дэмжлэг хэрэгтэй байгаа багш нарт зөвлөн туслах
- Хугацаандаа чанартай хийж, өөртөө амжилт гаргасан багш нартаа хамт олны өмнө урамшуулах

Нэг баг- нэг арга зүй зохион байгуулах алхамчлал

1. Багш өөрийн зааж буй судлагдахууны сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, хичээл сургалтыг үнэлэх үнэлгээний шалгуур, шалгуурыг хэрэглэх зөвлөмж, сурах бичгээ сайтар судалж, өөрийн гэсэн мэдлэг ойлголттой болох
2. Хичээлийн жилийн болон нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг секцийн багш нартайгаа зөвлөлдөж, боловсруулах
3. Нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг боловсруулахдаа суралцахуйн зорилтоо шинжилж, тухайн агуулгыг хэдэн цагаар төлөвлөхөө сайтар тооцох
4. Төлөвлөсөн нэгж болон ээлжит хичээлээ чанартай заах, хичээлийн туршид хүүхэд бүрийн явцын үнэлгээ хийж, тэмдэглэл хөтлөх
5. Багш сурагчдын явцын үнэлгээ, тэмдэглэл дээрээ тулгуурлан агуулгын хоцрогдлыг бүлэг сэдэв, анги, хүүхэд бүрээр анализ хийж үр дүнг тооцох, тухайн үр дүнгээс хамаарч ээлжит хичээлийн хөтөлбөрийг засан сайжруулах
6. Ээлжит хичээлийн төлөвлөлтдөө МХТ-ийн шинэ шийдлийг (контент, интерактив) ашиглан орон нутаг, хэл соёлын онцлогт тохируулан тусгах. Тухайлбал Үндэсний цөөнх казах тува хүүхдүүдийн хувьд “ЧИМЭГЭ” апп-ыг сургалтад ашиглах нь хэлний ялгаатай байдал арилахад дэмжлэг болохыг анхаарах
7. Удирдах ажилтнууд шаардах, даалгавар өгөх гэхээсээ илүү, хамтарч ажиллах тактикийг барих



Сургуулийн удирдлагуудын эв нэгдэл нь боловсролын байгууллагын үр дүнтэй үйл ажиллагаа, амжилтад чухал үүрэгтэй. Сургуулийн удирдлагууд, тэр дундаа захиргаа, багш, ажилчид, удирдах байгууллагууд хамтран ажиллаж чадвал сурагчдад эерэг, үр бүтээлтэй орчныг бүрдүүлж, байгууллагын нийт амжилтад хувь нэмрээ оруулж чадна.



АСУУДАЛ

Багш нарыг тогтвортой ажиллуулах бодлого барьж ажилладаггүй

- Дутагдалтай багшийн сонгон шалгаруулалтын зар мэдээг аймаг, сумын нээлттэй группт тавьж, багшийн цагийн ачааллыг тэнцвэржүүлж мэдээллээр хангадаггүй
- Өөр орон нутгаас шилжин ирж буй багш нарыг ялгаварлан гадуурхахгүй хүн ёсоор тэгш, хүртээмжтэй харилцан хамтран ажиллах талаар дутмаг. Мөн багш бүртэй гэрээ хийдэггүй
- Хамт олны нийгмийн асуудлыг дэмжих үйл ажиллагаа сул
- Сургуулийн нэгдсэн төлөвлөлт тодорхой биш, гэнэтин ажил ихтэй, менежмент сул хийгддэгээс болж, багш нарын ажлын бүтээмж буурч, стресстэж ядардаг



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн удирдлага, багш нартай хамтран ажиллах, илүү таатай орчин бүрдүүлэх зорилгоор “Багш ажилчдаа сонсьё” уулзалтыг зохион байгуулсан нь тодорхой үр дүнгээ өглөө. Багш бүртэй ганцаарчлан уулзаж, нийгмийн асуудал, сургалт явуулахад тулгарч буй бэрхшээл, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, хичээл орж буй ангийн сурагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч анги удирдсан багшийн сайн тал, дэмжлэг авах санал, багш бүрийн мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөө, хамт олны эерэг, эвсэг уур амьсгалыг бий болгоход ямар ажлыг зохион байгуулах, түүнд таны хийж чадах дэмжлэг юу байгаа зэргийг сонсов.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Шинэ, залуу багш нарт мэргэжлийнхээ сорилтыг даван туулж, сургуулийн хамт олонтойгоо илүү холбоотой байхад туслах зорилгоор “Залуу багш нарын уулзалт” - ыг зохион байгуулж, тэдний манлайллыг нэмэгдүүлэх, чадваржуулах үүднээс туршлагатай багшаар шинэ багшийг дэмжиж, удирдан чиглүүлдэг зөвлөх тогтолцоог хэрэгжүүлсэн нь багшийн тогтвортой, сэтгэл тайван, айдасгүй ажиллах боломжийг нээлээ.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Сургууль доторх хүний нөөцийн тогтвортой үйл ажиллагааг хангах нь ажлын таатай орчинг хадгалах, чадварлаг боловсон хүчнийг авч үлдэх, урт хугацааны амжилтад хүрэхэд зайлшгүй шаардлагатай.
- Багш, захиргааны ажилтан, туслах ажилтнууд зэрэг бүх ажилтны ажил, амьдралын эрүүл тэнцвэрийг бий болгох. Хэт их ачааллаас зайлсхийж, стрессийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх.
- Ажилтны байнгын мэргэжил дээшлүүлэх боломж, тухайлбал, семинар, сургалт, шинэ ур чадвар эзэмших боломжуудад хөрөнгө оруулалт хийх.
- Хүлээн зөвшөөрөх, үнэлэх соёлыг бий болгох. Эерэг, урам зоригтой

уур амьсгалыг бий болгохын тулд ажилтнуудын ололт, амжилт, хувь нэмрийг үнэлэх

- Гүйцэтгэлийн үнэлгээний шударга, үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх
- Шаардлагатай үед манлайллын үүрэг гүйцэтгэхэд бэлэн мэргэшсэн хүмүүс байгаа эсэхийг баталгаажуулахын тулд залгамж халааг төлөвлөх
- Ялгаварлан гадуурхах аливаа тохиолдлыг нэн даруй шийдвэрлэж, бүх ажилтанд тэгш боломж олгох.
- Сургуулийн хамт олны доторх зөрчилдөөнийг шийдвэрлэх тодорхой бөгөөд шударга үйл явцыг бий болгох. Асуудлыг цаг алдалгүй шийдэж, ажилтнуудаа сонсож, дэмжих
- Хүний нөөцийн үйл ажиллагаа нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, боловсролын зорилгод нийцэж байгаа эсэхийг шалгаж байх

Эдгээр зөвлөмжийг сургуулийн удирдлагууд ажилтнуудынхаа сайн сайхан байдал, өсөлтийг дэмжих тогтвортой, дэмжлэгтэй орчныг бүрдүүлж, эцэст нь сургуулийн нийт хамт олонд үр өгөөжөө өгөх боломжтой гэж үзэн тооцож ажиллахыг зөвлөж байна.

Шигтгээ 5. Товч асуулт хариулт

А: Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн бодлого гэж юу вэ?

Х: Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн бодлого (Хүний нөөцийн бодлого) нь ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүний нөөцийн менежментийг зохицуулах цогц заавар, зарчим, дүрэм юм. Энэ нь ажилд авах, боловсон хүчний хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ, ажилчдын харилцаа, нөхөн олговор, тэтгэмж болон сургуулийн ажиллах хүчинтэй холбоотой бусад асуудлууд зэрэг хүний нөөцтэй холбоотой янз бүрийн асуудалд сургуулийн арга барилыг тодорхойлсон.

А: Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн бодлогын зорилго ямар байх вэ?

Х: Боловсон хүчнийг тууштай, шударга, үр дүнтэй удирдах тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

А: Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн бодлогын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд юу юу орох вэ?

Х: Дараах бүрэлдэхүүн хэсгүүд орно. Үүнд:

- **Ажилд авах ба сонгон шалгаруулах:** Ажлын байрны тодорхойлолт, мэргэшил, ажилд авах журам, сонгон шалгаруулах шалгуур зэргийг багтаасан шинэ ажилтан авах заавар
- **Ажилд орох ба чиг баримжаа олгох:** Шинэ ажилчдыг угтан авах, тэднийг сургуулийн соёл, үйл ажиллагаанд нэгтгэхэд нь туслах үйл явц
- **Мэргэжил дээшлүүлэх:** Байнгын сургалт, зөвлөгөөн, ажилтнуудын ур чадвар, мэдлэгээ дээшлүүлэх боломжийг олгох бодлого.
- **Гүйцэтгэлийн үнэлгээ:** Ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, үнэлгээ хийх, санал хүсэлт өгөх, зорилгоо тодорхойлох журам
- **Ажилтны харилцаа, ёс зүй:** Ажлын эерэг орчныг бүрдүүлэх, гомдлыг шийдвэрлэх, хүндэтгэлтэй зан үйлийг төлөвшүүлэх, зөрчилдөөнийг зохицуулах удирдамж
- **Нөхөн олговор, тэтгэмж:** Цалингийн бүтэц, урамшуулал, урамшуулал, тэтгэмж, чөлөө олгох бодлого болон нөхөн олговрын бусад хэлбэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл
- **Олон талт байдал ба хамруулах:** тэгш байдлыг дэмжих стратеги бүхий, олон талт ажлын байрыг бий болгох амлалт
- **Эрүүл мэнд, аюулгүй байдал:** Ажиллагсад, оюутнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангах арга хэмжээ.
- **Ёс суртахууны хэм хэмжээ:** Ёс суртахууны зан үйл, нууцлал, мэргэжлийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх хүлээлт.
- **Оролцогч талуудын оролцоо:** Эцэг эх, асран хамгаалагчид, оюутнууд болон олон нийттэй мэргэжлийн түвшинд харилцах заавар.
- **Хуульд нийцсэн байдал:** Хөдөлмөрийн тухай хууль, боловсролын дүрэм журам болон боловсролын байгууллагад ажилд орохтой холбоотой бусад хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөх.
- **Ажлаас халах ба тусгаарлах:** Ажилтныг ажлаас халах, тэтгэвэрт гарах, зэрэг журам, үүнд гарах ярилцлага, зөвшөөрөл олгох үйл явц орно.

Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн бодлогыг сайтар боловсруулсан нь сургуульд ажлын эерэг орчин бүрдүүлэх, мэргэшсэн боловсон хүчнийг татан оролцуулах, хадгалах, сургуулийн ерөнхий зорилго, зорилтод хувь нэмэр оруулах хүний нөөцийн үр дүнтэй менежментийг хангахад тусалдаг. Энэ нь мөн сургуулийн хамт олонд үүсч болзошгүй хүний нөөцтэй холбоотой асуудал, зөрчилдөөнийг шийдвэрлэх тулах цэг болдог.

3.6.4 СУРГУУЛИЙН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ



АСУУДАЛ

Сургуулийн санхүүжилт, төсвийн зарцуулалт хаалттай

- Төсвийн хүрэлцээ (хувьсах зардал) – ний талаар мэдээлэл өгдөггүй
- Төсвийн шинэчлэлээр олгож буй зардлуудын зарцуулалтын талаарх мэдээлэл нээлттэй бус
- Боловсролын мэдээллийн системийн дата үнэн зөв, бодитой бус, өөрчлөлтийн мэдээллийг шинэчлэх ажил хийгддэггүй
- Холбогдох эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, зохицуулалтын аргачлал, зааврыг судалж, ашиглахдаа дутагдалтай /санхүүгийн ажилтанд шууд найддаг/
- Удирдлагын төсөв санхүүгийн мэдлэг боловсрол дутмаг, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг уншиж судлаагүйн улмаас хэрэгжилт, зохион байгуулалтад алдаа их гаргадаг



ЗӨВЛӨМЖ

- Төсвийн талаарх ойлголт, олгож буй зардлуудын зарцуулалтын талаарх мэдээллийг нээлттэй шилэн болгох
- Холбогдох эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, зохицуулалтын аргачлал, зааврыг судалж, ашиглалтыг сайжруулах
- Удирдах ажилтнууд төсөв санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх
- Төсвийг тооцон нийт багш нарт танилцуулж хэвших, зарцуулагдах хэрэглээний сонголтыг сургалтын үйл ажиллагаатай уялдуулан сонголт хийх боломжийг бүрдүүлж ажиллах

3.6.5 ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

Хамтын ажиллагаа, түншлэл яагаад хэрэгтэй вэ?

Түншлэл нь нийгэмд тулгарч буй гол сорилтуудын шинэлэг шийдлийг олж, өөрчлөлт хийхэд харилцан ашигтай хамтран ажиллахаар тохиролцсон гэрээ юм.

Ерөнхий боловсролын сургуулийн түншлэлийг сургуулийн дотоод үйл ажиллагаа дахь хамтын ажиллагаа, түншлэл, гадаад үйл ажиллагаа дахь хамтын ажиллагаа түншлэлээр тодорхойлдог. Энэ удаад сургуулийн гадаад үйл ажиллагаа дахь хамтын ажиллагаа, түншлэлийн

- Орон нутгийн засаг захиргаа
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага
- Олон нийт
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүрээнд авч үзнэ.

Боловсрол нь бүх нийтийн үйл хэрэг бөгөөд Монгол улсад салбар дундын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Сургууль нь олон талт хамтын ажиллагааны түншлэлээр үндэсний, олон улсын байгууллагууд, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг татан оролцуулах замаар хамтран ажиллах боломжтой байдаг.

Орон нутгийн засаг захиргаа, сургууль нь эхний зөвшилцөлд хүрсний дараа зорилгоо хэрэгжүүлэх стратегийг төлөвлөнө. Орон нутгийн музей, театр, номын сан, спорт клубууд нийгэм соёлын байгууллагууд, орон нутгийн бизнес аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгуудыг төлөвлөж болно.

Сургууль нь боловсрол эзэмшүүлэх, соён гэгээрүүлэх байгууллага тул эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч олон нийттэй түншлэн ажиллах замаар орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой. Орон нутгийн засаг захиргаа, сургууль, олон нийт багаа зөв бүрдүүлэн түншлэх нь үр дүнд чиглэсэн амжилттай түншлэлийг бий болгоход чухал нөлөө үзүүлдэг.



АСУУДАЛ

- Сургуулиас зохион байгуулсан аливаа үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, оролцоо муу. Хүүхдээ сургуульд хэт даатгадаг, өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарладаггүй, гэрийн даалгавар хийх боломж, орчин нөхцөлийг нь бүрдүүлж өгдөггүй, хүүхдээ хичээлд явуулдаггүй, үг хэлээрээ багш нарыг доромжилдог, багш, сургуулийн удирдлагуудтай ярилцдаггүй, ойлголцохыг хүсдэггүй сөрөг хандлагатай эцэг эхчүүд цөөнгүй байна.
- Тайлангийн асуудал хэсэгт түншлэл, хамтын ажиллагааны талаар тодорхой дурьдаагүй байгаа бөгөөд түншлэлийн асуудлыг илрүүлж харах нь цаг хугацааны хувьд болоогүй байгаа нь харагдаж байна.



ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ЖИШЭЭ

Сургуулийн удирдлагын багийн сургуулийн зорилгыг тодорхойлох, зорилгод хүрэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүхий л шатанд багш ажилтан сурагч, эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчид болон бусад төрийн болон ТББ-ийн оролцоог хангах, идэвхи санаачлагыг өрнүүлэх, сургуулийн зорилгод хүрэхэд бүх нийтээр түншлэн хамтран ажиллах арга хандлагын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн бөгөөд уг мэдлэг ойлголтыг практикт хэрэгжүүлж ажиллах эхлэлийг тавьж чадсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Сургууль нь нутгийн зөвлөлтэй хамтран, ногоон байгууламж сэргээх, засвар үйлчилгээ хийх, ургамлыг хамгаалах, усны бохирдлоос сэргийлэх арга хэрэгсэлд хүүхдүүдийг сургах, сургуулийн гадаад орчныг аюулгүй таатай байлгах, эрсдэл, аюулыг арилгахад хамтран ажилладаг.

*Эх сурвалж: Local Government and School Partnerships
State Government Victoria*

НТБ - ын төвийн багш нартай хамтран “Багшийн ёс зүй”-н манлайллын талаар багш нартай нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, БАГШИЙН ЁС ЗҮЙН МАНЛАЙЛЛЫН ТАЛААР ЖИШЭЭ – КЕЙС дээр ажиллаж, багш нарын хандлагад нөлөө үзүүлэхүйц ажил зохион байгуулсан.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас

Хүүхэд ирээдүйн баялаг ТББ болон Лингорс ХХК хамтран зохион байгуулсан “GURU” 4 цагийн Сэтгэл зүйд суурилсан Анги удирдсан багшийн хөтөлбөрт БАЗАН - аас 17 багш хамрагдаж, сургалтын үйл ажиллагаандаа тусган ажиллаа.

... аймгийн ... сумын ерөнхий боловсролын ... сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд хийсэн ажлаас



ЗӨВЛӨМЖ

- Тухайн орон нутгийн БШУГ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахад сургуулийн удирдлага манлайлал үзүүлж ажиллахыг зөвлөж байна.
- Хувийн хэвшлийн байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд сургуультай түншлэн ажиллах боломжтой тул санаачлагыг орон нутгийн засаг, захиргаа сургууль хамтран төлөвлөж хэрэгжүүлээрэй. Хэрэгжилтийн үр дүнд хүүхдэд эерэг өөрчлөлт гарсан байхад анхаарч төлөвлөөрөй.
- Үндэсний болон олон улсын байгууллагуудтай хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг ирэлхийлж ажиллаарай.
- Түншлэлийг оновчтой удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахын тулд тулгамдсан асуудлаа зөв тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга хэрэгсэл, бодит нөөц, боломж, бэрхшээл, давуу ба сул талыг судлан нэгдсэн ойлголтод хүрэх нь чухал байна.

3.6.6 СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ, САЙЖРУУЛАХ

Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийг яагаад үнэлэх хэрэгтэй вэ?

1. Сургуулийн зорилго, зорилтууд хэрэгжиж чадсан эсэх
2. Нэгдсэн цогц төлөвлөлт бүрэн хэрэгжсэн эсэх
3. Төсөөлж, хүлээсэн үр дүнд хүрсэн эсэх зэргийг тодорхойлох
4. Сургалт, үйл ажиллагаа, менежментийн доголдол, сул болон ололттой талыг илрүүлэх
5. Цаашдын чиглэл, юуг яаж сайжруулах арга замын зураглал гаргах

Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийг яагаад сайжруулах шаардлагатай вэ?

1. Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг дээшлүүлэх
2. Хүүхэд бүрийн хөгжлийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах



АСУУДАЛ

Сургуулийн үнэлэмж тааруу, удирдах багийн чадавх сул

- Сургалтын чанар, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид сэтгэл хангалуун бус
- Судлагдахуун бүрийн сургалтад анализ хийж засан сайжруулалтын явц, үр дүнг тооцдоггүй
- Сургалтын чанарыг сайжруулах санаачлага гаргадаггүй
- Зохион байгуулалт хийх чадвар дутмаг, оновчтой менежмент хийдэггүй



ЗӨВЛӨМЖ

№	Шаардлага	Зөвлөмж
1	Захирал нь албан тушаалын тодорхойлолт, сонгон шалгаруулалтын шалгуур хангасан байх	БСШУ-ны сайдын ...тоот тушаалыг болон ТАЗ-ийн ... тоот зөвлөмжийг, мөн 2023 онд батлагдсан боловсролын хуулийн дагуу 8-аас дээш жил багшилсан, 5-аас дээш жил сургалтын менежерээр ажилласан, багшлах эрхтэй, мэргэжлийн тэргүүлэх зэргээс дээш мэргэжлийн зэрэгтэй байж захирлын сонгон шалгаруулалтад орж байх, ингэхдээ “Сургууль хөгжүүлэх бодлого, мөрийн хөтөлбөр” боловсруулж өрсөлддөг байх Ингэж шатлан дэвшүүлэх зарчмаар шалгуур ханган томилогдсон захирал сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, үр дүнд хүргэх сайн менежмент хийж, багш сурагчдыг болон сургуулийг хөгжүүлж чадна.
2	Захирал шаардлагын түвшинд өөрийгөө хөгжүүлэх	Захирал өөрөө сайн багш байх, сургалтад байнга хяналт тавьдаг, сургалт руу ордог байх, Захирал санаачлагатай, бүтээлч, шаргуу, сайн удирдагч болох, бусдын сайн туршлагаас суралцах, ёс зүйг эрхэмлэх, хариуцлагатай, зарчимч байх
3	Захирал нь удирдагчийн олон чадваруудад суралцах	Боловсруулах, Төлөвлөх, Гүйцэтгэлийг удирдах, Зохион байгуулалт хийх, Үнэлгээний үр дүнг шинжлэн суурь асуудлыг тодорхойлох, тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх, Шинийг эрэлхийлэх, Хөгжлийн төлөвийг төсөөлөн менежмент хийх, Үр дүнд анализ хийх, Сайжруулах оновчтой менежмент хийх, Ажлыг гардан удирдаж удирдлагын багаа чадавхижуулах, Зөвхөн аж ахуйн даргын үүрэг гүйцэтгэх биш сургуулийн үндсэн үүрэг болох сургалтын менежмент хийх, IT-ийн хэрэглээний программууд дээр ажиллах, Хүүхдийн хөгжил төлөвшилд санаачлагатай байж зохицуулах, Урамшуулан дэмжих, Бусдад боломж олгох, Мэдрэмжтэй байх, Бусдад нөлөөлөх, Бусдыг дагуулах, Нөхцөл байдалд тохируулга хийх чадваруудыг эзэмших

4	Удирдлагын баг чадавхжих	Нэгдмэл, Дотоод ардчилалтай, Эрх мэдлийн хуваарилалттай байх, Хариуцлагатай, Зарчимч, Манлайлал сайтай байх, Онолын мэдлэг, заах арга зүй, хариуцлага, санаачлага, харилцаа хандлагын хувьд багш нараас илүү өндөр түвшинд байх, Сургуулийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хамт олноор хэлэлцүүлэх, саналыг нь тусган албажуулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, зөв төлөвлөх, оновчтой менежмент хийх, Сургуулийн үйл ажиллагаа бүрт сайн зохион байгуулалт хийх, Хүн бүрийн оролцоог чухалчлах, Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, Оновчтой шийдвэр гаргах чадварт суралцах, Ямагт хүнийг эрхэмлэх, Нийгмийн асуудалд санаачлагатай байх, Хүний хөгжлийг дэмжигч байх, Сургалтын боломжит таатай орчин бүрдүүлэх, Хурдтай, шаргуу ажиллах
5	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, сургуулийн үйл ажиллагааны менежментийг сайжруулах	<p>Бид төлөвлөж, хэрэгжүүлж, үр дүнгээ тооцдог ч Төлөвлөгөөг цогцоор нь хийдэггүй, хэрэгжихүйц, оновчтой гол ажлуудаа төлөвлөхдөө учир дутагдалтай, Хэрэгжүүлэхдээ сайн зохион байгуулалт хийж, ажил бүрийг эзэнжүүлдэггүй, Үр дүнгээ тооцохдоо зорилго зорилтууд биелэгдсэн эсэхэд анхаардаггүй, нэгтгэл анализ харьцуулалт хийдэггүй, гүйцэтгэл бүртээ үнэлгээ өгдөггүй бөгөөд цаашид сайжруулалт хийхийг орхигдуулдаг.</p> <p>Иймээс зохион байгуулсан ажил бүрийн гүйцэтгэлийн үр дүнг тооцохдоо цаашид хэрхэн сайжруулах, яаж илүү сайн зохион байгуулах, яавал үр дүнг дээшлүүлж болох талаар хэлэлцэн тухайн ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийг гүйцэтгэх арга хэлбэр, хүн бүрийн оролцоо, үүрэг, хариуцлага, гүйцэтгэл, үнэлгээг сайжруулах дараагийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж үр дүнгээ дахин тооцож, дараагийн сайжруулалтыг хийж байхыг зөвлөж байна</p>

Хяналт шинжилгээ, үнэлгээг дараах 5 алхамтай хийнэ.

Алхам 1	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүрээгээ тодорхойлох
Алхам 2	Үнэлгээ хийх хэрэгслээ боловсруулах
Алхам 3	Үнэлгээг хэн, хэзээ хийх төлөвлөгөө гаргах
Алхам 4	Мэдээлэл цуглуулах, боловсруулж, нэгтгэх, баримтад дүн шинжилгээ хийх, үр дүн гаргах
Алхам 5	Тайлагнах, сайжруулах арга замаа тодорхойлох <ul style="list-style-type: none"> • Хэн хэнд тайлагнах вэ? • Хэрхэн сайжруулах вэ?

Сургуулийн менежментийг хэрэгжүүлсэн сайн сургуулийг бий болгох үйл явцыг дараах 5 үйл ажиллагаанд хуваан үзэж болно.

Зураг 46. Сайн сургуулийн 5 үйл ажиллагаа

Сургуулийн асуудлыг илрүүлэх

Өнөөг хүртэл сургуулийг захирал болон сургалтын менежер удирдан зохион байгуулдаг. Нөгөө талаас сургуулийн үйл ажиллагаа бүрд оролцон, “яагаад, юуг, яаж, хэрхэн” хэрэгжүүлбэл сургалтын үр дүн хамгийн сайн байж чадах вэ гэдгийг шийдэж, хүүхдүүдийг шууд удирдан чиглүүлж, дэмжиж байдаг хүмүүс бол багш нар байдаг. Иймээс багш, удирдлагууд нягт хамтран ажиллаж “Сайн сургууль” -ийг бүтээхийн тулд юу юунаас илүү эхлээд “Одоо манай сургууль ямар байдалтай байна вэ?” гэдгийг тодруулах нь зүйтэй.



Сургууль бүрт өөрт тохирсон асуудлууд байсаар байдаг. Асуудал нь хэр гүн гүнзгий вэ гэдэг л болохоос биш өдөр бүр тухайлсан асуудлууд ар араасаа урган гарч ирдэг. Тэдгээр тухайлсан асуудлууд нь өнөөдөртөө шийдэх асуудлаас эхлээд хэдэн жил сайтар арга хэмжээ авч байж шийдэгдэх асуудал гээд янз бүр байдаг. “Сайн сургууль”-ийг бүтээхийн тулд аль тухайлсан асуудал нь сургуулийн хувьд тулгамдаад байна вэ гэдгийг тодорхойлж, хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх дарааллыг тогтоохгүй бол болохгүй. Ялангуяа сургууль нь жилээр сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөдөг учраас “Энэ жил шийдвэрлэх асуудал”-ыг сургуулийн асуудал гэж тогтоон, түүнийг шийдвэрлэхийн төлөө багш нар хамтран ажиллах зарчмаар бодож сэтгэж ажиллах нь зүйтэй.

Зорилго, зорилтыг сайжруулах

Сургуулийн асуудал нь тодорхой болонгуут дараа нь зорилго, зорилтоо тодорхойлох, сайжруулах шаардлага үүснэ. Гэвч сургуулиудын ихэнх нь нэг зорилгын дор нэгдэж, өдөр тутмын үйл ажиллагаанд тусгалаа олж, бодитой хэрэгжиж чадахгүй байна. Сургуулиуд зорилгоо олон янзаар тодорхойлж байна. Уриа төдийгөөр хязгаарлагдаж бодит байдал дээр сургууль, хүүхэд, гэр бүл, орон нутгийн өнөөгийн байдал болон сургуулийн асуудалтай нийцээгүй байх тохиолдол бий. Сургуулийн зорилго, зорилтыг тухайн сургуульд суралцаж буй хүүхэд уншаад өөрөө цаашид зорих дүрээ төсөөлж чадаж байна уу?, зорилт нь асуудлын шийдэл талаас бодитой болж чадаж уу? гэдгийг нягтлах нь зүйтэй.

Сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хэрэгжилт

Хамт олноороо хэлэлцэж тухайн хичээлийн жилдээ хүрэх боломжтой зорилго, зорилтоо тодорхойлсны дараа түүндээ үндэслэн хичээл, сургалтын үйл ажиллагаануудаа зураглах үе шатанд орно. Үүний тулд, эхлээд сургууль дээр явагдаж байгаа сургалтын үйл ажиллагаануудын чанарыг шалгаж, сургуулийнхаа сургалтын зорилго, зорилттой уялдуулан сайжруулах, цар хүрээг нь хумих, зарим тохиолдолд бүр хасах тухай эргэцүүлэх хэрэгтэй бөгөөд өөр хоорондоо уялдаа бүхий сургуулийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй. Ихэнх сургуулийн хувьд хүүхэд хамгаалал, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, сонгон, дугуйлан секцийн гэх мэт өөр өөрийн зорилго бүхий салангад олон төлөвлөгөө боловсруулдаг байна. Энэ нь сурагчийн ачааллыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны чанар, идэвхи оролцоог бууруулах зэрэг сөрөг үр дагавар үзүүлдэг байх талтай.

Үр дүнгийн үнэлгээ болон сайжруулалт

Тодорхой хугацаанд хичээл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан бол түүнийхээ үр дүнг үнэлэх нь шаардлагатай байдаг. Бид ямар ч үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бол түүнийгээ үнэлээд, сайжруулалттай холбох нь зүйтэй. Гэхдээ тэрхүү үнэлгээ нь “Үнэлгээний төлөөх үнэлгээ” болчихвол багшид хий дэмий ажилласан мэт сэтгэгдэл үлдээхээс цаашгүй. Нэгэнт хүч хөдөлмөр, цаг зав зарцуулан үнэлгээ хийсэн тохиолдолд хичээл, сургалтын үйл ажиллагаа нь сурагчдад ямар ахиц, эерэг нөлөө үзүүлснийг бодитой, үнэн зөвөөр илрүүлж, цаашдын хичээл, сургалтын үйл ажиллагааг сайжруулахад үр дүнтэй ашиглаад явах нь зөв. “Хичээл, сургалтын үйл ажиллагааг ямар хэлбэрээр зохион байгуулсан бэ?” гэдэгтэй холбоотой үнэлгээ, “сурагчдад ямар хөгжил, эерэг өөрчлөлт ажиглагдсан бэ?” гэдэгтэй холбоотой (outcome үнэлгээ)-г явуулж байхын тулд дараах мэдээллийг сургууль дотроо цуглуулж үнэлгээ хийж болох юм.

Бүх талын оролцоог хангах

Сургуулиуд шийдвэр гаргах, асуудал шийдвэрлэх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахдаа талуудын оролцоог хангах соёлыг хэвшүүлэх нь зүйтэй. Сургуулийн соёл гэдэг бол сургуулийн удирдлага, багш, сурагч, хамт олны нэгдмэл итгэл үнэмшил, үзэл санаа, үнэт зүйл, бахархал, хандлага хэмээх далд орших чанарууд, түүний тусгал, дадал зуршил, хэм хэмжээ, дүрэм журам, сахилга бат, эмх цэгцийг илтгэсэн цогц тогтолцоо юм. Тэгэхээр, “Хичээл зүтгэл хэчнээн гаргалаа ч сайшаагдахгүй” “Юу ч хийж, яаж ч хичээсэн үр дүнгүй”... гэх мэт хүнд нөхцөл байдалд итгэл найдвараа алдсан багшийг дэмжиж “Юу ч болсон хийгээд үзье”, “Хийгээд үзэхээр сурагчдад өөрчлөлт гарч байна шүү” гэж урагш тэмүүлж чаддаг болгох нь менежментийн арга

бөгөөд мөн зорилго нь юм. Сайн менежменттэй сургуулийг бүтээхийн тулд шаардлагатай нөхцөл болон аргачлалыг дээрээс доошоо чиглэлтэйгээр дамжуулах бус багшаас эхлээд сургуультай хамааралтай хүмүүсийн арга ухааныг нэгтгэн, хамтын ажиллагаагаар гаргаж ирэх нь зүйтэй. Мөн хичээл, сургалтын үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой бодит үр дүнг хамтрагч талууддаа мэдээлж, хуваалцаж байх нь чухал. Эерэг хандлагатай сургуулийн соёлыг бүрдүүлэхийн тулд энэ мэт энгийн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сургуулийн менежментийн зураглалыг хэрхэн боловсруулах вэ?

Сургуулийн менежментийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө “Сургуулийн менежментийн зураглал”-ыг боловсруулна. Энэ нь сургуулийн ерөнхий дүр төрхийг буулгасан нэгдсэн зураглал юм. Үүнийг боловсруулснаар тухайн жилийн сургуулийн зорилго, сургалтын үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой болно. Ямар сурагчийг бэлтгэхийн тулд ямар зорилго тавьж, түүндээ хэрхэн хүрэх вэ гэдгийг энэхүү зураглал/загвараар тодорхой харуулна. Ингэснээр нийт багш, эцэн эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн сургууль энэ жил ямар зорилгод хүрэхээр юу хийх гэж байгааг тодорхой мэдэж сургалтын үйл ажиллагаагаа оновчтой явуулах боломжтой болно. Нэгдсэн зураглалаар дэвшүүлсэн зорилго ба үйл ажиллагаатай хамааралгүй, шаардлагагүй ажлуудыг хэрэгжүүлэх эсэх талаар дахин хэлэлцэх, ирэх жилийн ажил руу шилжүүлэх зэргээр ажил сонголтыг шалгуур болгон ашиглах боломжтой. Зөвлөмжийн энэ хэсэгт сургуулийн менежментийн зураглал боловсруулах аргачлал бүхий дадлага ажлын удирдамжийг орууллаа. Та бүхэн хамтын оролцоотойгоор менежментийн зураглал боловсруулахдаа дараах аргачлалыг ашиглаж болох ба сургуулийн онцлог, боломж бололцоонд суурилан баяжуулж, хөгжүүлж болох юм.

Бид, “шийдэл гаргах”-д сургууль асуудлаа тодорхойлох ⇒ асуудлуудаас аль нь тулгамдаж буйг тогтох ⇒ тэдгээрт тулгуурлан хичээлийн жилийн зорилгоо тодорхойлох ⇒ тухайн хичээлийн жилийн зорилтуудаа тодорхойлох ⇒ зорилт бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох ⇒ тухайн үйл ажиллагааг хэний ямар оролцоотой хэрэгжүүлэхдээ санал нэгдэх ⇒ тухайн үйл ажиллагааг ямар хугацаанд хэрэгжүүлэхдээ санал нэгдэх ⇒ хүрэх үр дүнгээ хамтаараа тодорхойлох зэрэг сургуулийн хөгжлийн төлөөх үйл ажиллагааны төлөвлөлттэй илүү холбон авч үзэхийг зөвлөж байна.

Сургуулийн менежментийн зураглал
боловсруулах арга зүй



Сургуулийн менежментийн зураглалтай
уялдуулан хичээл сургалтын үйл
ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэн, үнэлж
сайжруулахад суралцах арга зүй



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ**

Цаасны хэмжээ: 176х250

Хэвлэлийн хуудас: 16,6

Хэвлэсэн тоо: 2000 ш

“Урангар пресс” ХХК-д хэвлэв.